



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-152
1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа	9-11
2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	14-91
3.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	91-152

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
09 дүгээр сарын 07-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 81 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтанхуяг, Д.Амарбаясгалан, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Н.Батсүмбэрэл, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, А.Ганбаатар, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Заяабал, С.Зулпхар, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, Л.Соронзонболд, Б.Түвшин, О.Цогтгээрэл, Ө.Шижир, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Б.Батцэцэг, Б.Бейсен, Ж.Ганбаатар, Г.Лувсанжамц, Б.Тулга, Г.Уянгахишиг, Р.Эрдэнэбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Д.Батбаяр, Х.Баттулга, Д.Ганбат;

Хоцорсон: Н.Алтаншагай-11 минут, Э.Болормаа-04 минут, Ч.Лодойсамбуу-11 минут, Б.Найдалаа-01 минут, Н.Номтойбаяр-11 минут, П.Сайнзориг-11 минут.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
нээлтийн ажиллагаа**

“Их хуралдай” танхим дахь Монгол Төрийн далбааны дэргэд Хүндэт харуул зогсож, Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлсэн байлаа.

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан;

Зүүн хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ;

Зүүн урд талд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга П.Баярмагнай, Нээлттэй парламентын газрын дарга Б.Амарбаяр, Мэдээллийн технологийн газрын дарга Т.Бат-Эрдэнэ, Захиргааны удирдлага, хүний нөөцийн газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Эрх зүй, эдийн засаг, төсвийн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Төмөр-Очир, Зохион байгуулалтын хэлтсийн дарга Т.Нармандах, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх;

Баруун урд талд Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга Д.Болормаа, Улсын Их Хурлын даргын зөвлөх Б.Анар, Г.Билэгзаяа, П.Тамир, Г.Золбоо, Улсын Их Хурлын даргын шадар туслах О.Мандах нар тус тус суудлаа эзэлсэн байв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Нээлтийн ажиллагаа 11 минут үргэлжилж, хуралдаан 10 цаг 13 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 09 дүгээр сарын 06-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2026.07.06-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр нарын 9 гишүүнээс 2026.07.22-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

Засгийн газраас 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Засгийн газраас 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нарын 10 гишүүнээс 2026.08.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Засгийн газраас 2026.08.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүнээс 2026.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Засгийн газраас 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Засгийн газраас 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Засгийн газраас 2026.09.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./14:05/

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт иргэн Д.Гансаруулаас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн “Оршуулгын газрын эмх цэгц, эрх зүйн шинэчлэлийг хийцгээе” асуудлаар Хуулийн төсөл санаачлах тухай нийтийн өргөдөл 2026.06.30-ны өдөр ирүүлснийг Улсын Их Хурлын Нийтийн өргөдлийн системд 2026.07.14-ний өдөр нийтэлж, 2026.08.14-ний өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 100,237 /нэг зуун мянга хоёр зуун гучин долоо/ иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Хууль зүйн байнгын хороо болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Өргөдлийн байнгын хороонд;

Иргэн Э.Батбаяраас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн “Орон нутгийн замын хураамж 10000 төгрөг болсныг цуцлах” асуудлаар Ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл 2026.07.20-ны өдөр ирүүлснийг Улсын Их Хурлын Нийтийн өргөдлийн системд 2026.07.24-ний өдөр нийтэлж, 2026.08.27-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33,095 /гучин гурван мянга ерэн тав/ иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд;

Иргэн Б.Болорчулуунаас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн “Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ буцаалт 2% биш 8% болгох” асуудлаар Ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл 2026.06.24-ний өдөр ирүүлснийг Улсын Их Хурлын Нийтийн өргөдлийн системд 2026.07.14-ний өдөр нийтэлж, 2026.08.23-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33,062 /*гучин гурван мянга жаран хоёр*/ иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./14:08/

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Ринчинбазар, А.Энхбат, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны ерөнхий эдийн засагч Н.Батсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар танилцуулав.

Илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Цэнгүүн, Г.Очирбат, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, М.Нарантуяа-Нара, Б.Мөнхсоёл, О.Номинчимэг, О.Батнайрамдал, Г.Хосбаяр, Д.Үүрийнтуяа, Ц.Туваан, М.Мандхай, Ц.Мөнхтуяа, О.Алтангэрэл, П.Наранбаяр, Да.Цогтбаатар, Ц.Баатархүү, Х.Булгантуяа, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Б.Жаргалан, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд

З.Мэндсайхан, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Энхтуяа, Ц.Туваан, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод, бусад Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Мягмар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Одонтуяа, Р.Ринчинбазар, А.Энхбат, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Г.Билгүүн, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга Г.Аззаяа, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Тусгай чиг

үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, аудитын менежер С.Нацагдорж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярмагнай, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сумъяа, Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ч.Сугармаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Бауыржан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төсвийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Б.Дэлгэрсайхан нар тус тус танилцуулав.

Хуралдаан 19 цаг 20 минутаас 19 цаг 50 минутад завсарлав.

Танилцуулга, дүгнэлтүүд, төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Г.Очирбат, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат, Л.Энхнасан, Г.Ганбаатар, С.Эрдэнэболд, С.Одонтуяа, Г.Хосбаяр, П.Батчимэг, Ц.Туваан, М.Мандхай, Б.Уянга, Да.Цогтбаатар, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Эрүүл

мэндийн сайд Э.Батшугар, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, С.Эрдэнэбат, Да.Цогтбаатар, Б.Батбаатар, Б.Жаргалан нар үг хэлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 23 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Япон Улсын Үндэсний Парламентын гишүүд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын референт Б.Мөнгөншагай, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 54 минут үргэлжилж, 126 гишүүнээс 87 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 23 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Бүгдээрээ сайхан намаржицгааж байна уу? Монгол Улсын Их Хурлын 2026 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн чуулганы хуралдааны ирцийг танилцуулъя. Ирвэл зохих 126 гишүүнээс 81 гишүүн буюу 64.3 хувийн ирцтэй байна. Чуулганы ирц хүрсэн байна. Чуулганы хуралдааныг нээж үг хэлье.

Хүндэт ард, иргэд ээ, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Эрхэм Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Нар, хур тэгширсэн дэлгэр зун өнгөрч, намрын их ажил хаа сайгүй өрнөн, ирэх өвлийн бэлтгэлээ шамдан базаасан энэ цаг үед хугацаа алдалгүй шийдвэрлэх асуудлууд үүсээд байгаа тул хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд миний бие Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж байна. Монгол Улсын эдийн засаг энэ оны эхний 7 дугаар сарын байдлаар 7.6 хувиар өсөж, экспорт 12 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 57 хувиар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтийн үр өгөөж иргэдийн амьдралд дэм болж, ахиц, дэвшил нь айл, өрхийн үүдээр орлого болж орох нь чухал.

Улс орны эдийн засаг, төсөвт тулгарч буй бодит хүндрэл, нөхцөл байдлыг тооцсоны үндсэн дээр Засгийн газар /ЗГ/-аас өргөн мэдүүлсэн улсын төсвийн тодотголыг Улсын Их Хурал /УИХ/ нэн даруй хэлэлцэж, ард, иргэдийн амьдралд ирж буй дарамтыг бууруулах хариу арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Энэхүү төсвийн тодотголоор хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүн, шатахууны нөөцийг нэмэгдүүлэх, өвлийн оргил ачааллын үед эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах, ахмад настны тэтгэвэр болон төрийн зарим албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх зэрэг иргэдийн амьдралд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр тусгасан онцлогтой байна.

Макро эдийн засгийн эерэг үр дүнг айл, өрх, ард, иргэдийн амьжиргаанд шингээх хүрээнд 435 мянган ахмад настны дундаж тэтгэврийг 250 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1.2 сая төгрөгт хүргэх, 149 мянган төрийн албан хаагчийн цалинг 20-оос 50 хувиар нэмэгдүүлэхээр тооцжээ. Энэ нь 600 орчим мянган айл, өрхийн орлогод шууд дэмжлэг болно гэсэн үг. Энэ удаагийн төсвийн тодотголыг үнийн өсөлтөд амьжиргаа нь хүндэрч буй иргэдээ хамгаалах, цалин, тэтгэврийг нэмэх, ирэх өвлийн түлш, шатахуун, хүнс, эрчим хүчний болзошгүй эрсдэлийг даван туулахад зориулан боловсруулжээ. Бид хэлэлцүүлгийн шатад төсвийн тодотголын тооцооллыг чамбайруулах аливаа шийдэл, хувилбар, санаачилгад олонх, цөөнх гэж ялгалгүйгээр нээлттэй хандах болно. Гагцхүү тэдгээр хувилбар, санаачилга нь иргэдийн амьжиргаа, цалин, тэтгэвэр, бизнес эрхлэх орчныг улам бүр сайжруулахад чиглэх ёстой. Бид өнгөрсөн хугацаанд төсөв хэлэлцэхдээ гагцхүү хэдэн төгрөг тавьсан бэ гэдгээр л хэмждэг байсан бол одоо харин чухам ямар үр дүн гарсан бэ

гэдгээр хэмждэг болох хандлагын өөрчлөлт рүү зоригтой шилжье. Олонх, цөөнхөөрөө хуваагдсан орлого, зарлага тойрсон хий хоосон популист талцлаа хойш нь тавьж, улс орны нийтлэг эрх ашиг, ард, иргэдийнхээ амьдралыг нэн тэргүүнд бодох цаг үе гэдгийг УИХ дахь намын бүлгүүд, гишүүддээ сануулъя.

Энэ удаагийн төсвийн тодотголтой хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүд өргөн мэдүүлжээ. Эдгээр нь зөвхөн энэ удаагийн төсвийн тодотголд хамаарах зохицуулалтын шинжтэй өөрчлөлт бус харин төсвийн тусгай шаардлага, тогтвортой байдал, цаашдын төсөв бүрдүүлэх механизмыг үндсээр нь өөрчлөх суурь зарчмын асуудлууд тул УИХ нухацтай хандах учиртай. Төсвийн тодотголд төрийн өмчит томоохон аж ахуйн нэгж /ААН/-үүдийн орлогыг төсөвт төвлөрүүлэх, ногдол ашгийг нэмэгдүүлэхээр тооцож оруулж ирсэн нь ард түмэндээ байгалийн баялгийн өгөөжийг тэгш, шударга хүртээж, жинхэнэ утгаараа баялагтаа эзэн Монгол болох цаг үеэ олсон сайн өөрчлөлтийн эхлэл хэмээн үзэж байна.

Эрхэм гишүүд ээ, геополитикийн нөхцөл байдал, дайн байлдааны үр дагавар нь дэлхийн улс орнуудын эдийн засагт хүндээр тусаж, эрчим хүч, газрын тос, хүнсний бүтээгдэхүүний үнээр дамжин улс орон, айл, өрх, хүн бүрийн амьдралд сөргөөр нөлөөлж байна. Ийм эгзэгтэй цаг үед бидэнд улс төржсөн төсөв бус улсаа бодсон хариуцлагатай төсөв, өнөөдрийг аргацаасан зохицуулалт бус харин маргаашийн тогтвортой байдлыг хамгаалсан бодлого хэрэгтэй. Иймд Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг 2026 оны төсвийн тодотгол болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцэхдээ улс орны эдийн засаг, хамгийн гол нь иргэдийнхээ амьдрал ахуй, эрх ашгийг 1 дүгээрт тавьж, ажил хэрэгч, хариуцлагатай, алсын хараатай хандахыг хүсье.

Одоогийн байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого 17.3 их наяд төгрөг, нийт зарлага 19.5 их наяд төгрөг болж, төсвийн алдагдал 2.2 их наяд төгрөгт хүрчээ. Төсвийн тодотгол бол үр ашиггүй зардлаа танаж чаддаг, зайлшгүй хэрэгцээгээ эрэмбэлдэг бодлогын зөв шийдвэр байх ёстой. Цалин, тэтгэвэр, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхдээ инфляц /inflation/-ад үзүүлэх сөрөг нөлөөлөл, төсвийн даац, эдийн засгийн бодит боломжтойгоо нягт уялдуулах шаардлагатай. Мөн хувийн хэвшлийн орон зайг хумих биш тэлж, эдийн засгийн эрх чөлөөг тэдэнд олгосон шиг олгох, амласан амлалт, баталсан хуульдаа эзэн болоход анхаарахыг уриалж байна. Түлш, шатахууны тасалдал, эрчим хүчний доголдол зөвхөн нэг салбарын асуудал биш. Үүний шалтгаан нь дотоодоос биш гадаад хүчин зүйлээс хамаатай ч бурууг бусдаас хайж, шалтаг тоочиж суух цаг биш. Өнгөрөгч хаврын чуулганы төгсгөлд УИХ-аас түлш, шатахуун, мах, хүнсний ногооны үнэ, хангамжид онцгой анхаарч, намрын ажил, өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах талаар ЗГ-т анхааруулсан. Үүний хэрэгжилтийг нэхэж ажиллах болно.

Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдлийн хуваарилалт, хариуцлагын заагийг маш тодорхой тогтоосон. Улсын төсвийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх нь ЗГ-ын бүрэн эрх. Харин түүнийг ард түмний нэрийн өмнөөс хэлэлцэж, хянаж, батлах эсэхээ шийдэх нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх юм. Энэ хоёр бүрэн эрхийг хольж хутгах, мөн төсвийн төсөл нь аль нэг улс төрийн хүчинд таалагдаагүй гэх шалтгаар төсөв санаачлах Үндсэн хуульд заасан ЗГ-ын бүрэн эрхийг хязгаарлах хууль тогтоомж Монгол Улсад байхгүй.

Нөгөө талаар оруулж ирсэн төсвийн төслийг хэлэлцэж, эцэслэн шийдэх эрх гагцхүү парламентад хадгалагдаж буйг онцлон сануулъя. Нэг зүйлийг энд зориуд тодруулж хэлье. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын Тамгын газар бүрдлийг нь шалгах, хянах зохицуулалттай. Энэ нь нэг талаасаа Үндсэн хуульд заасан хууль санаачлагчийн эрхийг хамгаалах, нөгөө талаас өргөн мэдүүлэх хуулийн төслийн бүрдлийг бүрэн хангуулах нөхцөл бүрдүүлж байгаа хэрэг юм. Харин хууль санаачлагчийн энэхүү эрхийг хязгаарлаж, бүрдэл хангагдсан хуулийн төслийг буцаах эрх Улсын Их Хурлын даргад ч, ерөөс хэнд ч байхгүй.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, та бүхнийг нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн хамгаална хэмээн өргөсөн тангарагтаа үнэнч байж, төр улсынхаа өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан, улс орныхоо эдийн засгийн тогтвортой байдал, иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг нэн тэргүүнд тавьж, зарчимч, зөв мэргэн шийдвэр гаргахыг хүсье. Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганд нээлтээ хийлээ. Нээлтийн үйл ажиллагаа өндөрлөлөө.

10.12 цаг

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар дараах хоёр асуудлыг хэлэлцэнэ. 14:00 цагаас нэгдсэн хуралдаан эхэлнэ. 1 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. ЗГ 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. 2 дугаарт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сан /НДС/-гийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. Ийм хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Одоо УИХ дахь намын бүлгүүд хуралдана. Үдээс хойших нэгдсэн хуралдаан 14:00 цагаас үргэлжилнэ.

*2026 оны 09 дүгээр сарын 07, Даваа гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 00 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдийн мэндчилгээг дэвшүүлье. МУИХ-ын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг 9 дүгээр сарын 6-ны өдөр төрсөн байна. Тэгээд УИХ-ын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгтээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон Танд болон таны гэр бүлд УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хамгийн эхэнд ирцэд бүртгүүлсэн 5 гишүүнийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа 9:00 цагт, Саруулсайханы Цэнгүүн, Ганбатын Очирбат, Сүхбаатарын Эрдэнэбат, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд өглөө 09:00 цагт ирцдээ орсон байна.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д УИХ-ын дарга хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Үүний дагуу УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Стандарт, техникийн зохицуулалтын тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг ЗГ 2026 оны 7 дугаар сарын 6-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

2.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн Пүрэвсүрэнгийн Наранбаяр нарын 9 гишүүн 2026 оны 7 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд,

3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

4.Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг ЗГ 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

5.Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуяг нарын 10 гишүүн 2026 оны 8 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

6.Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг ЗГ 2026 оны 8 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороо болон ХЗБХ-нд,

7.Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2026 оны 8 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг БОХХАА-н байнгын хороонд,

8.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

9.Монгол Улсын 2027 оны Төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг ЗГ 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

10.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг ЗГ 2026 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр өргөн мэдүүлснийг ХЗБХ-нд тус тус хуваарилсан.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц УИХ-ын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан. Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Монгол Улсын иргэн Давхардаваагийн Гансаруулаас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн оршуулгын газрын эмх цэгц, эрх зүйн шинэчлэлийг хийцгээе асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай нийтийн өргөдөл 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ирүүлснийг УИХ-ын нийтийн өргөдлийн системд 2026 оны 7 дугаар сарын 14-ний өдөр нийтэлсэн. Уг өргөдөл 2026 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 100237 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээний дагуу ХЗБХ болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан.

2.Монгол Улсын иргэн Энхтөрийн Батбаяраас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн орон нутгийн замын хураамж 10 мянган төгрөг болсныг цуцлах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдөр ирүүлснийг УИХ-ын нийтийн өргөдлийн системд 2026 оны 7 дугаар сарын 24-ний өдөр нийтэлсэн. Уг өргөдөл 2026 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 330905 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан.

3.Монгол Улсын иргэн Бямбацогтын Болорчулуунаас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалт 2 хувь биш 8 хувь болгох асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр ирүүлснийг УИХ-ын нийтийн өргөдлийн системд 2026 оны 7 дугаар сарын 14-ний өдөр нийтэлсэн. Уг өргөдөл 2026 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33062 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан. Холбогдох Байнгын хороод нийтийн өргөдлийг хуульд

заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж, нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулахыг чиглэл болгож байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгээ явуулна. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Учрал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

өнөөдөр үнийн өсөлт Монгол айл, өрх, Монгол хүний цалин, орлого, халаас, хэтэвчийг тэмтрэн нимгэлж байна. Үнийн өсөлтийн шуурганд айл, өрх, ард, иргэд, ААН-үүд бүгдээрээ өртөн хохирч байна. Тэр дундаа тэтгэврээс өөр орлогогүй ахмад настнууд, цалингаараа амьдардаг эмч, багш, төрийн үйлчилгээнийхэн илүү ихээр өртөн хохирч байна. Эрчим хүчний өртөг, тарифын өсөлтийг өрхийн үүдээр оруулахгүй байх, цахилгаан станц, шугам сүлжээгээ засаж шинэчлэх хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. Дэлхийн дэг журам өөрчлөгдөж цаг төр үймж, эрчим хүч, энергийн хомсдол, олон улсын худалдаа, тээвэр, нөөц хангамж доголдож байгаа ч Монгол төр, Монгол Улсын ЗГ Монгол хүнээ хамгаалахын төлөө чадах бүхнээ хийх ёстой. Дэлхийн байдлыг Улаанбаатарт шийдэж чадахгүй ч та бидэнд шалтаг тоочин суух эрх байхгүй. Манай улсын эдийн засаг гадаад хүчин зүйлээс хараат, дархлаагүй, эмзэг байгаагийн хэрээр та бид Монгол хүнийхээ төлөө Монголын төрд тоо бодож, тодорхой шийдвэр гаргах өндөр үүрэг хариуцлага ирлээ. Та бид дэлхийд хамгийн тодорхойгүй байдал хамгийн тодорхой хэвээр байгаа цаг үед улс орон, ард түмнийхээ ирэх жилийн ахуй, амьдралыг төсөөлөн төлөвлөхөөр цуглаад байна.

Энэ бүх тулгамдсан сорилтыг туулж давах бодит хэрэгцээ, шаардлагад үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын эрхэм гишүүд та бүхэнд танилцуулж байна.

Энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт орон нутгийн төсөвт хуримтлагдсан ашиглагдаагүй эх үүсвэрийн тодорхой хэсгээ хүнээ бодож хүндээ зориулах үндсэн ганц зорилготой. Ахмадын тэтгэвэр, эмч, багш, байгаль орчин, ХАА зэрэг төрийн үйлчилгээний албаны цалин, гэрэл, дулаан, мах, гурил, хүнсний нөөц, хангамж зэрэг зайлшгүй тулгамдсан бүгдэд илүү хүртээмжтэй зүйлд зарцуулах шийдвэр байх болно. Үүний хамт Төсвийн сахилга бат, тогтвортой байдлаа бататган бэхжүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгалаа. Орон нутгийн төсвийн өмнөх оны ашиглагдаагүй үлдэгдэл сүүлийн 3 жилийн хугацаанд 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 2026 оны байдлаар 2.8 их наяд төгрөгт хүрээд байна. Иймд ашиглагдаагүй энэ эх үүсвэрээ хүнээ бодсон, хүндээ хүрэх зайлшгүй хэрэгцээт зардал болгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Орон нутагтаа нэгэнт эхэлсэн болон зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтаа тасралтгүй үргэлжлүүлэхээр бэлтгэлээ. Иргэддээ зориулсан төрийн бүх үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг хангахаар давхар тооцооллоо. 2026 онд орон нутгийн төсвийн өмнөх оны ашиглагдаагүй үлдэгдлээс 998 тэрбум төгрөгийг зарцуулах эрхийг нээж, үүнтэй уялдуулж төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг 998 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тусгалаа. Үүнээс бусад төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг энэ удаад өөрчлөхгүй байхаар тооцлоо. ЗГ төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг огтхон ч орхигдуулаагүй. Тодруулбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төсвийн хүрээний мэдэгдлийн 9 үзүүлэлтэд 2024 оноос өмнө хэрэгжиж байсан нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ болон нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардлын хэмжээ гэсэн хоёр үзүүлэлтийг нэмж тусгалаа. Үүнтэй уялдуулж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагуудыг өөрчлөн найруулж, уул уурхайн орлогыг дагасан төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах чухал ач холбогдолтой зохицуулалтуудыг тусгаж оруулсан гэдгийг онцлон тэмдэглэе. Энэхүү өөрчлөлтөөр 1 дүгээрт төсвийн эх үүсвэрээ илүү үр өгөөжтэй, иргэндээ хүртээмжтэй ашиглах, 2 дугаарт хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтаа зогсоохгүй үргэлжлүүлэх, 3 дугаарт төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бэхжүүлэх зорилгыг хангах болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн өөрчлөлт нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг бүрэн хангасан болно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд Учралд баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Дэлгэрсайхан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг танилцуулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хуулиар хүлээсэн бүрэн эрхийнхээ хүрээнд төсвийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсвийн тогтвортой байдлыг хангуулах, төсвийн дүрмийг сахин биелүүлдэг байх, төсвийн оновчтой төлөвлөлтөөр дамжуулан макро эдийн засгийн өсөлтийг дэмжих, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах чиглэлд анхааран ажиллаж байна.

ЗГ-аас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах үндэслэлээ тайлбарлахдаа, Монгол Улсын 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн үндсэн үзүүлэлтүүдийг макро эдийн засгийн шинэчилсэн төсөөлөл, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай

уялдуулан шинэчлэн тогтооход оршино гэсэн зорилго дэвшүүлж, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хадгалах, иргэдийн амьжиргааг хамгаалах, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг сайжруулна гэсэн үр дүн гарна хэмээн тодотгосон нь өнөөгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудад чиглэсэн байна гэж үзлээ.

Дэвшүүлсэн зорилго, хөрөнгө, хүрэх үр дүн нь өнөөдөр эдийн засаг, нийгмийн бодит шаардлага байж болох ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн гол зохицуулалтад өөрчлөлт оруулах, төсвийн зарлага, алдагдлыг тус тус 1 их наядаар нэмэгдүүлэх, инфляц /inflation/-ын төсөөллийг 1 хувиар нэмэгдүүлсэн зэрэг гол өөрчлөлтүүдийг тусгасны үр дүн юу байхыг хуулийн төсөлд бүрэн тусган харуулаагүй байгаа нь энэ хуулийн төслийн гол анхаарах зүйл хэмээн үзэж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан гол дүгнэлтүүд:

1.Эдийн засгийн эрсдэл өндөр байгаа үед төсвийн алдагдал, зарлагыг нэмэгдүүлж байгаа нь эрсдэлтэй бодлогын сонголт юм. Эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байхад хийж буй төсвийн тэлэлт нь цаашид төсвийн орлогын уул уурхайн салбараас хамаарах хамаарлыг улам нэмэгдүүлэх, орлого дутагдах, зарлагаа гүйцэхгүй болох эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анхаарах шаардлагатай.

2.Төсвийн дүрмийн тогтвортой байдал алдагдаж байна. Төсвийн тодотголын хамт төсвийн тусгай шаардлагыг 2024 оны 8 дугаар сар хүртэл мөрдөж ирсэн хэлбэрт шилжүүлж байгааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дэмжиж байна. Гэсэн хэдий ч тусгай шаардлагыг байнга өөрчлөх хандлага хэвшил болж байгааг анхаарах шаардлагатай хэмээн үзлээ.

3.Төсвийн тогтолцоог сулруулах өөрчлөлт хийх хандлага үргэлжилж байна. Хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг хүчингүй болгохоор тусгасан нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглосон хуулийн хамгаалалтыг үгүй хийж байгаа учраас зөвлөлийн зүгээс хэвээр үлдээх хэрэгтэй гэж үзэж байна.

4.Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн орчин, нөхцөлтэй нийцтэй бус байгаа нь төсвийн орлогын төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байна. Хуулийн төсөлд 2026 оны нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцсон бол өнөөдөр нүүрсний хилийн үнэ 68 орчим ам.доллар байна. Энэ нь өнөөгийн аргачлал нь бодит байдлаас хэт зөрүүтэй тооцох нөхцөлийг бүрдүүлж байгаа тул орлогыг бодитой тооцох шаардлагад нийцүүлсэн, тэнцвэржүүлсэн үнийг тооцоолох аргачлалыг өөрчлөх хэрэгтэй байна.

5.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх байдал үргэлжилж байгаагаас гадна үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-аас 2026 онд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 22 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулийн уялдаа, нэгдмэл байдал, зохицуулах чадварт сөргөөр нөлөөлж ирсэн. Энэ нь төсвийн тогтвортой байдлыг алдагдуулж байна гэж Төсвийн зөвлөл үзэж байна. Иймд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тогтвортой байдлыг хадгалах, түүний үзүүлэлтүүдийг тодорхой болгох шаардлагын үүднээс нэрлэсэн ДНБ, Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал, Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, голлох эрдсийн

бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ зэрэг үзүүлэлтүүдийг нэмж тусгах санал гаргаж байна.

6.Төсвийн зарлагын өсөлтийн дүрмийг чангатгах шаардлагатай байна. Төсвийн тусгай шаардлагыг өөрчилснөөр төсвийн зарлага, урсгал зардлын тэлэлтэд тавих хяналтыг сулруулах нөлөөтэй. Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалтыг ДНБ-ий өсөлтийн дунджийн аль багын 1/2-ээс ихгүй байх гэж өөрчлөх нь ДНБ-ий өсөлтөөс давсан төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах нөлөөтэй хэмээн үзэж байна.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлтийг танилцууллаа. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийн өнөөгийн эрх зүйн орчинд байгаа төсвийн тогтвортой байдлыг хадгалах гол бодлогын баримт бичиг гэдгийг санаж, түүнийг зохицуулах хууль, эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой байдлыг хадгалах, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхийг Зөвлөлийн зүгээс хүсэж байна. Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Намхайн Батсайхан Монголбанкны ерөнхий эдийн засагч, Нанжидын Ургамалсүвд Монголбанкны Мөнгөний бодлогын судалгааны газрын захирал, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Ваанчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Галбадрахын Гантулга Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга. Нийслэлээс хүн байна уу? Мөн Монголбанкныхан хаачсан бэ? Мөнгөний бодлогын газрын захирал, Дэд ерөнхийлөгч ирсэн байна. Мөнгөний бодлогын газрын захирал алга байна. Ерөнхий эдийн засагч ирсэн байна.

УИХ-ын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан УИХ-д үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэж заасан байдаг. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчиж худлаа мэдээлэл өгсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж хуульд заасан байдгийг та бүхэнд сануулъя. Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулахыг хүсье.

Илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. 27 гишүүн асуулт асуухаар нэрсээ өгсөн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд төсвийн хүрээний мэдэгдэл энэ 9 тоотой холбоотой асуулт байхгүй. Нэгэнтээ бид өнгөрсөн онд төсөв батлахдаа маш алдаатай төсөв баталсан учраас одоо энэ хүрээгээ өөрчлөөд төсвөө тодотгохоос өөр арга байхгүй. Би дагаж орж ирсэн хуультай холбоотой нэг асуулт асууя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг уншаад би эхлээд маш их баярлалаа. Үгүй ээ, нээрээ овоо шүү дээ, нөгөө яг миний яриад байсан, өөрөө өөртөө чөдөр, тушаа тавьсан байгаа энэ асуудлыг чөлөөлж байгаа юм байна гэж дотроо би баярлалаа. 19.9-ийг хүчингүй болгож байгаа юм байна гэж. Та бүхэн маань санаж байгаа бол бид чинь гаднаас өчнөөн зээл авчихна, түүнийгээ тэгээд ашиглаж чадахгүй яг энэ чөдөр, тушаандаа баригдаад, тэгээд эцэс сүүлдээ өнгөрсөн жил хаврын чуулганаар, энэ жил шүү дээ, бид ямар хууль баталсан бэ гэхээр хоёр хуулийн хоёр төслийг төсвөөс ер нь гадуур гаргачихсан. Эрдэнэбүрэнгийн усны цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэр төсөвт орохгүй шүү гээд, ингээд энэ хоёр хуульд тусгайлсан ийм хууль гаргаад, энэ чөдөр, тушаадаа баригдаад энэ төсвөөсөө гадуур гаргачихсан.

Цаана нь дахиад өчнөөн зээл авчихсан байгаад байдаг, өдөр хоногоор үнэ ч нэмэгдэж байна, зээлийн хүү ч улам нэмэгдэнэ. Тэгэхээр энэ өөрөө өөртөө тавьсан байгаа чөдөр, тушаагаа тайлаач, энэ 19.9-ийг өөрчлөөч, хүчингүй болгооч гэдэг шаардлагыг өгсөн. Тэгээд уг нь бол ингээд авсан юм шиг эхний ээлждээ харагдлаа. Тэгээд яг алга таших гэж байсан чинь 6.1.2 дээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай эсхүл ашигтай байх гэсэн ийм зүйл заалтаар солигдоод, өөрчлөн найруулагдаад ороод ирлээ л дээ. Тэгээд энэ маань яг зарчмын ямар өөрчлөлттэй вэ? Уг нь бол нөгөө чөдөр, тушаагаа тайлж байгаа юм шиг миний хэлээд байсан асуудал шийдэгдчихэв үү, шийдэгдсэнгүй юу?

Тухайн оны үнээр тооцсон ДНБ эсхүл тухайн төсвийн жилийн ДНБ гэдэг энэ зөрүү дээр та хэд ийм өөрчлөлтийг оруулаад байна уу, ялгаа нь юу байна вэ гэдгийг тодруулъя. Ер нь бол 2 хувьдаа барина гэдэг бол өөрөө маш хүнд шүү дээ. Төсвийн хуулиараа л уг нь сахилга хариуцлагаа өөрсдөө бариад, энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар өөрсдийгөө хязгаарлахаа болимоор байгаа байхгүй юу.

2017 онд энэ чинь 10.4 хувь байсан юм, 2018 онд 9.5 хувь, 2019 онд 6.9 хувь, 2020 онд 12.5 хувь, ингээд хамгийн ойрын хугацаа 2022 онд 5.1 хувь, 2023 онд 3.6 хувь, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна гэсэн. Нөхцөл байдал улам хүнд болж байгаа шүү дээ. Орлого улам нэмэгдэх юм уу, зарлага бол үнэхээр тэлж байгаа, багш, эмч нарын цалинг нэмэхэд чардайж байна шүү дээ. Тэгээд ийм байхад 2 хувиараа хязгаарлах нь зөв үү, үгүй юу? Энийгээ засах бодлого байсан уу, үгүй юу гэдгийг тодруулъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. 2024 оноос өмнө нийт орлого, зарлага дээр тэнцвэржүүлсэн тэнцлийн тухай ярьдаг байсан. Нийт орлого, зарлага хоёрын тэр тэнцлийг ярьдаг байсан. 2024 оноос хойш болохоор суурь тэнцэл гэж олон улсын ямар ч практикт огт байхгүй. Сүүлд Валютын сан (IMF)-гийнхан "Энэ ямар ойлголт юм бэ?" гэж гайхаж байсан. Суурь тэнцэл гэдэг нь юу вэ гэхээр гадаад зээл, бонд /bond/-ыг алдагдалд тооцохгүй гэж ийм заалт хийнгүүтээ суурь тэнцэл нь 2 хувь ашигтай байна гэдэг хууль баталчихсан байхгүй юу. Тэгэхээр нэг талаасаа бид төсвийн сахилга бат, хариуцлагаа нэмэгдүүлэх гэж байгаа юм. Нэг ёсондоо тэнцвэржүүлсэн тэнцэл байна, тэнцвэржүүлсэн тэнцэл нийт орлого, зарлагын алдагдлыг тооцно. Алдагдал нь ДНБ-ий 2 хувьтай тэнцэх байна гэж яг өмнө нь 2024 оноос өмнө явж ирсэн л зарчим. Тэгэхээр энэ Ариунзаяа сайдын хэлээд байгаа "Бид өөрөө энэ гадаад зээл, бонд, санхүүжилтийг хэрэглэж чадахгүй байдалд орчихжээ" гэдэг дээр бид нэгдсэн орлого, зарлагаа тавиад тэнцвэржүүлсэн тэнцлээрээ явъя гээд 24 он руу буцаагаад аваачиж байна гэсэн үг.

УИХ-ын гишүүн Тэмүүлэн нарын гишүүд яг энэ төсвийн хүрээ дагалдуулсан хуультай концепт /concept/-ын хувьд яг ижилхэн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа юм байна лээ. Тэр Их Хурлын гишүүдийн тэр хуультай хамтатгаад хэлэлцээд явах нь зохимжтой болов уу гэж бодож байна.

2-т, бид энэ асуудлаар яг таны хэлж байгаа, жишээ нь 32.9 их наядын орлоготой, бид нарын батлагдсан төсвийн хүрээнд. 32.9 их наядын орлоготой атлаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар аймаг, орон нутаг өөрөө Иргэдийн хурлаараа төсөв батлахдаа орлого, зарлага нь ямар нэгэн алдагдалгүй л төсөв баталж болно гэдгийг хуулиар нээчихсэн учраас орлогоо хий төлөвлөөд яг түүнтэйгээ адилхан зарлагадаад яваад байсан. Нийслэл дээр, жишээ нь 2 их наяд гаруй төсөв нэмээд баталчихсан Их Хурал хууль баталсны дараа. Тэгэнгүүт нийслэл дээр нөгөө эх үүсвэр байгаад байдаг, хэрэглээ гэхээр төсвийн хязгаар тулчихдаг. Үүнийг нэгдсэн төсвийн бодлого руугаа оруулж ирье гэдэг утгаар, суурь агуулгаар нь шийдье гэдэг утгаараа орон нутаг, Иргэдийн хурал хэдийгээр шийдсэн ч гэсэн түүнийг нь энэ нэгдсэн төсөв дотроо оруулах нь өөрөө илүү хариуцлагыг дагуулах юм байна гэдэг утгаараа бид оруулж ирсэн.

Тэгэхээр нийслэл өвөлжилтийн бэлтгэлээ хангуулахын тулд нөгөө нэмэлт орлого олсон эх үүсвэрээ ашиглах гэхээр төсвийн хязгаар тулчихсан байгаад байгааг энэ төсвөөрөө нэгдсэн байдлаар баталдаг болъё гэдэг утгаараа үүнийг оруулж ирсэн. Тэгэхээр суурь тэнцэл 2 хувь ашигтай байна гэдэг заалт байхгүй буюу олон улсад мөрддөггүй энэ дүрмийг авч хаяад бид яг хуучин шигээ тэнцвэржүүлсэн тэнцэл буюу нэгдсэн төсвийн нийт орлого, зарлагынхаа алдагдлыг бариад л явна гэсэн үг. Тэгэхээр нэг том алхам бол урагшилж байна л.../минут дуусав/

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Ямар ч байсан өмнөх энэ чөдөр, тушааг тодорхой хэмжээнд тайлж байгаа юм байна, зөв зам руугаа орж байна гэж би ойлголоо. Бид ер нь бол үнэнээрээ л байх хэрэгтэй. Олон төсөв үүсгэж ердөөсөө болохгүй, алдагдалгүй төсөв гэдэг энэ утопи /utopia/-доо өөрсдөө хууртагдаад, тэгээд энэ Эрдэнэбүрэнгийн усны цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төсөвт огт байхгүй, тэгэхээр үнэнээрээ л байх хэрэгтэй шүү гэдгийг л хэлье. Тэгээд ямар ч байсан дэмжиж байна, баярлалаа.

С.Бямбацогт: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд. Тэгээд энэ төсөв маань өөрөө 2025 оны 11 дүгээр сарын 12-нд батлагдсан. Тэгээд батлах батлахдаа бүр 75 хувийн дэмжлэгтэйгээр энэ УИХ бол баталсан. Тухайн үед Лодойсамбуу гишүүн, Бямбасүрэн гишүүн бид гурав 1.2 их наядаар энэ маш их үргүй зардлууд байна, энийг багасгах боломжтой байна гээд зарчмын зөрүүтэй саналууд гаргасан. Гэтэл "Үгүй ээ, бид бүхэн анх өргөн барьснаараа явна" гээд л зүтгэсэн байгаа юм. Тэгээд 10 сарын дараа буцаад орж ирэхдээ "1.4 их наядаар хасахаас өөр аргагүй байсан юм байна" гээд ороод ирж байгаа байхгүй юу. Энэ өөрөө ЗГ-ын хариуцлагагүй байдал гэж шууд хэлнэ.

Яагаад гэвэл тухайн үед 1.2 их наяд үргүй зардал байна гэдэг нь тухайн үеийн тооцооллоор бодит харагдаж байсан зүйл шүү дээ. Тэгж байхад батлахгүйгээр явчхаад одоо төсвийн тодотгол гаргана, ээлжит бус чуулган хуралдуулна гээд ингээд ажил болж байгаа юм. Тэгээд ер нь нэг тийм хэмнэлт хийгээд байгаа юм уу гээд харахаар эргүүлээд 1.1 их наядаар урсгал зардлаа буцаагаад нэмээд оруулаад ирсэн. Тэр мөнгөө хаанаас авах вэ гэнгүүт 80 тэрбумаар ТӨК-иудаас төвлөрүүлэх байсан орлогоо 1 их наяд болгож оруулж ирж байгаа юм. Тэгэхээр гайхаад байна л даа, энэ ТӨК-иуд чинь төлөвлөлтөө гаргаад явчихсан байгаа, 80 тэрбум юм байна гэж ойлгож явж байсан. Гэтэл одоо 1 их наяд болгоод ирэхээр аль аль компаниас хэр их хэмжээний мөнгийг төвлөрүүлэх гэж байгаа юм бэ, тэр жагсаалт нь байна уу гэж асуумаар байна. Тэгээд тэр компаниуд, ТӨК-иудын яг тухайн эргэлтийн хөрөнгө нь ямар болох юм, ингэж төвлөрүүлсэнтэй холбоотойгоор тухайн компаниудын өр төлбөрийн асуудал ямар болж байгаа юм, тэрэн дээр хийсэн тооцоолол байна уу гэж асууя?

Хоёр дахь асуудал болохоор Төсвийн тогтвортой байдлын хуульдаа бид гар хүрч байна, олон ч удаа гар хүрээд байгаа юм. Тэгээд энэ дээр нэг хамгийн ноцтой зүйл нь болохоороо энэ 7.5 дахь заалтыг хасъя гэж байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 өөрөө дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно гээд ингээд заагаад өгчихсөн. Тэгээд энэ заалтыг хүчингүй болгох гэж байна. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнөөс асууя. Хэрвээ энэ заалтыг хүчингүй болгох юм бол танай байгууллага ер нь байх хэрэг байна уу? Танай байгууллага энэ дээр яг ямар бодолтой байгаа вэ? Тэрийгээ УИХ-ын гишүүдэд маш тодорхой хэлж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Эхлээд Ерөнхий сайд, дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя. Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Би төсвийн хэлэлцүүлэг эхлэхээс өмнө нэг хариуцлагатай үг хэлье. Энэ удаа ЗГ төсөв оруулж ирэхдээ сангийн хуваарилалт руу огт ороогүй. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сантай холбоотой сангийн хуваарилалт дээр үг, үсэг бичээгүй. Үе үеийн ЗГ Ирээдүйн өв сангаасаа авах ёстой л гэж ярьдаг юм байна лээ, би энийг дэмждэггүй. Тийм учраас сангийн хуваарилалт руу ороогүй.

2-т, ТӨК-уд Баялгийн сангийн хууль батлагдсанаас өмнө ногдол ашиг төвлөрүүлдэг байсан, ЭТТ, Эрдэнэт үйлдвэр бүгдээрээ л ногдол ашиг төвлөрүүлдэг байсан, ЗГ хувьцаа эзэмшигч учраас ногдол ашиг. Гэтэл 24 онд Баялгийн сангийн хуулийг батлахдаа төрийн өмчийн уул уурхайн компаниуд 34 хувиа Хуримтлалын санд хийнэ, үлдсэн хэсгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд буюу хуучнаар Эрдэнэс Монгол дээр төвлөрүүлнэ, тэр Эрдэнэс Монгол нь хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлнэ гэдэг заалтаар ногдол ашиг өгөх зардлыг нь түрүүлээд дундын компани авдаг болчихсон байсан.

Ерөнхий сайд хүний хувиар Эрдэнэс Монголынхоо дэргэд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж хэлээд тэр хуримтлалыг аваад нэг дэмий, хэрэгтэй, хэрэггүй зам, нийгмийн төсөл хэрэгжүүл гээд шахаад, шаардаад, улс төржөөд байвал болох л байх. Би хүсээгүй, энэ ногдол ашгаа төр авах ёстой, эргээд төсвөөрөө дамжуулаад татвар бууруулах тэр зардал буюу 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлэх гэж байгаа татварын ачааллыг бууруулах дээр өгөх ёстой, тэтгэвэр, тэтгэмждээ нэмэрлэх ёстой л гэж үзсэн. Тэрнээс биш ТӨК-ийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын жагсаалт, тэр засаглал энд огт хамаагүй. Бүх зардал гаргаад цэвэр ашгаа, ЗГ нь хувьцаа эзэмшигч учраас төрдөө ногдол ашгаа төвлөрүүлбэ, үүгээрээ хувьцаа эзэмшигчийн хувиар Их Хурал өөрөө шийдэг ногдол ашгаа. Яагаад гэхээр та бүхний баталсан ТӨК-ийн хууль 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр багадаа 30 хувь, түүнээс дээш ногдол ашиг төвлөрүүлэх үүргийг төрийн өмчит уул уурхайн компаниуд дээр үүрэгжүүлсэн байхгүй юу. Хуулийг хэрэгжүүлэх гэж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ удаа төсөв 1.4 их наядаар орж ирдэг нь бол өөрсдөө л бүсээ чангалж байгаа хэлбэр. Тэрнээс биш үр ашиггүй зардал ч биш л дээ. Он дуустал сайдууд бол зөвхөн төрийн албан хаагчдынхаа өдөр тутмын цалингаа тавиад л явна. Харин энэ хэмнэлт хийсэн зардал буюу ТӨК-иудаас ногдол ашгийг төвлөрүүлэх дээр нь тодотголоор 1.5 их наядыг төвлөрүүл гэж байгаа зардлаар бид юу хийх гэж байна вэ гэхээр та бүхний баталсан багш, эмчийн цалин хөлсийг энэ ондоо 50 хувь дээр нь хүргээд, энэ оноо дуусгахгүй бол бага орлоготой иргэдийгээ, тэтгэвэрт гарсан ахмадуудыгаа хамгаалах бодлогыг дагаж авч явахгүй бол 2026 оны 2 дугаар улиралд өрхийн орлого 4.9 хувиар агшчихаад байгаа юм, 4.9 хувиар.

С.Бямбацогт: ЕС гүйцээгээд хариулъя.

Н.Учрал: Жишээ нь, ЭТТ компани дансандаа мөнгөтэй байна. Энэ мөнгөө төсөвт ногдол ашиг төвлөрүүлээд, үүгээр нь татвар бууруулахад, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэхэд зарцуулахад бид татгалзах арга алга. Гэхдээ хуулиар чинь Эрдэнэс Монгол гэдэг дундын компани дээр энийг чинь аваад, тэр компани чинь бидний энэ ашигтай ажилласан цэвэр ашгийг маань дэмий юманд үрчих вий дээ. Энэ ногдол ашгийг чинь өгөөд, харин түүгээр нь тэтгэвэр тавиад, татвараа бууруулаад явбал бид өгөхөд бэлэн гэж байгаа Эрдэнэт үйлдвэр ч тэр. Ийм хэрэгтэй, хэрэггүй төслөөсөө салъя. Бүх юм төсвөөс санхүүждэг төсөл гэж байхгүй, манай ЗГ төр, хувийн хэвшлийн түншлэлийг онцгой дэмжиж байгаа. Гангийн үйлдвэр, зэсийн

үйлдвэр, пиролиз /pyrolysis/-ын үйлдвэр, хөнгөн цагааны үйлдвэр бүгд эхэлсэн, тэр асуудлыг сууриар нь харж чадах ёстой. Тэр утгаараа төсөв зөвхөн эдийн засгийг тэлэх гол бодлого биш шүү дээ. Тийм учраас бид энэ асуудлыг авч хэлэлцсэн.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Дэлгэрсайхан дарга хариулъя, индрийн 3 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Гишүүний асуултад хариулъя. Дэлгэрсайхан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг олон удаа өөрчилж байгаа. Дээрээс нь 7.5 дахь заалттай холбоотой өөрчлөлтийг саяхан хийсэн. Төсвийн тодотголыг энэ 3 сарын хязгаарлалтад хамруулдаг байсныг нь энэ зун бид хэд орж ирээд, төсвийн тодотголыг хязгаарласан хязгаарт нь алга болчихсон. Хэрвээ одоо энэ 7.5 гэдэг заалтыг аваад хаячих юм бол төсвийн тогтвортой байдлыг хадгалах бидний гол бодлогын хэрэгсэл гэж үзээд байгаа энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл өөрөө байнга өөрчлөгддөг энэ нөхцөл байдлыг нь ерөнхийдөө дэмжсэн ийм өөрчлөлт болно л гэж харж байгаа юм. Бидний хүчин чадал энэ дээр тодорхой хэмжээгээр суларна. Гэхдээ ЗГ-аас оруулж ирсэн нэг эерэг зүйл нь төсвийн дүрмүүдийг буцааж сэргээж байгаа. Тэр 2024 оны 8 дугаар сар хүртэл үйлчилж ирсэн тэр хувилбараар сэргээж байгааг бид харьцангуй эерэг бөгөөд макро эдийн засгийн түвшинд төсвийг хянах бололцоог маань харьцангуй нэмж байгаа гэж үзэж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: ЕС хариулъя нэмж.

Н.Учрал: Ер нь яагаад төсвийн тодотгол хийх болчхов гэхээр нөгөө багш, эмчийн цалин дээр төсөв батлахдаа эх үүсвэр нь тодорхойгүй төсөв баталчихсан юм, яг үнэнийг хэлэхэд. Тэгээд намайг ажил авахад багш, эмч нар хоёр цалинтай болчихсон байсан. Яагаад гэвэл байгаа орон зайдаа багтаахын тулд нэмэгдээгүй цалин дээр нь нэмэгдлийг нь тооцчихсон. Ингээд нэмэгдсэн цалин дээр нэмэгдлийг нь тооцъё гээд нэг тогтоолтой болгоод урагшилсан чинь санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байсан. Тэгэхээр өрхийн орлого 2 дугаар улирлын байдлаар 4.9 хувиар агшчихсан энэ үед өрхийн орлогоо иргэдийгээ хамгаалах зорилгоор энэ цалин хөлсийг тавьж энэ оныг дуусгах ёстой. Тийм учраас үүнийг хаанаас нөхөх вэ гэвэл ТӨК-ийн цэвэр ашгаас нь тэнд дэмий юм хийлгэж байхаар энд авсан нь илүү ард түмэндээ хэрэгтэй гэж үзсэн. Төсвийн тогтвортой байдлын хууль болбол дүрэм, журам, шаардлагууд бүр л чангарч байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Тэгэхээр хариуцлагагүй төлөвлөлт байсан гэдгээ хүлээн зөвшөөрч байх шиг байна. Тэгээд би их тодорхой л юм асуугаад байгаа юм л даа, 1 их наядыг ТӨК-иудаас цуглуулна гээд байгаа. Тэгэхээр тэр яг ямар, ямар компаниудаас, хэдэн төгрөгийг хэзээ яг татан төвлөрүүлэх гэж байгаа юм бэ, тэр жагсаалт хаана байгаа юм бэ гэдгийг л асуугаад байна? Тэр өөрөө тодорхой байж бид бүхэн энэ төсвийн тодотголыг цааш нь харах ёстой л доо. Тэрнээс биш ингээд ерөнхий багцаа дүн яриад, ингээд улс төр яриад байвал ингээд л яваад байна. Тэгэхээр жаахан ажил хэрэгч байдлаар тэр жагсаалтаа та бүхэн гаргаж ирж танилцуулна уу?

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Тийм багцаагаар төсөвлөж төлөвлөдөг гэж юу байх вэ. Мэдээж энэ чинь үндэслэл, тооцоотой л төсөв төлөвлөнө шүү дээ, юу гэж баримжаагаар төсөв төлөвлөдөг ямар 13 дугаар зуун байгаа биш. Тэгэхээр ТӨК-удийн ногдол ашиг гэдэг чинь өөрөө дансанд нь хуримтлагдсан мөнгө нь байгаа л байхгүй юу даа. Тэрийг нь төсөвт авъя гэхээр Баялгийн сангийн хууль дээр тэр заалтыг нь хийхгүй болохоор тэрийг чинь хуулиараа 34 хувь нь очоод, 66 хувь нь тийшээ оччих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 1.5 их наядыг бид тодотголлын хүрээнд ЭТТ компаниас уул уурхайн экспорт өссөн учраас цэвэр ашгаас нь төсөвт ногдол ашиг гэдэг хэлбэрээр авч, тэгээд наад саяын асуудлаа шийднэ гэсэн үг. Төсвийн тогтвортой байдлын хууль дээр илүү чангалж байгаа. Суурь тэнцэл гэдэг бол алдагдлыг орлого, зарлагын алдагдалд гадаад зээл, бондыг оруулахгүйгээр тооцдог заалт хийчихсэн байсан. Тэрийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ төсвийн тодотгол чинь угаасаа энэ намрын чуулганаар биш, хаврын чуулганаар л орж ирэх байсан юм л даа. Би тухайн үед нь хэлээд бараагүй юм. Яасан гэхээр 2025 оны сүүлээр төсөв мөнгөгүй болоод тухайн үеийн Ерөнхий сайд Занданшатар 1.2 их наяд төгрөгийг татвар төлөгч нараас түрүүлээд авчихсан, энэ дээр нь яасан гэхээр манай аудитынхан дүгнэлтээ гаргачихсан, ингээд 1.2 их наяд төгрөгийг түрүүлж авчхаад өнөөдөр мөнгөгүй байгаа юм, Ерөнхий сайд аа. Энэдээ нэг хариулт та хэлээд өгөөрэй. Ямар хуулийн зүйл заалтыг барьж, яаж энэ мөнгийг түрүүлээд, хэн гэдэг компаниас хэзээ авчхав гэдгээ хариулаарай. Би Төсвийн тогтвортой байдлынхантай, аудитынхан хуультай уулзчихсан байгаа юм, таны хариулттай харьцуулж үзнэ. Энэ ингээд ойлгомжтой.

Дараагийн асуудал бичлэг үзүүлнэ. 998 тэрбум төгрөгийн асуудал хэдүүлээ ярьж байгаа, тухайн үеийн Сангийн сайд асан, Сангийн сайд хоёрын товчхон юм байгаа, та хэд сонсчих. /3.Мэндсайхан:41.2 дээр орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд, тухайн жилийн төсөвт нийцүүлэн алдагдалгүй батална гээд заачихсан байгаа юм. 57.3 дээр орон нутгийн төсөв урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээс хэтрэхгүй байна гэж байгаа юм. Энэ хуулийн 57.3-ыг үндэслээд аймаг, орон нутгийн Иргэдийн хурал ийм юм хийчхээд байна. Тэгэхээр бид 57.2-ыг авч үлдэх буюу 57.3-ыг өөрчлөхгүй бол энэ асуудал аймаг, орон нутгийн Иргэдийн хурлын асуудлыг бид яаж хариуцлага тооцох вэ дээ. Б.Жавхлан: 57.3 нь шүү, 57.3-ыг энэ гишүүд нэг сонсож байгаарай. Энэ дээр ийм заалт байдаг байхгүй юу. Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна гэж байгаа юм. Тухайн жилд батлагдсан орон нутгийн зарлагыг зарлагдаж амжихааргүй бол тэрийг нь хойтонгийн жил дээр улсын төсөв зарлагдаж өгнө гэдэг үүрэг авчхаж байгаа юм энэ заалтаар. Тэгэхээр ойрын жилүүдэд ер нь гадаад нөхцөл байдал, эдийн засаг маш ийм тодорхойгүй байдлууд байгаа ийм үед та нар энэ заалтаа нэг эргэж харж, янзлахгүй бол болохгүй шүү. Энэ хэзээ нэг өдөр аль нэг ЗГ-ын аминд хүрэх ийм заалт болно./ Энэ Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 засагдаж орж ирээгүй, энэ дахиад та би тодруулга дээрээ дахиад мэтгэлцэх байх. Энд нэг хариулаарай, энийг засах ёстой байсан уу үгүй байсан уу гэдэг?

Ингээд яваад байхаар юун дээр очиж байна гэхээр Төсвийн захиран зарцуулагчид бүгд хариуцлагагүй хандаж байгаа, 2025 оны аудитын 25 оны гүйцэтгэл дээр аудитынхан хийсэн дүгнэлт дээр 20 албан шаардлага, төлбөрийн актууд тавигдсан. Аудитынхан энд хариулна. Хэн, хэн дээр нь төлбөрийн акт тавигдсан, хэн дээр нь шаардлага хүргүүлээд, хариу яаж ирсэн бэ, энийг хариулаадахмаар байна.

Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн энэ Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа хамгийн түрүүнд хамгаалаад сууж байх ёстой хүмүүс шүү. Энэ хэдэн дарга нарын чинь нэг ам, хамрыг нь хазаарлаж байхгүй бол энэ төсвийн тодотгол дагуулаад Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль өөрчлөөд орж ирж байгаа. Энэ байдлаараа явбал цаашдаа Монгол Улс байгаа бүх мөнгөө дураараа цацаад дуусгана. Ингээд цацаад дуусах тусам яах вэ, цаана нь инфляц өснө, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өснө, ард, иргэд, ААН-үүд амьдрахад хүнд байдал руу орно. Бүлэг дээр түрүүн бид ярилцаж, ярилцаж гарч ирсэн. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань 7.5, 6.1.2 энэ хүчингүй болгох гэж байгаа заалтууд дээрээ байр сууриа илэрхийлнэ үү.

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя. Нэмэлт нэг минут. Очирбат гишүүн.

Г.Очирбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань та хэд ажлаа хийхгүй бол Их Хурлын нүд, чих болсон хоёр байгууллага, аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Жил болгон зөвлөмж өгдөг, жил болгон дүгнэлт боловсруулаад өгдөг, авч хэрэгжүүлэх ажил байдаггүй, тэг zero. Тэгээд ингээд АН-ынхан тодорхой зарчмын байр суурийг илэрхийлж байгаа шүү дээ, 20 сайд чинь хэрэггүй байна, 3.5 сая иргэнд, 16 яам чинь хэрэггүй байна. Наана гарч байгаа зардлаа багасгаад, яамдынхаа тоог багасгаад, сайд нараа нийлүүлээд, чиг үүрэг ойролцоо яамныхаа сайдуудыг нийлүүлээд ажил хийгээд, бодитойгоор тодотгол, хэмнэлт хийгээч. Иргэд нь бүсээ чангалаад байна, ААН нь бүсээ чангалаад байна, төр нь улам гэдэс нь данхайгаад, бүс нь задрах гээд байна шүү дээ. Тэгээд ярихаар хуулийн алдаа гаргачихсан гээд байдаг. Боловсрол, эрүүл мэндийнхээ салбарынхаа цалинг нэмэхгүй бол болохгүй гээд байх бүх боломж байгаа Ерөнхий сайдаа.

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Очирбат гишүүн үндэслэлтэй л зүйл хөндөж байгаа юм л даа. Тэгээд төрийн ажлын залгамж чанар гэж байх ёстой, тэгэхдээ алдааг нь засаад урагшлах ёстой гэж би ойлгож байгаа. Тийм ч учраас асуудлыг сууриар нь шийдэх ёстой л гэдэг би ийм л үзэл баримтлалтай хүн. Тийм ч учраас намайг анх ажил авахад "Та нар тэтгэвэр нэм" гэсэн, би "Үгүй ээ, илүү олон жил төлсөн нь илүү тэтгэвэр авдаг байх ёстой багц хууль, реформоо хийе, тэгээд явъя" гэсэн хуулиа батлуулсан. Татварын багц хууль 2.3, 4 их наядын ачаалал хөнгөлнө, дараа жил 15 мянган ажлын байр бий болгох нь, энэ бодлого юм гээд ингээд оруулж ирсэн. Сая Төсвийн тогтвортой байдлын хууль дээр ямар заалтыг хөндчихөөд байна вэ гэхээр харин илүү хариуцлагажуулж байгаа юм. Суурь тэнцэл гэдэг дэлхийд байхгүй ойлголт энэ хуульд байсан. Суурь тэнцэл гэдэг юу вэ гэхээр алдагдал дотор гадаадын зээл, бондыг оруулахгүйгээр суурь тэнцэл гэдгийг оруулж ирсэн. Үгүй ээ, энэ чинь 2024 оноос өмнө тэнцвэржүүлсэн тэнцэл л гэж байсан шүү дээ. Нэгдсэн

төсвийн нийт орлого, зарлага, алдагдал 2 хувь ДНБ-ий ингээд л явдаг энэ зарчим руугаа оч гэж.

Дээрээс нь орон нутаг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар орон нутаг алдагдалгүй төсөв батлах үүргийг оногдуулчихсан. Тэгээд үүрэг оногдуулчихсан тэр заалтаа бариад улсын төсөв батлагдсаны дараа аймаг, нийслэл 2 их наядаар төсвийг давуулаад баталчхаж байна шүү дээ. Та бод доо, 32.9 их наядын орлого төлөвлөлөө гэхээр орон нутаг яаж байна вэ гэхээр дээр нь 2 их наядыг нэмээд баталж байгаа, 32.9 биш шүү, бид нарын харагдаж байгаа нь энэ, энэ чинь бараг 37 их наяд яг үнэндээ. Бид өөрсдийгөө хуураад байгаа байхгүй юу даа. Тийм учраас улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс, тийм учраас орон нутгаа илүү хариуцлагажуулъя, үнэнд гүйцэгдэж байна шүү дээ. Орон нутаг 2 их наядаар нэмээд баталчихсан чинь 998 тэрбум төгрөг дансанд нь байдаг, түлшээ авах гэсэн чинь мөнгөө гаргаж чадахгүй байна гэж Сангийн яамны төсвийн хязгаарт тулсан гэж байгаа юм. Энийг нэг хайрцагт хийх ёстой шүү дээ.

ТӨК-уд өнөөдөр ЭТТ компанид 5 удаа ногдол ашиг тараасан, 26.5 хувийг нь эзэмшдэг 1072 хувьцааны ногдол ашгийг хуваарилсан. Гэтэл үлдсэн хувийг эзэмшдэг төр яагаад ногдол ашиг аваагүй юм бэ? Өнөөдөр нэг ч удаа. Хэрвээ тэр ногдол ашгаа авсан байсан бол төсвөөр дамжуулаад иргэддээ хүргэх байсан шүү дээ. Яагаад бид орлого олдог байх үедээ элдэв гүүр, байгууламж, туннелээс хэтрэхгүй ингээд сууж байсан юм. Би ТӨК-уд дэмий балай юманд зардал гаргаж болохгүй, цэвэр ашгаа та нар төсөвт өг, төсвөөр дамжуулаад тэтгэвэр нэмнэ, цалин нэмнэ, ийм л юм яриад байгаа юм. Хүндээ, хүнээ бодох хэрэгтэй шүү дээ, тэгэхээр хүнээ бодохгүй байж болохгүй. Тийм учраас АН-ын гишүүдийн тавиад байгаа шаардлага асар зөв. Би энийг яаж хийж оруулж ирэх вэ гэдэг нь миний бодлого.

С.Бямбацогт: Тодруулъя, Очирбат гишүүн.

Г.Очирбат: Зарчмын хувьд ингээд Учрал сайд аягүй тийм уянгалаг, гэгээн сайхан юм ярьж байгаа, төсөв рүү татаж авчирч байж захиран зарцуулна гэдэг буруу. Та үнэхээр шударга шийдэх гэж байвал наад ТӨК-уд, ашигтай ажиллаж байгаа компаниудаа иргэддээ хувьцааг нь бүтэн өг. Энэ төр хувьцаагаар яах гээд байгаа юм бэ? Тэгж байж тэр хүний чинь бодит орлогыг нь дэмжих гэж байна шүү дээ. Тэгж байж тэр хүний чинь бодит халаасанд орж ирж байгаа мөнгө нь сар болгон ордог ийм систем рүүгээ тэгвэл явъя л даа. Заавал төр тэрийг авчирч ирэх ямар шаардлага байгаа юм, нэгдүгээрх асуудал ногдол ашиг. Харин тийм.

2 дугаарт гэвэл энэ тэнцвэржүүлсэн тэнцэл тухайн үед яригдаж л байсан. Суурь тэнцэл гээд. Хоёр юмаа ялгаж харъя гэсэн шүү дээ. Нэг нь яг Монгол Улс өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүн нь ямархуу байгаа юм бэ, бид юу хийж чадаж байгаа юм, энүүгээрээ харчихъя. Нөгөө талд нь тэнцвэржүүлсэн тэнцэл гэдэг чинь нөгөө бонд, гаднын зээлээ нэмээд ийм болж байна гээд хоёр янзаар харъя гэсэн шүү дээ. Би тухайн үед ингэж ойлгож байсан, буруудчихсан юм байна л даа, Жавхлан сайдаа, та нэг хариулаач.

С.Бямбацогт: Жавхлан дарга хариулах дэг байхгүй, Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм, энэ чинь дэгээрээ Ерөнхий сайд хариулах юм байна, Очирбат гишүүн, тийм. Тэгэхээр ТӨК-ийг, тэр ногдол ашгийг би яагаад яриад байна вэ гэхээр яг таны бодож байгаа, та бид нарын үеийнхэн арай өөр юм бодох гээд байдаг юм

шүү дээ, би тэрийгээ л оруулж ирж байна. Үнэт цаасны хууль хөндөж байгаа юм. Яагаад гэхээр ЭТТ-н 1072 хувьцаа буюу сая би BDO олон улсын санхүүгийн аудит /audit/ оруулчихсан, үнэлгээнүүд хийгдэж байна. Энэ хууль гарсны дараа ЭТТ компанийг хоёрдогч зах зээл дээр шууд бүртгэнэ, би тэрийг хариуцлагатай хэлье. Дээрээс нь Франклин Темплтон /Franklin Templeton/, энэ гурав дахид Блэк Рок /BlackRock/ ирж байна, төрийн өмчийн 20 компанийг багцалж байгаа хөрөнгийн зах дээр гаргана. Тийм учраас ТӨК-ийн ногдол ашиг даруй өснө, тийм учраас ирэх жил 3.5 их наядыг авна. Яагаад гэхээр хүн төрөлхтөн өөрөө иргэддээ тэр төрийн өмчийнхөө ногдол ашгийг хүргэхийн тулд төсвөөр дамжуулахаас өөр шинжлэх ухааны ололт олоогүй байхгүй юу. Гадуур байлгахаар чинь энэ улс төрчид цавчаад байна шүү дээ. Тийм учраас энд ороод нээлттэй хэлэлцээд тэтгэвэртээ өгье л гээд байхгүй юу.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя, аудит энд байхгүй байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Очирбат гишүүний асуултад хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн энэ өөрчлөлт болгон дээр өөрсдийн байр суурийг байнга илэрхийлж байгаа. Дүгнэлтдээ бид энэ 7.5-ыг авах ёсгүй гэсэн ийм байр суурь илэрхийлчихсэн. 6.1.2 дээр бид өнөөгийн шинэчилсэн 2024 оны 8 дугаар сар хүртэлх энэ хувилбар нь зөв гэж үзэж байгаа бол 6.1.3 дээр уул уурхайн бус болон уул уурхайн салбарын өсөлттэй харьцуулсан тэр харьцааг бид хязгаарлаж, 1/2-ээр нь, аль багынх нь 1/2-ээр гэсэн байдлаар оруулах ийм саналыг оруулж байгаа юм. Учир нь энэ заалт явснаараа аль ихээс нь ихгүй гэдэг заалт өмнө нь хэрэгжиж байсан. Энэ нь болохоор төсвийн зарлагыг ДНБ-ий нэрлэсэн өсөлтөөс байнга давах ийм нөхцөлийг бүрдүүлж, төсвийн тэлэлтийг дэмжсэн заалт учраас бид хязгаарлах нөхцөлийг өгч байгаа. Бидний зүгээс дээрээс нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зохицуулалтуудыг илүү чангатгах ийм байр суурийг яг энэ дүгнэлт.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Тэмүүлэнгийн урилгаар Японы парламентын гишүүд Монгол УИХ-ын чуулганы үйл ажиллагаатай танилцаж байна. Тэгээд Монгол Улсад айлчилж байгаа та бүхний айлчлалд амжилт хүсье. УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хэдүүлээ 2026 оны төсвөө тодотгохын тулд төсвийн хүрээгээ өөрчлөх гээд, өөрөөр хэлбэл илүү урт хугацааны бодлогын бичиг баримтаа 3 жилийн хугацаатай бид төсвийн хүрээ болон төсвийн төсөөллөө тогтоодог, энийгээ өөрчлөх гээд, энийгээ дагалдуулаад бүр суурь дүрэм болсон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчлөх гээд ингээд сууж байна. Тэгэхээр яах вэ, юуг дагуулж юу өөрчлөгдөөд байгаа юм, энэ бүх юм ингээд урвуугаар эргэчихсэн л харагдаад байна л даа. Энэ төсвийн тогтвортой байдал, төсвийн хүрээний мэдэгдэл зөвхөн ЗГ-ын бичиг баримт биш байхгүй юу, дотроо хэрэглэдэг. Энийг оролцогч хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, бусад талууд бүгдээрээ судалгаа, тооцоо, хөрөнгө оруулалтад энийг харж өөрчилдөг.

Гэтэл энэ нь өөрөө төсвийн нэг жилийн бичиг баримтаасаа илүү амархан өөрчлөгддөг, байнга дагаж өөрчлөгддөг иймэрхүү болчихсон байна. Уул нь энэ

дүрэм журмуудыг замын цагдаагаар жишээ авч үзвэл, хурдны дээд хязгаарыг 60 километр цаг гээд тавьчихсан байхад энэ нь өөрөө жишээлбэл эрсдэл дээр суурилад, тодорхой хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байлгах үүднээс ийм дүрэм тогтоодог, тэрийг нь хянах гээд цагдаа байдаг. Гэтэл машин барьж явсан нэг нөхөр шууд очингуутаа өөрийнхөө хурдандаа тааруулаад тэр дүрэм зөрчсөн хүнийг торгож байгаа цагдааг нь ч юм уу бүгдийг нь өөрчлөөд, дүрмээ шууд тэр хурдны дээд хязгаараа 90 километр цаг, 100 километр цаг болгож ингэж өөрчилж байгаа л ийм дүр зураг харагдаад байна л даа. Тэгэхээр яах вэ, цагдаа маань зовлонгоо ярьж байна. Энэ юмнуудыг болохгүй гээд байхад нөгөө жолооч маань "Үгүй ээ, чи энийгээ бүгдийг нь ингэж өөрчил, дээд даргатай чинь ярина, хууль дүрмийг чинь өөрчилнө" гэдэг л иймэрхүү л юм харагдаад байна. Уул нь энэ төсвийн энэ тодотгол дагуулж биш, ядаж энийгээ жилийн төсөв дагуулж оруулж ирж ярьдаг баймаар санагдаад байгаа юм.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад би Монголбанкнаас эхэлж асуумаар байна. Бид нарын хамгийн том асуудал инфляц байгаа, мөнгөний бодлого байгаа. Тэгэхээр Монголбанкны хувьд мөнгөний бодлогын гол энийг хариуцаж байгаа байгууллага нийтийн өмнө. Тэгэхээр инфляц /inflation/-ын түвшин маань 7 дугаар сард 13 хувь болоод ингээд нэмэгдчихсэн байгаа. Тэгээд дээр нь ер нь бол мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёр хоорондоо уялдаж байж бид энэ ард, иргэдийнхээ ажил, амьдралыг илүү зөв авч явах ёстой. Тэгэхээр инфляц маань өөрөө нэг талдаа татвар хасаад байгаа мөртөө нөгөө талдаа инфляц өндөр болохоор энэ бол татвар өндөр болоод байгаа. Тэр татварыг чинээлэг хэсэг нь биш, илүү жишээлбэл дундаж давхарга, бага орлоготой хэсэг маань энэ татварыг үүрдэг. Тэгэхээр энэ төсвийн тэлэлтүүд 1 дүгээрт Монгол банкин дээр энэ инфляцыг яаж удирдана, энэ та хэдэд ямар нөлөө, өөрчлөлтүүд яаж харж байна вэ, та хэд энийг яаж менеж /manage/ хийе гэж бодож байгаа вэ, энэ төсвийн тэлэлтийг?

2 дугаарт нь ТӨК-уд энэ орлого төвлөрүүлэлттэй холбоотой яг энэ арилжааны банкуудын зээлийн, жишээлбэл жилдээ 4, 5 их наядын шинэ зээл гаргадаг юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ ТӨК-удын бараг ихэнх нь яг мөнгө, ашиг, орлого олоод байгаа боловч орлогогүй, мөнгөгүй байгаа. Тэгэхээр энийг дахиад арилжааны банкны системээс зээлэх ийм нөхцөл байдал үүснэ. Дээр нь ЗГ дотоодын өрийн бичиг гаргана гэсэн байна, орон нутаг гаргана гэсэн байна гэх мэт ингээд яваад ирэхээр энэ мөнгөний нийлүүлэлт, зээлийн энэ хүрэлцээ бол ААН-үүд дээр нэлээн хомс, тэгээд бодлогын хүү нэмэгдчихсэн байгаа. Тэгэхээр энэ хүүгийн эрсдэл нэмэгдэх ийм эрсдэлүүд харагдаад, тэгэхээр хүү болон инфляц дээр хэлээч.

Дээр нь ЗГ-аас энэ өрийн хязгаарыг 45 байсныг 50 болгоод өөрчилж байгаа. Тэгэхээр энэ талаар энэ үзэл баримтлал дээр ерөөсөө дурдаагүй, шалтгаан, үндэслэлүүдээ ерөөсөө заагаагүй байна. Тэгээд энийг нэг илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч гэсэн ийм асуулт байна. Тэгэхээр Монголбанкнаас эхлээд асуултаа асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 3 микрофон. Монголбанк.

Г.Энхтайван: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын ЗГ-аас 2026 оны төсвийн тодотголыг 8 дугаар сарын 20-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Төв банкны зүгээс УИХ-аар хэлэлцэгдэх төсвийн энэ тодотголтой холбоотойгоор өөрсдийн урьдчилсан тооцоог хийж байна. Яг төсвийн тодотгол батлагдаагүй байгаад байгаа учраас яг хэдий хэмжээгээр нэмэгдэх, яах ийх тал дээр яг эцсийн

хариуг өгөхөд эрт байна. Гэхдээ урьдчилсан байдлаар энэ өргөн баригдаад байгаа төсвийн хүрээнд төсвийн зардал батлагдсан дүнгээс 1 их наяд төгрөгөөр нэмэгдээд 34 их наяд төгрөгт хүрэх, төсвийн алдагдал 1 их наяд төгрөгөөр өсөхөөр ингээд батлагдсан, хэрвээ энэ өргөн барьсан хэлбэрээр батлагдвал төсвийн 2026 оны 4 дүгээр улиралд энэ инфляцад 0.7 орчим хувийн, суурь инфляцад 0.7 хувийн орчим хувийн дарамттай байх болов уу гэсэн урьдчилсан тооцоолол байна, урьдчилсан шүү.

Тэгээд оны 12 дугаар сарын байдлаар инфляц 12.3 орчим хувьтай, эдийн засгийн өсөлт 5.3 орчим хувийн өсөлттэй байх болов уу гэсэн тийм тооцоололтой байна. Ер нь төсвийн үйл ажиллагаатай холбоотой Төв банк ЗГ-т зөвлөх чиг үүрэг хэрэгжүүлдэг, ЗГ энэ дээр төсвийн тодотгол болон төсөвтэй холбоотой асуудлыг УИХ бие даагаад өргөн барьдаг, Төв банк энэ дээр ямар нэгэн байдлаар хөндлөнгөөс санал өгдөггүй байгаа хуулиараа. Төсвийн тодотголтой холбоотой болон энэ төсвийн зардлын өсөлттэй холбоотойгоор мэдээж мөнгөний бодлогын орон зай тодорхой хэмжээгээр хумигдаж байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ инфляц 13 хувьд хүрчихсэн байгаагийн 7 нь яг энэ өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ, нийлүүлэлтийн гаралтай инфляц, 5 хувь нь мах шүү дээ, нэг хувь нь бензин, шатахуун, нэг хувь нь хүнсний ногоо, тэр дундаа төмс. Тийм учраас төсвийн тодотгол юу руу чиглэж байна вэ гэхээр бага орлоготой иргэдийгээ хамгаалах, стратегийн нөөцүүдээ бүрдүүлэх рүү чиглэж байгаа юм. Яагаад алдагдал ийм өндөр болчихсон бэ гэхээр уул уурхайн экспорт нэмэгдэж байгаа, нэмэгдэж байгаа, сайн байгаа. Гэсэн хэдий ч худалдаа, үйлчилгээний салбарын эдийн засгийн идэвхжил саарсан. ААНОАТ чинь бараг 761 тэрбумаар тасарчхаад байна шүү дээ, ХХОАТ чинь 254 тэрбумаар тасарчхаад байна. НӨАТ, зөвхөн импортын барааны НӨАТ чинь 214 тэрбумаар тасарчхаад байна гэхээр худалдаа, үйлчилгээний салбарын эдийн засгийн идэвхжил саарчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр төсвийн тодотгол орж ирэхэд нэг бодлого байх ёстой юу вэ гэхээр тэр стратегийн нөөцүүдийгээ бүрдүүлэх бүх процессыг нь цахимжуулах ажлыг бид хийчихсэн. Яг мах нөөцөллөө, тэр нь иргэддээ очиж байна уу гэдэг дээр системийг нь бүрдүүлчхээд, энэ жил стратегийн нөөцүүдээ авахын тулд тодотгол дээр оруулж хямд үед аваад, иргэддээ шаардлагатай үед нь зах зээл рүү нийлүүлэх энэ зарчим руу явж байгаа гэсэн үг.

2-т бол энэ ажлын байрыг нэмэгдүүлэх буюу энэ ААН-үүдийн орлого буурч байгаа дээр ямар арга хэмжээ авах вэ гэхээр 27 оны 1 сарын 1-нээс нөгөө татварын хууль хэрэгжих байхгүй юу. Жишээ нь, ХХОАТ-ын 722 доошоо тэглэгдэхэд л жилд 800 тэрбум, жилд нэг иргэн болгоны халаасанд 1 сая төгрөг үлдэж байгаа байхгүй юу. Тэрэн шиг энэ нөгөө ААН-үүдийн орлого буурсан дээр арга хэмжээнүүдийг нь давхар авах ёстой гэдэг ийм утгаар бол энэ тодотголыг оруулж ирсэн. Нөгөө талаасаа бол хэмнэлт хийж байгаа, нөгөө алдагдал их өндөр байгаа хэсэг дээрээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, хариултаа. Нэг минут.

Н.Учрал: Тийм, алдагдал энэ худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил саарчихсан учраас үүн дээр алдагдлаа санхүүжүүлэхийн тулд ТӨК-удын тэр ногдол ашиг дээр цэвэр ашиг шүү дээ, үйл ажиллагааны дараах цэвэр ашгийг нь төсвөөрөө

дамжуулаад иргэддээ өгье л гэж байгаа. Зүгээр улс төрчид магадгүй энэ нэг Эрдэнэс Монгол дээрээ нэг хэдэн төгрөг байлгаад төсөл санхүүжүүлээд байвал ашигтай, илүү бяртай байх гэж бодох байсан байх. Би Их Хурал өөрөө шийдэг гэж байгаа, ногдол ашгийг нь тэтгэвэрт өг, цалинд өг, иргэдээ бод, хүнээ бодсон, иргэдээ бодсон энэ 9 шийдвэрийг л гаргасан. Тэр байтугай төрийн өмчит уул уурхайн компаниудын татварын нэг хувийг хүртэл би төсвийн хуулийг дагуулаад зогсоож байгаа шүү дээ, ЗГ-ын зүгээс. Тэгэхээр энийг ч гэсэн иргэддээ л өгөх ёстой. Ер нь төр хаана ашигтай ажиллаж байна, иргэддээ тэр нь очдог байх ёстой байхгүй юу. Тэгээд 792 мянган төгрөг дээрээс тэглэдэгтэй адилхан энэ татварын хуулийн өөрчлөлт гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тэгээд яах вэ, гүйцэтгэх засаглалын хувьд сонгууль байна, ойлгох юмнууд микро талаасаа харвал шийдлүүд, тодорхой хэмжээний ийм шийдлүүд харагдаж байгаа. Би Монголбанкыг чиглэж асуугаад байгаа нь болохоор яг энэ бид нарын хувьд ингээд арга ядахад хоёр том мөнгөний болон төсвийн энэ хоёр бодлого байгаа. Тэгэхээр нөгөө талд тэнцвэржүүлэх гол субъект маань Монголбанк байгаа. Тэгэхээр энэ өнөөдрийн уулзалт дээр ч гэсэн ингээд асуултад хариулах гээд ирчихсэн байна. Тэгэхээр саяын хариулт таалагдсангүй л дээ. Өөрөөр хэлбэл нэлээн бэлтгэлтэй бид ч гэсэн ингээд материалуудаа үзээд судлаад ирж байхад Монголбанкны зүгээс бол "Бид хийж байна" гэдэг тайлбар өгмөөргүй байна. Тэгээд дараагийн юунууд дээр тодорхой яг байр сууриудаа илэрхийлэхгүй бол, дээр нь миний ойлгосноор Монголбанкыг бол харьцангуй бие даасан бодлогоо барина, өмнөх шиг ингээд ЗГ-ын түрийвч болохгүй, янз бүрийн үнэ тогтворжуулах хөтөлбөр санхүүжүүлэхгүй гэж байсан бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тэгээд би Энхтүвшин гишүүнтэй яг санал нэг байгаа. Ерөөсөө Монголбанк янз бүрийн хөтөлбөр хэрэгжүүлж болохгүй. Би ийм л байр суурьтай. Тийм учраас Монголбанкнаас ямар нэг байдлаар гүйцэтгэх засаглалын хувиар тийм хөтөлбөр хэрэгжүүлж, өмнө нь гарч байсан алдаа шиг мөнгө төгрөг хэвлэхийг би огт дэмжихгүй. Тийм учраас Монголбанк эрэлтийн гаралтай инфляцаа удирдах ёстой. Тийм ч учраас тэр бодлогын хүүг чангалаад яваад байх шиг байгаа юм. Түүнээс чинь болоод энэ татварын орлого буурсан шүү дээ. Зээл гарахгүй байгаа юм чинь, зээл гарахгүй улам чангалаад байхаар. Тэгэхээр ЗГ-ын зүгээс бол Монголбанктай зүгээр харилцан хамтарч ажиллаж, төсвийн бодлогоо уялдуулах ёстой байхгүй юу. Тэгэхээр ипотекийн 6 хувийг 16 мянган айл орон сууцжуулна гээд байсан бодлого дээр ЗГ 500 сая долларыг босгоод, босгосон долларыг төгрөг болгох свопын зардлыг төсөв дээр авбал барилгын салбарт 1.7 их наяд очих юм байна л гэдэг зарчмын хувьд иймэрхүү л зарчмын ажил хийнэ хамтарч. Тэрнээс биш Монголбанк бие даасан хөтөлбөр огт хэрэгжүүлж болохгүй.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн нэмэлт асуулт.

Д.Энхтүвшин: Тийм. Тэгээд яах вэ, зүгээр асуугаад байгаа нь болохоор хэн нэгэн хүний сайн мууг үзэх гээд байгаадаа биш, ААН-үүд энийг харж төлөвлөлт хийх гээд байгаа учраас үнэхээр, жишээлбэл төсөв ингээд тэлээд байгаа үед хувийн хэвшлийн хувьд мөнгөний олдоц ямар байх юм, зээл ямар байх юм, хүү яах юм, инфляц яах юм гэдэг багцаа баримжаагаа, энэ бид төсвийн хүрээний мэдэгдэл чинь

3 жилийн жишээлбэл бид ирээдүйгээ төсвийн багцаа баримжаа авч байгаа ийм төлөвлөлт хийдэг чухал бодлогын баримт бичиг байгаа ААН-үүдийн хувьд. Жишээлбэл, бид нарын хувьд ингээд төсөв дагуулаад л, тодотгол дагуулаад л өөрчилдөг байсан хэдий ч гэсэн ААН-үүдийн хувьд, хөрөнгө оруулагчдын хувьд шийдвэр гаргахад маш чухал үзүүлэлт болдог учраас энэнтэй уялдаатайгаар бусад нөгөө тохируулагч, зохицуулах энэ үзүүлэлтүүд нь өөрчлөгдөхөөр ААН-үүдэд ямар ачааллууд ирэх вэ гэдгийг баримжаа өгөх үүднээс л ийм асуултуудыг асуусан шүү. Тэгээд дараа нь энийг илүү сайн бэлдэж ирэхийг хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Төсвийн бодлого мөнгөний бодлоготойгоо уялдах, хоорондоо мэдээлэл солилцож ажлаа энэ үнийн өсөлт, инфляцыг яаж тогтвортой бага байлгах үед анхаарах ёстой, манай Монголбанкныхан бэлтгэлтэй ирж байгаарай цаашдаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байгаа учраас нэг зүйлийг би өмнө нь ч асууж байсан. Цаашдаа ер нь манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл юу гэж үздэг юм, Нийгмийн даатгалын сан, ЭМД-ын санг төсвийн урсгал зардал дотор оруулаад л яваад байгаа. Уул нь одоо яг анх удаагаа олгох гэж байгаа суурь тэтгэвэр буюу төсвөөс гаргаж өгч байгаа энэ орох ёстой. Сан нь өөрөө орлогоороо, зарлагаараа явж байгаа бол би орох ёсгүй гэж үздэг, түүнээс илүү төсвөөс татаас өгч байгаанууд нь ордог. Тэгэхээр энэ нь юутай нөлөөлөөд байна вэ гэхээр бид урсгал зардлаа тодорхой төсвийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдээрээ хязгаарлаад, хүчээр хязгаарлаад, тэгээд эргээд ингээд төсөв дотроос багтах, багтахгүй асуудал орж ирэхээр энийгээ ингээд хольж хутгаад ингээд яваад байгаа. Тийм учраас энэ тал дээр та нар энэ цаашдаа яая гэж бодож байна вэ? 27, 28 он дээр ч гэсэн энэ асуудал тодорхой яригдана гэж би харж байна.

Нийгмийн даатгалын ахмадуудын тэтгэвэр нэмэх асуудал аль хэдийн бид чинь нийгмийн даатгалынхаа реформоо яриад суурь тэтгэвэр олгоё, үнэ инфляц, ханш өсөж байгаа ийм үед болон ер нь ахмадууддаа тодорхой хэмжээний баталгаат буюу үнэ ханшаас хамгаалах зорилготойдоо л энэ концепцыг өнгөрсөн хаврын чуулганаараа бараг 80 гаруй хувьтайгаар баталчихсан шүү дээ. Тийм учраас өнөөдөр хэрэгжих хугацааг нь харин мах 30, 40 мянга хүрнэ гэж бид тооцсонгүй, түрүү жилийн өдийд, бензин, шатахуун ийм гадаад, дотоод нөхцөл байдлаас болоод ийм болно гэж бодсонгүй. Тийм учраас энэ үнэ ханшийн инфляцыгаа нэг сарын ч гэсэн өмнө хийе гэдэг би энэ бодлогыг дэмжиж байгаа. Манай гишүүд маань ахмадуудтай уулзаа байлгүй, тойрог, янз янзын зүйлээр л явсан байлгүй. Хамгийн түрүүнд асуудал тавьж байгаа нь ахмадууд бол байж байгаа, 60, 70 орчим хувь нь дөнгөж 700 орчим мянган төгрөгийн тэтгэвэртэй, нэг хонь авах тэтгэвэртэй боллоо л гэж ярьж байна лээ хөдөө орон нутгаар явахаар. Тэгэхээр энэ тал дээр нэг айхтар инфляц хөөрөгдөөд л, хөөрхий дийлэнх нь зээлээс зээлийн хооронд л дарамт л байж байгаа. Магадгүй дийлэнх нь 100 мянган төгрөг ч гэсэн нэг сарын өмнө тавивал нэг өвлийн улирал эхэлж байгаа үед би хэрэгтэй юм болов уу гэдэг үүднээс нь энэ төсвийн тодотголыг дэмжиж байгаа юм.

2 дугаарт багш, эмч нарын цалин, төрийн албан хаагчийн цалин гээд бид чинь түрүү жилийн тэрний өмнөх жилийн төсөв батлахдаа энийг шийдчихсэн би яг хэлж байсан төсвийг нь дутуу баталчихлаа шүү, энэ чинь эргээд дараа нь ингээд нэхэгдэж орж ирнэ. Бид өнөөдөр биш маргааш дахиад л орж ирэх юман дээр нэгмөсөн энийгээ яривал яасан юм бэ гэдэг саналыг анхааруулж хэлж байсан. Тэгээд тухайн үед болгоно, бүтнэ л гэдэг байдлаар л орхисон. Энийг харин тэр цалингийн зөрүү,

шинэ, хуучин цалингийн энэ чинь бөөн маргаан болсон шүү дээ. Тэгэхээр энийг бид 5 дугаар сард хийгээд, үндсэндээ сүүлийнхээ сарын цалин хөлсний санд багтаагаад, энэ хуулийнхаа дагуу ч гэсэн шинэ, хуучин цалин гэдэг ийм ойлголт дэлхийд байхгүй шүү дээ яг ний нуугүй хэлэхэд. Тэгээд энэнийхээ ард гарсан, тийм учраас энийг хийх нь зайлшгүй гэдгийг хэлмээр байна.

Харин ч илүү дахиад энэ шаардаж, шахаж байгаа юм байгаа юм байна лээ. Энийгээ ЗГ яах вэ тэр холбогдох байгууллагуудтайгаа яриад, зөвшилцөөд шийдэх ёстой болов уу гэж би бодож байна. Тийм учраас энэ тал дээр та бүгд маань энэ төсвийн энэ асуудал дээр энэ инфляцын хувьд ч гэсэн бид Монголбанк дээр очиж уулзаж байхад түрүүн Ерөнхий сайд хэлэх шиг боллоо. Ерөөсөө инфляцын бараг талаас илүү энэ махны үнийн асуудал, шатахууны үнийн асуудал, төмс, хүнсний ногоо л байна лээ шүү дээ. Нөгөө цалин, тэтгэвэр нэмэгдэхээр л үнэ өсчихдөг гээд байсан чинь суурь шалтгаан нь ерөөсөө тэр дийлэнх. Тийм учраас энэ асуудал дээр инфляцыг яах вэ, ийх вэ гэдэг дээр би яах вэ, тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлнэ. Гэхдээ тийм их хэмжээний, бүр ингээд энэ төсөв, эдийн засгаа дампууруулчих хэмжээний юм бол би энэ төсвийн тодотгол болон юунаас хамаараад нэг их айхтар нөлөөлөхгүй болов уу гэдэг ийм юу байгаа. Энэ тал дээр Монголбанкнаас хэлэх зүйл байна уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр түрүүний миний энэ асуусан асуулт болон сүүлийн асуусан асуулт хоёрт хариулаач гэж хэлмээр байна. Дараа нь Ерөнхий сайд.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт нэг минут.

С.Эрдэнэбат: Орон сууцны хэрэгцээ маш их өндөр байгаа юм байна лээ. Тэгээд энэ дээр ЗГ тодорхой хэмжээнд ингээд моргейж /mortgage/-ийн зээлийн бодлого оруулж ирж байгаа нь яах аргагүй эрэлт аргагүй. 10, 20 мянган хүн шууд орон сууцны хүлээлттэй. Нөгөө тал дээр нь яах вэ, зүгээр урт хугацаандаа энэ орон сууцны үнэ, тарифыг нэг сард ЗГ ингээд дэмжиж өгч байхад нөгөө талд нь энэ үнэ ханшийнх нь метр квадратынх нь үнэ, тарифууд нь ер нь тодорхой хязгаарлалт гэдэг юм уу, нөхцөл тавих уу, үгүй юү гэдэг дээр би тодруулж асууя. Тэгэхгүй бол 5 сая төгрөгийн, 3 сая 500-гаар зарагдаж байгаа байр маань моргейжийн зээл нэмэгдээд ороод ирэхээр "би 5 саяар зарна. Тэртээ тэргүй тодорхой хэмжээний эрэлт нэмэгдэж байгаа юм чинь" гэдэг нэг ийм зүйл рүү манай зарим компаниуд орох гээд байдаг. Энэ тал дээр ер нь ямар бодлого баримталж байгаа вэ? Нийлүүлэлт, эрэлтийн харилцан энэ үнэ ханшийн тогтвортой юунд нэг талаар төр засаг дэмжиж байгаа учраас тодорхой хэмжээний нөхцөлөө журамдаа тавиад явчихвал нэмэр болох юм болов уу гэж бодож байгаа. Энэ тал дээр ер нь ямар бодлого байгаа вэ гэдгийг л асуумаар байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд эхлээд хариулъя. Дараа нь Монголбанк, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулна.

Н.Учрал: 2023 оноос хойш анх удаа 2026 оны 2 дугаар улирлын байдлаар өрхийн орлого 4.9 хувиар буучхаад байна. Ийм үед ямар арга хэмжээ авах ёстой юм бэ гэхээр засаг төр хүнээ бодох ёстой. Нэгд, бодит орлогыг нэмэгдүүлэх буюу цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж дээр үйлдэл хийх ёстой. Тэгээд бид жаахан логиктой баймаар юм байна лээ. Нэг талаараа "Тэтгэврээ нэм, цалин нэм" гээд байдаг, нөгөө талаар нь инфляц өдөөгөөд байна, 1 их наяд чинь нэг инфляц 0.5 л нэгж хувь өдөөж байгаа шүү дээ. Нэг ахмад хүн, өндөр насны тэтгэвэр авагчдын 1/3 нь 769 мянган төгрөгийн тэтгэвэр аваад, ихэнх нь 20 гаруй жил ажиллачихсан төрдөө, тэгчхээд 769

мянган төгрөг авч байгаа дээр нь суурь тэтгэвэр гээд шинэ хуулийнхаа дагуу 300 мянган төгрөг бага тэтгэвэр авч байгаа дээр нь нэмэхээр "Инфляц өдөөнө шүү" гээд шүүмжлээд байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. ТӨК-уд дээр үүсчхээд байгаа, хуримтлагдчихаад байгаа ногдол ашгийг ахмадууддаа өгье, цалин хөлсөнд нь өгчихье гэхээр энэ юу нь болохгүй байгаа юм. Үгүй ээ, авахгүй тэнд хуримтлалын тэр компаниуд дээр байж болно шүү дээ. Тэр компаниуд юу хийх юм, хэрэгтэй, хэрэггүй юм хэрэгжүүлээд л, санхүүжүүлээд л ирсэн шүү дээ. Юундаа ингээд ард түмнээсээ таван цаасыг нь харамлаад байдаг юм. Надад энэ нэг их тийм хүнд биш гэж бодож байгаа. Тийм учраас Эрдэнэбат гишүүн бид зөндөө л хэлэлцүүлэг, уулзалт хийсэн. Энэ төсвийн тодотгол ийм дэлхийн тодорхойгүй байдал үүссэн үед бодит орлогоо нэмнэ, өөр арга байхгүй.

2-т, энэ ААН-үүдийн орлого буураад байна. Түүнээс чинь болж төсвийн алдагдал 1 их наяд хүрчхээд байна, худалдаа, үйлчилгээний чинь салбар саарчхаад байна, 700 гаруй тэрбум төгрөгийн татвар тасарчхаад байна. Энэ юу гэхээр энд идэвхжил хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг идэвхжүүлэхийн тулд тэр бидний баталсан Татварын хууль дэмжигдэж байж ирэх жил энэ эдийн засаг сэргэнэ.

2-т, өнөөдөр энэ орон сууцны бодлого гээд сая асууж байна. Орон сууц дээр гэхэд хувийн хэвшил барьчихсан 9700 байр байна шүү дээ. Хувийн хэвшил барьчихсан энэ байруудыг бид хөрөнгийг нь босгоод, тэгээд зүгээр свопын зардлын төсөв дээр аваад 1.7 их наяд барилгын салбарт хийвэл энд эдийн засаг идэвхэжнэ шүү дээ. Олон ажлын байр нэмэгдэнэ, эдийн засаг идэвхэжнэ, сэргэнэ, хүмүүс ажилтай, орлоготой, амьдралтай болно шүү дээ. Ийм бодлого явдаг болохоос биш нөгөө ингээд ийм хүнд үед дэлхийн тодорхойгүй байдал хамгийн тодорхой байгаа үед энэ асуудал дээр улс төрийн намууд улс төржиж болохгүй. Хүнд үеийг хамт давах ёстой. Тийм учраас Учрал л ярьж байгаа бол буруу гэдэг хандлагаа манай сөрөг хүчин болиод хэдүүлээ урагшаа харъя. Өөр арга байхгүй, энэ цаг үеийн хүндрэлийг Монголчууд хамтдаа давна шүү, ард түмэнтэйгээ хамт давж гарна гэдгийг уриалъя.

С.Бямбацогт: Монголбанк 3 дугаар микрофон.

Г.Энхтайван: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголоор төсвийн зардал 1 их наяд орчим төгрөгөөр нэмэгдэж байгаа, үүний 84.6 хувь нь цалингийн зардлын өсөлт байгаа. Инфляц, төсвийн орлого, төсвийн зарлага нэмэгдэж байгаагаар холбогдон энэ оны төгсгөлд суурь инфляц 0.7 орчим хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байгаа. Гэхдээ хэрвээ УИХ энэ төсвийн тодотголыг батлах юм бол шүү дээ, тэгэхээр урьдчилсан төсөөлөл ярьж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Төлбөрийн тэнцэл, төсвийн зардал 1 их наяд төгрөгөөр нэмэгдэх юм бол импорт 200 орчим сая доллароор нэмэгдэнэ. Нөгөө талдаа тэгэхдээ төсвийн гадаад зээл, бондын санхүүжилтийн дүн батлагдсан төсвөөс 132 сая доллароор буурч байгаа, өсөж байгаа. Тэгэхээр төлбөрийн тэнцэл цэвэр дүнгээрээ 65 орчим сая доллароор буурах ийм нөлөөтэй байгаа. Эдийн засгийн өсөлт суурь төсөөллөөс 0.2 нэгж хувиар нэмэгдэнэ, хэрвээ төсвийн тодотгол яг энэ хэвээрээ батлагдах юм бол. Тэгээд яах вэ, мэдээж төсөв талдаа зардлаа нэмж байгаа учраас мөнгөний.../минут дуусав/

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулах уу, хариулт байхгүй юу, алга. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн тодотгол орж ирж байна. Тэгэхээр татвар төлөгчдийн мөнгийг үр дүнтэй зүйлд зарцуулъя, үргүй зардлуудыг хэмнэе, таная. Ер нь сайдуудын зардлыг нэлээн сайн танасан, сайдууд ер нь нэг цалингаа л тавих ийм зардалтай үлдсэн гэж Ерөнхий сайд маань мэдэгдэж байгаа, энэ сайн. Гэхдээ бодит байдал ондоо байгаад байна. Ялангуяа зарим сайдуудын урсгал зардал гэж бүр хяналтаас алдагдсан ийм зүйл байгаад байна. Шадар сайд дөнгөж сая 7 дугаар сард "Цахилгаан экспортлох стратеги" 790 саяар боловсруулна гэсэн тендер зарласан, энийг би эхнээс нь маш их юм шүүмжилсэн. Яагаад вэ гэхээр ЭХЯ хуулийн өмнө хүлээсэн үндсэн үүрэг нь эрчим хүчний салбарын бодлого, стратеги боловсруулах ийм үүрэгтэй. Тийм ч учраас Стратеги, бодлогын хэлтэс гээд энэ дотор нь байдаг. Гэтэл энэ хэлтсийн хийгээд явж байх ёстой ажил дээр бүр татвар төлөгчийн 790 саяар ингээд тендер зарлачихсан сууж байгаа юм.

2 дугаарт нь Шадар сайд нь доороо ЭХЯ-тай давхцуулаад Эрчим хүчний экспортын хэлтэс гээд байгуулчихсан. Тэгээд маш өндөр зардалтай ийм хэлтэс байгуулчихсан. Тэгээд энэ бүхэл бүтэн хэлтэс нь цахилгаан экспортлох гэсэн ийм нэг таван өгүүлбэрийг боловсруулах чадваргүй, татварын мөнгөөр 790 саяар боловсруулна гээд сууж байна шүү дээ. Тэгээд ЭХЯ нь ингээд "манай ЭХЯ-ны харьяа төрийн байгууллага тендерт нь шалгарчихсан юм байна лээ" гээд хэвнэг хэлээд сууж байгаа байхгүй юу. Тэгээд та бүхэн бод доо, энэ бараг зууны онигоо болохоор зүйл байгаа биз дээ. Төрийн байгууллага төрийн тендерт шалгараад, төрийн ажлыг хийх гээд явж байгаа байхгүй юу, ингэтлээ эмх цэгц нь алдагдчихсан. Тэгэхээр тэр тендерт ороод төрийн ажил хийгээд халтуур хийгээд явдаг төрийн байгууллагыг татан буулгаад төсвөө хэмнэе л дээ. Хуулийн өмнө хүлээсэн үндсэн үүргээ хийж чадахгүй байгаа яамыг татан буулгана уу, нэгтгэнэ үү, төсвөө хэмнэе л дээ.

Тэгээд ЭХЯ-тай давхцуулаад байгуулсан тэр Эрчим хүчний экспортын хэлтсийг татан буулгаж төсвөө хэмнэе л дээ гэх мэтчилнээр ингээд сайдуудын урсгал зардал гээд хяналтгүй маш их хэмжээний төсөв байна. Сангийн яамнаас нь асуухаар "Сайдуудын урсгал зардлыг бид хянах боломжгүй" гэж хэлж байгаа юм. Тэгээд дөнгөж саяхан Шадар сайд нь журмын үнэлгээ хийлгэх 300 хэдэн сая төгрөг, хяналт, зохицуулалтыг сайжруулах зөвлөмж авах 370 хэдэн сая төгрөг, хуулийн төслүүдийг олон нийтэд танилцуулах дарга дахиад 300 хэд гээд нийлээд 1.2 тэрбумын үнэлгээ хийлгэх, зөвлөмж авах, стратеги боловсруулах гээд ийм их хэмжээний үргүй цаасанд татвар төлөгчийн мөнгийг зарцуулаад байна. Өөрсдийн хийх ёстой ажлыг их хэмжээний төсөвтэй тендер болгоод байна, энэ дээр хяналт тавиач. Тэгэхээр төрийн тендерт ороод яваад байдаг, халтуур хийгээд байдаг төрийн байгууллагыг татан буулгаач, давхардуулсан бүтцээ татан буулгаач. Энэ олон яамнуудаа цомхотгож, үнэхээр Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа бол хариуцлагын асуудлыг яриач. Хууль дээр товч бөгөөд тодорхой биччихсэн байгаа шүү дээ, энэ чинь хийгээд явах бүрэн чадвартай. Гэтэл ингээд хийх боломжгүй гээд ингээд сууж байгаа. Тэгэхээр ийм асуудлууд дээр та хариулт өгөөч? Таны энэ хэлж байгаа юм чинь зөв, маш зүйтэй. Гэтэл ингээд бодит байдал харахад маш их хэмжээний урсгал зардал сайдууд дээр чинь байгаад байна, хэмнэгдээгүй байна, тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөөч. Би тэгээд нэмэлт асуулт асууя гэж.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Сангийн яам бас нэмж хариулна биз. Сайдууд дээр нэмэлт зардал байхгүй шүү дээ. Цалингаа тавиад л оноо дуусгана. Илүү тийм зардал байхгүй дээ, тийм. Тэгэхээр эрчим хүчний салбар онцгой салбар. Энэ тийм, Энхцэцэг гишүүн их санаа зовнидог мэргэжлийн хүний хувиар, би ч байнга санаа зовдог. Тийм учраас бид ажлаа аваад эрчим хүчний салбарын тоног төхөөрөмж, засвар, шинэчлэлийг бол хийж дуусгасны үр дүнд хэдэн уурын зуух ашиглалтад ороод аятайхан болж байна. Тэгээд тэр сэргээгдэхийн 5 станц үнэ буухгүй гээд байсан буудгийг харууллаа. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтуудыг татаж байна. Сая энэ Коп-17 (COP17)-гийн үеэр хөрөнгө оруулалтын шинэ олон саналууд дээр зурлаа шүү дээ.

Одоо бол эрчим хүчний салбарын тэр стратеги гээд сая ЗГ-ын хурал дээр танилцуулсан эрчим хүчний салбарт шинэ стратеги барьж, энэ хөрөнгө оруулалтын том салбар юм гэдгийг ойлгуулах гэж байгаа юм. Дээрээс нь 10 аймгийн дулааны станц олон жил яригдаад бүтээгүй, Солонгост сүүлд би Ерөнхий сайдтай нь уулзсан. Тэгээд энэ үеэр 10 аймгийн станцаа дуусгана гэдэг байр сууриа илэрхийлсэн. Ингээд ирэх онд төсөв дээр 10 аймгийн дулааны станцыг дуусгах, дээрээс нь энэ төсвөөс бүх зүйлийг санхүүжүүлэхгүй гэж яриад байгаагийн гол шалтгаан юу юм бэ гэхээр, жишээ нь ирэх оны төсөв дээр дулааны 6 дугаар станцыг барина гээд оруулаад ирсэн юм. Энэ чинь 100 хувь төр санхүүжүүлэхгүй шүү дээ. Яг энэ 5 дугаар станцтай адилхан 20 юм уу, 30 хувийг нь төсөв дээр аваад л, 70 хувь дээр нь хувийн хэвшил оролцоод л хамтраад л барих асуудал байхгүй юу. Тэрнээс 100 хувь төсвөөр явна гэж байхгүй. Барьж байгаа зарчим бол төсвөөс санхүүжүүлж хөрөнгө оруулалт энэ тэр хийдгээ больё. Төр, хувийн хэвшлийн түншлэлээрээ хамтдаа явдаг больё л гэж ингэж л оруулж ирсэн.

Тийм учраас эрчим хүчний салбарт том реформ /reform/ хийгдэнэ. 1 кВт.ц (киловатт-цаг)-ийг 333 төгрөгөөр үйлдвэрлээд 304 төгрөгөөр зардаг ийм л улс үнэнтэйгээ нүүр тулчхаад байна. Нэг гараараа эрчим хүчний салбарын цалинг нэм гэдэг, цалинг нь нэм гэхээр тарифыг нь нэмэх болчихоод байдаг, тарифыг нь нэм гэхээр иргэдийн амьжиргаа ямар байгаа билээ гээд хэцүү. Тэгэхээр энэ дэлхийн цаг төрийн байдал ийм байгаа үед, бензин, шатахууны хомсдолтой ийм байгаа үед энэ өвлийн ид хүйтэнд эрчим хүчний тариф нэмж болохгүй. Тийм учраас зах зээлийнх нь зарчмаар яв, бид тэр ногдол ашгуудыг нь хуваарилаад татаасыг нь энэ он хүртэл аваад явъя. Тэгээд эрчим хүчний дулаан, цахилгааны үнийг нэмэхгүй шүү, харин ирэх жил эх үүсвэрээ нэмэгдүүлнэ шүү гэж хэлсэн. Ийм л зарчмыг барьж байгаа. Хэрвээ тийм янз бүрийн үрэлгэн зардал байгаа бол бид тийм асуудлыг явуулахгүй, тэр ойлгомжтой, тийм юм байх ёсгүй. Тэгээд та нарт цалин хөлснөөс өөр юм байхгүй биз дээ энэ дотор, тийм, Сангийн яам хариулаарай.

С.Бямбацогт: Сангийн яам, Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр эрчим хүчний салбар дээр хоёр л бодлогыг ЗГ барьж байгаа энэ тодотголын хүрээнд. 1 дүгээрт бид хэрэглэгч талдаа ЗГ иргэдийнхээ дулаан, цахилгааны үнэ тарифыг 26-аас 27 онд шилжих энэ цаг хугацаанд нэмэхгүй. Ингэхийн тулд импортоор авч байгаа татаасыг нь ЗГ зардлаа танаж эрчим хүчний салбарт татаас хэлбэрээр олгоё. Энэнд нийтдээ 107.3 тэрбум төгрөгийг зарцуулна. 107.3 тэрбум төгрөгийн татаасыг өгөхгүй бол эрчим хүчний салбар дээр энэ хэмжээний алдагдлыг нөхөхийн тулд үнэ, тарифаа нэмэгдүүлнэ, тэр хэрэглэгч дээр дулаан, цахилгааны үнийн өсөлт

болж очно. Тэгэхээр ЗГ 26-аас 27 онд дулаан, цахилгааны үнийг нэмэхгүй гэдэг бодлогыг барьж байгаа.

2 дугаарт нөгөө талдаа эх үүсвэр талдаа буюу өнгөрсөн жил нийтдээ дулаан, цахилгааны хязгаарлалтыг нийтдээ 17 удаа хийсэн, энэ өвлийн дүн 26-аас 27 оны шилжих өвөлжилт дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая, Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: 26-аас 27 онд шилжих энэ өвөлжилтийн өвлийн энэ хүйтэн үед дулаан, цахилгааны хязгаарлалтыг хийхгүйн тулд шаардлагатай засвар, үйлчилгээг эрчим хүчний салбарт хийж дуусгая. Энд хэрэгтэй байгаа 97.2 буюу нийтдээ 200 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт төсвийн тодотголоор ЗГ зардлаа танаж, татаас болгож оруулахаар энэ төсвийн тодотгол дээр оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье. Хэрвээ энийг хийж чадахгүй бол бид 1 дүгээрт эрчим хүчний эх үүсвэр талаасаа найдвартай ажиллагаа, нөгөө тал дээрээсээ хэрэглэгчдийнхээ цахилгаан, дулааны үнийг нэмэх ийм асуудал руу орно. ЗГ хэрэглэгчдэдээ эдийн засгийн хүнд үед дулаан, цахилгааны үнийг нэмэхгүй гэдэг бодлогыг барьж байгаа.

С.Бямбацогт: Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: Асуултдаа яг тодорхой хариулт авч чадсангүй гэж харж байна. Тэгээд Ерөнхий сайдын хувьд эрчим хүчинд маш их анхаарал хандуулан ажиллаж байгаа, үнэхээр зогсчихсон байсан 10 аймгийг үргэлжлүүлнэ, их засварын ажлууд гээд татаас дээр 200 тэрбум зөвхөн эрчим хүчний салбарт орж ирж байна гэдэг маш сайн. Тэгэхээр энэ татаас дээр орж ирж байгаа дээр нэг асуулт байна. Хятадаас эрчим хүч импортлох татаас нь 50 тэрбум гээд тодотгол дээр орж ирж байгаа. Тэгэхээр энэ хэр үндэслэлтэй вэ? Дөнгөж саяхан Зэс Оюут гээд хуваарилах байгууламжийг барилаа. Хятадаас 80 МВт-ыг авах боломжтой боллоо оргил ачааллын үед гэж ингэж үзэж байсан. Гэтэл зөвхөн оргил ачааллын буюу дутагдалтай үед авах юм байх даа гэж бодсон чинь үлдэж байгаа саруудад 150 сая кВт.ц буюу маш өндөр хэмжээний цахилгааныг ав гэж шахсан. Ийм учраас ингээд яалт ч үгүй 50 тэрбумын татаасыг зөвхөн тодотгол дээр суулгаж байна.

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Энхцэцэг гишүүн асуултаа дуусгачихъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр энэ Зэс Оюут станцыг бариад Хятадаас эрчим хүч импортлох энэ асуудал дээр бид УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орох ёстой байсан асуудал. Энэ эрчим хүчний хараат байдлыг нэмэгдүүлэх ийм үйл ажиллагаа болсон, энэ жил 50 тэрбумын татаас, ирэх онд хэдэн тэрбумын татаас бий болох вэ? Бид Оюу толгой /ОТ/ гээд маш том хэрэглэгчээ Хятад руу алдчихсан, хэзээ ч бид буцааж авч чадахгүй бараг. Гэтэл дараагийн цахилгааныхаа хэрэглэгчийг Хятад руу алдах ийм үүд хаалгаа нээчихсэн юм. Анх Диспетчерийн үндэсний төв энэ үлдэж байгаа саруудад 40 сая кВт.ц-ийг л авна, буюу 13 тэрбумын татаас л үүсэхээр байсан юм байна лээ. Гэтэл ингээд 150 сая кВт.ц буюу 50 тэрбумын татаас ингээд төсөв дээр орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр яалт ч үгүй бид дотоодынхоо зарим хямдхан эх үүсвэрүүдээ зогсоохоос аргагүй байдалд хүрнэ. Яагаад гэвэл бид өвлийн 3 сар хэд.../минут дуусав/

С.Бямбацогт: Найдалаа сайд хариулах уу? Эрчим хүчтэй холбоотой асуудал ярьж байна. Найдлаа сайдын микрофон, тэр зардал, урсгал зардал дээр чинь ямар мөнгө суусан, юу болоод байна, тэрийгээ нэг хариулчих.

Б.Найдалаа: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Саяын тэр Мэндсайхан сайдын дурдаад байгаа 200 тэрбум төгрөгийн 107 тэрбум нь импортын цахилгааны үнийн зөрүүг төлөхөд зориулагдаж байгаа. Яах аргагүй Монгол Улсын эрчим хүчний салбар эрчим хүчний чадлын дутагдалд байгаа. Та мэдэж байгаа өвлийн ачааллыг давахын тулд бид нарын хэрэглээг эх үүсвэрийн өсөлт гүйцэхгүй байгаа. Тийм болохоор БНХАУ-аас 80 МВт хүртэлх эрчим хүчийг төвийн болон өмнийн говийн бүсийн хэрэглээнд зориулж импортлохоор байгаа. Тэгэхээр яах аргагүй энэ бол бид нарын энэ өвлийг давахтай холбоотой зайлшгүй гарах ёстой зардал байгаа.

Түрүүн асуулт дээр би тодруулаад хариулчихъя, Энхцэцэг гишүүн яг тэр импорттой холбоотой асуудал дээр буруу ойлголттой байх шиг байна. Энэ Монгол Улсын Шадар сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд УИХ-аар баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газар.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, микрофон Найдалаа сайдын.

Б.Найдалаа: Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс бид экспортын стратегитай холбоотой судалгаа хийлгэх ажил юм байна лээ. Нэмэлт байдлаар Шадар сайдын албанаас мэдээлэл өгөх байх. Гэхдээ энэ яам тэрийг хийх ёстой гэсэн үг биш, эрчим хүчний экспортын асуудал бол Монгол Улсад эрчим хүчний салбарт анх удаа гарч ирж байгаа асуудал. Энд хийх ёстой судалгаа, тооцоо, горимын тооцоо бүх юм хийх шаардлагатай. Энийг бол зүгээр хэн нэгэн сууж байгаад хийчихдэггүй, та энэ дээр нэмэлт мэдээлэл аваад яагаарай, тэгээд энэ дээр улс төржих хэрэггүй байх. Баярлалаа.

С.Бямбацогт: Тэр зардлыг хариулчихъя, хоёр удаа асуучихсан, Энхцэцэг гишүүн. Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Энхцэцэг гишүүний асуулт дээр, энэ тодотгол дээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын бүгдийнх нь урсгал зардлыг танаж оруулж ирсэн, мөн ялгаа байхгүй Шадар сайд дээр, Доржханд сайд дээр 243 тэрбум төгрөгөөр зардлыг танаж оруулсан байгаа, 243 сая төгрөгөөр. Ер нь таны түрүүн надаас, та ажил эхэлсний дараа ч гэсэн асуугаад байсан, "Энд ингээд эрчим хүчний чиглэлийн тендерүүд зарлагдчихлаа, яам нь мэдэхгүй байна" гэдэг асуултууд ярьж байсан. Шадар сайд эрчим хүчний экспортыг хариуцах нэгжтэй, энэ хүрээндээ тендер зарласан. Сангийн яам тендер зарлаад батлагдсан хөрөнгө оруулалтыг танах эрх зүйн үндэс байхгүй. Гэрээ хийгээд хэрэгжиж байгаа бол бид урсгалаасаа танана. ЗГ төсвийг танахдаа ЗГ-ын хуралдаанаар хэлэлцээд эрэмбийг нь гаргасан байгаа. 1 дүгээрт, шаардлагагүй хурал, цуглааныг больё, гадаад албан томилолтыг больё ч гэдэг юм уу, ийм байдлаар бид зардлын эрэмбийг тогтоогоод, энэ дагуу зардлаа танаж орж ирж байгаа. Түүнээс биш юу.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу, өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд "Хүнээ бодъё" гээд тэгж байна, энэ үнэхээр зөв. Ер нь бид ингээд хүнээ хаячхаад салбараа хөөгөөд явснаас болоод өнөөдрийн энэ бүх асуудлууд үүсэж байгаа, энэ

их ядуурал, энэ олон, олон асуудлууд үүсэж байгаа. Тэгэхээр энэ тэтгэвэр, тэтгэмжийг нэмье гээд явж байгаа нь үнэхээр зүйтэй. Гэхдээ энэ өнөөдрийн асуудал яг үнэндээ хүнээ боддоггүй, өөрсдийгөө боддог өмнөх ЗГ-ын нөхдүүдийн хор уршиг, гай балгийг бид өнөөдөр энд хэлэлцээд сууж байгаа байхгүй юу. Өнгөрснийг мартаж юм бол бид өнөөдөр ч гэсэн дараагийн алдааг давтана. Өнгөрсөн жилийн өдийд энэ 24 онд 25 оны төсөв хэлэлцэж байх үед 18 тэрбум төгрөгийг хүүхэд, залуучуудын соёл, боловсролд зарцуулъя гэж байхад ухаан алдаад байж байсан Баян Бажаа гишүүн 25 онд 26 оны төсвийн 1.4 их наядын алдагдалтай төсвийг энэ өнөөдөр тодотгол хэлэлцээд байж байгаа төсвийг ямар хөөрхөн төсөв бариад ороод ирэв, их аятайхан төсөв байна шүү дээ гээд сууж байсан. Өнөө өглөө чуулганы нээлт дээр байж байсан хүн маасайтал инээгээд байж байсан, одоо ингээд тодотгол хэлэлцэх үеэр байхгүй бантаад алга болсон.

Өнгөрсөн жилийн өдийд 2026 оны төсвийг төсвийн ажлын хэсгийг ахалж байсан Ганхуяг гишүүн улаан, ногоон лаазтай юм өргөөд, нийт гишүүдийг уриалан дуудаад байж байсан тэр хүн өнөөдөр алга байна. Энхтүвшин гишүүн энэ өнгөрсөн жил 2025 оны төсвийг үхтлээ шүүмжилж байсан хүн 2026 оны төсвийг найр тавиад л ингээд баталсан, өнөөдөр болохоор ийм аядуу зөөлөн юм яриад сууж байгаа байхгүй юу. Энэ зөвхөн өөрсдийгөө боддог Занданшатарын Засгийн газар өөрийнхөө Засгийн газрыг авч үлдэхийн тулд 1.4 их наяд төгрөгийг яг үнэндээ өөрийнхөө Засгийн газрыг хамгаалж үлдсэн гишүүдийнхээ тойргийг тойглох энэ ажилд зарцуулсан шүү дээ. Тэгчхээд яасан нялх биетэй улс эх орныхоо төлөө гээд ирсэн намайг 1 тэрбумын кноп дарлаа гээд өөрсдийнхөө бүхий л тролл хэвлэлүүдийг дайруулж байсан. Гэтэл өнөөдөр энэ горьг нь бид өнөөдөр энд ярилцаад сууж байгаа байхгүй юу.

Өнөөдөр тэд нарын тарьсан гай балгийг өнөөдрийн Ерөнхий сайд үүрээд улалзаад сууж байгаа байхгүй юу. Өнгөрсөн төсвийн үед Үндэсний аудитын газраас хүртэл ерөөсөө энэ төсөв зураг нь байхгүй, газар нь байхгүй, төсөвт ингэж суугдаагүй ийм төслүүд маш их байна гэж хэлсээр байж байхад бүгдээрээ улаан, ногоон лаазаа өргөж байгаад баталсан шүү дээ. Тэгээд одоо тэрийгээ өнөөдөр бид үүрээд сууж байгаа байхгүй юу, яг үнэндээ. Тэгэхээр энэ хараа хүнээ бодъё гэж байтал хүнээ биш өөрсдийгөө боддог энэ улс төрчдийн гайтай, балагтай үйлдлээс болоод өнөөдөр энэ улс орны нөхцөл байдал ийм хүндрэлтэй нөхцөлд орж байгаа юм гэдгийг хэн ч хэлэхгүй байгаа учраас би хэлчихье.

Ингээд дараагийн асуултдаа оръё. Тэгээд хууль зөрчсөн аудитын дүгнэлттэй баахан төслүүдийг хассан уу, тэгээд ингээд хасчихсан гэж байгаа боловч энэ зардлуудыг хассан гэж байгаа боловч нөгөө хэдийгээ баахан ингээд өр болгоод дараа жилийн төсвөөс санхүүжүүлнэ гээд үлдээчихсэн юм биш биз дээ? Одоо тэгээд Засгийн газар нийтдээ хэдэн төгрөгийн өртэй байгаа юм бэ гэдгийг асууя?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Засгийн газар байгуулагдаад 4 сар гаруй хугацаа болж байна. Тэгээд ажил аваад ер нь анх удаа л манай Засгийн газрын төсөв буюу төсвөө дагасан бодлогоо оруулж ирж байна анх удаа. Ирэх оны төсвийг өргөн мэдүүлсэн. Энэ ирэх оны төсөв манай Засгийн газрын энэ чөлөөлье үндэсний санаачилгын бодитой хэрэгжилт байх болно. Бүлэг болгонд хүрсэн шийдвэрүүдийг гаргасан, тэгэхдээ 1-д хүнээ л бодсон. Хүнээ мартсан эдийн засаг гэж байхгүй. Сая Владивостокийн форум дээр очиход хүртэл "Ард түмнээ бодсон эдийн засаг, ард

түмнээ бодсон хөрөнгө оруулалт, ард түмнээ бодсон шийдвэр" л гэж ярьж байна дэлхий дахинд. Тэгэхээр хөдөлж байгаа хүн болгоныг дэмжих бодлого бол өөрөө бодлогын цөмд байх ёстой. Тийм ч учраас бид энэ удаа хүн рүүгээ чиглэсэн төсвөө оруулж ирсэн. Цаг үетэйгээ нүүр тулсан, үнэнээ хэлсэн, асуудлыг сууриар нь харахыг шийдвэрлэсэн.

Дээрээс нь ингээд зарим хүмүүс яриад байна намайг, "Их төсвийн тоо их том байна, ирэх оны төсөв бараг 40 их наяд хүрчихлээ" гэж. Үгүй ээ, энэ чинь Гадаад зээлийн ашиглалтын хууль гээд л хууль хийгээд л гаргачихдаг юм. Түүн шиг ОТ-н 3 их наяд, төрийн өмчийн компанийн ногдол ашгийн 3.5-ыг төсөв дээр бичихгүй гээд хэдүүлээ өөрсдийгөө хуураад, төсөв дээр бичихгүй явж болно. Орон нутгийн төсөв яг адилхан. Орон нутаг 32.9 их наяд улсын төсөв батлагдсан мөртөө орон нутагтайгаа нийлээд 37 шүү дээ. Угаасаа Эрдэнэс Монголоор дамжаад, ТӨК-удаар дамжаад зах зээл рүү нийлүүлэгдэж байсан мөнгийг энд орж ирэхээр яахаараа инфляц өдөөгөөд байдаг юм. Энэ төсвийн тодотголоор оруулж ирэх гэж байгаа 1.5 их наяд чинь бид энд хэрвээ ногдол ашиг гээд тэтгэвэр, тэтгэмж, цалинд өгөөгүй бол тэр ТУЗ-ийн хэдэн гишүүд чинь л хуваарилж байна шүү дээ. Нэг хэрэгтэй, хэрэггүй юм руу зараад л зах зээл дээр яг адилхан нийлүүлэгдэнэ, тэгвэл инфляц яг адилхан шүү дээ.

Энд оруулж ирээд "Тэтгэвэрт өгье" гэхээр л болохгүй гэнэ, энд оруулж ирээд "Цалин өгье" гэхэд л инфляц өдөөнө л гэнэ. Тэгээд яаж энэ ард түмнээ амьдар гээд байгаа юм бэ л гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Нарантуяа-Нара гишүүний энэ хэлээд байгаа санал нь зөв. Би хүндээ бодсон, хүнээ харсан. Энэ улс оронд чинь хүн амьдрах эрхтэй юм байгаа биз дээ. Тийм учраас тэнд нэг хэдэн нөхдүүд найрлаж байхын оронд энд авчраад ногдол ашгийг нь тэтгэвэртээ өг л дөө, ийм л юм яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зарчмыг би зөв гэж бодож байна. Өрийн хувьд 26 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Засгийн газрын өр 45.2 их наяд, ДНБ-ий 44.5 хувь хүрэхээр тооцоотой, тэгээд ч энэ чинь өр чинь 60 хувийн шаардлага байна шүү дээ, тэгэхээр 44.5-тай л явж байна гэсэн үг. Тэгэхээр энэ шаардлага дотроо л ингээд явж байгаа.

С.Бямбацогт: Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Ингээд хүнээ бодъё, тэртээ тэргүй тэнд ТӨХК-удын үргүй зарлагадаж байгаа, зах зээлд нийлүүлж байгаа, үргүй нийлүүлж байгаа энэ мөнгийг иргэддээ тэр дундаа ахмадууддаа нэн тулгамдсан хэсэг рүүгээ явуулъя, зарцуулъя гэж байгаа нь үнэхээр талархалтай байна. Тэр хүмүүс ч гэсэн маш их баярлаж байгаа байх. Ер нь ингээд цааш цаашдаа төсвийн мөнгөөр улс төр хийдгийг ерөөсөө халах хэрэгтэй. Тэгээд нэг Засгийн газраа бодож, ингээд төрийн наймаа хийдэг ийм асуудлыг залуу хүний хувиар Учрал сайд халах байх гэж итгэж байна. Тэгээд би хамгийн сүүлд нь нэмэлт нэг минутынхаа тодруулгыг аваад Учрал сайдаас нэг юм хүсчихье тэгэх үү, дарга аа, Бямбацогт дарга аа, нэг минутаа шууд үргэлжлүүлээд авчихъя.

С.Бямбацогт: Нэг минут нэмье.

М.Нарантуяа-Нара: Учрал сайдын энэ ЗГ-ыг огцруулъя энэ тэр гээд акцууд явж байх шиг байна. Миний хувьд таны ЗГ-ыг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцор гэхээс илүү та тодорхой нэг яамнуудаа, яамдынхаа сайдуудыг солимоор байна, жишээлбэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Аубакир сайдыг сольж

өгнө үү гэж хүсэж байна. Энийг яагаад ингэж байна гэхээр үндэстэн ястнаар ялгаварлан гадуурхсандаа биш, өнгөрсөн хугацаанд Монгол Улсын төр засагт гарсан энэ Монгол Улсаас урвасан Зарыдхан, Бекен, Жекей, А.Мурат зэргийн гишүүдээс харж байгаад би энэ Монгол Улсын ЗГ бодлогын яамыг Аубакир гишүүнээр удирдуулахгүй байх ийм санал танд гаргаж байна. Энийг хүлээж авна уу. Тэгээд би холбогдох материалуудыг би танд өөрт тань илгээгээд яагаад гэдэг энэ баримтыг хавсаргаад танд бичгээр явуулна. Баярлалаа.

С.Бямбацогт: Санал хэллээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд төсвийн тодотгол яригдаж байна, удахгүй тэгээд 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл яригдана. Тэгэхээр энэ сүүлийн олон жил яригдаж байгаа, нэг байнгын яригддаг юмнууд л давтагдаад байгаа. Тэр нь юу вэ гэхээр төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зөрчил, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 22 удаагийн нэмэлт, өөрчлөлт, тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Үндэсний аудитын газрын гаргаад байгаа дүгнэлт, зөвлөмж хэрэгжихгүй байгаа байдал гээд. Тэгээд энэ бүхнийг эргээд харахаар ерөөсөө хариуцлагатай холбоотой юм болов уу л гэдэг асуудал байгаад байна. Хариуцлага. Тэгэхгүй энэ доторх тоог мянга, энэ чинь мянга түм задрах асуулт, үг байж болно. Тэр нөгөө суурь төсвийн реформоо энэнтэйгээ уялдуулаад хариуцлага, сахилга батаа чангатгахгүй бол энэ ерөөсөө тэгээд л бидний цөөн Монголчууд бие биеэ хуураад ингэсхийгээд, нэг тэгсхийгээд инерцээрээ урагшлах юм биз дээ л гэж бодогдоод байх юм.

Тэгээд төсвийн тодотгол хийхээс өөр аргагүй болчихсоныг янз бүрийн баримтаар нотолж байна. Зүгээр сэтгүүлчдийн болон иргэдийн асуугаад байгаа зүйл нь яагаад энэ 998 тэрбум төгрөгөөр букуу бараг 1 их наяд төгрөг нэмэх болов гэдэг дээр асуугаад байгаа. Тэгээд тэрэн доторх зарим асуудлууд мэдээж ойлгомжтой, эрчим хүчний салбар дээр өвөл айсуй гэдэг шиг, тэгээд бусад асуултууд байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Төсвийн байнгын хороон дээрээ илүү детальчилж ярья.

Тэгээд нэг анхаарах ёстой юм нь юу вэ гэхээр, нөгөө хувийн сектор, бизнесийн салбараа Ерөнхий сайд маань чөлөөлье гэдэг аяны хүрээнд уг нь ингээд харж үзнэ гэсэн. Гэтэл тоон статистикаар харахаар төсвийн орлого бүрдүүлэлт ерөөсөө дотоодын татвар төлөгч дээр илүү ачаалагдахаар харагдаад байгаа. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий газрын орлого бүрдүүлэлт, эх үүсвэр 6.9 хувийн өсөлттэй, харин нөгөө талдаа ГЕГ-ынх -10 хувь, Сангийн яамных -28.2 хувь бууралттай гэсэн үг шүү дээ хасах гэдэг нь, гадаад тусламж 13.2 хувь ч гэдэг юм уу, ийм эсрэг дүр зураг харагдаад байгаад санаа зовоод байгаа юм шүү.

3 дугаарт, мэдээж улс төрчид ялангуяа дахин сонгогдохыг хүсэж байна, сонгогчид хэн билээ, нөгөө төрийн албан хаагчид, настууд орно шүү дээ. Тэгээд яах вэ, эдийн засагч, төсвийн анализ энээ тэрээ хэлдэг, ярьдаг хүний хувиар дуугүй байж болохгүй, бодит орлогын өсөлт, тэгээд бодит худалдан авах чадвар чухал шүү л гэдгийг манай иргэд, олон нийт ойлгох буй за. Тэгээд яах вэ, тэтгэвэр нэмж байгаа, цалин хөлс нэмж байгаа хугацаанаасаа яагаад урагшлуулаад байна вэ гэдэг дээр асуулт асууя. Ингээд товчхон базъя даа, тэгээд юм ярихаар хэцүү, ярихгүй байх хэцүү, улс төр болчихоод ер нь жаахан нэг төвөгтэй.

С.Бямбацогт: Хэн хариулах юм бэ, Ерөнхий сайд уу, Сангийн сайд уу? Сангийн сайд хариулъя.

3.Мэндсайхан: Мөнхсоёл гишүүнээ, энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулахаар өргөн барьсан. Ерөнхийдөө бид өмнө нь Сангийн сайд ямар арга хэмжээ авсан бэ гэхээр бид, та өөрөө мэдэж байгаа, Монгол Улс одоогийн байдлаар 13.8 их наяд төгрөгийн гадаад зээлийн үлдэгдэлтэй, гадаад зээлээ бид ашиглаж чаддаггүй байсан төсвийн хязгаараасаа хамаараад. Тэгэхээр энэ төсвийн хүрээндээ бид өөрчлөлт оруулаад, гадаад зээлийн ашиглалтыг гаргаж ирээд, энэ дээрээсээ бид том эдийн засгийн үр өгөөжөө өгөх төслүүдээ санхүүжүүлэх тэр гарцыг нээгээд явж байсан. Хавар 6 дугаар сард ЗГ Эрдэнэбүрэн, Газрын тос гэсэн хоёр том бүтээн байгуулалтын ажлыг бид Их Хурлаар хэлэлцүүлээд төсвөөс гаргасан шүү дээ, тийм ээ. Энэ хэмжээгээрээ бидэнд тэр хоёр төслийн чинь хэрэглээ гэхэд л 2027 онд 2.5 их наяд байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал маань ерөнхийдөө энэ хуулиар шийдэгдчихсэн учраас бид эргүүлээд Төсвийн тогтвортой байдлын хуулиа 2024 оных нь тэр үндсэн суурь зарчим дээр нь өөрчилж буцааж авчирч байгаа юм.

Энэ нь харин өөрөө эсрэгээрээ төсвийн сахилга батад хамгийн зөв, зүйтэй байх юм гэдгийг төсвийн тогтвортой байдлынхан ч гэсэн түрүүн сая хэлж байна лээ, энэ эерэг үзүүлэлт гэж. Тэгэхээр бид тэр Жавхлан сайдын хийсэн өөрчлөлт бол тийм муу муухай зүйл байгаагүй, энэ шилжилтийн үеийн зохицуулалтын үүргээ биелүүлсэн. Ер нь эдгээр асуудлыг бид цааш нь цогцоор нь яаж шийдвэрлэх вэ гэхээр Төсвийн тухай хуулиа бид эргэж бүтнээр нь харах ёстой, бид нөгөө яриад байдаг аккруэл суурь руу шилжих ёстой гэж энэ утгаар нь ЗГ 2027 оны төсвийн төсөлтэйгөө дагалдуулаад УИХ-ын тогтоолыг оруулж ирсэн байгаа. Энэ дээрээ бид цаашдаа бид GPS 14 рүү шилжих тэр хуулийн төслийг шинээр боловсруулах, төсвийн хуулиа шинээр боловсруулах, ингээд шилжих тэр зөвшөөрлийг Их Хурлаас авахаар тогтоолоо оруулаад ирчихсэн байгаа.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

Б.Мөнхсоёл: Тэгэхээр нэг санаа зовж байгаа зүйл нөгөө тогтвортой орлогын эх үүсвэр байхгүй байна, тогтвортой орлогын эх үүсвэр. Энэ нэмэгдэж байгаа бараг 1 их наяд чинь Ерөнхий сайдын дэргэдэх Төрийн өмчийн бодлогын хороо билүү, юу гэдэг билээ, тэнчээнээс орж ирж байгаа нь бараг 1 их наяд төгрөг байгаа шүү дээ бас. Тэгэхээр тэр тогтвортой орлого мөн үү ч гэдэг юм уу, ийм тогтвортой орлогын суурь алдагдаж байгаад санаа зовж байна. Тэгээд алдагдал огцом өсөж байгаад санаа зовж байгаа, өөрөө саяын 2 гадаадын тусламжийн зээл орж тооцогдож байгаагаар тайлбарлаж байх шиг байна, тийм үү? Тэгээд цаашлаад хэлбэл дахиад олон асуудал хөндөж болохыг нь би санаж байгаагаараа хэлээд байна. Дахиад нэг асуудал нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн макро эдийн засгийн үзүүлэлтүүдээ жишээлбэл яагаад тэгээд өөрчлөхгүй байгаа юм бэ? Өмнө нь 6 +,-2 гээд л баахан буруу, зөв, буруу, зөв гээд ярьсаар байгаад өнгөрдөг, 13 хувь боллоо. Цаашдаа сэтгүүлчид юу гэж асууж байна гэхээр "15-аас 18 хувь болох уу, болохгүй юу" энэ тэр гээд л зөндөө. Энэ чинь эргээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Төсвийн хүрээнээс гадна ер нь төсөвтэй холбоотой асуултууд явчхаж байгаа учраас хоёр асуулт асууя гэж бодож байна. 1 дүгээрт, яах вэ энэ нөгөө ТӨК-удаас ногдол ашгийг нь төсөвт төвлөрүүлж иргэддээ чиглэсэн энэ цалин цавууг, энэ тэтгэврийг нь нэмэх асуудлыг бүрэн дэмжиж байна. Ер нь энэ ТӨК-удыг бид төсвөөс гадуур, ил тод биш байснаас үүдээд Ерөнхий сайдын хэлж байгаа шиг хэн дуртайнх нь ямар нэгэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлээд явчихдаг. Тэгээд төрийн өмч өөрөө явж явж угаасаа л ард иргэд өөрсдөө өгөөжийг нь хүртэж байх ёстой зүйл байгаа. Тэгээд энэ дээр бол энэ ТӨК-уд дээр ийм бодлого гаргаад, ногдол ашгийг нь төсөвт төвлөрүүлж, тэрийгээ ил тод ингээд зарцуулалтыг нь бий болгож байгаа нь маш сайн, зөв алхам гэж би харж байгаа.

Ялангуяа энэ боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэртэй холбоотой асуудлууд дээр төсвийн тодотгол дээр орж ирж байгаа. Энэ дээр нэг асуух юм. Хэрвээ ингээд цаашид ч гэсэн бид ТӨК-ийнхоо ногдол ашгуудыг төсөвт төвлөрүүлээд төсвийн хүрээнд энийгээ бодлогоороо зарцуулдаг болох юм бол ТӨК-уд өөрсдөө үр ашигтай ажиллах хөшүүргийг их сайн бодох ёстой. Тэгэхээр "Нэгэнт л төр ингэчихдэг юм чинь" гээд өөрсдийн яг өөрийн компанийнхаа журмаар явах юм бол инсентив /incentive/ нь юу байх вэ, өөрөө ТӨК-уд яаж өөрсдөө илүү үр ашигтай ажиллах вэ гэдэг хөшүүргийг бид бол аль аль талдаа сайн харах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр тэн дээр ЗГ дээр хийгдэж байгаа нэлээн ажлууд байгаа байх. Ерөнхий сайд яг энэ ТӨК-уд менежмент /management/-ээ сайжруулж, үр ашигтай ажиллах тал дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт, төсвийн тодотголын орон зайг бий болгохдоо энэ нийслэлийн үнэт цааснаас 758 тэрбумын орон зайг ашиглаж байгаа юм байна гэж харж байгаа юм. Тэгээд энийг би ойлгохдоо бол энэ Сэлбэ хотхон, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын энэ үнэт цаас, бонд /bond/-ын ашиглалтын орон зайг ашиглаж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ ашиглаагүй үлдсэн байгаа гэдэг нь яагаад ашиглаагүй үлдчихэв? Энэнээс үүдээд энэ Сэлбэ дэд төв дээр явж байгаа бүтээн байгуулалт цаг хугацааны хувьд удаашрах, хоцрох асуудал байгаа юу? Яагаад гэвэл тэнд нийслэлийн нэлээн олон иргэд газраа чөлөөлөөд, мэдээж өөр газар орон сууцтай болох нь болж байгаа байх. Гэхдээ орон сууцны бодлого шинээр тэнд жишиг ийм хотхон барих гээд олон сургууль, цэцэрлэгтэй цогцоор нь явж байгаа. Энд нэлээн хүлээлт үүссэн байгаа. Энэ ажилд нөлөөлөх үү, эсвэл энэ нийслэл өөрөө зарцуулаагүй үлдчихсэн үлдэгдэл ингээд чөлөөт хэмжээ байгаад байна уу, хэрвээ тийм байгаа бол нийслэл яагаад энийгээ энэ жил зарцуулж чадалгүй үлдээчхэв гэдэг дээр тодруулж асууя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ТӨК-удийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ТӨК-ийн хуулийг баталчихсан, 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжих гэж байна. Энэ хууль дээр ТӨК-уд багадаа 30 хувь, түүнээс дээш ногдол ашгийг төвлөрүүлэх үүргийг ингээд хуулиар хүлээлгэчихсэн. Энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй. Ер нь ашиггүй ажиллана гэдэг ойлголт бол цаашдаа ТӨК дээр байхгүй. Хувийн хэвшил хийж гүйцэтгэх зарим ажлуудыг төрийн нэрийн өмнөөс төр өөрөө хийх шаардлагатай гэж үзвэл түүнийг тэр нийтийн үйлчилгээний байгууллагаар нь л статустайгаар нь л авч явна. Тэрнээс ашиггүй ажиллаж байгаа ТӨК гэж байхгүй. Тэгэхээр ЗГ хувьцаа эзэмшигч учраас ногдол ашгаа авах эрхтэй, тэр ногдол ашгийг нь төсвөөрөө дамжуулаад иргэддээ хүргэх эрхтэй. Ингэж байж тэр баялагтаа эзэн байх боломжууд үүснэ гэж ингэж харж байгаа.

Тэгэхээр ТӨК дээр, жишээ нь хэрвээ энэ дээр ингээд ТӨК-ийн ногдол ашгийг 1.5-ыг авахгүй гээд явлаа гэхэд энэ чинь Их Хурлаар орохгүйгээр л ТУЗ хавиараа яваад л зах зээл дээр мөнгө нь нийлүүлэгдэнэ шүү дээ, адилхан. Тэгэхээр инфляц өдөөнө л гэсэн үг, яг адилхан, яг л адилхан байхгүй юу. Ирэх жил орохгүй байлаа гэхэд, ирэх жилийн ногдол ашиг энд ярихгүй байлаа гэхэд тэнд дахиад л адилхан мөнгөний нийлүүлэлт явна л гэсэн үг. Саяын энэ төсвийн тодотгол дээр бол бид юуг оруулж ирсэн бэ гэхээр, жишээ нь тэр алдагдлыг бол огт нэмээгүй. Тэгэхдээ манайд улсын төсөв дээр алдагдлын орон зай байсан. Тэгэхээр тэр орон нутаг дээр урьд оны дансны үлдэгдлийг зарцуулах эрхийг нь л нээж байгаа. Тэр орон зайн дээр нэг ёсондоо нийслэл нэмэлт орлоготой, тэр орлогоо хэрэглэх гэхээр хязгаарт тулчхаад байгааг нь тэрийгээ хэрэглээд энэ өвөлжилтөө хангаад л гэдгийг нь нээж л өгсөн юм. Нэг ийм бодлогын хүрээнд тэрүүгээрээ ялгаатай.

Нийслэлийн тэр үнэт цаастай холбогдуулаад бол ирэх онуудад энэ бондын мөнгө ашиглагдаад явна. Тэрнээс биш энэ бондын мөнгө нь хураагдана гэсэн ойлголт биш шүү дээ. Энэ онд л ашиглахгүй, нийслэлийнхэнтэй ярилцсан. Тэгэхээр энэ үлдэгдлээ ирэх онуудад ашиглаад явна, ирэх оны төсвийг дагуулаад бас дагаад явж байгаа энэ ашиглах эрхүүд нь. Тэгэхээр ашиглагдаад явна. Тэгээд тэр Сэлбэ дэд төвийн гүйцэтгэл, гүйцэтгэлээр нь санхүүжих ажлууд бол хийгдэнэ. Тэр ажлаас буцаж ухарч байгаа зүйл байхгүй, нийслэлээр явж байгаа ажлууд явна. Ирэх оны төсөв дээр тэр санхүүжилтийг нь тавиад явж байгаа. Зүгээр оны төгсгөлд тийм юм байхгүй. Зүгээр өвөлжилт дээрээ тэр дансандаа байгаа хуримтлагдсан хуримтлалыг нь өөрсдөө ашиглаад яв гэдгийг нь бол бид нээгээд өгсөн. Тэгэхээр тэнд хэрэгжүүлээд явна л гэсэн үг.

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. 1.5 их наядын буурах орлогоо ямар ч байсан ТӨК-удын ногдол ашгаар 100 хувь санхүүжүүлэх гэж байгаа юм байна, зардлынхаа дунд нэг ёсондоо хөрвүүлэлт хийлгээд, урьд оны үлдэгдлээс санхүүжих зардал орон нутаг ч юу байх вэ дээ, энэ чинь нийслэл шүү дээ. Тэгэхээр нийслэлээс урьд өмнийн үлдэгдэл санхүүжүүлэх зардлын орон зай 998, нийслэлийн үнэт цаас 750 мянга гэхээр ойролцоогоор 1.7 их наяд төгрөгийг нэг ёсондоо нийслэлийн орон зайнаас зардлаа шилжүүлж байна л гэсэн үг шүү дээ, тийм үү? Иймэрхүү маягаар төсвийн тодотгол том зургаараа орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр бүгдээрээ нэг зүйлийг анзаараарай. Төсөв орж ирж байна уу, төсвийн тодотгол орж ирж байна уу, дандаа дагаж Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд. Ер нь түүхээр нь аваад үзэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдсанаасаа хойш 22 удаа өөрчлөгдсөн байдаг юм байна. Нэмэлт, өөрчлөлт орсон гэсэн үг. Тэгэхээр жилд ойролцоогоор 1.3 дахин өөрчлөгдөж байна гэсэн үг л дээ. Уул нь төсвийн тогтвортой байдлыг УИХ нэг ёсондоо "Төсөв иймэрхүү байна шүү" гэсэн зураглалаа, хашаагаа тавиад, фундаментаа тавиад, "Энэ дотор төсвөө батална шүү" гэсэн ийм уул нь концепц анх батлагдсан боловч бүх ЗГ, ер нь бүх ЗГ-ууд төсвийн тогтвортой байдлыг яг нэг төсөв дагаж орж ирдэг нэг хууль мэтээр орж ирж байгаа нь энэ өөрөө зарчмын хувьд аягүй тийм зөрчилдөөнтэй л байгаад байна л даа.

Өнөөдөр төсвийн тогтвортой байдлыг УИХ биш, яг үнэндээ хэлэхэд ЗГ тодорхойлж байна шүү дээ. Өөрсдийнхөө хүрээнд төсөв оруулж ирэхдээ төсвийн тогтвортой байдлын зарчмаа тэр чигээр нь өөрчлөөд л оруулаад ирж байгаа юм. Яах вэ, энэ удаа өөрчилж оруулж ирэхдээ суурь тэнцэл гэсэн тэр буруу концепцыг засаад ороод ирсэн байна, тэр сайн хэрэг. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ий 2 хувиас илүүгүй байна гэдгийг оруулж ирсэн байна. Өмнө нь нөгөө нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджаас хэтрэхгүй гэдэг зөв заалтууд оруулаад иржээ. Гэхдээ анхаарах ёстой зүйл урсгал зардлаа бид тавьж байсан хашаа тэр ДНБ-ий 30 хувиас багагүй байна гэдгээ авсан байна. Дунд хугацааны төсвийн төсөөлөл маань 3 сар дотор өөрчилж болохгүй гэсэн нэг ёсондоо хязгааруудаа авчихсан байна. Тэгэхээр энэ дээр ер нь УИХ өөрөө бодох хэрэгтэй. Үнэхээр төсвийн тогтвортой байдлыг цааш авч явъя гэж байгаа юм бол ЗГ болгон төсвөө барихдаа ингээд өөрчлөөд байвал энэ чинь ямар тогтвортой байдал байх вэ дээ. Энийг ер нь цаашдаа бид том зургаараа заавал авч үзэх ёстой гэж бодож байна.

2 дугаарт, ямар ч байсан ТӨК-ийн ногдол ашгаар 1.5 их наядаар ямар ч байсан буурах орлогоо санхүүжүүлъя гэж байгаа юм. байна. Түүхийг нь аваад үзэх юм бол 2025 оны нэг ёсондоо улсын төсөв дээрх ногдол ашгаас 2.7 дахин, сүүлийн 6 жилийн хугацаанд ТӨК-ийн оруулж байсан ногдол ашгаас 4.1 дахин их тоо л байна л даа. Гэхдээ ногдол ашгаа улсын төсөв рүүгээ аваад шаардлагатай санхүүжилтийг хийгээд явах тэр зарчим дээр ер нь жаахан анхааралтай дэмжиж байна. Гэхдээ нэг анхаарах ёстой зүйл ногдол ашиг гэдэг тухайн жил цэвэр ашигтай ажилласан тохиолдолд гарч ирдэг нөхцөлтэй орлого байхгүй юу. Нөхцөлтэй орлого. Хэрвээ эдийн засаг унаад манайх шиг уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засаг дээр цэвэр ашиггүй гарах тохиолдол их гарна, тэр үед урсгал зардал санхүүжүүлчихсэн бол буцаад тэрүүгээр яах вэ. Энийг бид урт хугацаандаа бодохгүй бол энэ эрсдэлийн менежмент /management/-ийг хийж явахгүй бол энэ аюултай юм руу орно шүү. Тэгэхээр цаашдаа төсөв ярихдаа Эрдэнэс Монгол компанийн захирал, гүйцэтгэх захирал гол асуудлаа өөрөө хариулах хэрэгтэй. Эрдэнэс Монгол компанийн захирал хаачсан бэ?

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн нэмж асуултаа гүйцээе, нэг минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр улсын төсөв дээр 1.5 их наядыг ногдол ашгаар төвлөрүүлэх үүргийг нэг ёсондоо Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-тэйгээ хариуцаж байна гэсэн үг байхгүй юу. Тэр хүмүүс өнөөдөр ирж асуултад хариулах хэрэгтэй, 1.5 их наядыг хаана хаанаас аваад 1.5 их наяд бүрдэх юм, дараа жилийн төсөв дээр цаашдаа яах юм. Ер нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр дараа нь ямар нэг шинэ зарчим нэмэгдэх юм байна. Тэр нь ТӨК-ийн ногдол ашиг нийт орлогын тэдэн хувиас хэтрэхгүй гэсэн ийм дүрэм нэмэгдэх л болж таарч байна л даа. Энэ бол нэг дараа жил ч юм уу, тэрний дараа жил нэг асуудал уу, эсвэл бид цаашдаа шийдэх ёстой асуудлын нэг болж ер нь таарах юм байна гэж би ерөнхийдөө харж байна. Тэгэхээр энэ дээр нийтдээ яг ямар бодлого барих вэ? Эрдэнэс Монгол цаашдаа Үндэсний баялгийн сангийн хэлбэр рүү, хөрөнгийн сангийн хэлбэр рүү ороод гадаад менежменттэй болно гэж байгаа, энэнтэйгээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төсвийн реформ хийнэ гэж их олон жил ярилаа. Манай энэ төсөв чинь өөрөө нэг ийм компанийн санхүүгийн тайлан болчихоод байна шүү дээ. Тийм учраас үе үеийн ЗГ энэ олон өөр өөрсдийгөө чөдөрлөчихсөн, тушчихсан олон заалтууд дотор үйл ажиллагаагаа явуулах, эдийн засгаа идэвхжүүлэх бодлого хэрэгжүүлэхэд дандаа л энэ зовлонг үүрч ирсэн. Тийм учраас үе үеийн ЗГ-ын үед энэ төсвийн тогтвортой байдлыг хөнддөг байх. Жишээ нь, суурь тэнцэл гэдэг ойлголт яагаад анх энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд орж ирсэн юм бэ гэхээр тухайн үед гадаадын зээл, тусламж, санхүүжилтийг нөгөө гүйцэтгэл нь явчхаад байдаг, санхүүжилтийг нь авъя гэхээр нөгөө тусгай шаардлагыгаа давж чадахгүй. Түүнээс болоод суурь тэнцэл гэдэг ойлголтыг бий болгоод тэрэн дотор бонд, нөгөө гадны санхүүжилт, зээл чинь багтахгүй шүү энэ алдагдалд тэр нь 2 хувь байна шүү гэдгийг оруулж ирж байж тухайн үед энэ өнөөдрийн Газрын тос, Эрдэнэбүрэн гээд том төслүүд чинь явсан. Нэг ёсондоо энэ суурь тэнцэл цаг үеийнхээ түүхэн үүргээ биелүүлсэн байхгүй юу.

Яагаад өнөөдөр суурь тэнцлийг бид одоо шаардлагагүй гэж үзэж байгаа юм бэ гэхээр Гадаад зээлийн ашиглалтын хуулийг баталчихсан байхгүй юу. Тэгэхээр Гадаад зээлийн ашиглалтын хуулийг баталчихаар тэр 3.5 орчим их наяд гадаад зээлийн ашиглалтын хуулиар гараад ирэхээр энэ орон зай бидэнд бий болчихгүй юу. Тийм учраас хуучнаараа тэнцвэржүүлсэн тэнцлээ бариад явъя л гэж байгаа юм. Дээрээс нь дэлхийн тодорхойгүй байдал хамгийн тодорхой байгаа цаг үед 3 сарын өмнө төсвийн хүрээ тооцно гэж байхгүй, энэтэй манай Их Хурлын гишүүд эвлэрмээр юм байна лээ. 3 сарын өмнө хэдэн төгрөгийн орлого олох, зарлагадахаа мэдчихээд энэ тоондоо багтаж яв гэхэд өнөөдөр дэлхийн байдал чинь өдөр, минут, цаг тутам өөрчлөгдөж байгаа шүү дээ. Өнөөдөр төсвийн хүрээ та бүхэн баталж өгсний дараа Их Хурлаар Татварын хууль баталсан, дараа нь Нийгмийн даатгалын хууль баталсан, ОТ-н ногдол ашгийн асуудал өнөөдөр яригдаж байгаа, тухайн үед яригдаагүй шүү дээ.

Гэтэл та нар төсвийн хүрээ, энэ хязгаарт та нар багтаагаад төсөв барина шүү гээд ингээд ороод ирэхээр бид яг гадаад зээл шиг гаднаас мөнгийг нь өгье гээд байдаг, хэрэглэж чаддаггүй, "Манайх дээд хязгаартай юм" гээд суугаад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ төсвийг дагалдуулаад, бид ирэх оны төсвийг дагалдуулаад тэр GCF 2014 оны стандарт руу шилжье, ядаж энэ төсөв чинь реформоо эхлүүлье, ядаж энэ өмчөө тоолдог больё гээд байгаа байхгүй юу. Тийм учраас ТӨК-ийн цэвэр ашгийг төсөв дээр ЗГ ногдол ашгаа авах эрхтэй шүү дээ, тэрийг нь өгье гээд байгаа байхгүй юу. Тэрнээс биш ногдол ашиг гэдэг чинь таны хэлж байгаагаар юу гэдэг юм, шууд үйл ажиллагаанаас нь аваад явна гэж байхгүй шүү дээ. Энэ чинь цэвэр ашиг, тэр бүх зардал нь гараад цэвэр ашиг, ашиггүй ажиллавал юугаа өгөх юм, ашигтай ажиллавал харин өгөх ёстой л гэдэг ийм л зарчмаар хандсан. Тийм учраас Баялгийн сан.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээгээд хариулъя.

Н.Учрал: Тийм учраас Баялгийн сангийн хууль дээр орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд буюу ЭТТ компани, жишээ нь тэнд ногдол ашигтай ажиллачихсан байна шүү дээ. Тэр нь тэр орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд рүү шилжээд, тэндээс төсөв рүү ногдол ашиг гэж өгдөг байхгүй юу. Энэ цэвэр ашгийн асуудал. Тэгэхээр та нөгөө ОТ-н ногдол ашиг дээр ч гэсэн, жишээ нь тэр Хуримтлалын сан руу орлоо ч юм уу, ингэлээ гэхэд тэр чинь түүгээрээ дамжаад ногдол ашиг хэлбэрээр ирэх гээд байхгүй юу. Энэ чинь эрүүл үзэгдэл байхгүй бол ер нь өөр санаатай хүн

бол миний оронд байсан бол дэргэдээ байлгаж байгаад л 1.5 их наядаар янз бүрийн төсөл хэрэгжүүлбэ гэж фантазлаад л, тэгээд л нэг баахан хувийн хэвшлийг урьж дуудаад л, бизнес рүү ороод завхруулаад л явах байх л даа. Надад тийм сонирхол алга, тэрийг ард түмэндээ хүртээе л гэж байгаа.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Нэг зүйл маш ойлгомжтой. Бид өнөөдөр ногдол ашиг ярихаар би яг үнэнийг хэлэхэд УИХ бүгдээрээ мэдэхгүй байгаа байхгүй юу. Ямар компани ямар ашигтай ажиллаж байгаа юм, ялангуяа Үндсэн хуулийн 6.2 дээр суусан стратегийн ордууд маань хэр ашигтай ажиллаж байгаа юм, дараагийн ногдол ашиг байгаа юм уу, үгүй юм уу? Тийм учраас миний хувьд шинэ хууль санаачилж байгаа, энэ намрын чуулгандаа багтаж өргөн барина гэж бодож байгаа. Стратегийн ач холбогдолтой ордуудын ил тод байдал, тайлагналын тухай хууль. 40 жил Эрдэнэт Монголыг тэжээсэн, гэхдээ Эрдэнэт нэг ч өдөр ирж УИХ дээр, чуулган дээр, Байнгын хороон дээр тайлангаа тавьж байгаагүй шүү дээ, бид мэддэггүй байхгүй юу. Тэгэхээр ингээд төсөвтэй уягдаж байгаа нь нэг талаасаа сайн хэрэг. УИХ дээр нэгэнтээ ард түмний өмч, энэ ард түмнийг төлөөлөөд бид сууж байгаа юм, жилд нэг удаа ирж тайлагналаа тавьж, ашигтай ажилласан хэрхэн ард түмний өмчийг захиран зарцуулснаа тайлагнадаг ийм процесс руу орох хэрэгтэй. Тийм учраас өнөөдөр бид 1.5 их наяд.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Байгалийн нөөцийн ил тод байдлын хуулийг манай Уянга гишүүн энэ чинь өнгөрсөн хугацаанд хэлэлцүүлээд, Засгийн газраас сая дэмжиж саналаа өгөөд, ингээд Их Хуралд өргөн мэдүүлэх гэж байна, ЗГ бодитой саналуудаа өгсөн. Таны хуулийн концепц Уянга гишүүнийхтэй нэгтгэгдээд, саналаа өгөөд хамтдаа ажиллаад явах нь цаг хугацаа товчлох байх гэж бодож байна. Тийм, тэгээд ер нь ТӨК-уудыг хэдүүлээ нэг зарчим байх ёстой шүү, ТӨК-удын засаглалд орохгүй шүү улс төрчдөө, засаглалд орохгүй шүү, ногдол ашгаа төвлөрүүл гэдэг үүргийг л өгөх болохоос биш үйл ажиллагаанд орохгүй шүү. 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс ТӨК-удын захирлыг нээлттэй сонгон шалгаруулна, үйл ажиллагаанд орохгүй, улс төрчид гар хөл дүрэхгүй. Тийм учраас би нэг Франклин Темплтон, Блэк Рокт засаглалыг нь өгнө, тэгээд эндээс гар савраа бүгд татах хэрэгтэй. Тийм учраас бүгдээрээ энэ дээр Батнайрамдал гишүүнтэй хамтарч ажиллая.

С.Бямбацогт: Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Энэ статистикийн мэдээллүүдийг харахаар эдийн засгийн өсөлт байна, мөн энэ экспорт нэмэгдэж байна. Биет хэмжээгээрээ ч гэсэн, мөн гадна талдаа нүүрсний үнэ өсөж байна, алтны үнэ өсөж байна, зэсийн үнэ сайн байна гээд ингээд эерэг мэдээллүүд яригдаад байдаг. Гэтэл яг хөрсөн дээрээ энэ эдийн засгийн өсөлт, энэ экспортын өсөлт чинь буухгүй байна. Яг тэр хөдөө орон нутагт байгаа ард иргэдийн амьдралд тэр уул уурхайн баялгаас орж ирж байгаа мөнгө яг амьдралд нь нэмэр болж очихгүй байна гэдэг ийм зүйлийг л яриад байна. Өнөөдөр Монгол Улс өнгөрсөн жил гэхэд 90 сая тонн нүүрс гаргасан байгаа. Энийг өдөр, цаг, минутад хуваагаад, секундэд хуваагаад үзэхээр нэг секундэд 170 тонн нүүрс хилээр гаргаж байгаа юм. Тэгээд ийм их баялгаа гаргаж, ингэж экспорт хийж байгаа байж энэ мөнгөний ханшаа барьж чадахгүй байна, мөн эдийн засагт яг энэ хөрсөн дээрээ бодит өсөлт гарахгүй байна гэж ингэж хараад байгаа юм.

Тийм учраас энэ яаж уул уурхайн баялгаас орж ирж байгаа мөнгийг энэ иргэдэд яг хөрсөн дээрээ айлын хаалгаар оруулах вэ гэдэг маш чухал асуудал байна. Тэгээд дээр нь энэ секунд тутамд гарч байгаа 170 тонн нүүрсний маань яг хэдэн тоннынх нь мөнгө орж ирээд байна, хэдэн тоннынх нь мөнгө тэр урьд өмнөх өр шир, тэр оффтейк /offtake/ гэрээ, өр төлбөртэй яваад байна вэ? Энэ дээр нэг багцаа тоо хэлж болох уу, Ерөнхий сайд? Тэгэхгүй бол тэгээд баахан экспортын биет хэмжээ, тоо дүн яриад байдаг, яг буцаад орж ирж байгаа, эдийн засагт орж ирж байгаа валют, мөнгө өр нь ямар түвшинд байна вэ? Энэ дээр нэг мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь, ингээд ирэх жилийн төсвийг ч, өргөн барьсан төсвийг ч харж байхад, одоо энэ төсвийн тодотголыг ч гэсэн харж байхад төсвөө нэмээд байхаар энэ мөнгөний ханш л нэлээн унаж, төгрөгийн худалдан авах чадвар буураад байна л даа. Тэгэхтэйгээ зэрэг өр нь энэ том бодлогоороо мөнгөний ханшаа тогтвортой байлгах, Монгол төгрөгийг үнэ цэнтэй байлгах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах тал дээр яаж анхаарч ажиллах вэ? Тэгээд өр нь энэ эдийн засагт яг аль аль салбарууд дээр өсөлт байна вэ? Мэдээж ихэнх салбарууд, жижиглэн худалдаа ч гэдэг юм уу энэ салбарууд унаж байна, өр нь яг өсөлттэй салбар нь аль салбар өсөлттэй байгаа юм бэ? Мэдээж бүгд муу хасах руу орчхоогүй л байх шиг байна л даа. Энэ дээр яг статистик байна уу, эсвэл Эдийн засаг, хөгжлийн яам нэг хариулт хэлээч гэж. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Араас нь Эдийн засаг, хөгжлийн яам хариулна.

Н.Учрал: Экспортын өсөлт энгийн ард түмний амьдралд нэмэр болохгүй байна. Тийм учраас ТӨК-ийн ногдол ашгийг ард түмнийхээ ахуй амьдралд нэмэр болгох зорилгоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжид л зарцуулъя л гэж байгаа юм. Алийн болгон ингэж явах вэ. Тэгээд ТӨК-ууд ашигтай ажиллаж байгаа, үгүй нь мэдэгдэхгүй, ашигтай байлаа гээд тэр нь ард түмэнд хүртээмжгүй байгаад байдаг. Тийм учраас анх удаа ийм том алхам хийлээ. ТӨК-удыг сайн ажиллаасай гэж ард түмэн хүсдэг болно цаашид, одоо бол хүсэхгүй байгаа шүү дээ. Яагаад гэвэл хэдхэн хүний л хувийн ашиг сонирхол тэнд чинь байдаг юм биш үү. Цаашид ТӨК-ууд сайн ажиллаасай, энэ компани илүү ашигтай ажиллавал миний ахуй амьдралд нэмэр болно гэж ингэж боддог болно. Тийм учраас энэ бол том боломж гэж ингэж үзэж байгаа юм.

Тэгээд яг мөнгөний нийлүүлэлтийн хувьд нэг зүйлийг бодох ёстой, 32.9 их наяд гэж баталчихсан хэдий ч орон нутагтайгаа нийлбэл бараг 37 шүү. Гадаад зээлийн ашиглалтын хууль баталчихсан чинь дахиад бараг 3 их наяд. Дээрээс нь энд яригдахгүй байгаа ч гэсэн Удирдах зөвлөл нь шийдээд явж байгаа, уул уурхайн компаниудын зах зээл рүү нийлүүлэгдэж байгаа мөнгө багадаа л 3.5 байхгүй юу. Энд ногдол ашгаар. ОТ-н ногдол ашгийг оруулж ирээд, иргэддээ нээлттэйгээр төсвөөр ярьж гээд энийг гаргаад явсан бол яах вэ бид харахад их тоо нь бага харагдана. Манай улс төрчдийн шүүмжлээд байгаа "Учрал их наяд том төсөв оруулж ирсэн" гээд яах вэ, манай ЗГ үнэнээ ярьж байгаа учраас, тэрнээс би хулхидаад байвал хулхидаад л байна шүү дээ. Нэг ийм хууль оруулж ирчхээд л энийг ингээд төсөвт оруулахгүй шүү, та нар харахад бага, зах зээл дээр харсан инфляц 13 хувь, энэ юутай холбоотой юм. Зөвхөн ТӨК-р дамжиж байгаа, орон нутгаар дамжиж байгаа нийлүүлэлт чинь өдөр тутам нэмэгдээд байгаа байхгүй юу нийлүүлэлт.

Тэгээд эргээд харсан чинь 700 тэрбум төгрөгөөр ААН-үүдийн орлого тасарчихсан, энэ худалдаа, үйлчилгээний салбар агшчихсан. Ийм тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ гэхээр, бага орлоготой иргэдийг дэмжихээс гадна нөгөө татвараа, татварын хуулиа хэрэгжүүлээд ирэх жил 15 мянган ажлын байр нэмэгдүүлэх гээд байна шүү дээ. Нэг ёсондоо ХХОАТ 800 тэрбум төгрөг халаасанд нь үлдэх нь байна. НӨАТ-ын суутган төлөгчийн босго 400 сая болсноороо НӨАТ төлөгч биш болчих нь байна, амьдрал ахуйд нь нэмэртэй байх нь байна. 600 компани 6-аас 10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байвал хуучин 25 хуучин 25 хувь төлдөг байсан бол 15 хувь болчихно. ААНОАТ 1 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого дээшилчихээр 23 мянган компани дээшилчхэж байгаа юм. Төсвөөс янз бүрийн санхүүжилт хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэрээс бид татгалзаад хувийн хэвшил рүүгээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр дэмжээд явчихаар нэг ийм боломжууд үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ их сайн, зөв жишиг рүүгээ хамт л ингээд явах гээд оролдож байна.

С.Бямбацогт: Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн идэвхжил чамлахаар чанга атга гэж боломжийн байна. Эхний хагас жилийн байдлаар 7.1 хувийн өсөлт үзүүлсэн. Хамгийн гол нөлөөлөл гадаад эрдэс буюу манай экспорт маш сайн байгаа. Энэ анхаарах асуудал буюу энэ дотоод хамгийн их ажлын байр бий болгож байгаа худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил сулраад байгаа, энийг бид анхаарах ёстой байна.

Уул уурхай 31.5 хувийн өсөлтийг үзүүлсэн. ХАА 11.3 хувийн өсөлт үзүүлж байна. Уул уурхайгаа дагаад тээврийн салбар 21.5 хувийн өсөлт үзүүлж байна. Барилга 7.9 хувийн өсөлт үзүүлсэн, боловсруулах салбар буюу худалдааны салбар бага буюу хасах утгатай гарч ирээд байгаа. Тэгэхээр боловсруулах, энэ худалдаа, үйлчилгээний салбарт хамгийн их ажлын байр хадгалагддаг.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Экспортын тухайд эхний 8 сарын гүйцэтгэлээр 14.4 тэрбум ам.долларын уул уурхайн голлох бүтээгдэхүүн экспортод гараад өмнөх оноос 58 хувиар өндөр яваа. Үүн дотор нүүрс 47 хувийн өсөлттэй, зэс 22 хувийн өсөлттэй, төмрийн хүдэр 7 хувийн өсөлттэй, ноолуур 49 хувийн өсөлттэй, мах 2 хувийн өсөлттэй буюу голлох экспортын үзүүлэлтүүд ингэж харагдаж байна. Бид нарын нөгөө төсөв тооцоолсон түүхий эдийн үнэ нүүрс 70 орчим ам.долларт яг тооцоолол дээрээ, төмрийн хүдэр бид 70-аар тооцсон бол 69 хилийн үнэ дээрээ ойролцоо, зэс бид 9700 гэсэн бол зах зээлийн үнэ 14 мянга хүрч, их нэмэлт орлогыг зэсээс нэлээн орж байна. Мөн алтнаас 2800-гаар 1 унацад тооцсон, энэ 4400 хүрч нэмэлт орлогуудыг бүрдүүлж байгаа ийм байдал байна.

С.Бямбацогт: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Би асуусан, нөгөө нэг секундэд 170 тонн нүүрс гаргаж байгаа зөвхөн нүүрс дээр жишээ авахад, тэгэхээр яг энэний мөнгө яг буцаад орж ирж байгаа юу, эсвэл тэр өмнөх өр төлбөр, янз бүрийн оффтейк юманд нь яваад байна уу? Ер нь зүгээр хэлж болох бол багцаагаар ер нь энэ экспортод гарч байгаа

бүтээгдэхүүний хэд орчим хувийнх нь орлого яг бодитоор эдийн засагт орж ирж байна вэ, энийг нэг хэлж өгөх боломж байна уу?

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Экспортын орлогыг бүрэн бүртгэх бүртгэл, хяналт доор явж байна. 7 дугаар сарын байдлаар манай төсвийн орлого 20 хувиар өссөн. Үүн дотор улсууд түрүүн яриад байсан Үндэсний баялгийн сан оны эхнээс 1.9 их наяд төгрөгөөр орлого нэмж төвлөрсөн байгаа юм. Ирээдүйн өв сан 2.8 дахин өссөн, Хуримтлалын сан 2.1 дахин өссөн, Тогтворжуулалтын сан 2.3 дахин өссөн, нийт татварын орлого 11 хувиар өссөн. Үүн дотор орлогын албан татвар 10 хувь, Нийгмийн даатгал 16 хувь, НӨАТ 12 хувь, АМНАТ 3 хувь, Гаалийн татвар 6 хувийн өсөлттэй, гол анхаарах сэдэв онцгой албан татвар 16 хувийн уналттай, хасах, бууралттай гарч байгаа. Энэ маань нефть бүтээгдэхүүний үнийг хямд байлгах зохицуулалтын хүрээнд онцгой албан татварын гаалийн татваруудыг чөлөөлсөнтэй холбоотой ийм уналт гарсан. Ер нь эдийн засгийн суурь үзүүлэлтүүд.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэг минут гүйцээгээд хариулчихъя.

Ж.Энхбаяр: Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд эвтэйхэн, Монгол Улсын валютын нөөц 8.3 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн 30 жилийн хамгийн өндөр үзүүлэлтийг хадгалаад байна. Ханш тогтвортой байна гэдэг нь валютын, нөгөө инфляцыг тогтоон барихад их томоохон үүрэг гүйцэтгэж байгаа. Экспорт дээр ЗГ маш сайн анхаарч, экспортын гарцыг нэмэгдүүлэх, энэ худалдаанд учирч байгаа саад тотгорыг арилгах, хүнд суртлыг арилгах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг тасралтгүй явуулж байна.

Бид нарын урсгал зардал байгаа. Урсгал зардал, цалин, тэтгэвэр, бусад төрийн албаны болон салбарын цалингийн өсөлт өөрөө огцом өсөлт нь өөрөө хуулиар заасан энэ огцом өсөлт энэ төсөв дээр жаахан ачаалал өгөөд байгаа л асуудал байгаа шүү дээ. Тэрнээс эдийн засгийн суурь нөхцөл, эрүүл мэндийн байдал боломжийн явж байна. Энэ төсвийн бодлого худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбар дээрээ онцгой анхаарч байгаа. Цалин, тэтгэврийн нэмэгдэл гэдэг маань эргээд энэ худалдаа, үйлчилгээгээ дэмжсэн, мөнгөний эргэлтийг л нэмэгдүүлэх ийм л бодлого шүү дээ.

С.Бямбацогт: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Надад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуух асуулт байна. 1 дүгээрт, та бүхний гаргасан дүгнэлт дээр төсвийн хэмнэлт буюу энэ хасаж орж ирж байгаа хэмнэлтийн 52.6 хувь нь нийслэлийн бондоос эх үүсвэрийг гаргахаар тоочжээ гэж дүгнэлт орж ирээд байна л даа. Ерөнхий сайдын хариултууд олон ч гишүүний асуусан асуултад хариулж байгаа хариултаар ТӨК-удын ногдол ашиг Эрдэнэс Монгол дээр төвлөрчихсөн байгаа, энэ ногдол ашгаас олгох юм гээд. Би ойлгохдоо энэ хуулийн төслийг судлаад нийслэлийн энэ бондын хасаж байгаа дүн Төсвийн нөгөө тогтвортой байдлын тухай хуулийн 2 хувийн хязгаарт тулсан зардлын хэсгийг л бууруулж байна. Тэр зардалдаа багтааж урсгал зардал орж ирж байна л гэж харж байгаа шүү дээ. Тэгээд энэ дүгнэлтээ тайлбарлаж өгөөч ямар учиртай юм 1 дүгээрт?

2 дугаарт цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдээд 697 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа нь инфляцад нөлөөлөх нь гэдэг ийм эрсдэл байна гэдэг дүгнэлтийг хийсэн байна. ТӨК-ийн ногдол ашиг 2024 оныг хүртэл яг явдаг журмаараа улсын төсөвтөө төлдөг байсан. Би Эрдэнэт үйлдвэрт энэ орлогыг төвлөрүүлдэг, гарын үсэг зурдаг байсан хүний хувиар энийг мэдэж байна л даа. 2024 оны Үндэсний баялгийн сангийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр Эрдэнэс Монгол дээр 66 хувь нь очоод тэнд төвлөрдөг болчихсон. Тэгээд энэ тэнд байгаа төсөл хэрэгжүүлэхээрээ инфляцад нөлөөлдөггүй, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл болоод ард иргэдэд очихоороо инфляцад нөлөөлдөг болсон дүгнэлт юунд үндэслэж ямар тооцоо, судалгаанаас гарав гэдгийг тодруулъя?

Сангийн яамны танилцуулга, энэ хийж байгаа мэдээлэл дотор инфляцын өсөлтийн тал нь, бараг тал нь үндсэндээ махны үнийн өсөлт байна л гэж байна шүү дээ. Тэгээд энэ цалин хөлсний өсөлт яаж нөлөөлөөд байгаа юм. Энэ нэмж байгаа мөнгө чинь өнөөдөр эдийн засаг дээр эргэлтэд байгаа мөнгө биш юм уу. Цалин хөлс нэмэхээр эдийн засгийн өсөлт чинь харин эргэдэггүй юм уу. Эдийн засгийн дотоод цусны эргэлт чинь хурдасдаггүй юм уу. Энэ хүмүүс цалин хөлснийхөө нэмэгдэл, тэтгэврийнхээ нэмэгдлээр хоолоо л авч иднэ шүү дээ. Гадагшаа ямар нэгэн худалдан авалт, тоног төхөөрөмж гэдэг юм уу импорт, валютаар худалдан авалт хийхгүй шүү дээ, энэ чинь эргээд дотоод эдийн засгаа дэмждэггүй юм уу? Энэ дүгнэлтээ тайлбарлаж өгөөч?

Мөн энэ дүгнэлтүүд дээр харахаар энэ "дорвитой бодлого дутагдаж байна" гэдэг хэд хэдэн дүгнэлт орж иржээ. Дорвитой бодлого гэдгийг яг юу гэж харж байгаа юм бэ? Би энийг нэг тодруулчихъя гэж бодсон юм. Би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг УИХ-ын гишүүн болсон хоёр жилийн хугацаанд таван төсөв батлахад бүгд дээр нь би дэмжиж ирсэн. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг хэрэгжүүлэх ёстой ч гэж би маргадаг гишүүдтэй. Гэхдээ энэ удаагийн төсвийн дүгнэлт дээр үнэхээр яг сэтгэл дундуур байгаад байгаа юм. Энэ уул уурхайн салбарын уналт ирэнгүүт энэ урсгал зардал нэмж байгаа юм чинь төсөвт дараа болох нь гэж орж ирсэн байна л даа. Уул уурхайн салбарын уналтыг та бүхэн яаж прогнозчилов, хэдий хугацаанд гарна гэж тооцов?

Нөгөө талдаа бид бүх нийтээрээ нэг ийм шүүмжлэгч болчихсон сэтгэлгээтэй байгаа энэ цаг хугацаанд нийгмээрээ бид юмыг шүүмжилдэг, хардаг болчихсон энэ цаг хугацаанд мэргэжлийн, тэр тусмаа Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын зөвлөл би ийм дүртэй битгий болчихсоой гэж хүсэж байна. Тэгэхээр дорвитой бодлого гэдгээ та бүхэн гаргаж өгөөч. Ямар дорвитой өөрчлөлтийг хүсэж байгаа юм бэ? Магадгүй энэ хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд орсон нь нөлөөлсөн байна гээд дүгнээд байгаа юм. Тэгээд нэг гараараа дүгнээд тайлбарлаад байдаг, нөгөө гараараа үгүйсгээд байгаа энэ дүгнэлтүүд дээр ойлгомжгүй олон асуудлууд байгаад байгааг тайлбарлаж өгөөч гэж хүсэж байна. ТӨК-ийн ногдол ашиг бол ТӨК-ийн ч аваад үрээд байгаа юм биш, манай гишүүд ойлголт буруугаас болж буруу зөрүү тайлбар, буруу зөрүү ойлголтыг ард иргэдэд их өгч байна. Компаниуд өгдөг юмаа, төлдөг юмаа төлдгөөрөө л төлж байгаа өнөөдрийг хүртэл.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 3 номерын микрофон хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан. Энэ дээр нэг ийм, эхний асуултад нь

хэмнэлт гэж ярьж байгаа, бид нарын дүгнэлтэд хэмнэлтийг ашиглаж байгааг эерэг зүйл мөн гэж хэлсэн. Энийг та түрүүн сонссон байх. Хэмнэлтийн гээд байгаа зүйлийн 50 хувь орчим буюу 750 тэрбум нь нийслэлийн бондоос, бондын хэрэглэгдээгүй үлдэгдлийг бууруулах замаар буцаагаад ч тэр зарцуулах эрхийг нь нээсэн гэсэн үг. Төсвийн баримт дотор байгаа, нээгээд зөрүүлээд тодорхой төслүүдэд мөнгө зарцуулж байгаа ийм хувилбар байна гэсэн ийм үгийг хэлсэн юм. Инфляц дээр би танд тодруулга өгөхийг хичээе.

Инфляцын хувьд та яг манай төсвийн хүрээний мэдэгдлийн дүгнэлтээс асуугаад байна уу, Төсвийн тодотголын дүгнэлтээс асуугаад байна уу гэдгийг нь ойлгосонгүй. Инфляц дээр бид нэг ийм л дүгнэлт хийж байгаа юм. Инфляц яг тэгнэ, ингэнэ гэсэн зүйлийг бид тодорхой хувиар хэлээгүй. Таны хэлж байгаа зүйл дээр бид 700 гаруй тэрбум төгрөг 11, 12 дугаар сард хэрэглээн дээр очих юм байна гэдэг агуулгаар инфляц ер нь Монголбанкны бодлогын хүү өссөн, дээрээс нь Монголбанкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдах ийм төлөвтэй байна гээд байгаа.

Яагаад ингэж хэлж байгаа вэ гэдэг үндэслэлийг нь тайлбарлая. 1 дүгээрт, яах вэ төрийн өмчийн компаниудын мөнгө тэндээ явж байсан мөнгийг наашаа татаж ашиглаж байгаа гэдгийг ойлгож байгаа. Тэгэхдээ инфляцыг бий болгох нөлөөллийн хувьд зарцуулалт өөрчлөгдсөнөөр инфляцад тодорхой хэмжээн дээр очиж байна. Инфляцыг бий болгож байгаа зүйлийг та тодорхой хэллээ. Хэрэглээн дээр байгаа үндсэн хэрэглээ буюу махны үнэ болон бусад суурь хэрэглээтэй холбоотой инфляцын суурь инфляцаас бусад өсөлт нь тодорхойлогдож байгаа шүү дээ. Дараа нь дорвитой өөрчлөлт гээд байгаа нь манай Төсвийн зөвлөлийн барьж байгаа бодлого бол төсвийн зардлыг хэмнэх, бууруулах, төрийн оролцоог бууруулах чиглэлд бид явах ёстой. Өнөөдрийн энэ бодлого нь төсвийн зардлыг тэлэх байдлаар эдийн засаг руу, эдийн засгийн өсөлтийг хангах, иргэдийн амьжиргааг хамгаалах нь өнөөдрийн энэ цаг хугацаандаа зөв боловч олон жил бид энэ бодлогыг хэрэгжүүлж ирсэн нь бодлогын хувьд засварлах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Бид ингэснээрээ төрийн өмчийг, төрийн оролцоог нэмэгдүүлж, дээрээс нь хувийн хэвшлийн орон зайг хумьж байгаа энэ байдал нь сүүлийн үеийн статистик тоо баримтуудаас харагдаад байгаа юм. Уул уурхайн салбарын уналт гэдэг үгийг бид яг тэр үгээр нь байгаа эсэхийг би сая хайгаад олсонгүй, уул уурхайн салбарыг манай хавар хийсэн таамаглал дээр ойрын 3 жилдээ уул уурхайн салбар л дэмжих ийм нөлөөтэй байна гэж харсан. Харин эсрэгээрээ бид уул уурхайн салбарын энэ эерэг нөлөөлөл нь эдийн засгийн өсөлтийг тэтгэж байгаа боловч бусад салбар дээр эдийн засгийн нөхцөл байдал хүртээмжтэй байж чадахгүй байгаа учраас ийм нөхцөл байдалд уул уурхайн салбараас хамаарах орлогыг нэмэгдүүлэх нь төсвийн эрсдэлийг тодорхой хэмжээгээр өсгөх нөлөөтэйг цаашдаа анхаарч дараад.../минут дуусав/

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Таны үг, дүгнэлт хоёр хоорондоо зөрөөд л байна л даа. Тэр 1 их наяд 152 тэрбум төгрөгийн урсгал зардлын өсөлтийн 697 тэрбум нь цалингийн зардалд зарцуулагдахаар байгаа нь одоогийн өндөр инфляцыг улам хөөрөгдөх магадлалтай байна гээд олон зүйлийг давтаад "энэ алдаагаа давтахгүй байх шаардлагатай" гэдэг дүгнэлт байж байна шүү дээ. Танай дүгнэлтийн 3 дахь хуудас.

Дараа нь та "энэ зардлын эх үүсвэрийг ийм зүйлд зарцуулаад байна" гэдэг дээр би тэр нийслэлийн бондыг хэлье. Төсвийн танилцуулгын, тодотголын танилцуулгад дурдсанаар 1.4 их наядын зардлыг танаж цалин, тэтгэвэр зэрэг ийм зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ хэмнэлтийн 52.6 хувь нь бондын эх үүсвэр байна гээд та дүгнээ шүү дээ. Тэр уул уурхайн салбарын уналт гэдгийг би дахиад хэлээд өгье. Хуудас 5. "Эдгээр компаниудын төсөвт төвлөрүүлэх орлогыг тэлж байгаа нь уул уурхайн салбарын уналт бий болсон тохиолдолд төсвийн орлого дутах ийм эрсдэлийг үүсгэж байна" гээд дүгнэхээд байна шүү дээ, би яг таны.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулах уу? 3 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Сая би хариултдаа яг л наадхыг чинь л уг нь хэлсэн л дээ. Инфляцыг энэ нийт урсгал зардал 1,05-аар нэмэгдэж байгаагийн 700 орчим нь цалин, тэтгэвэрт очих юм байна. Энэ одоогийн инфляцыг өдөөх нөлөөтэй. Эсрэг талд нь ЗГ-аас санал болгож байгаа тэнцвэржүүлэх, нийлүүлэлтийн талыг дэмжих бодлогоо цаг хугацаа алдалгүй хэрэгжүүлэхгүй бол инфляцад нөлөөтэй гэсэн энэ давхар тайлбартай байгаа. Харин түрүүнийхийг тодруулахад яг таны хэлсэн зүйл дээр сая тод харагдаж байна. Уул уурхайн салбарын уналт ирэх юм бол өнөөдрийн энэ бодлогоос шалтгаалаад гэсэн сая таны уншсанаар хариулъя. Уул уурхайн салбарын уналт хэзээ нэгэн цагт ирээдүйд тохиох юм бол гэдэг агуулгаар өнөөдрийн энэ бодлого маань уул уурхайн салбараас илүү их хамааралтай төсвийн орлогын бодлого болж байна шүү гэдэг ийм л дүгнэлтийг хэлсэн.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүн нэмж асууя.

Д.Үүрийнтуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт гэдэг УИХ-ын гишүүдийг хамгийн сайн мэдээллээр хангах ёстой дүгнэлт байх ёстой болохоос биш судалгаа, тооцоогүй шүүмжлэл байж болохгүй гэдгийг би дахин хэлье.

ТӨК-уудын асуудлыг сая ярихад би Батнайрамдал гишүүний хэлсэн "Тэр ил тод байдлыг хангах зохицуулалт байхгүй" гэдэг дээр нэг зүйлийг тайлбарлаж хэлэх шаардлага байна. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийн 7.5-аас 7.7 дахь заалт дээр бүр тодорхой заагаад өгчихсөн байгаа. Энэ хууль батлагдчихсан шүү дээ, 9 дүгээр сарын 4-ний өдрийн энэ төрийн мэдээлэл дээр гарчихсан байна. Энэ дээр ЗГ нэгтгээд ТӨК-уудын мэдээллийг жилд нэг удаа УИХ-д тайлагнадаг болчихсон. Бид хуулиа баталчихсан, тэгэхээр энэ хуулиараа явчихад боломжтой. Харин байгалийн нөөцийн ашиглалтын ил тод байдлыг сайжруулах асуудлыг стратегийн гэж хуваахгүйгээр бид бүх нөөц дээрээ энэ ил тод байдлыг хангах Уянга гишүүний маань санаачлаад явж байгаа, Мөнхсоёл гишүүн мөн Жаргалан гишүүний хамтраад боловсруулж байгаа энэ хуулийн төсөл дээр бид дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлье.

С.Бямбацогт: Үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. 2026 оны төсвийн хүрээ өөрчлөгдөх гэж байна, 2027, 2028 оны төсөөлөлдөө өөрчлөлт оруулах гэж байна. Эдгээр асуудлууд энэ төсвийн тодотголтой холбогдолтой холбоотой оруулж ирж байгаа. Тэгэхээр тодотгол ярих давхардаад л орох байх. Тэгээд үүний өмнө хэд гурван зүйлийг хэлэхгүй болохгүй байна.

Улс орон даяар энэ худалдаа, үйлчилгээний салбарт ер нь энэ цус эргэхээ больсон. Энэ салбар маш их хүнд байдалтай, борлуулалт байхгүй болсон. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайлан дээр ч гэсэн энийг бичсэн л байна. Ерөнхий сайдын үгэнд ч гэсэн гарч байна. Дэлгүүрүүд орлогогүй болсон, зах дээр хүнгүй болсон, жижиг цайны газрууд, кофе шоп /coffee shop/ хүнгүй болсон. Энэ юу хэлж байна гэхээр нөгөө худалдааны салбар эргэлтгүй. Тэгэхээр учир нь юу гэхээр хүмүүсийн гар дээр мөнгө багассан байна, эдийн засагт мөнгө алга байгаатай л холбоотой. Суман дээр хөдөөгөөс орж ирж гайгүй худалдан авалт хийдэг хүнээ "Манай дэлгүүрээр оруулаач" гэдэг зүйл яригдаж эхэлсэн. Энэ бол урьд нь тийм юм сонсогдож байгаагүй. "Танай хамаатан чинь гайгүй худалдан авалт хийдэг, манайхаар оруулаад нэг юм авхуулаач" гээд дэлгүүрүүд нь ярьдаг болсон. Энэ худалдаа, үйлчилгээний салбарын эргэлт байхгүй болсонтой холбоотой. Тэгэхээр энэ дээр энэ улсын төсвийн тодотгол нэмэр өгнө гэж ярьж байна, нэмэр өгөх байх гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Үнийн өсөлт замбараагаа алдаж байна шүү дээ. Үнэ үнэхээр тамтаггүй өсөж байгаа. Яагаад худалдааны салбарын эргэлт байхгүй гэдэг чинь нөгөө талаасаа энэ өндөр үнэтэй юмыг авч чадахгүй байна, үүнтэй энэ худалдааны салбарын уналт чинь холбогдож байгаа. Би инфляц /inflation/ дээр инфляцыг дахин, дахин ярилаа гээд байдаг дээр санал нэгдэхгүй байна. Инфляцыг ярихаас өөр арга байхгүй. Энэ ойрд сонсогдоогүй л инфляц шүү дээ, 13 хувь. Тэгээд энэ инфляц чинь бага, дунд орлоготой иргэд, анхан шат руу очихоороо хоёроос гурван дахин нэмэгдээд очдог байхгүй юу. Энд л 13 хувь гэсэн тоо яригдаж байгаа боловч энэ чинь бараг 30 хувь болоод л очихдог. Тэгэхээр нөгөө жаахан нэмж байгаа цалин, тэтгэвэр, янз бүрийн юмыг чинь энэ инфляц гээд энэ чимээгүй хулгайч чинь буцаагаад л хулгайлаад аваад гарчихна. Тэгэхээр инфляцаа барьдаг газруудад нь, шийдвэр гаргадаг газрууд нь ярихаас өөр арга байхгүй. Тэгээд нөгөө муу бол нөгөө муу махны үнэ, төмс, хүнсний ногооны үнэ, үнэн л дээ, энэ инфляцад нөлөөлж байна л гээд байна. Одоо энэ бензин, шатахууны үнэ инфляцад нөлөөлөх үү? Энэ дээр нэг яг холбогдох хүмүүс нь хэлээдхээч, энэ үнүүд чинь бүр зарим нь даблдаад /double/ шахуу өсөж байна шүү дээ. Тэгэхээр энэ бензин шатахууны үнэ энэ инфляцад нөлөөлөх үү гэдэг нэг асуулт.

2 дугаарт, энэ 998 тэрбумаар оруулж ирж байгаа. Энэ дээр нөгөө тодорхой хэлбэл энэ эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнуудын тэр нөгөө дутуу тооцоолсон төсөв. Би энийг гайхаад байна. Энэ 998-ыг нөхөж цалин цавуу олгох гэж байгаа юу гэдэг зүйлийг Сангийн яамныхнаас асуумаар байна. Яагаад гэхээр 1 дүгээр сараас 5 дугаар сарын 1 хүртэл боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтан нэмэгдэл аваагүй шүү дээ, нэмэгдэл цалин. Тэгэхээр энэ өсөлтийг үлдсэн хугацаанд нь өгөөд дахиад дутчихаад байгаа юм уу? Ямар учиртай мөнгө юм бэ? Энийг нэг Сангийн яам нэг тайлбарлаад өгөөч. Түрүүн Ерөнхий сайдын үгэнд гарсан ТӨК-удын тэр нэг хувийн борлуулалтын орлого, борлуулалтын орлогын нэг хувийг гаргадаг энэ зүйлийг зогсоосон гэж хэлчхэв үү, би эсхүл буруу сонсов уу? Энэ 3 дээр нэг хариулт авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тэр төрийн өмчит уул уурхайн компаниудын татварын нэг хувийг нөгөө буцааж олгодог тэр заалтыг Төсвийн хуульдаа дагалдуулаад өргөн мэдүүлсэн. Их Хурал хэрвээ баталбал төрийн өмчит уул уурхайн компаниудын татварын нэг хувиар янз бүрийн нөгөө төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдгийг зогсоох

ёстой. Тэгж байж энэ татварын орлого чинь 180, 190 тэрбумаар нэмэгдэх юм байна лээ. Тэрнээс биш би тийм арга барилтай нийцэж ажиллаж чадахгүй юм байна лээ. Татварын нэг хувиар юу хийх вэ дарга гээд ингээд компаниуд асуухаар "Би тойргийнхоо сургуулийг янзлаад өгье" гэлтэй биш. Тэгээд тэр бол дэмий юм, хувийн хэвшил татварын нэг хувийнхаа буцаалтаар ажлаа хийх нь илүү шударга гэж үзэж байгаа юм.

Инфляц энэ үнийн өсөлт бол үнэхээр толгойны өвчин байгаа. 13 хувь хүрнэ гэдэг түүний 7 нь өөрөө, энэ чинь нийлүүлэлтийн гаралтай, тэр дотроо 5 нь мах, нэг хувь нь шатахуун, нэг хувь нь хүнсний ногоо, тэр дотроо төмс байхгүй юу. Тэгэхээр бид эхлээд энэ инфляц өдөөгөөд байгаа бараа, бүтээгдэхүүнүүд дээр арга хэмжээ авах ёстой гэдэг утгаараа манай ЗГ тэр и-баримт тийм системийг нь хөгжүүлсэн. Жишээ нь, стратегийн нөөц бүрдүүлээд мах нөөцөллөө гээд иргэдэд яг тэр их хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хамрагдсан компаниуд яг мах нөөцөлж байна уу гэдгийг хянаж чаддаггүй. Тийм учраас өнгөрсөн жил 5 мянган тонн, тэрний 2500 нь яг очсон юм байна, бусад нь яасан юм мэдэгдэхгүй зээл авдаг, өөр юманд зарцуулчихдаг гэдэг ийм л хардлага, шүүмжлэл дотор байгаад байгаа юм. Тийм учраас эхлээд системийг нь хийж авсан, системийг нь хийнэ гэдэг бүх процессыг ил тод болгож байгаа.

Нэг ёсондоо мах зарах гэж байгаа малчин иргэн хүрч ирээд махаа тэр агуулахад нийлүүлэхэд тэр агуулахыг эзэмшиж байгаа компаниуд дээр нь зээлийн шугам үүсгээд, түүн дээр нь шууд санхүүжилт нь компанид орохоор тэр хүн мөнгөө аваад л буцах, яг тэр нөөцөлж байгаа мах нь зах зээл рүүгээ очих ёстой. Тийм учраас төсвийн тодотгол дээр 20 мянган тонн мах нөөцлөх зардлын шийдээд оруулж ирсэн. Анх удаа бид ногоо нөөцлөх гэж байна, 12 мянган тонн ногоо. Бензин, шатахуун дээр сая гэхэд манай ЗГ-ын үед 150 мянган м3 сав баригдаж дуусаж байна. Энэ чинь 20 тэрбумын л хөнгөлөлттэй зээл дээр дэмжлэг үзүүлээд л явсан ажил, энийгээ үргэлжлүүлнэ. Ингээд 300 мянган тонн хүргэнэ. Улаан буудайн дээр, гурилын үнийг энэ цаг үеүдэд тогтвортой байлгахын тулд 100 мянган тонн улаан буудай, тэгээд систем хөгжүүлчихсэн учраас цогцоор нь энийгээ нөөцлөөд яг зах зээл рүү хүргэнэ. Ингээд хямд үед нь хуримтлуулаад, тэгээд үнийг тогтворжуулна. Мөн бид цаашдаа үнийг тогтворжуулахын тулд бол энэ агуулах, савууд барих ажил руу анхаарах хэрэгтэй учраас зоорь барих ажил дээр хөнгөлөлттэй.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Ерөнхий сайд, дараа нь Сангийн яам бэлдэж байгаарай.

Н.Учрал: Тэгэхээр нөөцүүдийн хөнгөлөлттэй зээлээр энэ зоорь барих ажлуудыг үргэлжлүүлнэ. Тийм учраас энэ төсвийн тодотгол дагуулаад тэр АХБ-ны санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг оруулж ирсэн. Энэ бол гамшгийн үеийн онцгой нөхцөл байдалд ямар, ямар зүйл дээр дэмжлэг үзүүлэх вэ? Тэгэхээр иргэдийнхээ орлогыг баталгаажуулах, энэ зах зээл дээр энэ инфляц өдөөгөөд байгаа махан дээр, ногоон дээр, гурилан дээр, энэ төмс дээр, түлш дээр арга хэмжээ авч байж, дээрээс нь давхар нөгөө иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлж байж, цалин хөлсийг нэмэгдүүлж байж, тэтгэврийг нэмэгдүүлж байж, нөгөө нэг ахмадуудын 769 мянгыг сая 77 мянган төгрөг хүргэж байж хүнд цаг үеийг хамтдаа давах байхгүй юу. Тийм учраас бүгд бүсээ чангалж байна гэсэн үг шүү дээ. ТӨК ногдол ашгийн хүүг хүнд үед битгий очоод тэнд дэмий хэрэгтэй, хэрэггүй юм хийгээд бай. Ногдол ашгаа өг, ард түмэнд нь хүртээ. Энэ ард түмний энэ экспортын орлого өсөж байгааг яагаад энэ өрхийн амьжиргаагаар оруулж ирэхгүй байгаа юм. Энийг хүртээ, ийм л бодлоготой.

С.Бямбацогт: Сангийн яам, Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Туваан гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсвийн төслийг батлахдаа Их Хурал багш, эмч нарын цалинг нэмнэ гэж явж байгаад яг батлахдаа "багш, ажилчдын цалинг нэмнэ" гэдэг тогтоол гаргасан. Ингэнгүүт төсөвт өртөг чинь хоёр дахин нэмэгдээд явчихсан. Төсвөөр 640-ийг шийдээд, зардал дотор нь багтаагаад явсан, цаана нь энэ дутагдаж байгаа 674.5-ыг шийдэхгүйгээр явчихсан байхгүй юу, эрүүл мэнд 90, боловсролын 674.5, эрүүл мэндийн 90-ийг. Тэгэхээр энэнийг бид зардлаа танаж гаргаж ирж байгаа юм. ЗГ зардлаа танаад тэр гаргасан орон зайн дээрээ энэ зардлыг нь нэмж өгч байгаа гэсэн үг. Түүнээс биш ЗГ цалин нэмж байгаа ойлголт огт биш. Баталчихсан Их Хурлын баталсан цалин нэмэх тогтоолыг л хэрэгжүүлэхийн тулд энэ тодотголыг хийж зардлаа танаж байгаа гэсэн үг. Инфляц дээр 7 дугаар сарын суурь инфляцаар 13 хувьтай гарсан, энэ шатах, тослох материал буюу бензин 92, 95 гэдэг бензин чинь 1.2 хувийг нь инфляцад эзэлж байгаа.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

3.Мэндсайхан: Инфляцын 13 хувийн 50 хувь нь буюу 6.5-ыг нь манай дотоодын хүнсний бүтээгдэхүүн эзэлж байгаа юм. Тийм учраас ЗГ тодотголоор энэ өөрсдийнхөө удирдаж болох инфляц буюу энэ дээрээ нөөц бүрдүүлж, хүнсний ногоо, улаан буудай, тэгээд шатах, тослох материалаа нөөцлөх сав, түүний татаасыг дэмжье гэдэг зорилгоор 150 тэрбум төгрөгийн татаасыг тодотголоор төсөвлөж оруулж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: ЗГ мэдээж орлого багатай иргэдийнхээ эдийн засгийн хамгаалалт хийх нь зөв. Нэг л юм хүсье. Нөгөө талд чинь яг малаа зарж амьдарч байгаа, малаа зарж хүүхдийн сургалтын төлбөрөө төлж байгаа сумын төвийн тэндээ нэг мал бүхий иргэн, тэгээд тэндээсээ нөгөө нэг мал дээр байгаа хэдээсээ махыг нь авчирч борлуулаад мөнгө олж байгаа хэдийнхээ халаас руу нь, орлого руу нь гар дүрнэ шүү дээ. Энийгээ манай хэд яг энэ ганцхан махыг онилж, төмс, хүнсний ногоог онилж явж байгаад энэнийхээ үнийг унагаагаад нөгөө нөхдүүд чинь дахиад орлогогүй болоод хэцүүднэ шүү дээ. Ер нь бүх юм чинь хоёр талтай учраас тэрийг яг энэ төсөв яригдаж байгаа, тодотгол яригдаж байгаа энэ үед бодож үзээрэй. Тэр стратегийн нөөцүүдээ мэдээж бүрдүүлээд, шаардлагатай үед нь тэр вэрхаус файнансинг /warehouse financing/ байдлаараа ингээд санхүүжүүлээд явах нь зөв гэсэн ийм зүйл байна. 1-ээс 5 дугаар сар дээр цалингийн нэмэгдэл аваагүй шүү.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя. Энхбаяр сайд хариулъя, Эдийн засгийн хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Яг худалдаа, үйлчилгээний салбарын эрэлт сулраад байгаа нь үнэн. Нөгөө талаас өрхийн бодит орлого инфляцтай холбоотойгоор агшиж байгаа. Тэгэхээр бидэнд нөхцөл байдлыг нийгэмдээ, ард түмэндээ үнэнээр нь хэлэх ёстой байгаа юм. Дэлхийн ертөнц, гадаад орчинд гарч байгаа энэ хямралт байдал Монголын эдийн засагт бүх талаар тусгалаа, нөлөөллөө үзүүлж байна. Бид шатахуунаа 100 хувь импортоор авч байна. Тодорхой хэмжээний эрчим хүчээ гаднаас авч байна, бидний үйлдвэрлэх чадавх сул байна. Голцуу түүхий эдийн

экспорт дээр эдийн засгийнхаа гол орлогоо бүрдүүлж байна. Энд л бид бодлогын том өөрчлөлтүүдээ цаашдаа хийх шаардлагатай. Ер нь үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээгээр хол явахгүй, үйлдвэрлэл, энэ уул уурхайн экспортод нэмүү өртгөө дахин боловсруулалтдаа анхаарах, энэ экспортоо саад тотгоруудыг арилгах, энэ худалдаанд гарч байгаа хүнд суртлыг арилгах, хөрөнгө оруулалт.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хөрөнгө оруулалтад их таатай болох хэрэгтэй. ЗГ-ын хэрэгжүүлж байгаа, энэ оруулж ирж байгаа энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, энэ Зөвшөөрлийн хууль, Хөрөнгө оруулалтын хуулиуд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, гаднаас хөрөнгө оруулж байж, нэмүү өртөг үйлдвэрлэж байж бид энэ эдийн засгаа л тэнцвэржүүлнэ үү гэхээс биш, ер нь цаашдаа энэ уул уурхайгаас хэт хамааралтай тогтвортой бус орлого дээр энэ тогтмол зардлыг хуульчлан ингээд эрс нэмээд байгаа байдал манай эдийн засгийн аюулгүй байдлын хувьд жаахан эмзэг байдлыг л нэмж байна гэсэн үг. Энийгээ л бага багаар бүгдээрээ зөөлрүүлээд л, засаад л гарах хэрэгтэй. Яах аргагүй олон улсын нөхцөл байдал хүнд байна, аль болох хохирол багатайгаар даван туулах хариу арга хэмжээнүүдийг ЗГ-аас авч байна. Энэ төсвийн бүх зүйл үндсэндээ иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, мөнгөний нийлүүлэлтийг нэмж, энэ худалдаа, үйлчилгээг идэвхжүүлэх чиглэл рүү л явж байгаа. Хэрэгжиж байсан энэ хүнсний үйлдвэрлэл, хүнсний хангамжийн бүх бодлогууд үргэлжилнэ.

С.Бямбацогт: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Махны үнэ дээр болбол тэгж хүчээр барина гэж байхгүй, махыг. Тэгэхээр махан дээр бол нэгд, зүгээр бүртгэлжүүлэлт, тэр үйл явцыг нь цахимжуулаад, ингээд ил тод болгоод, бид нарын нөөцөлж байгаа мах тэр зах зээлдээ хүрэх. Тэрнээс биш 20 мянган тонн нөөцөллөө гээд хэрэгцээг хангахгүй шүү дээ. Энэ чинь яг үнэндээ бол үнэ тогтворжуулахад л хэрэглэж байгаа механизм. Тэрнээс биш махны үнэ дээр тэгж хүчээр бариад, үнэ буулгаад явах тийм зах зээлийн нийгэмд тийм боломж байхгүй. Бага орлоготой иргэд рүүгээ илүү чиглэсэн, зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн л арга хэмжээ шүү дээ. Тэрнээс биш стратегийн нөөцийг бүгдийг нь бүрдүүлж чадахгүй. Түрүүн хэлээд байсан багш, эмч нарын цалин дээр манай засаг байгуулагдахад 1 дүгээр сараас 5 дугаар сард бол багш, эмчийн цалинг 2025 оны цалингаас нь бодоод нэмэгдлийг нь тооцчихсон байсан. Тэгээд хоёр цалинтай энийг нь бид нэг тогтоолтой болгоод нэмэгдсэн, хувь хэмжээ нь нэмэгдсэн дээр нь нэмэгдлийг нь тооцдог болгосон. Тэгэхээр энэ тодотгол бол нэмэгдэл хөлс, хувь хэмжээ бүгдийг нь шийдэж оруулж ирнэ.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя. Алга байна, асууя.

М.Мандхай: Төсвийн тодотголтой холбоотойгоор, төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой нэг асуулт асууя. Энэ ЗГ-ын танилцуулгаар суурь тэтгэврийн жилийн шаардагдах төсвийг 1.2 их наяд төгрөг байхаар тусгасан. Цалингийн арга хэмжээг хэрэв бид жилээр тооцох юм бол бараг их наядын хэмжээний мөнгө шаардагдахаар байна. Тэгэхээр хоёр шийдвэр үндсэндээ энэ 2027 оны өсөлтийн боломжийн 85-аас 90 хувийг бараг залгихаар ийм тооцоо харагдаж байгаа. Тэгэхээр энэ үлдэж байгаа 300 орчим тэрбум төгрөг бусад бүх салбарын тэр инфляц, шинэ хөрөнгө оруулалт, өвөлжилтийн бэлтгэл гээд энэ зэрэгт яаж багтах

вэ, хэрхэн багтах вэ? Энэ тооцоог төсвийн хүрээний мэдэгдэлд хэрхэн тусгаж байгаа вэ гэдэг асуултыг асууя?

Орон нутгийн үлдэгдэл гээд энд нэг айхтар тоо байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулга дээр орон нутгийн энэ урьд оны үлдэгдэл 3 жилийн хугацаанд 2.3 их наядаар өссөн байна, энэ нь өөрөө 2.8 их наядад хүрсэн байгаа. Тэгэхээр энэ хуримтлал ер нь яагаад үүссэн бэ? Орлого ер нь хэт өсчхөв үү, эсвэл энэ зардал зарцуулах чадвар нь дутагдчихав уу, заримдаа гүйцэтгэл ер нь хангалтгүй яваад байсны хор нь гарч байгаа юм уу? Энэ дээр нэг тайлбар өгөөч.

С.Бямбацогт: Сангийн сайд Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2026 оны төсвийн тодотгол батлагдсан төсвийн хүрээнээс давсан зүйл байхгүй. Батлагдсан төсвийн хүрээний хэмжээ нь буюу 31.9-ийн орлоготой, 32.9-ийн зарлагатай төсөв 2026 онд баталсан. Энэ хүрээндээ бид зардлаа 1.4 их наядаар бууруулаад, энэ гаргасан орон зайн дээрээ эдгээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр оруулж ирж байгаа. Таны асууж байгаа тэр 988-г яагаад оруулж ирэв гэхээр энэ орон нутгийн алдагдал буюу ер нь товчхондоо хэлэхэд нийслэлийн алдагдал явж байгаа юм. Төсвийн тухай хууль дээрээ "Орон нутгийн төсөв алдагдалгүй байна" гэсэн нэг заалттай, нөгөө заалт нь юу вэ гэхээр зэрэг "Өмнөх онд санхүүжүүлж чадаагүй дүнгээр нэмэгдүүлж болно" гэсэн заалттай юм байгаа юм. Тэгээд энүүгээр нь нийслэл маань төсвөө өсгөөд яваад байдаг, зардлаа өсгөөд яваад байдаг. Энэ нь нэгдсэн төсвийн алдагдлыг тэр чигээр нь эзлээд байгаа юм. Тэгэхээр улсын төсөв алдагдлаа хийж чадахгүй. Ийм байдлаар нийслэл дээр ямар асуудал гардаг вэ гэхээр оны эцэс рүү Сангийн яам улсын төсвийнхөө алдагдлыг барихын тулд нийслэлийн мөнгө нь байгаад байгаа ч гэсэн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг хязгаарлаж эхэлдэг.

Тэгээд энэ хуримтлагдсан зардал чинь явсаар байгаад 2.8 болчихсон байгаа, их наяд болчихсон байгаа. Тэгэхээр энийг төсвийн хариуцлага, сахилга батыг тодорхой болгох энэ зардлыг Их Хурал өөрөө баталж өгдөг болохгүй бол Их Хурал төсвөө баталсны дараа орон нутаг буюу Иргэдийн хурлууд маань төсвөө батлахдаа хязгаараас давуулаад баталчхаж байгаа юм. Тэрний хамгийн тод жишээ нь нийслэл дээр болсон. Тийм учраас 2.8 их наядын энэ зардлын 1 их наядыг нь төсвийн хүрээнд өөрчлөлт орсноороо алдагдлын хэмжээ нь 1 их наядаар нэмэгдэж байгаа, энэ орон зай дээр нь нийслэлийн өмнө хуримтлагдсан байгаа, санхүүжүүлж чадаагүй 1 их наядыг санхүүжүүлж өгөх тэр боломжийг нь нийслэлд гаргаж өгч байгаа ийм л зохицуулалт юм байгаа юм. Түүнээс биш нийт орлого, зарлагад өөрчлөлт ороод байгаа асуудал байхгүй.

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Тэгэхээр энэ нийслэлийн дийлэнх нь нийслэлийн өр гэлээ. Тэгэхээр энэ 998 буюу энэ их наяд орчим төгрөгийг нээгээд цаана нь 1.8 их наяд төгрөгийн үлдэгдэл байна. Тэгэхээр энэ үлдсэн хэсгийг нь яг ямар журмаар ер нь нээх юм бэ? Дараагийн жилүүдийн төсөвт яаж ер нь тусгах ийм төлөвлөгөө байгаа вэ? Ялангуяа тэр бусад гээд мөрөнд нь бараг 4 их наяд орчим төгрөг буюу ДНБ-ий 3.9 хувьтай тэнцэхүйц хэмжээний мөнгө харагдаж байна. Тэгэхээр энэ үлдэгдэлтэй ер нь холбоотой мөнгө үү, эсвэл өөр ийм хөрөнгийн зардал харагдаж байна уу?

Энэний задаргааг нь гаргаж өгч болох уу? Орон нутгийн хөрөнгийн зардлын бусад хэсэг дээр.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Сангийн яам индрийн 4 дүгээр микрофон. Санжаадорж дарга хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Урьд оны үлдэгдэл бол үүсээд байгаа шалтгаан нь түрүүн тайлбарлачихсан. Одоо бол нийт үүсчихсэн байгаа нь 2.8 их наяд төгрөг байгаа, эндээс бид 1 их наядыг нь энэ удаа оруулж ирж байгаа. Тэгээд ирэх оны төсөв бол хэлэлцэгдэж эхлэхээр ирэх оны төсөв дээр бид дагаж байгаа тогтоол оруулж ирж байгаа. Энэ тогтоол дээр бол ер нь GPS 2014 рүүгээ бид шилжье гэдэг ийм амлалтаа, үүргээ бол Их Хурлаас авч байгаа, тэгэхдээ GPS 2014 нь өөрөө төсвийн хуулиа шинэчлэх тийм агуулга бүхэлдээ орж ирэх ёстой юм. Тэгэхээр төсвийн хууль маань өөрөө бараг 2 жил ингээд бичигдээд, 2 жилийн бэлтгэл хангаад, ингээд маш том ажил болох учраас тэн дээр бол энэ орон нутгийн урд оны үлдэгдлийн асуудлыг бол бид цогц байдлаар нь шийдэх асуудал нь орж ирнэ. Одоо бол энэ 1 их наядаар орж ирсэн шалтгаан нь угаасаа нөгөө нийт зарлагын хэмжээ болон алдагдлын хэмжээндээ хязгаарлагдаад л 1 их наяд нь орж ирэх.../минут дуусав/

С.Бямбацогт: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Эхлээд нэг санамж хэлнэ. Дараа нь Үндсэн хуулийн заалт сануулъя гэж бодож байна. Сая Энхбаяр сайд хэлж байна л даа, Жадамбын Энхбаяр сайд. Бид ард түмэндээ үнэнээ хэлэх хэрэгтэй гэнэ. Та бүхэн маань сонгуульд орохдоо аягүй гоё үнэнээ хэлмээр байна. Сонгуулиар баахан гоё амлалт хэлж шуруулж оруулаад, тэгээд яг ажлаа хийх болохоороо "болохгүй, байхгүй, бүтэхгүй" гээд ингээд тоочдогоо болимоор байна. Ийм нэг санамж хэлье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "ЗГ төрийн хуулийг биелүүлж аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 38.2.2-т "шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж УИХ-д өргөж, гарсан шийдвэрийг биелүүлнэ" гэж байгаа юм. 41.1-д "Ерөнхий сайд ЗГ-ыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна" гэж байгаа юм Үндсэн хууль дээр. 41.2-т "ЗГ үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана" гэж маш тодорхой заасан байгаа. Товчхондоо УИХ шийдвэр гаргана, ЗГ хэрэгжүүлнэ. Ерөөсөө л энэ шүү дээ.

Ерөнхий сайд хэрэгжилтийг УИХ-ын өмнө хариуцна, ЗГ Их Хуралд тайлагнана гэсэн ийм товчхон юм байж байгаа шүү дээ хууль дээр, Үндсэн хууль дээр. Гэтэл манай засаг нь бараг энэ Их Хурлынхаа дээр гараад суучихсан юм шиг байгаад байгаа байхгүй юу, яг үнэндээ. Ерөнхий сайдаас асуулт, УИХ 2020 оны 21 дүгээр тогтоолоор зээлийн хүүг батлах стратегийг батлахдаа зээлийн хүүг 2019 оны түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувь буюу жилийн 12 хувь орчим хүргэх тодорхой зорилт тавиад, хэрэгжилтийг ЗГ, Монголбанк, СЗХ-нд даалгасан. Гэтэл өнөөдөр иргэд, ААН-үүд жилийн 12 хувийн зээл бодитоор авч чадахгүй, өндөр хүүгийн дарамт нь хэвээрээ байна. Тэгэхээр УИХ-ын тогтоолоор өгсөн энэ зээлийн хүүг 1 хувьд хүргэх зорилт яагаад биелүүлээгүй юм бол, үүний хариуцлагыг хэн хүлээх вэ? Хамгийн гол нь танай ЗГ иргэдийн төлж байгаа зээлийн

бодит хүүг хэзээ, хэдэн хувь хүртэл бууруулах боломжтой байгаа вэ гэдгийг Учрал сайдаас асууя 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. УИХ-ын 109 дүгээр тогтоолоор Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг батлахдаа 2026 онд багшийн үндсэн цалинг 2.8 сая төгрөгөөс доошгүй байхаар баталсан. Гэтэл энэ тодотголоор боловсролын салбарт нэмж байгаа 674.5 тэрбум төгрөг өмнө нь шийдвэрлэсэн цалингийн өсөлтийн дутуу санхүүжилт гэж танилцуулсан. Өөрөөр хэлбэл энэ мөнгөн дүн одоо авч байгаа 2.2 сая төгрөг дээрээ нэмэгдэл, нэмэгдэл хөлсөө тооцоод явахад л энэ оныг дуусах мөнгө, 2.8 сая төгрөгт хүргэх мөнгө суугаагүй гэсэн үг. Багшийн үндсэн цалин 2026 онд 2.8 сая төгрөгөөс доошгүй болгож, цаашид улсын дундаж нэрлэсэн цалингаас доошгүй түвшинд байлгах зорилт батлагдчихсан байгаа улсын хөгжлийн төлөвлөгөөнд. Тэгтэл 2026 оны улсын дундаж нэрлэсэн цалин хэд байхаар тооцож байгаа вэ? Түүнд үндэслээд 2027 онд багшийн үндсэн цалин хамгийн багадаа хэдэн төгрөг болох вэ? Хамгийн гол нь энэ уялдааг жил бүр багш нар жагсаж, цуглаж цалингаа нэмүүлдэг биш, энэ улсын дундаж нэрлэсэн цалин өсөхөд багшийн цалин дагаж шинэчлэгддэг тогтолцоог ЗГ бий болгох уу? Ийм хоёр асуулт байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Хязгааргүй хэрэгцээг энэ хязгаарлагдмал нөөцөөр бүрэн хангаж, хүн бүрийг сэтгэл ханамжтай байлгана гэдэг хүнд. Гэхдээ ЗГ хүндээ хандсан төсөв оруулж ирэх гэж бүх талаар хичээсэн. Та сая надаас энэ зээлийн хүү, энэ Монголбанкны чиг үүрэгтэй холбоотой асуудлыг яриад байх шиг байна. Би мэдээж бодлогын хүү зарладаг эрхтэй субъект биш. Монголбанк шиг би тэр банкнуудын өр, орлогын харьцаа энэ тэрийг, хувь хэмжээг нь тогтоодог тийм эрх хэмжээ надад байхгүй. Монголбанк эрэлтийн гаралтай нийлүүлэлтийнхээ инфляцыг удирдах хэрэгтэй, мэдээж тэр хуулиар олгогдсон чиг үүрэг, би үүрэг өгөх ч эрхгүй хүн.

Гэхдээ ЗГ Монголбанкны үйл ажиллагаанд оролцож, янз бүрийн хөтөлбөр хэрэгжүүлж, мөнгө төгрөг хэвлэж, принтерлэх ийм бусармаг зүйлтэй бид эвлэхгүй, нэгдэхгүй. Тийм ч учраас энэ оны төсөв дээр энэ олоод байгаа орлого чинь принтерлэсэн, хувилсан мөнгө төгрөг огт биш. Энийг тэр ТӨК-ийн ногдол ашиг, ОТ-гоос орж ирэх гэж байгаа ногдол ашиг гээд ирэх оны төсөв дээр тавьсан, илүү төсвийн сахилга батыг нэмэгдүүлэх гэж байгаа. Тийм учраас Монголбанкийг ийм ажиллагаанд би оролцуулахгүй, ард түмнийгээ ирэх он жилүүдэд ийм хүнд ачааг битгий үүрээсэй. Тийм учраас Монголбанктай харин ямар хэлбэрээр ажиллах вэ гэвэл би 16 мянган айлын ипотекийн орон сууц, тэрэн дээр таны ярьдаг багш, эмч салбаруудаар нь оруулах, ипотекийн 6 хувь, энэ дээр бид зөвхөн хөрөнгө босгоод свопын зардал дээр нь л хамтарч ажиллая гэж. Тэрнээс Монголбанкны үйл ажиллагаанд оролцохгүй, энэ бол хараат бус байгууллага, тэгэхээр энэ зарчмаараа явах нь зүйтэй гэж ингэж үзсэн.

Дээрээс нь ЗГ байгуулагдаад Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагалдуулаад Банкны хуульд өөрчлөлт оруулаад гаднын банк орж ирэх эрх зүйн орчин нээгдсэн. Түүнээс хойш хэд хэдэн банкнууд хүсэлт тавиад байна. Би банкны салбарт чөлөөт өрсөлдөөн бий болох ёстой гэж боддог, иргэд өөрөө хожих ёстой гэж боддог. Тийм ч учраас Монголбанк харин гаднын банк орж ирэхэд бодлогоор дэмжих ёстой шүү гэдэг саналыг би байнга хэлж байгаа юм гэдгийг хэлье. Эдийн засгаа идэвхжүүлнэ, зайлшгүй эдийн засгаа идэвхжүүлэх учраас ЗГ энэ ажлуудаа

хийж байгаа. Багшийн цалин дээр Мөнхтуяа гишүүнээ, та бид хоёр хоёулаа л багшид хайртай хүмүүс. Тэгэхдээ энэ бол бүх боломжоо дайчилж байгаа, ирэх жил 1.7 их наяд шүү дээ багш, эмчийн цалин чинь. Энэ төсвийн тодотголоор бид амласан, ярьсандаа хувь хэмжээ нь нэмэгдсэн дээрээ нэмэгдлийг нь тооцсон нэг цалинг бид яг олгож.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Ерөнхий сайд нэг минут.

Н.Учрал: Тэгээд энэ оныг ингээд дуусгана бид. Тэгэхээр тодотголоор энэ багшийн цалинг шийдэж байгаа. Тэрнээс биш багшийн цалин шийдчихээд бусад нөгөө нэг цаг уур, байгаль орчин, хөдөө аж ахуй, соёл, спорт гээд та нарынхыг нэмэхгүй, багшийг 75 хувь болгох ёстой гэвэл энэ чинь нэг улс. Тийм учраас 50 хувь гэдэг бол энэ оныг дуустал явахын тулд тодотголоо оруулж ирээд алдааг засаж байна л гэсэн үг. 1-ээс 5. Эмчийг ч гэсэн би 20 хувь нэмээд, багштайгаа ижилхэн 50, 50 дээрээ байгаад шударга байя л гэж байгаа юм. Бусад төрийн үйлчилгээний албан хаагч нарыг огт нэмээгүй байсныг нь нэмээд 50 хувьтай нь байлгая л гэж байгаа юм. Ирэх жилээс бүгдийг нь инфляцтай уялдуулж нэмээд явах нь, 4 дүгээр сарын 1-нээс нэмээд явах нь зарчмын хувьд зөв л гэж байгаа юм. Тэтгэврээ 1 дүгээр сарын 1-нээс нэмээд явъя гэж. Тэгэхээр бүгдээрээ энэ асуудал дээр нэлээн олон талаас нь бодоод, багш, эмчийн цалин дээрээ ийм олон хуулиар зохицуулагддаггүйгээр ийм зарчимтай явъя.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхтуяа гишүүн нэмж асууя.

Ц.Мөнхтуяа: 2020 онд УИХ-ын тогтоол гарсан юм байна, зээлийн хүүг бууруулах, тэгээд энийгээ хэрэгжүүлдэггүй юм уу л гэж асуугаад байгаа юм. 2020 онд чинь МАН төр барьж байсан тийм ээ, тэгээд энийг яагаад хийхгүй байна гэдгийг намайг хүмүүс асууж өг гээд байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт, багш нарын цалинг яг хэдэн төгрөгт хүргэх вэ гэдгийг тодорхой тоогоор хариулт авмаар байна. 2 сая 800 мянга хүргэнэ гээд ЗГ-ын 5 жилийн үндсэн чиглэлдээ оруулчихсан байгаа биз дээ, тэгээд энийгээ хийх юм уу, хийхгүй юм уу гэдгийг би асуугаад байгаа байхгүй юу? Та нар маань болохоор зүгээр нэг гөлөг төөрүүлсэн нэг иймэрхүү маягаар асуултад хариулаад л, тэгээд л дараа нь тэгээд нөгөө ярьсан юм байхгүй болдог байхгүй юу. Учрал сайдаа та яг тоо хэл.

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя, Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид цалин өсгөнө гэсэн амлалт доор хүрээд явж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Ингээд тодотголоор бид багш, эмч нарын цалинг нэгтгэсэн, манай ЗГ гарч ирээд хуучин үндсэн цалингаас нь нэмэлтийг нь бодоод, шинэ цалинг нь, суурь хувийг нь өсгөсөн гэдэг ийм юм явж байсныг нэмэгдсэн цалингаас нь урамшууллыг нь боддог болгоод 5 дугаар сарын 1-нээс энэ цалинг цэгцэлсэн. Зөрүүг нь бид тодотголоор зардлаа танаад шийдэж өгч байна. Он гарангуут бид, энэ оны эцэс гэхэд бүх төрийн албан хаагчийнхаа цалинг нэг түвшинд авчраад 4 дүгээр сарын 1-нээс эхлээд 10 хувиар дахиад нэмэх гэж байна инфляцтай уялдуулаад. Энэ чинь бид үе шаттай ингээд боломждоо нэмээд явж байгаа. Түүнээс биш сугалж аваад ганцхан багш нарыг ингэж шийднэ гэх асуудал биш. Ер нь цалин хөлс цаашдаа нэмэхдээ бид бүтээмж дээр нь суурилж нэмэх ёстой, энэ асуудлыг бид эргэж харах ёстой. Яг өнөөдрийн байдлаар хэд аваад явж байгааг нь та Боловсролын сайдаасаа илүү тодорхой

болгоод асуучих, ЗГ үе шаттайгаар цалин хөлсний бодлогоо хэрэгжүүлээд явж байгаа.

С.Бямбацогт: Хариултаа гүйцээчихье, Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Зээлийн хүүгийн асуудал дээр Монголбанк мэдээж сая инфляцтай уялдаатайгаар бодлогын хүүгээ нэмлээ. Гэлээ гээд бид эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг агшаахгүйн үүднээс ЗГ 2027 оны төсөв дээр хоёр асуудлыг оруулж ирж байгаа. 1 дүгээрт, олон улсын зах зээл дээрээс мөнгө босгоод, хөрөнгө, своп зардлыг нь ЗГ төсөвтөө авах замаар Төрийн банкаар дамжуулаад жилийн 10 хувийн хүүтэй бичил бизнесийг дэмжих зээлийг гаргая. Нийтдээ 1.1 их наядын санхүүжилттэй зээлийг гаргахаар бид төсөвлөөд оруулж ирсэн. Орон сууц дээр, эхний 3 жилд 6 хувийн хүүтэй, 4 дэх жилээсээ 12 хувийн хүүтэй ипотекийн зээлийг илүү хүртээмжтэй болгоё, 16 мянган айлын орон сууцны асуудлыг шийдье гэдэг байдлаар төсөвлөөд оруулж ирсэн. Ингээд бид банк, санхүүгийн салбар дээр зээлийн хүү бууруулах, зохистой түвшинд авчрах ажлуудыг бид ЗГ хийж байгаа. Та 2027 оны төсвийг хэлэлцэхээр энэ асуудал тодорхой болоод явах байх.

С.Бямбацогт: Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Төсвийн хүрээ ярьж байгаа энэ үед юуны түрүүнд энэ Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд баяр хүргэмээр байгаа юм. Шүүмжлэх зүйлээ шүүмжлээд яг хараат бусаар ингээд өөрсдийнхөө байр суурийг тогтмол илэрхийлээд явж байгаа энэ үйл ажиллагаанд. Миний асуулт их тодорхой. Монголбанкнаас асууя гэж бодсон юм. Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлд Монголбанкны үндсэн зорилт нь Монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино гээд заачихсан байгаа. Ингээд инфляц /inflation/ ярихаар төгрөг ярихаар Монголбанк нэг бодлогын хүүг нэмсэн, хассан гэдэг юм яриад болчихдог. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь макро эдийн засгийн түвшинд дандаа төсвийн бодлогоор бүгдийг шийдээд байх боломжгүй гэж хэлээд байхад зөвхөн энэ инфляцыг төсөвтэй холбодог. Монголбанк ямар үүрэг гүйцэтгэж байгаа, юу хийж байгаа гэдэг нь мэдэгддэггүй ийм байдалтай байна.

Энэ инфляц гээч юм чинь ард иргэдийн халааснаас хулгайлж байна амьдрахад нь улам хүнд болж байна. Энэ асуудлыг зөвхөн ЗГ-ын асуудал мэт хандаад байж болохгүй байна л даа. Энэ олон мянган айлын орон сууц гэдэг ч юм уу төсөл, хөтөлбөртэй холбоотой зүйлүүд ярьж байна. Үгүй ээ энэ төгрөгийнхөө тогтвортой байдлыг хангахын тулд юу хийгээд байгаа юм бэ? Ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Энийгээ ард иргэддээ нэг ойлгомжтой тайлбарлаад өгөөч. Аливаа нэг зүйлийн буруутан цорын ганц субъект байх ёсгүй шүү дээ. Монголбанк юу хийгээд байгаа юм бэ? Манай энэ Даваагийн Цогтбаатар гишүүний шүүмжлээд тэр томилгоонд нь шүүмжлээд энэ удам дамжлаа гээд шүүмжлээд байсан тэр томилогдсон хүмүүс юу хийж байна, тэр албан тушаалтнууд нь юу хийж байна, улс төрийн хариуцлага үүрэх юм уу, үүрэхгүй юм уу инфляцад? Та нарт хариуцлага хүлээдэг тогтолцоо гэж байна уу, үгүй юү? Ямар арга хэмжээ авч байна вэ? Энэ талаараа дэлгэрэнгүй хариулт өгөөч?

С.Бямбацогт: Монголбанк хариулъя 3 дугаар микрофон.

Г.Энхтайван: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Төв банкнаас ЗГ-тай харилцах харилцааг хуулиар нарийн зохицуулсан байдаг. Энэ хуулийн дагуу бид

бүхэн ЗГ зөвхөн зөвлөх үүрэгтэй оролцдог, төв банк мөнгөний бодлогынхоо хүрээнд эдийн засгийн зөвхөн эрэлтийн талыг зохицуулж явдаг. Эрэлтийн хамгийн сүүлийн инфляц 13 хувьтай байна гэж байна, 13 хувьтай инфляцын 8,7 хувь нь нийлүүлэлтийн гаралтай инфляц буюу бараа бүтээгдэхүүний тээвэр логиستيкийн асуудал хангалтын асуудлаас холбоотой байгаа. Төв банк он гарснаас хойш мөнгөний бодлогыг маш хатуу төлөвт барьж байгаа. Бодлогын хүүг 12 хувиас 12,5 хувь болгож нэмэгдүүлсэн, банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөг дээр 19,5 хувь, доллар дээр 14 хувьтай. Энэ заавал байлгах нөөцийн хэмжээг урьд хожид байгаагүйгээр чангаруулж байна нэг талаасаа.

Нөгөө талаасаа иргэд дээр өр, орлогын харьцааг бид бүхэн 45 хувь дээр барьж байна. Энэ олон улсын түвшинд ч тэр бүс нутгийн бидэнтэй ижил төстэй эдийн засагтай орнуудын хувьд ч гэсэн маш өндөр үр дүн. Энэ нь хэдийгээр бид бүхэн сүүлийн хэдэн жил тэр дундаа 23, 24 онуудад дараалсан тэр хэрэглээний зээлийн өсөлт 50 гаруй хувьтай байх үе дээр үүссэн эдийн засгийн халалтыг өөрсдийнхөө бодлогын арга хэмжээний хүрээнд татаж бууруулж байна. Эдийн засгийн энэ халалттай холбоотой хэрэглээний зээлийн өсөлт маань эргээд төлбөрийн тэнцэл гадаад валютын нөөцөд маш дарамттай байгаа. Тэгэхээр Төв банк өөрөө энэ дээр эрэлтийн талыг аль болохоор эрэлтийг бууруулах, эдийн засгийн халалтыг намжаах чиглэлд бодлогын төлөвөө хатуу түвшинд барьж байна.

Гэхдээ шууд эдийн засгийн өсөлт инфляц /inflation/ 2 хамааралтай, эдийн засгийн өсөлт энэ оны төгсгөлөөр 5,3 хувьтай байна. Эдийн засгийн өсөлт маань өөрөө нөгөө талдаа инфляцыг үйлдвэрлэдэг, ажил хийхэд халалт үүсдэг шүү дээ. Түүнтэй адилхан эдийн засгийн өсөлт маань өөрөө инфляцыг үйлдвэрлэдэг. Яг бидний олон жилийн судалгааны үндсэн дээр Монгол Улсын эдийн засаг инфляц нэг ойролцоогоор 6-аас 8 орчим хувьтай эдийн засгийн өсөлт 6 орчим хувийн өсөлттэй байх нь хамгийн зохистой юм гэж үзэж байгаа. Тэгээд Төв банк 27 оны 2 дугаар улирлын дундаас эхлээд эдийн засгийн өсөлт болон энэ инфляцыг Төв банкны энэ бодлогын зорилтот түвшинд шийдээд явна гэж байгаа юм. Инфляцын зорилт маань өөрөө дунд хугацааны бодлогын зорилт байдаг. Энэ хугацаанд дунд хугацаандаа энийг тогтворжуулах бодлогын хүрээнд төв банкны мөнгөний бодлого чангаруулаад явдаг. Учиргүй инфляцыг яаж бууруулах юм бэ гэхээр бүгдийг хааж нам доор гацааж байж л бууруулна шүү дээ. Инфляцыг эдийн засгийн өсөлтийг гацааж байж нам доор түвшинд барьж байж эдийн засгийг идэвхгүй болгож байж л буурна. Гэхдээ эдийн засгийг ингэх нь маш хортой өртөгтэй байдаг учраас Төв банк энэ дээр балансыг нь олж ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Алтангэрэл гишүүн тодруулж асууя.

О.Алтангэрэл: Тэгвэл үндсэндээ бид ойлгоод байна л даа. Төв банкнаас бүх зүйл шалтгаалахгүй гэдгийг. Тэгвэл шалтгаалж байгаа хэсэг дээрээ хариуцлага хүлээх юм уу, шалтгаалж байгаа хэсэг дээрээ хэн нэгэн хүн хариуцлага хүлээх юм уу? Маш тодорхой асуулт. Та бүхэн дотроо энэ асуудлыг ярьдаг юм уу? Энэ асуудал дээр Монголбанк хариуцлага хүлээх юм уу? Энэ ард иргэдийн амьдрал өдрөөс өдөрт хүндрээд байхад бид ингээд баахан шалтаг, шалтгаан хэлээд юу нь мэдэгддэггүй байж болохгүй шүү дээ. Заавал нэг үр дүнтэй байх ёстой, хууль тогтоомж чинь болдоггүй юм бол энэ хуулиасаа энэ Монголбанкныхаа зорилтыг тэгвэл авч хая л даа. Хууль тогтоомждоо өөрчлөлт оруул л даа, саналаа хэл л дээ. Тэгээд энэ дээр хариуцлага хүлээх юм уу, хэн хариуцлага хүлээх юм бэ гэдэг маш тодорхой асуулт Монголбанкнаас асууя.

С.Бямбацогт: Монголбанк хариулъя, 3 дугаар микрофон.

Г.Энхтайван: Төв банкны мөнгөний бодлого ч тэр, ЗГ-ын төсвийн бодлого ч тэр аль аль нь Монгол хүнийг эрүүл, аюулгүй орчинд амьдруулах, ард түмний амьжиргааг дээшлүүлэх л тийм л үндсэн зорилготой байгаа. Хэрэгжүүлж байгаа мандат, арга зам нь л өөр болохоос. Төв банк үүнийг мөнгөний бодлогоороо эрэлтийн гаралтын инфляцыг тогтворжих замаар хүргэдэг. Хэрвээ бид бүхэн инфляцыг шууд нам доор түвшинд барина гээд өөрсдийгөө хамгаалаад бодлогын хүүгээ тэнгэрт тултал чангалаад бүх зээлээ хаагаад тэгээд явбал эргээд энэ маань өөрөө л ард иргэдийн ахуй амьдрал дээр бизнес эрхлэгчдийн нуруун дээр ирж байгаа ачаалал улам нэмэгдэнэ гэсэн үг. Тэгэхээр бид бүхэн энэ дээр балансыг нь л олж харж байгаа гэсэн үг. Ер нь тэнцвэрийг нь олно л гэдэг, эдийн засгийн ухаан маань өөрөө тэнцвэрийг нь олж байгаа л асуудал гэсэн үг. Түүнээс биш бид бүхэн өөр өөрсдийнхөө хууль дээр олгогдсон мандатыгаа л хэрэгжүүлнэ гэж үзээд зөвхөн бодлогын хүүгээ тэнгэрт тултал чангалаад бүх өр орлогын харьцааг байхгүй болгоод хэрэглээний зээлийг бүтэн танаад эдийн засгийн идэвхжил болон энэ цусны эргэлтийг хориод явах тийм боломж байхгүй.

С.Бямбацогт: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ удаагийн энэ төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ ард иргэдийнхээ амьжиргааг шууд харсан, ард иргэдэд эдийн засгийн өсөлт жоохон ч гэсэн байвал тэр нь ард иргэдийн орлого болж орохуйц ийм төсвийн төсөл тодотгол орж ирж байгаа юм байна. Тэгээд бид анхаарах зүйлүүд байгааг хэлэхгүй байж болохгүй. 1 дүгээрт энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 22 удаа энэ 14 жилийн хугацаанд өөрчлөгдчихсөн ийм хууль. Ингээд энэ хууль өөрөө төсвийн тогтвортой гэхээсээ илүү хамгийн тогтворгүй хууль болчихоод байгаа. Одоо 23 дахь өөрчлөлтийг нь бид хийх гэж байна. Ерөнхий сайдын өгсөн тайлбараас тэр суурь тэнцэл гэж дэлхийд байхгүй ийм зүйлийг авч хаяад, төсвийнхөө тэнцвэржүүлсэн орлого, зарлагаар нь явъя гэсэн ийм зүйл гэж ойлголоо. Гэхдээ энэ дээр бид анхаарах ёстой шүү. Ялангуяа энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж гаргачхаад энийгээ ингээд жил болгон жилд тодотгох болгондоо, төсвөө батлах болгондоо өөрчлөөд ингээд яваад байвал бидний энэ төсөвт хэн итгэх вэ ийм нөхцөл байдал үүснэ шүү гэдгийг анхааруулъя гэж бодож байна.

Энэ Монголбанктай холбоотой асуудлууд гараад байна. Ялангуяа энэ төсөв тэлсэн алдагдлыг нь 2 их наяд руу оруулж ирсэн ийм үед Монголбанк өөрсдийнхөө бодлогыг бодлогын хүүгийн асуудлаас авхуулаад санхүүгийн янз бүрийн хэрэгслүүд байгаа, энэ хэрэгслүүдээ хэрхэн ашиглах вэ гэдгийг мэргэжлийн түвшинд хариулчихмаар байгаа юм. Тэр өр орлогын хувь хэмжээ, үндсэн нөөцийг энэ 19 хувьд барина ч гэдэг юм уу, бодлогын хувиар 12,5 байна гээд. Тэгээд Монголбанкийг очоод эдийн засгийг царцаачих гэж хэлээгүй шүү дээ. Гэхдээ ямар ч байсан төсөв тэлэлтийн үед хумьсан ийм солбио бодлого барьж явахгүй бол тэрийгээ эдийн засгийнхаа халалтыг дийлж чаддаггүй болохыг та бүхэн мэдэж байгаа. Тэгэхээрээ энэ дээр та бүхэн жишээлбэл үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэтээр ипотекийн зээл гаргаж ирсэн тэрэн дээрээ өөрөө өөрсдийгөө бариад өгчихсөн шүү дээ. Энэ дээрээ ямар дүгнэлт хийж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асууя гэж бодлоо.

2 дугаарт энэ инфляц /inflation/ дээр өнөөдөр ингээд хүнсний бүтээгдэхүүн тэр дотроо махны үнийн асуудал маш их яригдаж байна махны үнэ. Ингээд БЗД дээрээ сонгогчидтойгоо уулзаад явахад энэ махны үнийг л хамгийн түрүүнд ярьж байна. Тэгээд тэдэнтэй ярилцаж байхад ерөөсөө энэ махны үнэ дээр төрөөс ялангуяа Улаанбаатар хотоос энэ буруу дохио өгсөн гэж яриад байгаа юм. Нөөцийн махыг 20 мянган тоннд хүргэж байсан нь ковидын /covid/ үед, энэ удаад 20 мянган тонн орж ирж байгаа юм байна. Ингээд 5 мянга дотор барина гээд зарласан. Нөгөө талдаа малчдыг шууд ирээд зар гэж хэлсэн. Ингэнгүүт нөгөө мах оруулж ирж зардаг бид ченж гэж хэлсэн энэ улсууд нь болохоороо мах нөөцлөхөө больчихсон. Ер нь энэ чинь хангалттай ороод ирэх юм байна ийм учраас мах нөөцлөхгүй гээд. Тэгээд саяын энэ үнэ өсөлтийг ерөнхийдөө шулуудуулчхав уу гэж харж байгаа юм. Энэ дээр ямар дүгнэлт хийж байна, ямар дүгнэлт хийж байна вэ? Мөн махны экспорт /export/ ихэвчлэн ямаа, адуун дээр байгаа. Тэгэхээр энэ экспорт энэ махны үнийн өсөлтөд нэг их нөлөөлөхгүй байгаа болов уу гэж бодож байна. Энэ дээр ЗГ-ын зүгээс тодруулъя. Энэ махны үнийг тогтворжуулахад өөрөөр хэлбэл махны үнэтэй ямар нэг хэмжээнд нөөцөө гаргаж ирж зарж энэ махан дээр интервенц хийх дээр ЗГ яг идэвхтэй ямар бодлого барих вэ?

Түрүүнд ярьсан энэ иргэдийн яриад байгаа энэ бодитой юу, үгүй юу, буруу дохио өгсөн. Энэ бодитой юу, үгүй юу гэдэг дээр энэ холбогдох улсууд нь хариу өгвөл сайн байна. Энэ дээр яригдаж байгаа нэг зүйл ялангуяа ЖДҮ-лэгч, жижиг, дунд худалдаа эрхлэгчид. Нарантуулаар явлаа, Дүнжингараваар явлаа ингээд жижиг, дунд ийм дэлгүүрүүдээр явлаа. Ингээд ирэхээр энэ дээр ер нь 6 улирал дараалаад, надад нэг минутыг нь өгчхөөрэй. 6 улирал дараалаад яг энэ худалдаа, үйлчилгээ чинь дандаа бууралттай, уналттай гараад байгаа юм. Энийг яриад байх шиг байна. Гэтэл бид цаашдаа энэ дээр яаж энийгээ босгож ирэх вэ гэдэг асуудлыг л яримаар байгаа юм.

С.Бямбацогт: Асуултаа дуусгая, минут нэмж өгье.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ дээр юу вэ гэхээр зэрэг бид өнөөдөр Монгол Улсын хөрсөнд Монгол орны хөрсөнд ургасан тариа, хүнсний ногоо, мах, сүүн бүтээгдэхүүнүүд гээд ингээд энэ зүйлийг борлуулахад НӨАТ-ынхаа хуулиар 13.10 гэсэн заалт байгаа үүгээрээ 13.1 дээрээ чөлөөлнө гээд заачихсан НӨАТ-аас. Гэтэл 13.10 дээр ороод ирэхээрээ ерөөсөө дамжуулан борлуулагч бол чөлөөлөхгүй гээд. Ингэхээр нөгөө муу жижиг, дундууд чинь жижигхэн ийм 8 нэрийн болоод ийм супермаркетууд чинь 10 хувийн нэмэгдэлтэй зараад эхэлж байгаа юм л даа. Чөлөөлөгдөж байгаа тавхан дэлгүүр байгаа. Энэ дээр Ерөнхий сайд бизнес эрхлэгч нартай уулзахдаа энэ асуудлыг ер нь анхаарч үзье, Үндэсний үйлдвэр, жижиг, дунд энэ наймаа эрхлэгч нараа дэмжье гэсэн ийм байр сууриа илэрхийлсэн байгаа. Тэгэхээрээ энэ дээр ЗГ яг ямар бодолтой байна энийг тодруулж асууя гэж бодсон юм?

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Махны нөөц бүрдүүлэх Наранбаяр гишүүнээ юу яах гэж байгаа асуудал огт биш. Нийтэд нь хавтгайд нь бид махны үнийг удирдаад энэ дээр интервенц хийгээд явах асуудал биш. Яагаад гэхээр та өнгөрсөн хаврыг харж байгаа байх. Хаврын улирал онцлогтой манайх чинь өөрөө нийлүүлэлтийн улирал нь хавар хүнсний бүтээгдэхүүний дутагдалтай болдог. Өвлөө даваад, хаврын тарчигхан үеэр нойтон мах

нийлүүлэгддэг энэ зах зээл чинь хумигддаг. Яг тэр хумигдах нийлүүлэлтийн шокийг нь бид тогтвортой байлгах үүднээс махаа нөөцөлье гэж байгаа юм. Тэр нийлүүлэлтийн дутагдлаас үүдээд махны үнэ өссөн ийм л асуудал өнгөрсөн онд үүссэн. Тэгэхээр бид яг тэр улирлын шинж хамааралтай нийлүүлэлтийн доголдлыг арилгах үүднээс махаа нөөцөлье гэдэг энэ бодлогын хүрээнд төсвийн тодотгол дээр мах нөөцлөх асуудал оруулж ирж байгаа юм. Түүнээс биш экспортод гарч байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа мах, махан бүтээгдэхүүн дээр ЗГ ямар нэгэн тийм хязгаарлалт тавихгүй экспорт гардгаараа л гараад явна. Зөвхөн хаврын улирал буюу тэр 1, 2, 2, 3, 4 дүгээр сард улирлын хамааралтай нийлүүлэлт дээр гарч ирдэг дутагдлыг хамгаалах үүднээс оруулж ирж байгаа юм.

Та тэр нэмэгдсэн өртгийн албан татварын асуудлыг ярьж байна. Бид яах вэ энэ шууд чөлөөлнө гээд явчихаар зэрэг одоо томоохон ААН-үүд дээр тийм алдаа гараад байгаа юм. Том юунууд нь болохоор зэрэг энэ талбайг түрээслээд мах, гурилаа нийлүүлж байгаа нөхдүүд маань зардаг учраас бид чөлөөлөгдөнө гээд явчихдаг. Дамжуулан худалдагч нар дээр энэ НӨАТ-ыг төлөөд байгаа асуудал байгаа. Тэгэхээр бид системээ боловсронгуй болгохгүй бол болохгүй байна. Тэрэн дээр Сангийн яам тэр НӨАТ, татварын системээ бид сайжруулах чиглэл дээр нь ажиллуулж байна. Яагаад гэхээр импортоор орж ирж байгаа хүнсний ногоог дотоодын хүнсний ногооноосоо ялгах боломжгүй. Энэ чинь өөрөө бид дотоодын газар тариалангийн үйлдвэрлэлээ устгачих тийм нөхцөл рүү орчих гээд байгаа юм. Тэгэхээр энэ 2-ын заагийг бид гаргаж бүртгэлээ сайжруулж байж энэ асуудлыг хөндөхгүй бол дотоодын нөгөө нэг нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолно гэдэг шиг дотоодын хүнсний гурил үйлдвэрлэгч, энэ тариа, хүнсний ногоо үйлдвэрлэгчдээ татаад унагаачих тийм нөхцөл рүү орчих гээд байгаа юм. Тэгээд тэр эрсдэлийг Ерөнхий сайд чиглэл өгөөд бид энэ дээр Сангийн яам бүртгэлийн талд нь илүү анхаарч ажиллаж байна. Ирэх он гэхэд энэ асуудлыг бид нэг цэгцлээд ороод ирэх болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр тэр махны юу дээр ойлгож байна нөөцийн юуг тэр 20 мянган тонн дээрээ авчраад ингээд явна гэдгийг. Тэгэхээр хамгийн гол нь энэ уялдааг л сайн хараарай тэгэхгүй бол дохио буруу өгсөн шүү. Тэрнээс болсон гэдгийг та бүхэн анхаараарай. Яг энэ бэлтгэл хийх үе дээр нь.

2 дугаарт яах вэ энэ цалингийн нэмэлттэй холбоотой нэг зүйл яригдаад байгаа дээр би өөрийнхөө нэг байр суурийг хэлчихье. Яагаад гэвэл энэ 618 тэрбум төгрөгийг УИХ баталж өгсөн юм, ЗГ тухайн үедээ 1,1 их наядаар тооцож оруулж ирсэн УИХ дээр энэ нь багш, ажилчдын цалинг нэмэх нь 618 тэрбум төгрөгөөр баталж өгсөн. Үүнийг нь үндсэн цалингийн өсөлт дээр бид оруулж ирж ингэж тооцож эхэлсэн. Энэ гэхдээ нэг анхаарах зүйл нь бид үндсэн цалинг өсгөхөд илүү сайн анхаарах хэрэгтэй. Түрүүнд яриад байгаа 2,8 сая руу хүргэхэд ч боломжтой. Цаашдаа бид харин элдэв нэмэгдлийг 30 хувьд нь барихгүй бол одоо 50, 50 гэж явах юм бол дийлэхгүй шүү. Өнөөдөр бүх нэмэлтээ ахиад нэмэгдэл цалингууд дээр тавих гэж байна ингээд дийлэхгүй шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Энэ дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай ЗГ их гоё төсөөллөөр төсвийн тодотголыг өргөн барьж байна. Тэгээд өөрсдөө тайлбарлахаараа уул уурхайн салбар 30 хувь, ХАА-н салбар 20 хувийн өсөлттэй байна ер нь Монгол Улс маш сайхан байна л гэж яриад байгаа юм. Яг энэ бодит байдал дээр нөгөө татвар, энэ бодитой тоог нь би хэлээд өгье. Онцгой албан татвар 2025 онд батлагдсан гүйцэтгэлээрээ 8,5 их наяд, 8,6 их наяд. Энэ оруулж ирж байгаа тодотголын дараах дүнгээр 8,9 их наяд буюу бараг өөрчлөлтгүй, энийг хувийн хэвшил бий болгож байгаа. Тэгэхээр хувийн хэвшил дээр энэ өөрчлөлт алга байна. Хөрөнгийн албан татвар, хөрөнгийн албан татвар энд 609 тэрбум 2025 онд байгаа, 2026 онд тодотголын дараах дүнгээр 514 болж буурч байгаа, энэ чинь хувийн хэвшил хөрөнгийн нааш цааш нь гүйлгэж байгаа хэлбэр, иргэдийн нааш цааш нь хөрөнгөө хөдөлгөж байгаа хэлбэр харагдахгүй байгаа гэж эндээс харагдана. Тэгээд энд дахиад гадаад үйл ажиллагааны орлого буюу энэ импортын албан татвар энэ чинь 1,8 их наядаар төсөвлөж байсан төсөөлөл өнөөдөр 1,8 дээрээ хэвээрээ байгаа.

Тэгэхээр ЗГ-ын яриад байгаа нөгөө гоё, гоё тоо засгийн эдийн засгийн өсөлт сайжирч байна гээд байгаа юм бол байхгүй, хувийн хэвшил бүсээ чангалаад дуусчихсан. ЗГ бүр хангалттай. Энхбаяр сайд өөрөө хэлсэн шүү, хэдэн хулгайч тэжээдэг байсан ТӨК-удынхаа хулгайлж байсан мөнгийг төсөв рүү оруулж ирж байна гээд. Тэгээд манай Ерөнхий сайд болохоор энэ МАН дотроо 2 хуваагдчихсан, 2 хуваагдсан гишүүдийнх нь эсрэг талынхан нь юм асуухаар АН тэтгэвэр нэмье гэхээр эсэргүүцээд байна гээд тэр Ардын намын гишүүнийхээ асуултад хариулахдаа андуураад байгаа байхгүй юу. Ингээд та өөрөө ингээд вакумжаад эсвэл намаа 2 хувааж манай намтай нэгтгэж хараад байх шиг байгаа юм. Тусдаа шүү дээ Ерөнхий сайдаа. Тэгэхээр ер нь нэг иймэрхүү хөөсөрчихсөн юмнаасаа салъя гэдэг нэг ийм зарчмын санал байгаа юм.

Энх-Амгалан сайд энэ Наранбаяр сайд 2-ын хэн нь зөв тооцоо хийсэн юм, хэн нь алдаатай тооцоо хийсэн юм, ямар хариуцлага тооцох юм бэ? Энийг зүгээр солиод тоглоод өнгөрдөг баймааргүй байна. Хариуцлага хаана байна Ерөнхий сайд аа? Энэ дээр та нэг хариулт хэлмээр байна.

Сангийн сайд энэ нийслэл чинь би НИТХ-ын төлөөлөгч нарыг хэлээгүй. Тэгэхдээ нийслэл дээр маш олон том дарга нар байгаа. Нийслэлийн төсвийн алдагдал явсаар байгаад улсын төсвийн алдагдлаас хэтийдсэн хэмжээнд орчихсон, энэ тооцооллууд чинь энэ төсвийн тодотголд орж ирж байгаа юу, үгүй юү? Нэгдсэн улс л гэж та нар ярихдаа сайн, энэ нийслэлээ ч хүчрэхгүй байна шүү дээ та нар яг бодит байдал дээр энэ дээр нэг тайлбар.

Тэгээд энэ Монголбанк энэ нөгөө инфляц чинь өссөөр байгаад 15 хувь болчихлоо гээд байгаа юм. Тэгээд та нар долоосоор байгаад л томилж өгсөн нөгөө Тэргүүн дэд Ерөнхийлөгч чинь энэ зунжингаа наадам хэсээд л нэг торгон дээл өмсчихсөн уяачид эсвэл сагсчид гээд л яваад байдаг. Инфляц руугаа анхаарал хандуулах ёстой албан тушаалтан одоо энд ч алга байна шүү дээ. Нэг даргын цай зөөдөг байсан хүн тэнд суучихсан, гишүүдэд нэг ойр зуурын лекц уншаад байгаа юм уу. Хэн хариуцлага хүлээх юм гээд асуугаад байна шүү дээ. Тэгээд лекц уншиж байгаад буцаад суучихдаг ийм хариуцлагагүй баймааргүй байна УИХ-ын даргаа.

6 +,-2 гэдэг инфляцын түвшин батлуулсан Монголбанкны мөнгөний бодлого. Одоо энэ эдийн засаг чинь өөрөө 2 их наядаар асуудалд орчихоод байна гээд 15 хувь дээр байгаа инфляц чинь та нарын тооцооллоос 2 дахин өөрчлөлт орчихоод байна.

Та нар мөнгөний бодлогодоо өөрчлөлт оруулахгүй юм уу, ажлаа хийхгүй юм уу битгий энд орж ирж лекц уншаад бай. Энэ хариултыг хариултад битгий тооцоод бай Их Хурлын даргаа. Тэгээд асуултдаа хариулт авч байгаад тодруулга авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Манай ЗГ асуудлыг сууриар нь л харъя гэж хичээж байгаа. Аргацаагаад явбал явахаар л тийм нөхцөл байдал руу шахаж байгаа байхгүй юу. Тэгэхдээ энэ улс төржилт, энэ хийрхэл нөгөө аль нам ярьж байгаагаас нь болоод буруу, зөв гэж дүгнэдэг байдал энэ тэр гол асуудал биш л дээ. Дэлхий дахины дэг журам өөрчлөгдчихсөн, энэ дэлхийн тодорхойгүй байдал чинь хамгийн тодорхой болчихоод байгаа энэ үед хамтдаа урагшаа л харах ёстой. Надад улс орны нийтлэг эрх ашиг, энэ ард түмний амьдрал ахуй л хамгийн чухал байна. Тэрнээс биш дотроо улс төржөөд хийрхээд байх надад тийм цаг зав ч алга. Тийм учраас сууриар нь шийдье л гэсэн.

Тийм учраас өнөөдрийн энэ төсвийг бид ингээд хамтдаа хэлэлцэж байгаа. Үнэхээр энэ үнийн өсөлт чинь 13 хувь гэж энийг яаж дийлэх юм бэ ард түмэн, яаж дийлэх юм? Тийм учраас энэ тодотгол зөвхөн тэр стратегийн нөөц рүүгээ л анхаарсан. Ингэлээ гээд бүх юмны үнэ бууруулж чадахгүй хэдий ч бага орлоготой иргэдийгээ хамгаалах бодлого амьдрал дээр хэрэгжинэ. Тэгээд энэ нүдээ олохгүй байсан учраас энийг нь тэр бүх процессыг нь цахимжуулаад, яг бүртгэлжүүлж авч байгаад хариуцлагатайгаар зах зээл рүү нь нийлүүлье л гээд байгаа юм. Махаа, гурилаа, тэр хүнсний ногоогоо, төмсөө, энэ бензин, шатахууны саваа сэтгэл байвал болж л байгаа шүү дээ. Бензин, шатахууны сав өнөөдөр эхнээсээ 14 хоногийн нөөцийн сав баригдаад л болж л байна. Энэ төсвөөр төсвийн тодотголоор энэ зооринуудыг дэмжинэ. Энэ Монголчууд хүнсний ногоогоо махаа сайхан энэ өвлийн хүйтэнд нөөцлөөд ингээд өвлийг давж болно шүү дээ. Ард түмнээ бодсон ийм сэтгэл байхгүй байгаа. Тэгэхээр ингээд төрийн өмчийн компанийн ноогдол ашиг гээд л ингээд л би зөндөө тайлбарлаад байгаа. Бидний цаагуур яваад байгаа мөртөө зах зээлд нийлүүлэгдээд байгаа юмыг дотор нь оруулж ирэх ёстой.

Тийм учраас Монголбанк бол энэ эрэлтийн гаралтай инфляц дээрээ ажиллах ёстой. Бид бол энэ нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулах дээр энэ стратегийн нөөцөөрөө, дээрээс нь энэ түлш, шатахууны хамааралтай байна шүү дээ бид чинь. Тэгээд сая Орост ч гэсэн хэлэлцээрүүд хийлээ, Хятадаас, Солонгосоос авахаар тохирлоо. Тэгээд л бензин, шатахуун дээрээ ингээд үзэж тарж л байна. Тийм учраас бидний асуудал чинь нэг байхгүй юу. Тийм учраас Цогтбаатар гишүүн ТӨК-ийн ноогдол ашгийг шууд оруулж ирээд ингээд явж байна шүү дээ. Төрийн өмчийн нэг хувийг тэгээд явж байна шүү дээ. Тэгээд Монголбанкны удирдлагууд хариулах нь зүйтэй, Их Хурлын харьяа байгууллага шүү дээ.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ 2 сайдын буруу гэхээсээ илүүтэй бид төсвөө батлахдаа Их Хурал багш нарын цалинг нэмнэ гээд шийдвэр гаргаад, тогтоолоо гаргахдаа багш, ажиллагсдын болгоод баталчихсан байхгүй юу. Тэнд очоод хэрэгжүүлэхдээ Наранбаяр сайд ямар асуудал гарсан гэхээр төсөв нь хүрэхгүй болохоор үндсэн цалинг нь ингэж нэмлээ шүү гээд нэг нэмээд, нэмэгдэл, урамшууллыг нь хуучин цалингаас нь боддог ийм л 2 цалинтай болгочихсон байхгүй юу. Тэр асуудлыг нь манай ЗГ нэг болгож шийдсэн.

Нэмэгдсэн цалин дээрээс нь урамшууллууд нь тооцдог тэр зарчим руу нь шилжүүлээд цалингийн нэг шатлалтай болгож өгсөн.

Одоо дутагдаж байгаа, тэгээд тэр асуудлаа шийдвэрлэхийн тулд бид оны төгсгөл рүү санхүүжих ёстой байсан дүнг нь урагш нь татаад тавиад ирсэн. Одоо дутагдаж байгаа 674,5 буюу төсөвт тавигдаагүй энэ эх үүсвэрийг бид зардлаа танаж бий болгож гаргаж ирж байна л гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд гүйцээгээд хариулчихъя. Нийслэлийн төсөвтэй холбоотой.

З.Мэндсайхан: Нийслэлийн төсөвтэй холбоотой тодотгол дээр бид төсвийн хүрээ өөрчлөгдсөн тохиолдолд алдагдал маань 1 их наядаар нэмэгдэж байгаа юм. Тэр орон зайн дээр нь нийслэлийн өмнө санхүүжүүлж чадаагүй байгаа 2,8 их наядаас 1 их наядыг нь санхүүжүүлбэ гэдгээр тодотгол дээр тавиад ороод ирсэн. Нийт бүхлээрээ 26 оны төсөв дээр ямар нэгэн орлого, зардлын түвшинд нэмэлт гараагүй гэсэн үг. Нэг ёсондоо цаашдаа бид нийслэлээ хянаад явах тэр боломжийг нь оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Одоо би нэг иргэдийн хүсэлтийг хэлэх гэсэн юм. Уг нь түрүүн энд Зам, тээврийн сайд сууж байсан. Иргэдийн хүсэлт шүү Их Хурлын даргаа. Энэ Коп-17 /COP17/ гээд бид цөлжилтийн эсрэг аягүй гоё хурал хийсэн. Үр дүн нь Монголд цөлжилт хэвээрээ үргэлжлээд байна. Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдаас хатуу хучилттай авто зам барьсны дараа тээвэр хийх ёстой гээд гэрээтэй. Тэгсэн чинь нөгөө компаниуд чинь ЗТЯ-ны сайд, энэ говийн бүсээс сонгогдсон Дэлгэрсайхан гишүүнийг авлигадсан юм уу бүү мэд. Баянхонгор аймгийн харьяат ЗТЯ-ны ТНБД Баярмагнай даргыг авлигадсан юм уу бүү мэд. Замаа бариагүй, нөгөө говийн эмзэг хөрсөн дээр чинь тээврээ хийгээд эхэлчихсэн. Энийг зогсоох талаас нь ямар арга хэмжээ авах юм бэ? Бид Коп гээд нэг гоё цөлжилтийн эсрэг хурал хийдэг, бодит үр дүн дээрээ бид говийн эмзэг хөрс нөхөн сэргээгддэггүй эмзэг хөрсийг улам цөлжүүлэх ажил хийгээд байна. Нэг гараараа нэг гоё юм ярьдаг, нөгөө гараараа худлаа ярьдаг. Тэгэхээр энэ дээр ямар арга.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээе, нэг минут.

Да.Цогтбаатар: Тэгэхээр энэ дээр ямар чиг баримжаатай ажиллах юм бэ? Бид цөлжүүлээд байх юм уу, эсвэл мөнгө хэрэгтэй байна гээд зүгээр тэр эмзэг хөрсөө эвдээд байх юм уу? Энэ говийн, Өмнөговийн иргэд ч хандаж байна, Баянхонгор аймгийн говийн сумын энэ иргэд ч хандаж байна. Энэ дээр уг нь тодорхой чиглэл өнгөрсөн хаврын чуулган дээр ярьж байхад Дэлгэрсайхан сайд бол зам барьсны дараа тэр дундаа сая Тавантолгой дээр та бүхний нээдэг хатуу хучилттай хүнд даацын тээврийн зам нээсний дараа бид тээвэр явуулна гэсэн чинь одоо зүгээр шороон дээр нь шууд явуулж байгаа. Өмнөговь аймагт Цагаан хадан дээр нэг асуудал үнэхээр хүнд байгаа. Адгуус ч тогтохгүй, мал, амьтан ч тогтохгүй нөхцөл байдал Баянхонгор, Өмнөговьд дахиад шинээр бий болох гэж байна гэдгийг нэг анхаараад өгөөч гэж иргэдээс ирсэн хүсэлтийг дамжуулж байгаа шүү. Энэ дээр Ерөнхий сайд болж байгаа бол Дэлгэрсайхан сайдыг дуудаж байгаад нэг хариулт өгүүлчихвэл их сайн байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан сайдын орж ирэхээр хариулт өгүүлье, тэгэх үү. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Монголбанк хариулъя. Инфляц 15 болсон уу, 13 гэж яриад байсан. Бодлогын хүү, мөнгөний бодлого батлахдаа +,-, 6 дээр +,-2 гэж баталсан. Тэгээд одоо ийм болчихлоо, яг юу бодож байна вэ гэж.

Г.Энхтайван: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Инфляц хамгийн сүүлийн тооцоогоор 13 хувьтай байгаа, энэ оны төгсгөлөөр 11,7 орчим хувьтай гарах болов уу гэсэн хүлээлттэй байна. Хэрвээ УИХ энэ төсвийн тодотголыг өргөн барьсан хувилбараар нь хэлэлцэж батлах юм бол. Инфляц өөрөө эрэлтийн гаралтай, нийлүүлэлтийн гаралтай гээд дотроо хуваагдаж байгаа. Эрэлтийн гаралтай нь 8,7 хувьтай байгаа, үгүй ээ нийлүүлэлтийн гаралтай нь. Дийлэнх нь нийлүүлэлтийн гаралтай учраас төв банк мөнгөний бодлогыг чангаруулаад энэ нь эргээд иргэд, ААН-үүд дээр, бизнес эрхлэгчид дээр л том хэмжээний дарамт учирна гэж Төв банк энэ дээр харж байгаа, хүлээцтэй байгаа нэг талаасаа.

Нөгөө талаасаа заавал байлгах нөөц, өр орлогын харьцаа гэсэн 2 макро арга хэмжээ авдаг. Өр орлогын харьцаа 45 хувьтай. Энэ манай өр орлогын харьцаа мөрдүүлж эхэлснээс хойших хамгийн өндөр хувь. Ер нь дэлхий дээр ч энэ өр нь маш өндөр хувьдаа орж байгаа. Заавал байлгах нөөц дээр ч гэсэн 14, 19 хувьтай байгаа. Энэ нь ч гэсэн маш өндөр зардлыг арилжааны.../минут дуусав/

С.Бямбацогт: Тэр Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч нар чинь яасан юм? Тэд нарыгаа хуралд ирүүлээрэй. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Эдийн засгийн бүтэц, бодлого үнэхээр сүүлийн 10 жил маш буруу явсны л илрэл өнөөдөр гарч ирж байна шүү дээ. Жолоочоор Монголбанк инфляц өндөр байна гээд тоормосоо гэнэт гишгэж байна, ЗГ хаазаа гишгээд байна шүү дээ. Энэ жил их сонин жил болж байна 26 он Монгол Улсын түүхэнд их сонин жил болж байна. Парадокс. Монгол Улс түүхэндээ хамгийн их нүүрсийг зөөж гаргалаа. Экспортын орлого 57 хувиар нэмэгдлээ, өмнөх жилтэй харьцуулахад нүүрсээ 54 хувиар илүү их тээвэрлэж зарлаа. Орлого ийм өндөр байхад алдагдлаа 2 их наядаар нэмэгдүүлж байна, ЗГ зарлагаа нэмэгдүүлж байна. Зээлжих эрхээ Мэндсайхан сайд 5 дахин нэмэгдүүлчихнэ шүү дээ, ЗГ бонд гаргах гэж байна. Энэ юу илэрхийлж байна вэ гэхээр зүгээр энгийн логикоор бодъё л доо. Хамгийн их цалин авч байгаа жилээ айл өрх хамгийн их өрөнд орж байгаатай адилхан байгаа байхгүй юу.

2 дугаарт дахиад энэ 26 он илүү тодоор эдийн засагчид дүгнэх ёстой. Үнийн өсөлтийг иргэдийн амьдрал үнэхээр гүйцэхгүй байна. Хувийн хэвшил гүйцэхгүй байна. Өрхийн бизнес эрхлэгчдийн бодит орлого 33 хувиар унаж байна шүү дээ. Орлого маш багасаж байна, нөгөө талд нь үнийн өсөлт маш ихээр өсөж байна. Хуучин ийм байдаггүй байсан, 2 хэцүү зүйл хоёуланд нь иргэдийн өмнө тохиолдож байна л даа. Тэгээд ЗГ бүсээ чангал гээд л байнга хэлдэг байсан. Иргэдэд одоо чангалах бүс алга байна. Үнэхээр хүнд байдалтай байна.

Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн тодотгол энэ тэр чинь төрд ашигтай тодотгол байна. Хувийн хэвшилд ашиггүй байна Мэндсайхан сайд та анхаараарай. Бондыг 1 их наядаар гаргах юм байна, банкнууд л энийг авдаг, банкнууд хамгийн найдвартай санхүүгийн хэрэгсэл гэж үзээд энийг худалдаж авдаг, жирийн бизнес эрхлэгчид зээл өгөхөө хумьдаг. Өнөөдөр зээл хумигдаж байна, гадуур бэлэн мөнгө олдохгүй, зээл хумигдаж байна. Хувийн хэвшил хумигдана.

Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь ажил хийж байгаа, бизнес эрхэлж байгаа тэр дундаа жижиг бизнес эрхлэгчдээ шахсан төсвийн хүрээний мэдэгдэл орж ирж байна.

2 дугаарт энэ зээлийн эрхээ нэмэгдүүлэх гэж байна шүү дээ. Гадаадын зээлийн эрхээ. Энэ зээлийн хүүг өрийг ирээдүй үед төлнө. Тэгэхээр бидний харж байгаа энэ төсвийн бодлого чинь зөвхөн энэ нэг өнөөдрөө бодсон, өнөөдөр хүмүүс яавал болох вэ гэсэн ийм бодлого болчихсон байна. Энэ маань эргээд инфляц үйлдвэрлэх эрсдэл байгаад байна. Тэгэхээр Ерөнхий сайдаа эдийн засгаа энэ хувийн хэвшлээ хамгаалъя гэж хамгийн их ярьдаг, яг энэ хувийн хэвшлийг хамгаалах хамгийн сайн төсвийг оруулж ирэх боломж байгаагүй юм уу? Энэ танд оруулж ирэхдээ энэ Сангийн яамны мэргэжилтнүүд энэ санхүүгийн хэрэгслүүд одоо байгаа энэ бүтэц дээр чинь уул уурхайн төсөв нэмэгдсэн байна, тэгээд ногдол ашиг нэмэгдсэн байна энийг оруулж ирээд л оруулаад ирсэн байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь яваандаа төр уурхай хийдэг, олборлодог, тээвэрлэдэг, хуваарилдаг, бүх зүйл төрөөс хамааралтай болоод, төр өөрөө хувийн хэвшлийн дайсан болоод, хувийн хэвшлийн саад нь төр өөрөө болох ийм эрсдэл рүү Монгол Улс явж байна. Төрд ойрхон хэдхэн бизнес босдог, бусад нь дампуурдаг чиглэл рүү явж байна.

С.Бямбацогт: Асуултаа дуусгая.

Ц.Баатархүү: Тэгэхээр энэ жил болгоны орж ирж байгаа төсвийн бодлого, төсвийн хүрээний мэдэгдэл ч яг адилхан байна, өвөг дээдсийнх нь үлдээсэн энэ байгалийн баялаг буюу нүүрсээ хэрхэн хэр сайн зарсан бэ гэдэг дээр л тулгуурлаж байна. Энэ боловсруулах үйлдвэрүүдээ хөгжүүлэх, хувийн хэвшлийг үе шаттай яг бойжуулж гаргаж ирэх хөрөнгө оруулалтуудын сан байгуулах, бид энэ станы орнуудын жишээг зөндөө л ярилаа шүү дээ. Яг нэг ийм реформ /reform/ оруулж ирэх болж байгаа юм уу гэдгийг Ерөнхий сайдаас тодруулъя?

2 дугаарт Сангийн сайдаас 2 зүйл тодруулъя. Үнэхээр 1 их наядын бонд гаргах гэж байгаа юм уу дотоодын бонд? Гадаадын зээлжих эрхээ та 5 дахин нэмэгдүүлээд 2 их наяд 700 тэрбум төгрөгийн эрх авах гэж байгаа юм уу? Яагаад ингээд алдагдлаа маш ихээр нэмж байгаа юм бэ? Яагаад ЗГ тэвчиж болох зардлаа хэмнэхгүй байгаа юм бэ? Би зүгээр энгийн жишээ хэлье. Томилолтын зардал чинь нэмэгдсэн байна шүү дээ, 76.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Цаг үетэйгээ нийцсэн энэ иргэдээ үнийн өсөлтөөс хамгаалах зорилготой тодотгол оруулж ирлээ. Тийм 1.4 их наяд хэмнэж байгаа нь үнэн. Хэмнэсэн зардлаа хаана өгч байгаа нь үнэн. Өндөр настны тэтгэвэр авагч нарын 769 мянган төгрөг 1/3-ийг нь эзэлж байна. Тэрэн дээр та бүхний баталсан нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлж суурь тэтгэврийг нэмэх гэж байна. Эмч нарын цалинг багш нартайгаа адилхан 50 руу хүргэх гэж байна. Бусад салбарын төрийн үйлчилгээг 50 хувьд хүргэх гэж байна. Ингэж байж иргэдийнхээ орлогыг баталгаажуулах гэж байна. Өрхийн орлого чинь дунджаар 4.9 хувь руу агшчихаад байна. Энэ чинь юунаас болоод байна вэ гэхээр ААН-үүдийн орлого буурчихсан байна. 2.2 их наядын алдагдал гэдэг чинь түрүүн би хэлсэн ААНОАТ чинь 761 тэрбумд царцаад байна. Тэр чинь юу гэхээр худалдаа, үйлчилгээний салбар

идэвхгүй байна шүү дээ. ХХОАТ чинь бараг 250 тэрбум төгрөгөөр төсөөлснөөс багасчхаад байна шүү дээ.

Энэ юу вэ гэхээр наад бензин, шатахуунаас чинь болоод энэ гадна, дотноос автомашин авдаг энэ чинь багасчихсан байхгүй юу автомашин авдаг. Дээрээс нь энэ нөхцөл байдалдаа тохируулаад бид чинь нөгөө түлш дээр татвар дээр хөнгөлөлт үзүүлчихгүй юу хувийн хэвшлээ дэмжээд. Тэгээд түүнээс чинь болоод энэ татварын орлого багасчхаад байгаа байхгүй юу. Татварын орлого. Тийм болохоор энэ алдагдал бий болж байгаа, тэр алдагдлыг санхүүжүүлэх зардал чинь өөрөө бүсээ чангалах. Нэмэлтээр ТӨК-удынхаа ногдол ашгийг шахаад, түүнийгээ юунд өгөх гэж байна гэхээр тэтгэвэр, цалин хөлс, дээрээс нь маш ойлгомжтой наад стратегийн нөөц байхгүй юу. Наад мах, гурил, улаан буудай, бензин, шатахууны сав, хүнсний ногоо, тэр дундаа төмс. Тэгээд тэр санхүүжилтийн хөтөлбөрүүд тэр чигээр нь тэр иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах бодлого руугаа л чиглүүлчихсэн. Маш ойлгомжтой.

Дээрээс нь эрчим хүчний салбарт хийгдэх шаардлагатай засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг нь өвлийг давахын тулд хийчихлээ. Зөрүүн дээр гарсан мөнгийг нь тавьчихлаа эрчим хүчний цахилгаан, дулааны үнэ нэмэхгүй. Энэ иргэдээ л бодсон төсөв шүү дээ. Таны яриад байгаа тэр бонд гээд байгаа тэр дотоод бонд байхгүй юу дотоод бонд. Хувийн хэвшлээ дэмжих тал дээр ер нь энэ төсвийн тодотгол ч бай, ирэх оны төсөв ч бай онцгой сайн дэмжиж байгаа шүү. Бид нэг юм ойлгох ёстой. Төсвөөс хөрөнгө оруулалтын төсөл санхүүжүүлнэ гэдгийг нь болих хэрэгтэй. Төсөв дээр бичигдэхгүй мөртөө гангийн төсөл, зэсийн төсөл, хөнгөн цагааны төсөл, энэ эрчим хүчний төслүүд бүгдээрээ явж байгаа шүү дээ. Манай ЗГ-ын үед төр, хувийн хэвшлийн түншлэл онцгой сайн хэрэгжиж байгаа шүү дээ. Та нар болохоор энд оруулж ирж төсвөөр заавал ярих ёстой юм шиг бодоод байх шиг байна. Тийм юм байхгүй шүү дээ. Монгол Улс зөв зам руугаа явж байна гэж бодож байна.

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя.

З.Мэндсайхан: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр нэг их орлого нь ихэдчихээд байхад Сангийн яам ер төлбөр тавиад орж ирж байгаа асуудал огт биш. Нүүрсний орлого сайн байгаа, экспортын хэмжээ нэмэгдэж байгаа, биет биет хэмжээ нэмэгдэж байгаа. Гэхдээ үнэ бид нарын төсөвлөсөн 70 долларын хэмжээнд байж чадахгүй байгаа. Он гарсаар 64 доллартой явж байгаад сая 7 сарын дунджаас эхлээд нүүрсний үнэ 68, 9 доллар луу ирж байна. Төлөвлөсөн хэмжээ рүү дөхөж ирж байна. Дотоод бонд гаргалаа гээд бид энэ бондыг ямар нэгэн байдлаар урсгал зардал санхүүжүүлэх ийм асуудлаар хэрэглэхгүй. Нийтдээ бид гадаад болон гадаад зээл болон гадаад бондын төлбөрт 3.6 их наядыг төлөх ёстой энэ жил. Өмнө авсан зээлүүддээ. Гаргаж байгаа бонд маань дахин санхүүжүүлэх зорилгоор л хэрэглэгдэж байгаа. Түүнээс биш бид энийг аваад урсгал зардал юм уу, хөрөнгө оруулалт.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулах уу, Баатархүү гишүүн тодруулъя.

Ц.Баатархүү: Тэгээд тодотгол дээр илүү нарийн тодруулаад явъя даа. Ер нь бонд гэдэг чинь бондын тэр өгөөж чинь илүү сайн байж бондоо гаргах ёстой шүү дээ. Зөвхөн нэг зээл төлөхийн тулд ингэж бонд гаргадаг. Монголд ингээд давтагдаж байгаа нэг зүйл үзэгдэл энэ болоод байна л даа. Ер нь Монголын эдийн засгийн

орлогыг чинь өмнөд хөршийн гангийн үйлдвэрийн үнэ, ханш ингээд тодорхойлж байна. Уул уурхайн компани чардайж байгаад хамгийн их нүүрс тээвэрлэлээ шүү дээ. Энэ бидний өвөг дээдсийн үлдээсэн л өв. Гэтэл бид ирээдүй үедээ өр үлдээх гээд байна. Тэгэхээр эдийн засгийн бүтэц чинь болохгүй байгаагаа бүгд ойлгож байгаа. Тэтгэвэр нэмэхийг бид бүгд дэмжиж байгаа. Энэ бүтцээ сайжруулах реформын шинжтэй юмыг оруулж ирээсэй гэж би хүсэж байна. Би энэ залуу Ерөнхий сайдыг Монгол Улсад нэг реформ хийчих болов уу гэж хараад байгаа юм, хийчхээсэй гэж бодож байна. Хэн нь ч ялгаа байхгүй. Өнөөдөр яг энэ эксел /excel/ файл дээр нүүрсний орлого нэмэгдэхээр нь орлого.../минут дуусав/

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя.

3.Мэндсайхан: Орлого олох бүтцээ өөрчилье гэж байгаатай Баатархүү гишүүнтэй санал нэг байгаа. Тийм учраас манайхан ер нь төсөв дээр ямар хүндрэл гараад байна гэхээр урсгал зардал байнга тэлж байгаа тийм үү. Гэхдээ энэ урсгал зардлын тэлэлт чинь өнөөдөр яагаад асуудал болоод байна гэхээр бид ДНБ-ээ тэлэх буюу тэр боловсруулах үйлдвэрүүдээ бий болгож чадахгүй байгаад л учир байгаа. Тийм учраас манай ЗГ хувийн хэвшил рүү маш онцгой дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа ЗГ гэж хэлж болно. Бид явж байгаа бүх том төслүүдийг дэмжиж байгаа уул уурхайн төслүүдийг. Нөгөө талдаа бид Бизнесийн эрх чөлөөний хуулийг гаргасан. Сая хаврын чуулганаар татварын багц реформыг хийсэн. Энэ хүрээнд ААН-үүд дээр 2.8 их наядын хөнгөлөлтийг үзүүлж байгаа. Энэ үзүүлж байгаа хөнгөлөлтийг бид зардлаа танаж, төсвийн орлогоо, татварын орлогоо нэмэгдүүлэх замаар хувийн хэвшил дээр үлдээгээд явж байгаа. Энэ чинь хувийн хэвшлээ дэмжиж байгаа бодлого. Түүнээс биш тэр татварын хөнгөлөлт чинь хөнгөллөө гээд ЗГ дээр ирж байгаа ямар нэгэн дэмжлэг биш байхгүй юу. Орж ирэх ёстой орлогынхоо 2.8-ыг нь хувийн хэвшил.../минут дуусав/

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Энэ удаагийн төсвийн тодотгол энэ ЗГ-ынх биш, өмнөх ЗГ-ын өргөн барьсан төсөв алдаатай байсныг өнөөдөр засаж байна гэсэн үг. Тухайн үед олон гишүүд хэлж л байсан л даа. Тэгээд тэрүүнийг улс төржилт гэж авсан. 2027 оны хавар гэхэд яг энэ төсвөөр явбал эдийн засаг аягүй хүндрэхээр байна шүү дээ, алдагдал нэмэгдэхээр байна шүү дээ гэхэд улс төржиж ийм юм ярилаа гэж яриад байсан. Одоо үүнийхээ горьг бид амсаж байна. Төсөв уг нь улс төрчид бидэнд халааснаас нэгэнт бүрдээгүй нь ойлгомжтой. Энэ баялаг бүтээж байгаа, татвар төлж байгаа жижигхэн наймаачин, жижиг, дунд бизнес эрхлэгчдээс авхуулаад, наймаачид, цалин хөдөлмөрийн хөлс авч байгаа анхны ажлаа хийж байгаа залуу хүртэл энд хувь нэмэр оруулж байгаа юм. Тэгээд үүн дээр уг нь нэг улс төр гэдэг өнцгөөс нь биш, нээрээ яагаад гэдэг өнцгөөс нь нэг хардаг болмоор байх. Тэгээд 1 хэсэг нь асуугаад л, нэг хэсэг нь нэг хариулсан болоод л өнгөрөөд л, сүүлдээ бид нэг л энд нэг л анх удаадаа төсөв баталж байгаа хүмүүс биш, ийм байдаг юм, ингэдэг юм гээд л зарим нь хариулж байгаа хүмүүс нэг иймэрхүү онол, практикийн бага хурал дээр илтгэл тавьж байгаа аятай ингэсээр байгаад л төсвийн хэлэлцүүлгүүд ер нь дуусдаг болж байна.

Тэгэхдээ нэг ийм юман дээр нэг анхаармаар байна. 1 дүгээрт ОУВС энэ тэрээс ер нь биднийг яах вэ улс төржиж янз янзын төсөв баталж байгаа ч гэсэн Ирээдүй өв сандаа, Баялгийн сангаа улам сайжруулаад яваад байгаад ер нь бас ч гэж Монгол Улс мэдээж улс төргүй байна ч гэж юу байх вэ, гэхдээ болж байна даа

гэж хардаг байсан. Дээрээс нь нэмээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа хамаагүй гар хүрч оролдохгүй байгаад нь яах вэ болж байна даа гэж боддог байсан. Одоо энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд энэ өөрчлөлт оруулахад та нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс сая энэ дүгнэлт дээрээ бичсэн байна. Ямар үр дагавар гарна гэж та бүхэн харж байна вэ? Энэ тухай олон улсын байгууллагуудаас, ялангуяа Валютын сангаас байдаг юм уу та бүхэн уулзсан барьсан зүйл байгаа юу, үүний ирээдүйн үр дагаврыг юу гэж харж байна вэ? Би Валютын сангийн хөтөлбөрийн хүнд үед Сангийн дэд сайд хийж байсан хүний хувьд ахиад Валютын сангийн хөтөлбөрт орчих вий дээ гэдэг айдас байна.

Дахиж ингэж төсвөөр ер нь нэг улс төржихгүй байх хэдүүлээ нэг гаргалгаануудаа хийхгүй юм уу? Багш, эмч нарын цалин дээр төсөв батлахдаа эх үүсвэрийг нь тодорхойгүй баталсан гээд Ерөнхий сайд тэгж байна. Тэгвэл хэн ийм хуульд нийцээгүй зарчмын зөрүүтэй санал гаргасан юм бэ, УИХ-ын Тамгын газар бараг 300 хүнтэй Тамгын газар ийм хуульд тоо, тогтоол хоёр нь хоорондоо зөрүүтэй юм батлагдах гээд байж байхад яагаад үүн дээр ажиллаагүй юм бэ? Дээрээс нь нэмээд ажлын хэсгийн дарга тэрүүн дээр юу хийж байсан юм, Байнгын хорооны дарга тэрүүн дээр юу хийж байсан юм гээд ар араасаа аягүй олон асуултууд байгаа байхгүй юу? Ирээдүйд ийм юм үүсвэл яах юм бэ? Төсөв гэдэг чинь ялангуяа цалин дээрээ бид ямар цалин батална түүнд нь багтааж л цалингаа тавих ёстой шүү дээ. Тэрнээс биш цалингаа дүнг нь тавьчихаад дутахаар нь тодотгол хийдэг, үлдсэнийг нь тавьдаг тийм зүйл байж болохгүй шүү дээ. Өмнө нь тийм зүйл болж байсан. Тэгэхдээ тэр нь сонгуулийн дараа таараад тэгээд нэгэнт ард түмэн хариуцлага тооцчихсон хүмүүстэй олон юм яриад юу гэх вэ дээ гэж бодож байсан болохоос биш энэ байж болохгүй шүү.

Дээрээс нь нэмээд энэ төлөвлөлтөө бид хийж чадахгүй л байна гэсэн үг шүү дээ. Та бүхэнд олон хүмүүс энэ 27, 26 оны төсөв дээр хэлж байсан. Тэгээд энэ мэргэжлийн яам нь мэргэжлийн байгаач, улс төрийг дагаж битгий та бүхэн маань, Сангийн яам ялангуяа манай Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн би тийм байх болов уу гэж бодсон. Төсвийг ерөөсөө л улс төрийн хэрэгсэл болгож ашигладаг боллоо. Кноп худалдаж авахад, албан тушаал дээрээ үлдэхэд, татвар төлөгчид та нарыг албан тушаал дээрээ үлдээхийн тулд энэ татварын мөнгийг чадан ядан төлөөгүй шүү дээ. Тэгээд ийм юм.../минут дуусав/

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Булгантуяа дарга энэ Их Хурал дээр ажлын хэсгийн хүрээнд л ингээд асуудал хөндөгддөг, түүнээс болоод энэ ачааг нь ЗГ даахаа больдог л гэдэг зүйлийг хэлээд байна л даа. Яг үнэн л дээ. Ингээд төсөв хэлэлцэж байхад нийгмийн шаардлагаар ч гэдэг юм уу, зарим салбарын цалин, хөлсийг нэмэх шаардлага үүсдэг. Тэгээд тойргуудын хөрөнгө оруулалтынхаа ажлууд хоорондоо гүйдэг хөдөлдөг. Тэгээд ЗГ өөрөө бодлогоо хэрэгжүүлэх гээд орж ирээд орсон төсвийнх нь бодлого ингээд алдагдчихдаг. Өнгөрсөн жил ч гэсэн бараг энэ чинь 1.3 их наяд төгрөгийн хөдөлгөөн хийсэн. Тэгэхээр энэ төсвийн анхны бодлого, зорилтуудыг хазайлгасан л байхгүй юу.

Тэгэхээр ЗГ гүйцэтгэх засаглал ажлаа хийх гээд бидний хувийн хэвшлийг дэмжсэн эдийн засаг дахь энэ 61 хувийн харьцааг буулгах гэсэн бодлоготой. Тэр 10 их наяд нэмээд байгаагийн 10 их наяд чинь 5 нь бараг татварын хууль, нийгмийн даатгалын багц хуульдаа зориулагдсан ийм концепцтой хууль юм. Энэ төсөв

батлагдвал 15 мянган ажлын байр шууд нэмэгдэнэ, баталгаатай хэлээд байна шүү дээ. Дандаа энэ төр хувийн хэвшлийн оролцоон дээр суурилсан ийм төсөв барина гээд үздэг. Гэтэл яг амьдрал дээр очихоор нөгөө танигдахын аргагүй болчих эрсдэл байдаг. Тэрнээс биш юу гэдэг юм валютын сан ч гэдэг юм уу одоо бол тийм хөтөлбөрт орох хэмжээнд очоогүй шүү. Тэгж ярьж болохгүй байх. Зүгээр ер нь экспорт бид нарынх сайн л байгаа.

Харин төр хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд явуулж л байгаа. Нэмүү өртөг шингэсэн, технологийн агууламж шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтууд биелж байгаа. Харин манай ЗГ хурдтай, шуурхай, чадна, чадахгүй гэдэг асуудал дээр л асуудалд хандаж явж байгаа, болно, болохгүй гээд. Тийм учраас энэ олон суурь асуудлуудыг бүхлээр нь шийдсэн. Тэгэхээр одоо батлагдсан төсөвтөө багтааж бид ингээд шийдвэрээ гаргаад л явдаг ийм л зарчимтай. Тэгэхээр Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг энэ ЗГ-ын барьж орж ирсэн энэ төсвийн бодлогыг дэмжиж өгөөч гээд байгаа юм. Эргээд танигдахгүй болчихдог. Эргээд ЗГ-аасаа хариуцлага нэхэх гэхээр төсвөө ч таньдаггүй тэгээд ийм л байдалтай болчихдог. Тийм учраас энэ төсвийн бодлого чинь энэ удаа бол нөгөө тойргуудад ч юм тавиад байна гэхээсээ илүү энэ чинь нөгөө ЗГ бүтээгдэхүүнтэй болсон байхгүй юу ядаж төсөв дээр тавих 100 ногоон сургууль шүү, Кембриджийн хөтөлбөртэй сургууль шүү, төрөлжсөн ахлах сургууль шүү. Энийг гишүүдийн төсөв дээр эрэмбэлээд тэр гишүүдийн тойргууд дээр эрэмбэлээд аяндаа суучихаар гишүүд хараад “манай тойрог чинь сургууль хэрэгтэй байсан шүү дээ” гэдэг байдлаар хардаг болохоос биш чи юу хүсэж байна гэнгүүтээ тэрийг нь тавиад ингээд явчихаар чи ингээд хэрэгтэй, хэрэггүй газар хөрөнгө оруулалт очоод энэ шударга бус болчихсон байгаа. Тэгээд ЗГ бүтээгдэхүүнээ танилцуулаад, түүнийх нь дагуу хуваарилаад явснаараа харьцангуй онцлог болсон л гэж дүгнэж болно.

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: 26 оны төсвийг Занданшатарын ЗГ өргөн барихдаа төрийн албан хаагчдын цалинг огт нэмэхгүйгээр оруулж ирсэн төсөв бол нэмэгдсэн нийт зарлага нь, тэгэхдээ огт нэмэхгүйгээр орж ирсэн. Тэгэнгүүтээ гадаа жагсаал болоод, багш нар ажил хаяад, эмч нарын асуудал хөндөгдөөд эхлэнгүүт сандарсандаа нэмэх шийдвэр УИХ дээр, ажлын хэсэг дээр гаргуулсан. Тэгээд ийм их том өөрчлөлтийг УИХ дээр, ажлын хэсэг дээр гарахад алдаа гарах магадлал их өндөр байдаг байхгүй юу. Тэгэхээр уг нь энэ нийгмийн уур амьсгалыг ЗГ өөрөө мэдрээд, үүнийг уг нь оруулж ирэх ёстой байсан.

Дээрээс нь нэмээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 2023 оны хавар 6 сард гарсан зөвлөмж байдаг. Төрийн албан хаагчдын цалинг хэн нэг нь жагсахаар нь, 90 жилийн ойн баяр нь болох гэж байгаа юм гээд, сайд нь аягүй их хөөцөлдлөгөөтэй болохоор, Сангийн сайдтай ойрхон болохоор гэж нэмэхгүй гэдэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан. Энэ зөвлөмжийг зөрчсөн. Аль нэг салбарыг жагсахаар нь нэмнэ гэдэг чинь болохгүй шүү дээ. Төрийн албан нэн ялангуяа.../минут дуусав/

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Төрийн албан хаагчийн цалин хөлсийг 33 хуулиар зохицуулж байна. Тэгээд наад эрүүл мэндийн салбар дээр 8 сарын 1-нээс 9, 9, 9, 9, 9, 9 гэж яваад 76 хүрнэ гээд, багш дээр болохоор 11 сараас 75 болгоно гээд ийм хэлэлцээр хийчхээд

байгаа байхгүй юу. Ийм боломж байхгүй. Эмч 50 хувь хүрэх ёстой 20 хувь, 50, 50 ирэх онд инфляцтай уялдуулахад 65 хувь хүрнэ шүү, бусад ТҮ-ээ яах гэж байгаа юм төрийн үйлчилгээгээ тэд адилхан 50 хувь болгох ёстой шүү дээ. Ингээд нэг ийм хөрөөний ир ашиг байхаа болиод, юманд жоохон зарчимтай хандъя л ийм л юмаар оруулж ирсэн. Тэгэхээр энэ чинь иргэдийн орлогыг хамгаалж байгаа байхгүй юу. Дээрээс нь шударга хандаж байгаа төрийн албан хаагч нарт. ТЗ, ТТ-гээ ч гэсэн ирэх оны 4 сарын 1-нээс нэмээд л явъя. Инфляцын яг энэ үед биш, яг энэ зарчмыг алдагдуулахгүй л батлаад гарчихвал энэ эдийн засагт сөргөөр нөлөөлөхгүй байхгүй юу. Гэтэл дахиад нэг жагсаал цуглаан болдог тэдэн хувь гээд л ингээд л ялгаад л.../минут дуусав/

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн нэмж асууя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдтай санал нэг байна. Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг одоо ямар ч арга байхгүй. Энийг хийхээс өөр аргагүй. Өнөөдөр улаан гал руу хүний өмнөөс амийг аврах гээд орж байгаа онцгой байдлын ажилтныг жагсаагүй юм чинь гээд цалинг нь нэмэхгүй байж болохгүй. Жагсаж болохгүй төрийн албан хаагчид гэж байдаг байхгүй юу. Тэр хүмүүсийг тэгээд яах юм, орхих юм уу? Нэг хэсэг нь болохоороо жагсаж байгаад 50 хувиар цалингаа нэмүүлчхэж болохгүй шүүдээ. Тэгэхээр үүнийг ижил тэгш өнөөдөр төрийн албан хаагчдын энэ олон 200 гаруй мянган төрийн албан хаагчдын цалингийн бодлого нэгдмэл байх ёстой, энэ хүмүүсийн ур чадвар, ажлын онцлогийг нь үнэлж нэгдсэн бодлого байх ёстой гэдэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг өмнөх ЗГ зөрчсөн шүү. Ахиж ийм юм хиймээргүй байна. Үүн дээр Улсын Их Хурал ч гэсэндээ ийм төсөв батлах уг нь ёсгүй л байсан юм. Тэгээд ар араас нь ингээд л олон жил уг нь төсөв баталсан, олон жил төрд байсан хүмүүс алдаагаа одоо араас нь засах гээд л төлөөсийг нь татвар төлөгчид төлөөд явж баймааргүй байна.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Надад 3 багц асуулт байна. Сая өмнөх гишүүдийн хэлдэгчлэн яг энэ төсвийг сонгуулийн хэрэгсэл болгох гээд АН, МАН гэлтгүй болимоор байна. Өчигдөр, уржигдархан АН-ын нэг гишүүн мэдэгдэл хийсэн байна лээ. Тойргийн гишүүдээ трактор тараасан өнгөрсөн хавар, одоо энэ жил хүүхдүүдэд iPad тараана гээд. Татвар төлөгчдийн мөнгө ингээд явж байж болохгүй шүү дээ. Тэгэхээр ийм байдлаар зарцуулдгаа бүгд хаана хаанаа анхаармаар байна.

Асуулт 1 дүгээрт энэ компанийн ногдол ашгийг төсөвт татаад, түүгээрээ цалинг, тэтгэвэр нэмэх гэж байгаа юм байна гэж ойлгож байна. Жил бүр ингэж явах уу? Компанийн ногдол ашиг хуваарилах шийдвэр дараа оны 3 сардаа гардаг, төсвөө бид өмнөх оныхоо 11 сардаа баталдаг. Энэ 2 хугацаа хоорондоо зөрөөд байна. Энийг яаж ямар зохицуулалт хийх юм бэ? Яг үүнтэй холбоотой хэрвээ компани ашиггүй ажиллавал Хятадууд бид нараас нүүрсээ худалдаж авахгүй бол буцаагаад цалингаа буулгах уу, тэтгэврээ буулгах уу цаашид яах юм бэ нэг дэх асуулт?

2 дугаарт Монголбанкны ахлах эдийн засагч Ананд гээд нэг хүний судалгааг 23 онд хийж байсан судалгаа байна, 24 онд юм шиг байна. Энэ судалгааг уншсан төрийн албан хаагчийн цалинг 10 хувиар нэмэгдүүлэхэд инфляц 4.4 хувиар өсдөг гэдэг судалгаа гарсан байна. Өнөөдөр бид төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар хэрвээ өсгөвөл бараг 14, 15 хувиар инфляц нэмэгдэх юм биш биз дээ гэдэг энэ дүр зураг яг энэ судалгааг уншихаар гарч ирж байна. Тэгэхээр цалин нэмэгдсэний дараа

өнөөдрийн 13 хувийн инфляц сая 18 хувь болно гэж Монголбанкнаас хэллээ. Үүний эсрэг яг ямар арга хэмжээ авч байгаа учраас та нар 18 хувь гэдэг тооцооллыг гаргаж ирээд байгаа гэдгээ маш тодорхой хэлээч гэж байгаа юм?

2 дугаарт хувийн хэвшилд энэ цалингийн нэмэгдэл хэрхэн нөлөөлөх вэ? Хувийн хэвшил зайлшгүй цалингаа нэмэх хэрэгцээ шаардлага үүсэх үү? Үүснэ. Тэгэхээр энэ бүхэн дээр яг төрийн ямар бодлого яг хувийн хэвшил рүүгээ яаж чиглэх юм бэ гэдэг нэг ийм асуулт байна.

Хамгийн сүүлд яг энэ төсвийн тодотгол дээр төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулга дээр нэг анхаарал татсан нэг тоо гарч ирсэн. Ажилгүйдэл өмнөх оны мөн үеэс 20 хувиар өсөж 79 мянга болсон, ажилгүйдлийн түвшин 20 хувиар өссөн. Тэгэхээр инфляцыг бид өсгөхгүйн тулд нөгөө эсрэг авдаг арга хэмжээ нь бүтээмжийн бодлого байгаад байдаг. Гэтэл ажилгүйдэл ингэж жил ирэх тусам өсөөд, тэр дундаа ХАА-н салбар, үйлдвэрлэлийн салбар гээд хэд хэдэн салбарын ажилгүйдлийн түвшин маш сэтгэл зовоох ийм тоонууд энэ дээр гарсан байна. Тэгэхээр яг энэ хөдөлмөр эрхлэлтийн бодлого ЗГ-т ямар бодлого байна вэ гэсэн ийм 3 асуулт.

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Ногдол ашгийг жил бүрийн ногдол ашгийг өмнөх оны ашгаас л тооцож явна шүү дээ. Өмнөх оных нь ашгаас. Жишээ нь ЭТТ компани 5 удаа иргэдэд ногдол ашиг тараахдаа төрд ногдол ашиг өгөөгүй л байхгүй юу. Тэгээд 24 оны Баялгийн сангийн хуулиар 66 хувь нь тэнд ирнэ гэхээр тэр төсөл, хөтөлбөрт зарцуулна гэхээр үе үеийн нэг улс төрчдийн ийм хэрэгсэл болоод байж болохгүй шүү дээ. Би байгаа үедээ энийг нэг зөв болгоё л гэж бодсон юм. Тэрнээс биш үе үеийн Ерөнхий сайд иргэдээ Эрдэнэс Монгол компанидаа дуудаад 66 хувь нь ирэнгүүт наадхаа ТУЗ-өөрөө оруулаад нэг төмөр зам хийгээдэх, наадхаараа нэг зам хийгээдэх, наадхаараа нэг нийгмийн төсөл хийгээдэх гээд дарамтлаад сууж байвал энэ улс оронд чинь ард түмэн баялагтаа яаж эзэн болох юм.

Тэгэхээр ногдол ашиг гэдэг өмнөх оны ашгаас нь тооцоод авна. Жил бүрийн 6 сард аудитлагдсан тайлангаас нь ашгаас нь тооцож жил бүрийн дараа жилийн 9 сард өргөн барихдаа тусгана гэсэн үг. Шинэ та бүхний баталсан ТӨК-ийн хуулиар 1 дүгээр сарын 1-нээс ТӨК ашиггүй ажиллана гэж ойлголт байхгүй болно. Хэрвээ тийм бол татан буугдана. Зарчим л тэр шүү дээ. Татан буугдана Сайнзориг гишүүн. Танай та бүхний баталсан хууль тэр 30 хувь. Ер нь цаашдаа ТӨК-уд ногдол ашгаа өгөх ёстой. Тэгээд түрүүн та бүхний гишүүдийн хэлээд байгаагаар би иргэдэд хувьцааг нь эзэмшүүлэх ёстой гэж байр суурьтай байдаг. Ирэх жил 3.5 их наядыг ногдол ашиг төвлөрүүл гэж үүргийг төрийн өмчийн уул уурхайн компаниудад өгч байна. Энэ бүрэн үндэслэлтэй 3.5 байтугай 6 их наяд хүрэх юм байна лээ ер нь. Одоо 3.4 их наядын ногдол ашигтай ажиллах юм байна лээ. Түүний 1.5-ыг тодотголд аваад иргэндээ өгье л гэж байгаа шүү дээ. Та бүхний баталсан Татварын хуулийг 1 сарын 1-нээс хэрэгжүүлбэ л гэж байгаа. Энүүгээрээ л гол онцлог нь энд шингэж байна гэсэн үг.

Өөр юу билээ? Хувийн хэвшлийг дэмжих буюу эдийн засаг дахь харьцааг 61 хувийг буулгана. Яагаад гэхээр төсвөөс би ямар нэгэн хөрөнгө оруулалтын төслүүд санхүүжүүлэхгүй байгаа шүү дээ. Дээрээс нь дандаа ажлын байр нэмэгдүүлэх, ялангуяа барилгын салбар ийм богино хугацаанд ажлын байрыг их нэмэгдүүлнэ.

Тэгэхээр тэр ипотекийн зээлийн санхүүжилт, тэр дундаж давхаргын хөтөлбөр энэ тэр гэдэг чинь дандаа л ажлын байрыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, дээрээс нь хөрөнгө оруулалтууд чинь энэ төсөвт сууж байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалтын цаана дандаа бусдаар гүйцэтгүүлэх зардал шингэж байдаг. Тийм учраас ажлын байр бий болох бололцоо бүрдэнэ гэж байгаа байхгүй юу. Ер нь төрийн оролцоог бүрэн хумиад энэ ногдол ашгийг илүү татвар, тэтгэвэр шимтгэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Инфляц дээр ийм л юм байгаа юм. Жишээ нь 4 сарын 1-нээс төрийн албан хаагч, төрийн захиргаа, төрийн тусгай албан хаагчдыг нэмэгдүүлэхээр тооцсон. Тэтгэврийг оны эхнээс инфляцтай уялдуулаад 10 орчим хувиар нэмэгдүүлэхээр тооцсон. Тэгэхээр эрэлтийн гаралтай инфляц 1.6 орчим байх болов уу гэж. Дээрээс нь тодотголын хүрээнд стратегийн нөөцүүдийг бүрдүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдээ авснаараа энэ хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт саарна, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт буурна, үүний нөлөөгөөр 2.1 орчим нэгж хувиар буурна гэж тооцож байгаа. Ер нь таны тоо, тэр тоо ч их өндөр л дөө. Зүгээр 1 их наяд орчим дээр дээд талдаа л 0.5 шүү дээ. Дээрээс нь ямар шинэ мөнгө хэвлэх гээд байгаа канондох гээд байгаа юм байхгүй юм чинь. Бид төсөв дээр л энийг яриад байгаа болохоос тэртээ тэргүй л тэр ТУЗ-өөр зах зээл рүү ирэх жил 3.5 байтугай.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариултаа дуусгачихъя.

Н.Учрал: Тэгэхээр тэр тэртээ тэргүй нийлүүлэгдэх байхгүй юу. Жишээ нь ирэх жилийн тэр манай төсвийн хүрээний тоог өндөр гээд байгаа чинь 3.5 их наяд ТӨК-иос ногдол ашиг руу авна гэдэг чинь энийг хэрвээ та бүхэн хуулиар хийхгүй бол тэртээ тэргүй 3.5 хамгийн багадаа дээшээгээ нийлүүлэгдэнэ, харин тэр тэтгэвэр, татварт зарцуулагдахгүй байх. Тэр бол хэрэгтэй, хэрэггүй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх байх. Тийм л юм. ОТ дээрээс ярьж байгаа тэр ногдол ашиг авах асуудлыг бид инфляц, тэр чинь шинэ мөнгө байхгүй юу. Нөгөөдөх нь зах зээлийн тэр динамик дээр эрэлтийн динамик дээр угаасаа байгаа л дүн байхгүй юу. ОТ-н ногдол ашиг бол шинэ мөнгө. Тийм учраас тэр илүү суурь асуудлаа шийдэх учраас тэр 10 аймгийн станц, 6 дугаар станц энэ тэр лүү оруулаад нэг хувийг нь хуримтлал, 1 их наядыг нь Хуримтлалын санд аваад явбал зарчмын хувьд зөв юм гэж ингэж үзэж байгаа. Тэр шинэ асуудал мөнгө биш.

С.Бямбацогт: Тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Ажилгүйдэлтэй холбоотой статистикийн талаарх асуулт байсан. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого энэ ЗГ дээр ямар бодлого явах вэ гээд? Ажилгүйдэл өмнөх оны мөн үеэсээ 20 хувиар өссөн, өсөж 79 мянга болсон гэдэг ийм статистик сая энд бидэнд өгсөн материал дээр, танилцуулга дээр байна л даа. Тэгэхээр бүтээмж нэмэгдэхгүй хэр нь энд төрийн албан хаагч цалин нэмэгдээд байгаа асуудал дээр эсрэгцүүлэн авах ямар бодлого байгаа вэ л гэж асуугаад байгаа гэсэн үг. Хөдөлмөр эрхлэлт, бүтээмж дээр ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэсэн үг.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Хөдөлмөрийн зах зээлийн идэвх буурч байгаа. Тэгээд хамгийн гол анхаарах салбар хөдөлмөрийн шингээлт ихтэй ХАА, боловсруулах, үйлчилгээний салбарын энэ үзүүлэлтүүд буугаад байгаа. Яг улсын байдлаар өнөөдөр ажилгүйдлийн түвшин 5.5 хувьтай, ажиллах хүчний оролцооны түвшин 61.5 хувьтай, нийт 1 сая 368 мянган хүн яг ажлын байраар хангагдсан, ажилгүй иргэд 79 мянга гэсэн ийм үзүүлэлт гарсан байгаа. Уул уурхайн салбарт идэвхжилт сайтай холбоотойгоор ажиллах хүч 7 хувиар ажлын байр нэмэгдсэн байгаа. Тээврийн салбар 2 хувиар нэмэгдсэн байгаа. Барилгын салбарт 8 хувиар нэмэгдсэн байна. ХАА-н салбарт 12 хувиар багассан, боловсруулах салбарт 20 хувиар багассан, үйлчилгээ болон бусад боловсрол, санхүү, даатгалын салбарт 9 хувь өссөн гэсэн ийм үзүүлэлтүүд гарсан. Өнөөдрийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Нийт дүнгээрээ ажилгүйдэл өссөн юм уу, буурсан юм уу, дээрээс нь тэр инфляц 18 хүрчих гээд яриад байгаа тэр үнэн юм уу, худлаа юм уу бодитой зөв мэдээлэл өгөхгүй бол болохгүй байна. Энхбаяр сайд нэмээд хариулчих уу, гүйцээгээд хариулчихъя.

Ж.Энхбаяр: Хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэхийн тулд төсвийн бодлого үндсэндээ чиглэж байгаа. Уул уурхайгаа идэвхжүүлнэ, экспортыг идэвхжүүлнэ, дагаад тээвэр, үйлчилгээ сайжирна, барилгын салбартай холбоотой ипотекийн эх үүсвэрүүдийг 1.7 их наядын ипотекийн нөөцийг энэ арилжааны банкнуудад боломжийг гаргаж өгнө. Барилгын салбарт бий болчихсон байгаа 16 мянган бэлэн болчихсон барилгыг борлуулах энэ маань өөрөө нэлээн томоохон хөдөлгөөн болно. ХАА, боловсруулах салбар дээр хүнсний хувьсгал, Атрын 4, Цагаан алт энэ үед хэрэгжиж байсан бодлогын арга хэмжээнүүд үргэлжилнэ. Нөөцийн бүрдүүлэлт, нөөц бүрдүүлэх чиглэлээр нэлээн томоохон ажлууд хийнэ. Үйлчилгээний салбарын худалдаа, үйлчилгээ идэвхжүүлэх гол бодлого маань өөрөө энэ цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотойгоор энэ маань буцаад л үйлчилгээ худалдан авалтад эргэж эдийн засгаа идэвхжүүлэхэд нөлөөлнө шүү дээ. Энэ үүднээсээ төсөв, одоо бол тодотголтой холбоотой бас нэг зүйл хэлэхгүй бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулт болсон уу, гүйцээгээд хариулчих уу? Энхбаяр сайд дахиад гүйцээгээд хариулчихъя.

Ж.Энхбаяр: 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл үндсэндээ үндсэн бүх гол макро эдийн засгийн тоонууд хэвээрээ байгаа шүү дээ. Эдийн засгийн өсөлтийн тоо хэвээрээ, орлогын хэмжээ хэвээрээ, зарлагын хэмжээ хэвээрээ, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ хэвээрээ. Гол нь дотооддоо салбарын хооронд гүйлгээ хийгээд 1.4 их наядыг гаргаад, түүгээрээ тулгамдсан энэ нөөц бүрдүүлэх болон цалин, тэтгэвэр, эрчим хүч, энэ өвөлжилтийн бэлтгэл нөөц бүрдүүлэх, боловсролын салбарын эх үүсвэрийг гаргаж байгаа ийм л төсвийн өөрчлөлт шүү дээ. Тэгэхээр ямар нэгэн гол макро эдийн засгийн тэр тооцоолол талдаа тооны алдаа гараагүй ийм л зүйл хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: 18:00 цаг болсон байна. Өнөөдрийн 2 асуудал байгаа эхний асуудлаа хэлэлцэж байна. Араас нь төсвийн тодотгол орно. Энэ асуудлуудаа хэлэлцэж дуусаж цагаа сунгачих уу? Тэгье, цагаа сунгалаа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Тодотголыг төсвийн тодотголыг хэлэлцэх үед тэр тоог нь ярья даа. Төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл 2 хязгаарыг тогтоож байгаа. Тэгээд энэ нь

хэдэн төгрөг вэ гэдгээсээ илүү дүрэм ямар болж өөрчлөгдөж байгаа юм бэ, ямар дүрмээр дүрмийн дотор тоглох гэж байгаа юм бэ гэдэг ийм л асуудал болж байгаа. Тоог өөрчлөөд оруулж ирэх ЗГ-ын эрх, энэ дүрмийг өөрчлөх УИХ-ын хариуцлагын асуудал шүү дээ. Бид энэ оруулж ирж байгаа ЗГ-ын тоог яаж батлах вэ гэдэг Их Хурлын хариуцлагын асуудал гэдгийг гишүүд маань анхаармаар байгаа юм. Гишүүдийн яриад байгаагаар Засгийн газар болоод, гишүүдийн яриад байгаагаар Занданшатар Ерөнхий сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдын төлөвлөсөн, Сангийн яам, сайдын тооцсон өргөн барьж Их Хурлаар том ажлын хэсэг гаргаж баталсан. Энэ утгаар маш муу хүмүүс 26 оны төсвийг батлуулсан байна. Агуулга нь тэгж уншигдаж байна.

Тэгээд энд 3 цэг их анхаарал татаж байгаа юм. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хүрээний төсөөлөл. Энэ дээр харахаар юу өөрчлөгдөж байгаа юм, яаж өөрчилж байгаа юм, өөрчлөн найруулж ямар зохицуулалт шинээр бий болгож байгаа юм, ямар хуучин зохицуулалтыг байхгүй болгож байна гэдэг энэ 3 зүйл дээр нэг хармаар байх шат дараалсан. Сайн зүйл байна. Сайнаас нь эхэлж хэлье. 24 оноос өмнө мөрдөгдөж байсан зарлагын өсөлтийн хэмжээ, хөрөнгийн зардлын хэмжээ гэсэн 2 үзүүлэлтээ буцаагаад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлдээ оруулж ирж байна. Энэ нь буцаагаад оруулж ирж байгаа нь зөв гэж харж байна. Зарлагын өсөлтийг эрдэс баялгийн бус дотоодын ДНБ-тэйгээ уялдуулах, мөчлөг дагасан тэлэлтээсээ сэргийлэх энэ хандлага, бас 6.1.3 дахь заалтыг нь шинэ найруулахаар орж ирж байна. Энэ сайн.

Гэхдээ үүнээс гадна боломгүй харагдаж байгаа зүйлүүд, дутуу харсан зүйлүүд байна гэж харж байна. Жишээлэхэд хязгаараа 2 хувь гээд тавьчихсан, төсөөлөл нь өөрөө орж ирж байгаа нь 2 хувиар орж ирж байна. Нэг хувиар, 1.5-аар, 1.7 хувиар орж ирээгүй, таазанд нь тулгаж алдагдлынхаа төсөөллийг орж ирж байна. Энэ оны эхний хагасын тайлангаар гарч байгаа гүйцэтгэлээр гарч байгаа аж ахуйн нэгжийн татвар, онцгой албан татвар энэ бүх зүйлүүд 70 орчим хувийн гүйцэтгэлтэй орлоготой байгаагаар харахад бодит тасалдал ирэх онд бодит тасалдал дахиад үүсэхээр, нөгөө 2 хувиа давчихвал яаж зохицуулалт хийх юм, дахиад тодотгол оруулж ирэх юм уу гэдэг асуудал үүснэ. Тэгэхээр бид ингэж таазанд нь тулгаж оруулж ирж байгаа чинь ер нь гүйцэтгэлээ багтаах л тийм зорилготой хийж байгаа л гэж харагдаад байгаа юм.

Тусгай шаардлагуудыг хэмжих боломжгүй үзүүлэлтүүдийг тавьсан байгаа юм. 12 жилийн дунджаар ДНБ-ий дунджаар өсөлтийг ингээд тооцно гэсэн. Үүн дээрээ ямар нэг мөнгөн дүнгээр тэрбум төгрөг гэж тавьсан болохоос биш дундаж үзүүлэлтийг тооцож тавьж оруулж ирсэн зүйл төсөл дээр алга байна. Тэгэхээр энийг шалгах боломжгүй. Дээрээс нь 5 заалтыг өөрчилж байгаа. Энэ 5 заалтаас нэг л заалт нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаатар гишүүн асуултаа дуусгая.

Б.Батбаатар: 5 заалтыг оруулж ирж байгаа. Тэр 5 заалтаас нэг л заалт нь танилцуулгатай, тайлбартай бусад 4 заалт нь ямар нэг танилцуулгагүйгээр заалтуудыг, хуулийг өөрчилж хүчингүй болгож байгаа. Энийг яагаад ингэж байгаа юм бэ? Тэр өрийн 50 хувийн шугам гээд 26, 27, 28 онд ДНБ-ий 50 хувь гэж байна. Тэгэхдээ энэ чинь 12 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа дүн шүү дээ өрийн дүн нь. ДНБ өсөж байгаа боловч тоон үзүүлэлт буюу мөнгөн дүнгээрээ 12 их наядаар өсөж байгаа, өр бол жил болгон нэмж үйлдвэрлэгдчихэж байна. Тэгээд энэ шинэ

хязгаарын 2 хувь тэр өсөлтийн хувиар илэрхийлж байгаа 12 жилийн дундаж гэдгийг яаж оруулж ирж байгаа юм бэ? Тэр 5 заалтынхаа энэ тайлбарлаагүй 4 заалтыг яагаад хүчингүй болж байгаа юм. Энэ хүчингүй болж байгаа заалтуудаар.../минут дуусав/

С.Бямбацогт: ЕС хариулъя.

Н.Учрал: Энэ төсвийн тодотголыг төлөвлөхдөө хэд хэдэн зарчим барьсан юм. Энэ суурь асуудлаа ер нь шийдэхгүй бол Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл 1 төсөвтэй мөртөө Их Хурал нь улсынхаа төсвийг баталсны дараа орон нутаг нь орлого, зарлага, орлогодоод, зарлагдаад алдагдалгүй л байвал хамаагүй гээд хуулийн заалтаа хэрэгжүүлээд 2 их наядаар давуулаад баталчихдаг ийм л нөхцөл байдалтай яваад байгаа юм. Тэгээд яг үнэндээ 32.9 их наяд гэж яриад байгаа мөртөө энэ чинь бараг 37 болчихсон шүү. Өөрсдийгөө л хуурч байгаа. Тэгээд яах вэ орон нутаг нь өөрөө үнэнд гүйцэгдээд тэр төсвөө гаргаад авъя гэхээр хязгаартаа тулчихдаг. Тэгэхээр энэ болгоныгоо цэгцтэй болгохын тулд хязгаартаа оруулж ирж байгаа гол нь. Үүгээрээ онцлогтой.

Дээрээс нь ТӨК-уд чинь ТУЗ-өөрөө дамжуулаад ногдол ашгаа төрдөө өгөхгүй мөртөө хэрэгтэй, хэрэггүй юмыг санхүүжүүлээд суугаад байна. Энийг яагаад ард түмэн хүртэхгүй байгаа юм бэ, яагаад хүнээ бодохгүй байгаа юм бэ, ТӨК-уд дээр олон хүний эрх ашиг байдаг л даа. Тийм учраас их өрвөлзөөд, сандарч тэвдээд байгаа хүмүүсийг би мэдээд л байгаа юм. Тэгэхдээ байгаа үедээ энийг ТӨК-удыг нэг жоохон үүрэгжүүлээд цэгцлэхийг нь цэгцлээд, ногдол ашгийг нь ард түмэнд нь хүргэхийг юм сан гэж бодоод энэ төсвийн тодотгол дээр ер нь асуудалд ингэж хандсан юм.

Дээрээс нь тусгай шаардлагуудыг бол бид бүрэн биелүүлж байгаа. Төсвийн сахилга бат, хариуцлага бол 1 дүгээр том асуудал. Гэхдээ тусгай шаардлагуудыг биелүүлэхдээ тэр өмнө нь үүргээ биелүүлчихсэн тэр суурь тэнцлийг жишээ нь тэнцвэржүүлсэн тэнцэл буюу нэгдсэн орлого, зарлагын дундах алдагдал нь л тэр ДНБ-ий 2 хувь байна гэдэг зарчмаа бариад явъя. Тэрнээс биш тэр гадаад зээл, бондыг нь хасаад, тэр алдагдал нь суурь тэнцлийн 2 хувь байна гээд явах тэр үүргээ биелүүлсэн, одоо бол урагшаагаа хараад явъя. 24 оноос өмнөх шууд тусгай шаардлагаараа явъя энэ нь илүү зохимжтой. Мөн төсвийн реформоо эхлүүлъя. Энэ төсөв чинь өөрөө зүгээр нэг ийм санхүүгийн тайлан байгаад байна. Тэгэхээр энэ дээрээ өмч хөрөнгөө бүгдийг нь оруулаад ер нь энэ урт хугацааныхаа энэ бодлогоо одоогоос хэрэгжүүлж эхэлъя гэж ингэж шийдсэн. Хүрээн дээр байгаа өрийн хязгаар 50 хувийг хавар 27 оны хүрээ батлахад 50 болгосон та бүхэн. Тэгэхээр бид өрийн хязгаарт тулгаад яваад байгаа юм байхгүй, яг тусгай шаардлага дотроо яваа гэсэн үг.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд нэмж хариулъя.

З.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулахад тэр төсвийн өрийн хязгаарын 50 хувийг 27 оны төсвийн хүрээг батлахдаа 50 болгож баталсан байгаа. Өрийн удирдлагын хуулиар бид ДНБ-ий 60 хувь хүртэл зээл авч болно гэж байгаа. Тэгэхдээ зээлийг та бодох хэрэгтэй, ЗГ дураараа аваад байдаг зүйл биш. Их Хурлаар хэлэлцүүлээд ямар төсөл, хөтөлбөрт зарцуулах вэ энэ зээлийг авах уу, үгүй юү гэдгийг Их Хурал эцэслэн шийдэж байгаа.

2 дугаарт гадаад зээлийг өр нэмэгдлээ их муу юм гэж яриад байж огт болохгүй. Та баригдаж байгаа газрын тосны үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС энэ гадаад зээл хийж байгаа энэ Монголын эдийн засаг, ард түмэнд өгөөжтэй төслүүдийг бүгд гадаад зээлээр хийж байгаа. Тэгэхээр гадаад зээл гэдэг чинь хөрөнгө оруулалт. Бид хөрөнгө оруулалтаа хийхийн тулд зээл аваад энэ эдийн засаг, нийгэмд үр өгөөжөө өгөх төслүүдээ хэрэгжүүлж байгаа юм. Түүнээс биш өр аваад бид цалин хөлс тавиад байгаа ойлголт огт биш. Харин ЗГ энэ Өрийн удирдлагын тухай хууль болон төсвийн хүрээн дээр тавьсан энэ харьцаагаа л барьж явах гэж байгаа юм.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Яах вэ ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсөл дотор би дэмжиж байгаа сайн гэсэн зүйлүүдээ хэлэхээр сайн гээд санал нийлээд хэлчихсэн зүйлийг минь эргэж надад ярьж өгөөд байх юм. Энэ нь болохгүй юм биш үү, энэ нь ямар учиртай юм бэ, энэ эргэлзээтэй байна гээд хандсан зүйлийг нь ярьдаггүй. Төсвийн хүрээний мэдэгдлээс би нэг зүйлийг хэлж байгаа юм. Тэр хязгаар 2 хувь гэж байгаа шүү дээ. Тэр 2 хувийг энэ төсөл дотор оруулж ирэхдээ 2 хувиар нь таазаар нь тулгаад оруулаад ирчихсэн байна. 1.7, 1.5 байж болоогүй юу гэж асуусан? Түүнээс биш би тэрийг алдагдалгүй төсөв байх ёстой гэдэг утгаар огт яриагүй. Жоохон тийм нэг ёсондоо хязгаар 2 хувь, төсөв 2 хувийн нөөц тэг гэдэг тоо надад харагдаад байгаа байхгүй юу. Нөөцөө авч үлдэж болоогүй юм уу гэж асуусан. Тэгээд дээрээс нь дүрмээ давчхаад дүрмээ өөрчилж байна, 5 заалтыг хүчингүй болгож байна, 3 жилийн дотор өр.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Өр 12 наядаар нэмэгдээгүй 5.2 их наядаар нэмэгдэж байгаа. Тэр зардлын 2 хувийг яагаад та бүрэн ашигласан юм гээд байна. Нэгэнт бид төсвийн хүрээн дээр өөрчлөлт ороод төсвийн тэр суурь зардал ойлголтыг бид шинэ хуулиараа төсвийн 24 онд хэрэглэж байсан хуулийнхаа анхны хэлбэрт нь аваачихаар зэрэг алдагдал дээр чинь 1 их наядын орон зай гарч ирж байгаа юм. Тэр орон зай дээр нийслэлийн хуримтлагдаад байгаа, санхүүжүүлж чадахгүй байгаа төсөл, хөтөлбөрүүдээ явуулъя гээд 988-аар буюу 1 их наядаар нь оруулж ирж байгаа юм. Нэг ёсондоо та бүхэн хавар ярьж байсан нийслэлийн төсөв гадуур яваад байна гэж байсан бол бид улсын нэгдсэн төсөвтөө энэ алдагдлынхаа хүрээнд нийслэлийн хуримтлагдсан зардлыг санхүүжүүлэх байдлаар нэгдсэн төсөвтөө нэгтгэж оруулж ирж байгаа юм. Төсвийн сахилга бат талаас.

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Гунигтай байна нөхөд өө. Энэ зун Монголчууд бид ямар айхтар дарамтад амьдрал. Юмны үнэ тэнгэрт хадчихсан, ядаж байхад яг зуны дэлгэр сайхан цагаар хүмүүс хөдөө, гадаа аялдаг цаг хугацаан дээр шатахууны хомсдолд орчихсон, зуны энэ цөөхөн өдрүүдийг бид бүгдээрээ л энэ шатахуунд очерлож өнгөрүүлээ шүү дээ. Сая 9 сарын 1 болох гэж байхад гол, гол худалдааны төвүүдийнхээ хавь орчимд хөл хорьчихсон, одоо гэсэн хичээл, сургууль эхэлчхээд байхад тэгш, сондгой дугаарын хязгаарлалтад орчихсон. Ер нь хүмүүс яаж энэ ажил, амьдралаа зохицуулах ёстой юм бэ. Ийм л хүнд нөхцөлд бид амьдарч байна.

Тэгэхээр энэ асуудлуудаа УИХ дээр ярья, энэ үнийн өсөлтийг яах юм, энэ инфляцаа ер нь яаж зогсоох юм, төсвөө цаашид ер нь яах юм гэдэг асуудлыг ярьж гээд УИХ дахь АН-ын бүлгээс удаа дараалан шаардлага тавьсан. УИХ-ын дарга бидний шаардлагыг хүлээж аваад ээлжит бус чуулган зарлаад, тэгээд 1 долоо хоногийн өмнө ч гэсэндээ энэ асуудлуудаа ярьж байгаад баяртай байна.

Харамсалтай нь ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн тодотголын төсөл бидний хүлээлтэд огт хүрсэнгүй. Тэгэхээр яг бид төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа учраас энэ төсвийн хүрээний мэдэгдэлд хамаарах 9 тооны хүрээнд л ярьж гэж бодож байна. 2026 оны эхний 7 сарын байдлаар төсвийн алдагдал 2.2 их наяд төгрөг хүрчихсэн байгаа. Төсвийн орлого тасалдсан байж байгаа. Тиймээс энэ төсвийн алдагдлаа бууруул, төсвийн урсгал зардлуудаа бүгдийг нь тана, ЗГ-ын бүтцээ цомхотго гэдэг шаардлагыг АН-ын зүгээс тавиад байгаа шүү дээ. Гэтэл ЗГ-аас төсвийн тодотгол өргөн мэдүүлэхдээ төсвийн алдагдлаа бүр даруй 2 дахин нэмэгдүүлээд 2 их наяд гаргачихсан ийм тодотгол оруулаад ирж байгаа юм. 1.4 их наяд төгрөг хэмнэсэн гээд байгаа боловч яг бодит зардлын зүйл ангиллаар нь шүүгээд үзэхээр ер нь хэмнэгдсэн зардал маш цөөхөн байна.

Хамгийн гол нь инфляц 13 хувьтай байгаа гэж байгаа. Хүнсний инфляц 25 хувь нөгөө махны үнэ, төмсний үнэ юу болж байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Сая би буруу сонсоогүй бол Монголбанк инфляц оны эцэст 12, 13 хувь болно гэсэн тооцоо гаргасан, судалгаа гаргасан гэж хэлэх шиг боллоо. Гэтэл тэгвэл яагаад бид төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ 2026 он дээр 8 хувь гэхчихсэн тоо яриад тавьчихсан, тэр тооныхоо хүрээнд яриад байгаа юм бэ? Угаасаа одоо энэ 13 хувьтай байгаа инфляц чинь яаж ч бодсон гэсэн энэ 8 хувь дээр очихгүй нь байна шүү дээ. Дээрээс нь ингээд төсвөө тэлээд оруулаад ирчихсэн. Энэ 13 хувь гээд бидний яриад байгаа энэ тоонд яг энэ наадмын дараагаас бий болсон энэ шатахууны үнийн өсөлт, дээрээс нь энэ 2026 оны 2 дугаар хагасаас ингээд нэмэгдсэн дулаан, цахилгаан, цэвэр, бохир усны тарифын нэмэгдлүүд энэ тэр ерөөсөө огт ороогүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ суурь үнүүд чинь бүгд нэмэгдчихээд байна. Тэгэхээр энэ суурь үнийн чинь шок ямар нөлөөлөл үзүүлэх юм бэ? Дээрээс нь энэ төсвийн тэлэлт чинь ямар нөлөөлөл үзүүлэх юм бэ? Энэ инфляц дээр 8 хувь байна гэж байхгүй болчихлоо шүү дээ та минь ээ. Тэгээд бид яагаад ийм хийсвэр тоон дээр энэ төсвийн хүрээний мэдэгдлээ авч үзээд, тэгээд энэ дээрээ бүгдээрээ ухаантай юм ярилцаад ингээд суугаад байгаа юм бэ?

Төсвийн тогтвортой байдлын хуулийг 22 удаа, 23 дахь удаагаа засах гэж байна гээд л бүгдээрээ л халаглаж л байна. Тэгээд би Ерөнхий сайдыг гайхаж байна 2024 онд энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3-ыг өөрчилж гэж байхад та Оюун-Эрдэнийн ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан хүн. Таны боож оруулж ирсэн тодотгол дээр энэ таны гайхаад дэлхийд байхгүй зүйл энэ тэр яриад байгаа энэ өөрчлөлтийг чинь тухайн үед тэгээд оруулсан шүү дээ. Яахаараа дандаа ингээд өчигдөр төрсөн юм шиг яриад байгаа юм бэ? Та нар тэнгэрээс унаж ирчхээд, одоо л энэ бүх зүйлтэй танилцаж байгаа юм уу? Та тухайн үед тэр ЗГХЭГ-ын дарга байхдаа тэрийгээ ЗГ дээр эсэргүүцсэн юм уу?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараа нь Монголбанк бэлдэж байгаарай. ЕС.

Н.Учрал: Удирдаж чадах инфляцаа удирдах гээд энэ улирлын инфляцыг багасгах, хязгаарлах төсвийг л оруулж ирж байна. Яах вэ та сэтгэл хангалуун биш,

хүлээлтэд чинь хүрэхгүй байна гээд та хэллээ. Юу ч яриад танд угаасаа хүлээлтэд хүрэхгүй тэр ойлгомжтой. Нөхцөл байдал ийм л байгаа юм. Тийм учраас ЗГ инфляцыг удирдахын тулд, улирлын чанартай инфляцыг удирдахын тулд энэ төсвийг өргөн мэдүүлсэн тодотголын. Энэ тодотгол өөрөө юу юм бэ гэхээр төсвийн орлого буурсан би танд хэлсэн шүү дээ. Тэр онцгой татвар тэглэгдсэнтэй холбогдуулаад төсвийн орлого буурсан, Евразийн хэлэлцээрт нэгдсэнтэй холбогдуулаад буурсан. Тэр 700 гаруй тэрбум төгрөг тэр худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил буурсантай холбогдуулаад энэ бензин, шатахууны хомсдолоос болоод автомашин орж ирэх тоо ч багассан. Ингээд буурсан. Нийслэл төсөв давуулж баталчихна, тэр төсөв давуулж баталчихаад байгаа дансандаа байгаа мөнгөө хэрэглэж чадахгүй хязгаарт тулсан. Ингээд өвөлжилтдөө тэрийг зарцуулъя гэхэд нь бид алдагдлынхаа орон зайн дээр оруулж ирж байгаа юм. 1.4 их наядыг танасан уу гэвэл танасан. Энэ татвар буурсантай холбогдуулаад үүнийг ТӨК-ийн ногдол ашгаар нь нөхье гэж байгаа юм.

Тэгээд энийгээ стратегийн нөөц бүрдүүлэх дээр 5 чиглэлд зарцуулъя гэж байна. 12 мянган тонн хүнсний ногоо, 100 мянган тонн улаан буудай, 20 мянган тонн мах, бензин, шатахууны сав 20 тэрбум татаас, 150 мянган м3 сав баригдчихсан байна. Ирэх жил дахиад 150 мянга нэмэгдэнэ. Монгол Улс түүхэндээ анх удаа нөөцийн савтай болж байна. Энийг нь Батчимэг гишүүн мэдэж байгаа. Хувийн хэвшил манлайлаад маш олон савуудыг барьж байна шүү дээ. Энэ цаг үеэ ашиглаад бид хувийн хэвшлийнхээ дэмжлэгтэйгээр нөөцөлье гэж байгаа. Бид Жаргалан гишүүнээ бид 97 хувийг нь бензин шатахууныг импортолж авдаг улс. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийг би өөрийнхөө хяналтад аваад шахаж байгаа. Газрын тосны эрэл, хайгуул 14 байршил дээр ил явж байна, түүхий эд. Би энэ газрын тосны үйлдвэр чинь 28 оны төгсгөл гэхэд шахаад дуусах гээд явж байна. Би ажил аваад 4 сар болж байна. Асуудлыг сууриар нь шийдэх гэж байна. Та залуу хүн байж ингээд нэг Учрал юу ч ярьж байвал буруу гэж байгаа юм шиг ингэж хандах юм. Та тэртээ тэргүй миний энэ барьж ирсэн төсвийн тодотголыг уншаад мэд гэж байгаа шүү дээ. Та заавал энийг ингэж буруугаар нь харж, унших ямар ч шаардлагагүй шүү дээ. Зөв юмыг нь зөв гэж, буруу юмыг нь зөв гэж та бид залуу хүмүүс.../минут дуусав/

С.Бямбацогт: Монголбанк хариулъя, 3.

Г.Энхтайван: Жаргалан гишүүний асуултад хариулъя. 7 дугаар сарын инфляц түрүүн хэлсэнчлэн 13 хувьтай байгаа, оны төгсгөлөөр хэрвээ одоо өргөн баригдаад явж байгаа төсвийн тодотгол энэ хэвээрээ батлагдах юм бол инфляц 12 сарын эцсээр 11.7 орчим хувьтай гарах урьдчилсан төсөөлөлтэй байгаа. Тэгэхдээ төсөөлөл учраас энэ суурь нөхцөл байдлууд өөрчлөгдөх юм бол өөрчлөгдөх боломжтой. Төв банк дунд хугацаандаа инфляцыг 6 дээр нэмэх, хасах 2 хувьд тогтворжуулна гэсэн бодлогын зорилттой, дараа оны 2 дугаар хагасаас эхлээд Төв банкны бодлогын зорилтот түвшинд ойртох болов уу гэсэн хүлээлттэй байна.

С.Бямбацогт: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Та залуу хүн, тэгээд сая Ерөнхий сайдын ажлыг авлаа. Таны яг ингээд оруулж ирж байгаа анхны төсөв энэ байлаа. Тэгээд бид өөрсдийнхөө цаг хугацаан дээр ингээд нэг бодитой, зоригтой шинэчлэл, реформ хийх ёстой шүү дээ. Гэтэл та өмнөх Засгийн газруудынхаа бүх алдааг яг давтаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Оюун-Эрдэнийн ЗГ ковидын /COVID-19/ үед 10 их наядын төлөвлөгөө

энэ тэр гээд л энэ хамаг төсвөө тэлээд л байсан, бүх зардлуудаа нэмэгдүүлээд л байсан. Эдийн засаг дахь төрийн оролцоог нэмсэн. Тэгээд одоо бид төрийн горьг амсаж байна шүү дээ. Дараачийнх нь та болж байна шүү дээ. Тэгэхээр энд чинь ерөөсөө ямар ч бодлогын шинэчлэл, реформ харагдахгүй байгаад байгаа учраас аргагүйн эрхэнд бухимдаад байна шүү дээ. Бид энэ бүх алдааныхаа горьг дахиад хэдэн жил амсах юм бэ, тийм биз? Тэгээд иргэдийн орлогыг энэ хэцүү, хүнд цагт дэмжих ёстой, хамгаалах ёстой. Гэхдээ хувийн хэвшлийг төсөв тэлж дэмждэггүй байхгүй юу даа. Цаана чинь хувийн хэвшилд ажиллаж байгаа сая гаруй иргэн байна шүү дээ. Зөвхөн төрийн албан хаагчдын цалин.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ирэх оны төсвийг ярихад дэлгэрэнгүй ярьж болно ирэх долоо хоногт. Тэгэхдээ төсөв огт тэлээгүй. Би хариуцлагатай хэлчихье. Төсвийн тодотгол дээр хэллээ шүү дээ. Цалин хөлс нэмэгдүүлээд эх үүсвэргүй цалин нэмчихсэн байсан, орлогыг нь хаанаас оруулж ирэх вэ гэвэл төрийн өмчит ногдол ашиг, дээрээс нь зардлаа хэмнээд 1.4 их наядыг гаргаж ирж байна шүү дээ. Дээрээс нь нэг талаасаа тэр тэтгэвэр, тэтгэмжээ 11 сарын 1-нээс нэмж тэр нэг бага тэтгэвэр авч байгаа ахмадуудынхаа тэтгэврийг нэмье гэж байна шүү дээ. Орлогыг нь хамгаалахын тулд тэр цалин хөлсөн дээр нь тэр нэг салбарыг тухайлан авч үзэхгүйгээр 50 хувьд нь хүргэе гэж байна шүү дээ зарчим нь. Тусгай шаардлага дотор ямар ч өөрчлөлт хийхгүй. Тэр нийслэл дээр тэр тусдаа Иргэдийн хурал өөрөө улсын төсвийг давуулж баталж байгааг энэ хайрцагтаа оруулж ирье гээд хариуцлагажуулж байна шүү дээ. Иргэддээ л тэгж хүргэж байна шүү дээ. Ирэх оны төсөв тэр чигээрээ реформ. Бид 4 сарын хугацаанд бүх реформуудыг хийж дуусгасан шүү. Харин 1 сарын 1-нд мэдэрнэ.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Жаргалан гишүүнээ энэ төсвийн бодлого байна шүү дээ энэ төсвийн тодотгол эдийн засгийг бид хүндрэлтэй, жоохон агшилттай байна гэж үзээд байна шүү дээ. Тэгэхээр энэ эдийн засгийн агшилтын үед төсвийг тэлэх нь их чухал байгаа. Эдийн засаг халаад эхлэх юм бол төсвийг хумиад, ингээд мөчлөг сөрсөн ийм эдийн засгийн тогтвортой байдлыг л хангахад чиглүүлж байгаа шүү дээ. 26 оны эхний хагас жилээр эдийн засгийн дотоод идэвхжил хэд хэдэн салбар сулраад, өрхийн орлого 4.8 хувиар унаад байгаа байхгүй юу. Энийг бид идэвхжүүлэхийн тулд энэ бодлогын арга хэмжээ, цалин хөлс, тэтгэврийн нэмэгдэл худалдан авалтыг идэвхжүүлэх ажил руугаа л энэ төсвөөр дамжуулж нөлөөлж байгаа шүү дээ. Хэрэв ингээд хамгийн гол асуудал энэ тодорхой бус байдал гадаад, дотоод орчиндоо хүчтэй нөлөөлөөд байна л даа, дэлхий ертөнцийн тодорхой бус байдал. Энэний нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил ингээд сулрах эрсдэл байгаа юм. Тэгэхээр энийг сөрсөн бодлого чинь энэ төсвийн тодотголоор дагаж орж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна, алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Ингээд 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийг бид хэд хэлэлцэж байна. Энд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг. Ер нь энэ нэг төсөв хэлэлцдэг процедур, төсвийн талаарх баримтлах бодлогын зохицуулалтуудаа нэг эргэж хараад цэгцлэх цаг болжээ. Тэгээд энэ асуудлуудаа яг нэг тодорхой хэмжээнд уян хатан зохицуулж чадахгүй учраас ингээд

л нөхцөл байдал нь нэг ийм улс төр болсон байдалтай л яваад байна. 1 дүгээрт энийг шинэчлэх, бүхлээр нь Төсвийн тогтвортой байдлын хуулиа нэг эргэж харъя. Төсвийн тухай хуулиа нэг эргэж харъя. Төсвийг төлөвлөхөөсөө эхлээд төсвийн гүйцэтгэлийг гаргуулах хүртэлх энэ процессоо нэг эргэж харъя.

2 дугаарт бидний зовлон ойлгомжтой л байна л даа. Нөгөө үйлдвэрлэгч биш, боловсруулагч биш, үйлдвэрлэе, боловсруулъя гэхээр гаднын явуулга байдаг юм уу, энд гаднын явуулгад өөрөө орж байгаагаа ч мэдэхгүй хэсэг бүлэг хүмүүсийн гацаадаг, нураадаг, эсэргүүцдэг, эх оронч баг зүүж байгаад, ард түмний нэр барьж байгаад бүх зүйлүүдийг гацаадаг, саатуулдаг, дараа нь хожим нь маш өндөр өртөгтэйгөөр тэр асуудлыг шийдэхээс өөр гарцгүй байдал руу тулгаж оруулдаг энэ нөхцөл байдал сүүлийн 30 жил явлаа шүү дээ. Энд л харагдаж байгаа. Тэгээд ер нь суурь юм уу бараа бүтээгдэхүүний суурь өртөгт нөлөөлж байгаа энэ зүйлүүдээ л бид хэд анхаарахаас өөр аргагүй гэдэг нь л харагдаж байна л даа. Ядаж нефть боловсруулах үйлдвэрээ 50 хувиа ядаж хангахын төлөө л маш нэг өдрийг ч гэсэн нааш нь татаж авчрах хэрэгтэй л байна. Эрчим хүчний найдвартай бөгөөд өрсөлдөөнт байдлаар зах зээлийг хямдруулах бололцоог бид бүрдүүлмээр байна.

Ажиллах хүчний бодлогоо бид хэд анхаармаар байна. Ядаж дотоодын зах зээл дээр энэ нийлүүлэгдэж байгаа гэж ярих уу, бий болж байгаа энэ ажиллах хүч чинь ажил олгогчийн чинь эрэлт хүлээлтийг гүйцэхгүй байна шүү дээ. Зөрүүтэй байна. Тэгээд энэ ажилгүйдлийн түвшин чинь энэ чигээрээ нэмэгдэж байна. Жижиг ААН, байгууллагууд чинь тэр зөрүүтэй бэлтгэгдэж байгаа боловсон хүчнийг чинь бэлтгэх зардлыг гаргаж чадахгүй байгаа байхгүй юу. Тэр боловсон хүчнийг бэлдэнэ гэдэг чинь 2-оос 3 жил том ачаа үүрч явна гэсэн үг. Бэлдээд гараад ирэхээр нь том ААН-үүд нь цалингаар татаад авчихдаг ч юм уу. Тэгээд бид хэд энэ ерөөсөө ингээд л том зургаараа эргээд яриад л байдаг, яриад л байдаг энэ зүйлүүд шийдэгдэхгүй байгаагийн нэг зүйлүүд гараад байгаа гэдэг зүйл эндээс харагдаж байна.

Дээрээс нь нэг зүйл байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя нэлээн том дүгнэлтүүд байна. Төсвийн тусгай шаардлагыг чангатгах хэрэгтэй байна, дорвитой бодлого хэрэгтэй байна. Ийм яг улс төрч шиг хандаж, ийм дүгнэлт гаргадгаа болимоор байна. Эсхүл энэний бүрэлдэхүүнд нь 30 хувьд нь Сангийн сайд байсан, Сангийн яамны дэд сайд байсан хүмүүс орог, тэгээд юмаа шийдэг. Хэт онолын ч юм шиг, мэргэжлийн ч юм шиг ингээд ойлгомжгүй, бид хэд энд нь ингээд л улс төрчид нэг ийм шипи ч юм шиг нэг юм болоод л хэрүүл хийлгэх гээд л. Тэгээд яг энэ дээр ингээд тоймтой барьж байгаа бодлогын ерөөсөө санал, зөвлөмж байхгүй. Тэгэхээр энэ дээрээ яг илэн далангүй хэлээч, яг энэ ажиллах хууль, эрх зүйн орчны хувьд яг юу гэж бодож байна вэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс?

2 дугаарт энэ ТӨК-ийн ногдол ашгийг хэдүүлээ буруу, зөв ойлгоод явж байна. Энэ хуулийн этгээдийн засаглалд ерөөсөө орох гээд байгаа зүйл биш. Энийг олон жил хийчихье гээд л явсан шүү дээ. Энэ зах зээл дээр байгаа мөнгө байхгүй юу. Шинээр нийлүүлэх гэж байгаа гэж би ойлгохгүй байгаа. Тэгэхдээ би ЗГ-ын тэргүүнээс асууя. Энэ байгаа мөнгийг харин олж ирж байгаагийн хувьд урсгал зардал санхүүжүүлж болохгүй шүү. Энэ бүтээн байгуулалт, юу гэдэг юм, энэ хувийн хэвшлийг дэмжих, хувийн хэвшил, бизнесийн орон зайгаа тэлэх тэр зүйлүүд рүү зарцуул. Түүнээс биш ингээд урсгал зардлууд санхүүжүүлдэг байдлыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээе, нэг минут нэмье.

П.Сайнзориг: Урсгал зардлыг л бид хэд одоо юунаас санхүүгийн эх үүсвэр олж ирэх гэдэг юм уу, төсвийн орлогыг олохоо мэдэхгүй байж л уралдаж энэ урсгал зардлыг нэмэх асуудал дээр л яаравчилж байгаа шүү дээ. Тэгээд яг үнэндээ хэлэхэд нэг хуулиар цалин хөлсний бодлогыг зохицуулаад бүх юм шийдэх гээд байгаа зүйл биш шүү. Энэ цэвэр энэ танхимын мэдрэмжийн асуудал. Тэгэхээр энэ дээрээ анхаараач. Тэгээд ер нь энэ ТӨК-удын ногдол ашиг авч байгаа бодлогын цаана энэ компаниудыг олон нийтийн болгох ажил явагдах ёстой гэж харагдаж байна. Ядаж Эрдэнэтийн 20, 30 хувийн хувьцааг зөвхөн Монгол Улсын иргэдэд авах санал болгох энэ ажлыг нь намар хийчихвэл яадаг юм бэ, ирэх жилээс Ерөнхий сайд, энэ дээр та ер нь ямар байр суурьтай байна?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя.

Н.Учрал: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл төсвийн зарлагыг нэмэгдүүлж байгаа нь ард түмний амьжиргааг хамгаалахад зориулагдана, энэ нь өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн гэж дүгнэсэн, дүгнэлтийг харахаар тийм. Тэгээд ер нь цаг үетэйгээ нийцсэн, энэ хүнд цаг үеийг давж гарах нүдээ олсон төсвийн тодотгол байгаа нь стратегийн нөөцүүдийг бүрдүүлэх болоод яг энэ иргэдээ цалин, хөлс, орлогынх нь баталгааг хангуулах чиглэлээр хийж байгаа алхмуудтай би холбож тайлбарлаад байгаа юм.

ТӨК-удын ногдол ашиг зах зээлд шинээр нийлүүлэгдэж байгаа энэ эрэлтийн динамик дээр шинээр нийлүүлж үүсгээд байгаа зүйл биш шүү. Энэ байгаад л байна мөнгө. Энэ шинээр нийлүүлэгдэж байгаа мөнгө огт биш. Харин Их Хурал дээр ногдол ашиг ирээд яригдаад үүнийг нь та бүхэн батлах гэж байгаагаараа онцлогтой. Тэрнээс биш энэ тэр ТӨК-уд дээрээ байгаад ТУЗ нь хуралдаад нөгөө нэг хэрэгтэй, хэрэггүй юманд зараад ингээд байвал байна шүү дээ. Байгаад л ирсэн юм чинь, байлганаар байвал байгаа сонирхол хэнд байгаа юм гээд байгаа байхгүй юу. Яагаад ТӨК ашигтай ажиллахад түүнийг нь аваад татвар бууруулахад зориулъя гээд, 15 мянган жилд ажлын байр шинээр хийе гэхээр энэ жинхэнэ реформ шүү дээ. ТӨК-ийн хууль засаг бариад та бүхэн баталсан. 30 хувь багадаа дээшээ ашигтай ажиллуулахыг хуульчилчихсан. Энэ төсвийн тодотголоор Үнэт цаасны хуульд өөрчлөлт орж байгаа, Үнэт цаасны хуулиар төрийн өмчит уул уурхайн компани 50-иас илүү хувьцаа эзэмшигчтэй бол 2 дахь зах зээл дээр шууд бүртгэнэ гэж байгаа юм. Энэ юу вэ гэхээр банк гэсэн ганцхан тулгууртай эдийн засагтай болчихоод байна шүү дээ Монгол Улс, ганцхан тулгууртай, энийг 2 болгохын тулд ЭТТ компанийг 2 дахь зах зээл дээр бүртгэх ажлыг энд Үнэт цаасны хуулиар хийж байгаа байхгүй юу.

Ингэсний дараа 1072 хувьцааг 2 дахь зах зээл дээр бүртгээд нээлттэй болгоно, компани нээлттэй болно. Үүний дараа Сайнзориг гишүүний яг хэлж байгаа Эрдэнэт үйлдвэр шинэ хуулиараа энэ чинь компани болно шүү дээ. Энэ компанийн тодорхой хувьцааг нь тэнд тухайн оршин суугаа иргэд нь давуу эрхтэйгээр ч юм уу, бусад иргэддээ ч юм уу хувьцаа болгоод өгөх ёстой байхгүй юу. Ингээд хувьцаа эзэмшигчид үйл ажиллагаанд нь оролцдог зарчим руу шилжиж байж, иргэд, олон нийт хяналтаа тавьж байж Монголын ард түмэн баялагтаа эзэн болно. Тэгж байж энэ эдийн засаг чинь банк, хөрөнгийн зах гэсэн 2 тулгууртай болно. Энийг ЭТТ компани дээр харуулах гэж байгаа юм. Тийм ч учраас 3 дахь өдөр БлэкРок /BlackRock/ ирэх гэж байна, 20 төрийн өмчийн компанийг бирж дээр гаргаж үзүүлнэ.

Үүний цаана санхүүгийн зах идэвхэжнэ. Ингэснээр иргэд, олон нийт жинхэнэ байгалийнхаа баялагт эзэн болох байхгүй юу. Тэр л их чухал. Би санал нэг байна.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя, 3 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид дүгнэлт дээрээ тодорхой саналуудыг шууд өгч байгаа гэдгийг хэлье. Бид 2, 3 зүйлийг л шууд хүсэж байгаа юм. 1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөхгүй байхыг, мөн төсвийн тусгай шаардлагуудыг чангатгах гэдэг дээр бид зардлын өсөлтийг хязгаарлах саналыг энд өгсөн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-ыг өөрчлөх нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг ерөнхийдөө сулруулж байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн энэ заалтыг хэвээр байлгах, үүнээс гадна дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг шинэчлээд өгөөч гэх мэт тодорхой саналуудыг хэлсэн. Дорвитой гэдэг дээр бид 2 жилд 2, 3 зүйлийг л байнга давтаж хэлж байна. Төрийн оролцоог бууруулъя. Хувийн хэвшлийг дэмжсэн бодитой бодлого явуулъя, тэр зардлыг танаж хувийн хэвшилд орон зай гаргаж өгөх энэ чиглэл рүүгээ явъя гэсэн энэ саналыг бид дорвитой бодлого гэдэгтээ хамруулж хэлж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Ямар ч байсан энэ ТӨК-ийн талаар баримталж байгаа энэ бодлогыг үргэлжлүүлээсэй гэж хүсэж байна. Монголд байгаа авлига, ашиг сонирхол, энэ далд гэдэг юм уу бид хэдийн хяналтгүй байгаа эдийн засгийг нэг цэгцтэй, сахилга баттай болгох энэ асуудлууд ингээд цэгцрээд явна. Энэ компанийн хэвийн үйл ажиллагааг харин алдагдуулж болохгүй. Тэр техник, технологио нэмэгдүүлээд явах ёстой, харин шударгаар хувийн хэвшил болон бусад оролцогчидтойгоо өрсөлдөөд явах ёстой. Харин цэвэр ашигтай ажилласан тохиолдолд түүгээрээ булагнадаг байсан мөнгийг одоо байхгүй болж байгаа л гэсэн үг. Булагнуулахгүй гэсэн үг. Халаасандаа нэг хэдэн чихэр тасалж авч идчихээд бага багаар идээд яваад байдаг хүмүүс байдаг шүүдээ. Иймэрхүү байж болохгүй л гэсэн үг. Тэр лүү чинь улс төрчдийн гар хөл нь тэмүүлээд байгаа байхгүй юу. Энэ бүх зүйлийг таслан зогсоож байгаа гэж би ойлгож байгаа. Тэгээд энэ ТӨК-ийн ногдол ашгийн бодлогыг энэ банк, санхүүгийн салбар дээр ч гэсэн анхаараарай. Хөгжлийн банк гэхэд л ирэх өнгөрсөн жил.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ, гүйцээгээд асуучихъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Жишээ нь энэ банк, санхүүгийн салбар, төрд байгаа 2, 3 банк байна. Өнөөдөр орон сууцны банк байгуулах гэдэг юм уу бөөний банк байгуулах асуудал намрын чуулганаар хэлэлцэх гээд байж байтал Төрийн банканд нэг дөнгөн данган, гэтэл Хөгжлийн банк нь 289 тэрбум төгрөгийн алдагдалтай өнгөрсөн жил ажиллажээ. Яах юм бэ? Тэгэхээр энэ бүх зүйлүүд дээрээ хариуцлага, хяналт, ил тод байдал, эргээд энэ бүх зүйлүүдээ анхааръя. Нэг талдаа болгох гээд үзээд байдаг, нөгөө талдаа нэг ийм нөхцөл байдлууд ингээд яваад байх нь энэ бодлогын цэгцрэлт цаашдаа явахгүй гэсэн үг. Тэгэхээр энэ дээрээ анхаараач. Тэгээд энэ төсөв хэлэлцэж байгаа хууль, эрх зүйн орчноо нэг цэгцэлчихье, тэгэхгүй энд ингээд л нэг зарим улс төрчид нь төсвийн сахилга бат гээд л ингэж гүйгээд л, рекламдаж гүйгээд л бид төсвийн сахилга батыг цэгцэлж байна гээд байдаг. Яг үнэндээ хэлэхэд

төсвийн тусгай шаардлагыг бариулж болно, тэгэхдээ энэ дэлхийн гадаад бодлого гэдэг юм уу энэ нөхцөл байдлуудыг чинь дайн байлдааныг бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Санал хэлчихлээ. УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайд гараад явчихлаа. Төсөвтэй холбоотой асуудал дээр үндэслэл, нотолгоо бүхий логиктой асуулт асуугаад байр сууриа илэрхийлэхээр тухайн Их Хурлын гишүүн рүү зохион байгуулалттайгаар гүтгэлэг, дайралт хийж, гэр бүл рүү нь, эцэг эх рүү нь халдаж, ямар нэгэн байдлаар харлуулах гэсэн увайгүй үзэгдэл одоо ч Монголын төрд идэвхтэй байгаад байгаа. Тэрний нэг жишээлбэл нэг хохирогч нь Батбаярын Жаргалан гишүүн, манай Цэнгүүн гишүүн. Ялангуяа эмэгтэй хүн рүү бүр эрээ цээргүй дайрах юм. Энэ бол яаж байна гэхээр хэвлэлд, олон нийтийн харилцаанд төрийн бодлогыг хөтлөгдүүлж явуулах гэсэн арга ядсан алхам.

Их Хурлын индэр дээрээс хариуцлагатайгаар хэлэхэд зарчмын байр суурь илэрхийлж байгаа, аргумент дэвшүүлж байгаа гишүүд рүүгээ хэвлэл мэдээллийг зориудаар өдөөн хатгаж, зохион байгуулалттайгаар төлбөртэй мэдээлэл явуулахыг эрс эсэргүүцэж байгаагаа хэлье, ЗГ-ын тэргүүнээ. Өрсөлдөх чадварын үндэсний тайлан гаргадаг компетитивнес индекс /competitiveness index/ гаргадаг ОУБ-ын үзүүлэлтээр сүүлийн 10 гаран жил Монгол Улсын эдийн засгийн гэдэс дотрыг шинжилж үзсэн. Хөгжил, дэвшлийг боомилж байгаа, чөдөрлөж байгаа 5 гол шалтгаант нөхцөлийн нэгд нь, хамгийн эхэнд нь төрийн данхар бүтэц. Их Хурлын дарга ч гэсэн яг энэ талаар Шинэ Зеланд улсад очиж судалгаа хийж байсан. Нийтийн өмч, төрийн өмчийн асуудлаар, төрийн энэ данхар байдал төсөв дагаж орж ирдэг. Үүнийг нь шийдэх хуулиуд явж байгаа.

Тэгэхээр энэ төсөв данхар байна гэдэг чинь өөрөө иргэдийн амьжиргаанд хүртээмж муутай, нөгөө л төсвийнхөө арга ясыг цусны эргэлтээр хангах гэсэн асуудал учраас Жаргалан нарын гишүүд ингэж шүүмжлээд байгаа юм. Манай улс нэгдмэл улс Үндсэн хуулиараа. Харамсалтай нь төсвийн төсөөлөл нь, хүрээ нь, төсөв нь өөрөө холбооны улсын хэв маягтай орж ирдэг. ЗГ огцрох, эс огцрох барьцаа нь төсөв болдог, улс төрчдийн шантааж нь төсөв болдог, дахин сонгогдох тойргоо бэлдэх нь төсвийн хуваарилалт болдог ийм л эмгэнэлтэй дүр зураг харагдаад байгаа юм. Сууриар нь асуудлыг яаж өөрчлөх вэ гэдэг дээр бид анхаарах ёстой. Улс төрийн мэдэгдэл хийгээд популизмд автаад, хэдэн биеийгээ улс төржиж намнадаг нам дагасан хүмүүс биш Монголын ард түмний өмнө, Монгол төрийн өмнө тангараг өргөсөн төрийн түшээдийн хувьд бид асуудалд хандах ёстой. Түүний хамгийн гол уугуурга нь төсвийн асуудал.

Тийм учраас Монгол хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж байгаа, Монгол хүний амь насанд заналхийлж байгаа, өвчлөлтийг дэвэргэж байгаа суурь шинжтэй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлж, хөгжлийн хөтөлбөрөө төсвийн төсөөлөл, хүрээгээ оруулж ирдэг байя гэж олон удаа зарчим хэлсэн. УИХ-ын дарга ҮАБЗ-ийн 3 хүнийх нь нэг явж байгаа. Тийм учраас энэ асуудлыг Магнайсүрэн дарга олон хүмүүст хэлсэн. Өнөөдөр ойлголт авах нь бол шинэ үзэл баримтлал батлагдсаны дараа энэ шалгуур үзүүлэлт гарна гэдэг байдлаар хойшлогдоод байгаа юм байна. Тийм учраас энэ асуудлыг яаралтай оруулж ирмээр байна. Бид энэ байгаа төсөв дотроо мянган удаа

чи би дээ хүрсэн ч гэсэн суурь шинжтэй асуудлуудыг шийдэж чадахгүй л байх юм бол Монголын зовлон дуусахгүй. Улс төржиж дуусахгүй, хэрүүл дуусахгүй. Тийм учраас Монгол Улсын хөгжил гэдэг нэг шалгуураар богино, дунд, урт хугацааны 10 гаран бодлогын бичиг баримттай нийцүүлж энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Доржзовдын Энхтуяа гишүүн үгээ хэлье.

Д.Энхтуяа: УИХ-ын дарга та яг ингээд төсөв хэлэлцэх ер нь энэ хуулийн хэлэлцүүлэг дээр хамгийн түрүүн таны хэлдэг үг бол энэ төсвийг батлахаар орж ирж байгаа энэ төрийн албан хаагчдыг УИХ-д худал мэдээлэл хүргэх, мөн хууль зөрчсөн үйлдэл гарах юм бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ гээд маш хариуцлагатай мэдэгдэл хийдэг. Энэ мэдэгдлээ та Ерөнхий сайдад хэлэх ёстой гэж бодож байна. Энэ хууль адилхан тэгш үйлчлэх ёстой. Ерөнхий сайд энэ төсвийн тодотголыг оруулж ирээд их л олон зүйл хууль зөрчсөн үг, үйлдэл гаргалаа гэж би ингэж харж байна.

Ерөнхий сайд энэ дайн байлдааны нөхцөл байдал хүнд байгаа учраас эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна гээд л өдөржингөө яриад суугаад байна. Харин Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлт дээрээ гадаад худалдаа маш сайн байна, харин төлөвлөлт, хуваарилалт муу байгаа учраас макро эрсдэл өндөр байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байна. Тэгээд ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд 2010 онд энэ хууль батлагдсанаас хойш 16 удаа өөрчлөлт орсон байгаа юм байна. Тэгэхээр энэ төсвийн тогтвортой байдлыг хангахгүй юм бол энэ хуулиар яах юм. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдгийг Төсвийн тогтворгүй байдлын зөвлөл болгочхоод, тэртээ тэргүй манай төсөв маш тогтворгүй, байнгын өөрчилж байдаг учраас энэ тогтворгүй энэ өөрчилж байгаа нөхцөлд энэ мэргэжлийн хүмүүс ямар дүгнэлт өгөх юм бэ гэдэг дээр хуульд нь өөрчлөлт оруулаад нэр томьёог нь ч гэсэн Төсвийн тогтворгүй байдлын зөвлөл гээд, энэ мэргэжлийн хүмүүс санаа оноогоо хэлээд, энэ дүгнэлтээ шулуухан, шударга, ийм бөөрөнхийлсөн байдлаар биш ингэж гаргаж байвал яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Дээрээс нь төсөв одоо мөрдөгдөж байгаа тусгай шаардлагыг хангаагүй байна гэж дүгнэсэн байгаа. Тэгтэл одоо хангаж байна гээд л ингээд байх юм. Тэгээд гадаад худалдааны энэ эргэлт нь маш сайн байгаа. Нүүрсний биет хэмжээ 7 сарын байдлаар 53 хувь өссөн байна шүү дээ. Тэгэхээр энэ сайд нар, Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд юм болгоныг л энэ дайн байлдаантай холбож ингэж ярихаа болиоч. Яг энэ мэргэжлийн хүмүүс чинь, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн, Сангийн яамныхан энэ тооцооллыг чинь яг гаргаж ирээд ингээд цагаан цаасан дээр хараар бичээд ороод ирчихсэн байна шүү дээ.

2-т, Төрийн өмчийн компаниудаас орлогыг нь татан төвлөрүүлнэ л гэж байна. Тэгэхээр энэ бол МАН-ын дарга, Ерөнхий сайд урьд нь энэ ТӨК-удад намынхаа авлига, хээл хахууль байсныг, идэж ууж байсныг зөвшөөрч, хүлээн зөвшөөрч байна л гэж ингэж харж байна. Өнөөдөр ухаан орж байгаа юм шиг хөөх ийм их мөнгөтэй байсан юм байна, энэ хотын захиргаа чинь, энэ нийслэл хот чинь бүр тусгай улс байгуулчихсан байсан юм байна гээд өглөө дөнгөж өнөөдөр сэрсэн юм шиг л ийм мэдэгдэл хийгээд суугаад байх юм. Тэгэхээр энэ ард түмнээ хуурдаг, энэ авлига, хээл хахуультай хүлээн зөвшөөрч байгаа, хамтарч байгаа энэ асуудлаа өөрсдөө эхлээд дотроо ярих ёстой юм биш үү. Бид нарыг, энэ ард түмнийг ингээд хуураад, өнөөдөр ард түмний цалин цавыг нэмэх гэсэн чинь АН ингээд эсэргүүцээд байна гээд мэдэгдэл хийгээд суугаад байгаа юм чинь өнөөдөр энэ 10 жилд манай АН

жишээлбэл энэ асуудалд ерөөсөө оролцоогүй шүү дээ. Өөрөө өөрсдийгөө ийм юмаа яриад ингээд суухаа сайн ичээч Ерөнхий сайдаа.

Тэгээд энэ мэргэжлийн хүмүүсийг энэ улсууд чинь та нарын улс төрийн гаргасан, Ерөнхий сайдын гаргасан шийдвэр дээр чинь л энэ тоог нь өнөөдөр мөрдөгдөж байгаа энэ хуулийн хүрээнд л нааш цааш нь махаа идээд л тэгээд л нэг юм бичээд ингээд ороод л ирчихсэн байна шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс худал хэлэх, хуулийн эсрэг ярих ийм эрхтэй хүмүүс мөн юм үү? Тэгэхээр энэ Ерөнхий сайддаа энэ хариуцлага хүлээлгэнэ, худал мэдээлэл өгч болохгүй УИХ-д хуулийн дагуу хариулах ёстой гэсэн энэ шаардлагаа энэ Ерөнхий сайдад эхлээд тавих ёстой юм биш үү, УИХ-ын даргад би хандаж энийг хэлж байна. Тэгэхээр ингэж бие биеийгээ хуурч, худлаа ярьж суумааргүй байна.

С.Бямбацогт: Энэ чинь яг өөр өөрсдийн байр сууринаас, өөр өөрсдийнхөө тоо, үндэслэл баримтуудаа яриад л манай ЗГ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, гишүүд, сайдууд үгээ хэлж байгаа. Түүн дээр гарцаа байхгүй яг ийм асуудал дээр яг ингээд худлаа хэлчихлээ, ингээд буруу мэдээлэл өгчихлөө гэх нотлогдох зүйл байвал манай гишүүдээс тодорхой саналууд гаргаж болно. Тэрийг бид Тамгын газраар нягтлуулаад, шаардлагатай бол ямар ч албан тушаалтанд хариуцлагын асуудал ярихад бэлэн байгаа. Тийм болохоор энэ дээр манай холбогдох албан тушаалтнууд анхааръя. Гишүүд иймэрхүү асуудлууд байвал өгөөрэй. Цэвэгдоржийн Туваан гишүүн үгээ хэлье.

Ц.Туваан: Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулмааргүй байна гээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн хэлээд байна л даа. Энийг нь хэдүүлээ авбал яасан юм? Ер нь тэгээд энэ удаагийн тодотгол чинь бидний өөрсдийн л алдаа байна шүү дээ. Нөгөө авах цалингийнх нь хэмжээг бүрэн тооцоолоод баталж өгөөгүйгээс болоод тэр мөнгө нь дутагдаад, тэгээд тэр мөнгө нь дутагдаад ирэнгүүт нь тодотголоо ээлжит бус зарлаж хийе гээд. Тэгээд тодотгол хийх болсон чинь нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийнхөө хуульд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт орох ийм гинжин урвалд орчихоод байна шүү дээ. Тэгэхээр бид өөрсдийн энэ хариуцлагагүй төсвөө тооцоолж хийгээгүй, дээрээс нь ЗГ-т ч юм шиг, Их Хуралд ч буруу нь байгаа юм шиг энэ асуудлууд чинь чөтгөрийн тойрогт ороод явчихлаа. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд гар хүрэлгүйгээр энэ зөвлөлийнхний саналыг авбал яасан юм бэ гэдэг ийм зарчмын санал тавьж байна.

Энэ зөвлөлийн дүгнэлт дээр тэнцвэржүүлсэн орлого 1.2 их наядын алдагдалтай, тэгээд гадаад нөхцөл байдал сайн, уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ, ханш сайн байгаа энэ үед, ялангуяа зэсийн үнэ, нүүрсний үнэ, алтны үнэ их таатай байгаа үе дээр бид ингээд тодотгол оруулж ирж байна. Тэгээд оруулахгүй байх боломж, нөхцөл байгаа л юм шиг харагдаж байгаа юм. АН-ын зүгээс энэ боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтан, эмч, багш нарын цалинг нэмэх дээр бид дэмжээд саналаа өгсөн бүгд мэдэж байгаа. Ахмадуудын тэтгэврийг нэмүүлэх дээр бүгдээрээ сууж байгаад дэмжээд саналаа өгсөн мэдэж байгаа. Тэгэхээр энийг АН-ынхан эсэргүүцээд байна гэдэг ийм зүйлийг ярихгүй байх нь зөв гэж ингэж бодож байна.

Дараа нь нэг зүйл хэлэх гээд байгаа нь энэ татварыг урьдчилж авах, энэ ирээдүйд бий болох жишээлбэл энэ он дээр аудитын дүгнэлт дээр харагдаж байлаа шүү дээ 1.2 их наядын татвар урьдчилаад авчихсан. Тэгээд тэр чинь өнөөдөр бид

Монголын энэ 26 оны төсөвт нөлөөлөөд байна шүү дээ. Одоо үлдэгдэл дахиад энэний дутуу тэр олох байсан 600 хэдэн тэрбум төгрөгийн асуудал ингээд л яригдаж байна. Тэгэхээр одоо залгуулаад тодотгол явна, тун удахгүй төсөв явна. Тэгэхээр бид энийгээ дор нь мартчихгүйхэн шиг дараагийн төсвүүдээ батлах дээрээ санаж алдаа гаргамааргүй явмаар байна. Энэ дээр УИХ-ын Тамгын газар ч гэсэн нэлээн сайн анхаарч ажилламаар байна. Ер нь тэгээд л хойд хормойгоо аваад л урд хормойгоо нөхөөд л, дараа нь дахиад л нөгөө урд хормой чинь урагдаад ингээд л явж байгаа шиг ийм л зүйл болоод байна шүү дээ гэдгийг энэ ташрамд хэлье.

Дээрээс нь түрүүн бензин, шатахууны үнэ дээр одоо ингээд яг намрын ажил болчихсон, ургац хураалт болчихсон. Төв аймгийн Цээл сумын Засаг даргын орлогч Ууганаа гээд залуу над руу ярьж байгаа юм. Ингээд яг гол ажлууд болсон чинь манай дээр Петровисын шатахуун түгээх газар байдаг, ингээд тасалдахгүй байгаа түлш чинь ч байхгүй байна, бензин ч байхгүй байна гэж. Тэгэхээр ургацын комисс хуралдаж байгаа байлгүй, энэ асуудлыг нэлээн анхаарч цаг үеийнхээ асуудлыг энэ цаг хугацаан дээр авч үзээрэй гэдэг зүйлийг энэ ташрамд хэлье.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Би өмнө нь хэлж байсан 2 санаагаа л давтаж дахиж хэлмээр байна. 1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль энэ асуудлыг бүр бүрэн эргэж харъя. Тэгээд нэгэнт УИХ-аас баталсан хууль нь төсөв дээр нэмэлт ачаалал гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа хуулиудыг ЗГ санаачилгаараа үйлчлэх хугацааг нь нааш нь татаж үйлчлүүлдэг ч гэдэг юм уу ийм зүйлийг нь болиулъя.

2 дугаарт батлагдсан төсөвтэй уялдуулахгүйгээр дагаж гарах тогтоол ч гэдэг юм уу энэ хуулиуд дээр нь алдаа гаргаж байгаа ч гэдэг юм уу, бодлогын гэдэг юм уу, эсвэл тухайн үе дэх улс төрийн шахалт гэдэг юм уу, нийгмийн энэ уур амьсгалд хөтлөгдөөд ингээд гаргадаг зүйлүүд дээр ямар тохируулга хийхээ шийдье. Бүх зүйлүүд л ерөөсөө энэ дээр байна шүү дээ. Түрүү жил багш, эмч нарын цалин дээр, ялангуяа багш нарын цалин дээр багш нарын цалинг нэмэх гэж байтал багш, ажилчид гээд л ороод ирж байгаа юм. Энэ ингээд гарчихсан байгаа байхгүй юу. Бид хэд Нийгмийн даатгалын багц хуулийг баталж ирэх жилээс хэрэгжинэ гэтэл өөрчлөөд аваад ирж байна. Магадгүй өнөөдөр хэрэгтэй байж магадгүй. Тэгэхээр бид хэд ер нь энэ асуудлуудаа нэг эргэж хараад, тоглоомын дүрэм гэдэг юм уу энэ бүх зүйлүүдээ нэг тодорхой болгочих нь зөв байх. Энэ дээрээ хэдүүлээ нэг судалгаатай, УИХ-ын дарга ажлын хэсэг гаргаад, ЗГ-тайгаа хамтраад яг энэ Төсвийн хууль батлагдсаны дараагаар энэ хуулиудыг нэг бүхэлд нь эргэж авч үзмээр байна 1 дүгээрт.

2 дугаарт Монголбанк эдийн засгийн харилцаан дээр голлогч, гол тоглогч, бас нэг тоглогч. Ер нь Монголбанкныхаа энэ хууль, эрх зүйн орчин, засаглалын асуудлыг ярихгүй юм уу? Маш олон судалгаанууд хийгдээд энэ засаглалын асуудлыг шийд гээд өгчхөөд байдаг, дараад хэвтчихсэн юм байна лээ шүү дээ. Би Наранцогт Ерөнхийлөгчийг шинээр томилогдоод жоохон эрчтэй ажиллах байх, энэ асуудлыг ярьж байсан, энэ намрын чуулганаар орж ирэх байх гэж харж байгаа. Өмнөх удирдлагууд ингээд энэ Монголбанкны чинь засаглалын асуудал болохгүй байна шүү гэдгийг олон улсын судалгаа, зөвлөмжүүдээр өгчихсөн юм байна лээ. Тэгээд одоо хүртэл хэрэгжүүлээгүй. Монголбанкнаас энэ судалгаа дараастай байж

байгаа, хэдэн дарга нарт танилцуулагдсан. Энийг хэдүүлээ ажил хэрэг болгомоор байна.

2 дугаарт энэ ТӨК-ийнхоо реформыг цаашаа явуулах ёстой, энэ намар ТӨК-ийн талаар төрөөс баримтлах бодлогыг оруулж ирэх ёстой, аль компанийг зах зээл дээр олон нийтийн болгохыг шийдмээр байна, хэдэн хувийг нь гаргахыг шийдмээр байна, аль алийг нь багцалж гаргахыг шийдмээр байна. Ингээд иргэддээ цалин, орлогоосоо гадна бусад баялгаасаа хүртэх энэ боломжийг олгох ёстой. Ингэж байж хяналт сайжирна. Ингэж байж энэ дарга нарын булагнадаг, энэ ТӨК дээр хяналтгүйгээр урсаж байсан мөнгөнүүд цэгцэрнэ. Бид зүгээр төр гэдэг буюу ард түмний өмнөөс төр гэдэг институт эцсийн өмчлөгчийн өмнөөс хувьцаа эзэмшигчийг хэрэгжүүлж байгаагийн хувьд л ногдол ашиг авах гэж байгаа шүү дээ. Тэгэхдээ энийг компанийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх ёстой, энэ хяналтгүй явж байгаа мөнгөнүүдийг, тэр компанийн үйл ажиллагаанд хамаагүй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлдгийг зогсооё л гэж байгаа. Ямар ч байсан энэ дээрээ ухрахгүй байх гэдэгтээ би итгэлтэй байна.

Харин цаашдаа орж ирж байгаа мөнгийг юунд зарцуулах вэ, яах вэ гэдэг дээрээ ярилцах ёстой. Одоо энэ алах баавгайн тухай ярьж байгаа ОТ-н ногдол ашиг. Энэ алаагүй байгаа гэхдээ ер нь алж мэднэ гээд яриад байгаа. Энэ алах гэж байгаа баавгайг харин юунд зарцуулах вэ гэдгээ сайн бодно шүү. Улс төрчид нь гадуур мөнгө тараана гээд явж байна. Тийм юм байхгүй шүү. Тэгвэл энэ Монгол Улсыг бүхэлд нь хорлочоод бууя гэж энэ парламент үзэж байгаа бол бид эртхэн тарах нь зөв шүү дээ. Тийм учраас энэ жоохон мөнгөний сургаар ингэх ёстой, тэгэх ёстой гэдэг байдлаар популист янз бүрийн юм ярьдаг хүмүүсээ болих хэрэгтэй. Энэ ард түмэнд хүлээлт үүсгэж байгаа байхгүй юу, ОТ-н мөнгийг хэзээ тараах юм, хэзээ дансанд орох вэ гээд. Манай тойргийн хүмүүсээс ийм л юм асууж байна. Тэгэхээр энэ дээрээ болгоомжтой байя. Ерөөсөө ийм л зүйлүүдийг хүлээлт үүсгээд бэлэн мөнгө.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлээ.

18.53 цаг

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

өнөөдөр Монгол айл өрх, Монгол хүн мах, гурил, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, түлш, шатахуун, тог, дулааны хомсдол, ахуй амьдралын зовлон бэрхшээлтэй өдөр тутам тулгарч байна. Монгол Улсын ЗГ олон түмэнтэйгээ зовлон жаргал нэгтэй байж, үнийн өсөлтийн шуурганаас хамгаалахын төлөө өөрөөсөө хамаарах бүхнийг хийх үүргээ ухамсарлан ажиллаж байна. Тийм ч учраас сайд нарын зардлаас 1.4 их наяд төгрөгийг танаж, шинэ оныг хүлээхгүйгээр 11 дүгээр сарын 1-нээс эмч, төрийн үйлчилгээний бүх албан хаагчийн цалин нэмэх, ахмад настан бүрд баталгаа болгон шинээр суурь тэтгэвэр олгох зэрэгт зориулах 2026 оны төсвийн тодотголоо өргөн барьж, хэлэлцүүлж байна.

Дэлхийн цаг төр хурцадмал олон улсад хүнс, түлш, шатахууны үнэ өсөж, худалдаа, тээвэр, нөөц нийлүүлэлтийн хомсдол нүүрлэж байгаа ч бид бусдад буруу чихэж, шалтаг тоочихгүй. Цагийн юмыг цагт нь шийдээгүй, холын хараа, хариуцлага дутсан, олон жил дуусгалгүй ярьсаар ирсний өр төлөөсийг өнөөдөр улс орноороо төлж, айл өрх бүр өртөн хохирч байна. Экспортын эрэлт буурч, импортын өртөг нэмэгдэж, төсвийн орлогод дарамт болж байна. 2026 оны эхний 8 сарын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 17.3 их наяд төгрөгт хүрлээ. Харин нийт зарлага нь 19.5 их наяд төгрөг болж, төсвийн алдагдал 2.2 их наяд төгрөг болоод байна. Төсвийн орлого төлөвлөснөөс 1.4 их наяд төгрөгөөр тасарсан тул төсвөө тодотгох зайлшгүй шаардлагатай тулгарлаа.

Нүүрсний экспорт биет хэмжээгээр өсөж, уул уурхай эдийн засгийг дэмжиж байгаа ч худалдаа, үйлчилгээ зэрэг бусад салбарын идэвх сулхан байна. Үүний үр дагавар нь ААН-үүдийн ашиг орлого хумигдаж, ажлын байр, авах цалин татарч байна. Төсөв бол эмнэлэг, сургуулийн тог, дулаан, эмч, багшийн цалин хөлс, хүүхдийн мөнгө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж юм. Төсвийн тоо, үг бүрийн цаана Монгол хүний цалин, тэтгэвэр, тэтгэмж, Монгол айлын ахуй амьдрал бий. Айл өрх амьдралын бодит нөхцөлтэй нийцүүлж, орлого, зарлагаа тооцоолдог шиг улс орон ч төсвөө хэмнэлттэй, гамтай, хэрэгтэй зүйлдээ зарцуулах гэж тодотгодог.

Монгол Улсын ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн 2026 оны улсын төсвийн тодотголын төсөл бол хүнээ бодсон шийдвэр юм. Төсвөө иргэддээ зориулж, дарамтыг төр өөртөө авах бодлогын шийдэл юм. Сайд нарын урсгал зардлын 1.4 их наяд төгрөгийг ард түмэндээ зориулах зорилго, даалгавар юм. Бид татвар нэмж айл өрх, ААН-үүдийнхээ нурууг чилээхгүй. Бид татварын ачаа дарамтыг буулгаж, хувийн хэвшилдээ хөдөлмөрлөж, ажиллах хүндээ лай болохоор зай болохыг хичээх болно. Бид эрчим хүчний импортын зөрүүнээс үүдэлтэй гэрэл, дулааны үнийн өсөлтийг өрхийн үүд, айлын хаалгаар оруулахгүй.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын Чөлөөлье үндэсний санаачилгын дагуу төр хэмнэлтээ өөрөөсөө эхэлж байна. Төрийн байгууллагуудын томилот, сургалт, тавилга хэрэгсэл, унаа тэрэг, хурал, форум, баяр ёслол, зар сурталчилгаа зэрэгт зарцуулах байсан мөнгийг цалин, тэтгэвэрт шилжүүлж байна гэж шууд хэлж болно. Энэ онд

эцсийн бодит үр дүн нь гарахгүй төсөл, арга хэмжээний төсөв мөнгийг хасна. Иргэддээ зориулсан үндсэн үйлчилгээг харин огт танахгүй, хүндээ хүртээлгүй олон зардлыг танаж байна. Энэ бүхнээс 1.4 их наяд төгрөг хэмнэхээр тооцлоо. Өнөөдөр төр түргэн, цагдаа, онцгой байдлынхнаас бусад машин авах цаг биш. Өнөөдөр хүний төлөө шийдэх цаг. Өнөөдөр төр хурал, форум хийж дуусдаггүй яриагаа сунгах цаг биш. Өнөөдөр хоосон яриа биш, бодит шийдвэрийг сонгох цаг ирсэн байна.

Хэмнэсэн мөнгөө хэнд, юунд, хэдийг хэрхэн зарцуулах вэ. Энэ асуултын хариултыг хэлэлцэж, хүндээ зориулахаар энэ танхимд бид хэлэлцэж байна.

Нэг.196.3 тэрбум төгрөгийг 435 мянган ахмад настан бүрд 11 сарын 1-нээс шинээр суурь тэтгэвэр олгоно. Ахмад настан бүр ажилласан жил, төлсөн шимтгэлээсээ хамаарч 100-аас 300 мянган төгрөгийн суурь тэтгэврийг авна. Илүү олон жил төлсөн нь илүү өндөр тэтгэвэр авах шударга шинэчлэлийг шинэ оныг хүлээлгэхгүйгээр шууд эхлүүлж байна. Энэ бол нэг удаагийн халамж биш, хүний насан туршийн ажил хөдөлмөрийн шударга үнэлгээний шинэчлэл байх болно.

Хоёр.844.6 тэрбум төгрөгөөр эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарынхны цалинг 20 хувь нэмнэ, энэ онд нэмсэн 30 хувь дээр нэмж нийлээд 50 хувь болно. Байгаль орчин, цаг уур, хөдөө аж ахуй, соёл, спорт зэрэг төрийн үйлчилгээний бүх албан хаагчдын цалинг нэгэн жигд нийтэд нь 50 хувь нэмнэ. Боловсролын салбарын дутагдсан цалингийн зөрүү зардлыг бүрэн шийдвэрлэнэ.

Гурав.50 тэрбум төгрөгөөр гэрт ойрхон сургууль бол хамгийн сайн сургууль. Хаана гэртээ ойрхон улсын сургууль байхгүй байна, тэнд зориулалтын барилга байшин, анги танхимыг нь түрээсэлж, тоног төхөөрөмж, төрөлжсөн ахлах сургуульд зарцуулах болно.

Дөрөв.150 тэрбум төгрөгөөр мах, улаан буудай, хүнсний ногоо нөөцлөх, хадгалах зориулалтын нөөцийн савуудыг барьж байгуулна. 100 мянган тонн улаан буудайг нөөцөлнө, 20 мянган тонн мах нөөцөлнө, 12 мянган тонн төмс, хүнсний ногоо нөөцөлж авна. Хүнсний үнийн өсөлтийн талаас илүү нь болдог мах, гурил, төмс, ногооны илүү их нөөцтэй болно. Хүнсний хангамж, нөөцөө хаана, хэд байгааг шууд харж мэддэг цахим хяналтыг тогтооно, энэ нь хэн хэндээ амар. Айлаар бол идшээ бэлтгэдэг, үүцээ хийдэг улс болъё гэсэн шийдвэр юм.

Тав.200 тэрбум төгрөгөөр импортын цахилгааны үнийн өсөлтийг өрх айлууддаа үүрүүлэхгүй. Үнэ, тарифын зөрүүг нь нөхөж төлнө. Өвлийн ид хүйтнээс өмнө цахилгаан станц, шугам сүлжээгээ засаж, янзалж, шинэчилж, сайжруулна.

1 их наяд 600 тэрбум төгрөг буюу ТӨК-удын 1.6 их наядын ногдол ашгийг төрийн өмчийн жинхэнэ эзэд болсон иргэддээ зориулах болно. Төрийн өмч бол ард түмний өмч. Эзэн нь болсон иргэддээ үр ашгаа өгдөг байх нь шударга зарчим юм. Эрхэм гишүүд та бүхний 2 сарын өмнө баталсан хуулийг ёсчлон хэрэгжүүлэх нь ЗГ-ын хүлээсэн үүрэг юм. Төрийн өмчөөс иргэдийнхээ хүртэх үр өгөөжийг өсгөж арвижуулах, ил тод, нээлттэй болгох, дуусдаггүй яриаг дуусгахын төлөө та бүхэнтэйгээ нягт хамтран ажиллана. Төсөв үндсэндээ татварын орлогоос бүрдэж, тэр хэрээр баялаг бүтээгч нартаа, хөдөлмөрлөж байгаа хүмүүсийнхээ нуруун дээр ачаа дарамт нэмж байгааг дорвитой засах бодитой алхам юм. Төсвийн тодотгол бол ТӨК-удын ногдол ашгийг төсөл, хөтөлбөр нэрээр зарцуулахын оронд ард

түмэндээ зориулах, 2 сарын өмнө баталсан хуулийг амьдралд хэрэгжүүлэх бодитой шийдвэр юм.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

энэхүү төсвийн тодотголыг үр дүнд 2026 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 31.9 их наяд төгрөг, нийт зарлагыг 34 их наяд төгрөг, төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувьтай тэнцэх 2 их наяд төгрөг байхаар тооцооллоо. Энэ зөвхөн тооны өөрчлөлт биш. Энэ тоо, үг бүрийн цаана төрийн хэмнэлт бий. Энэ тоонууд, өгүүлбэрүүд бүрийн ард Монгол хүний ахуй амьдрал, эрүүл мэнд, хүүхдүүдийнх нь боловсрол, цалин, тэтгэвэр бий.

УИХ-ын эрхэм гишүүд та бүхнээс төсвөө иргэндээ зориулж, дарамтыг төрдөө авах тодотголын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсэж байна. Үнийн өсөлтөөс Монгол хүн, Монгол айл өрхүүдээ хамгаалахын төлөө шийдэл хэлэлцье. Цалин, тэтгэврээс өөр орлогогүй ахмад настан, төрийн үйлчилгээний албан хаагчдаа хамгаалахын төлөө ухаан бодлоо уралдуулцгаая. Монголын баялгаа Монгол хүндээ зориулж, илүү маргаашийн төлөө өнөөдөр шийдэх цаг ирлээ. Та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайдад баярлалаа. Төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Магнайсүрэн: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын ЗГ-аас УИХ-д 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэн, аудитын тайлан дүгнэлтийг УИХ-д хүргүүлсэн.

Тус аудитын зорилго нь ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль, эрх зүйн хүрээнд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг хянаж дүгнэлт өгөхөд чиглэгдсэн. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалгуурт нийцэж байгаа эсэх талаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1.ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан өөрчлөлтүүд нь Үндэсний аюулгүй байдал болон улсын хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцэж байгаа боловч нийгэм, эдийн засгийн богино хугацааны эрсдэлийг бууруулах хүрээнд хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж, урсгал зардлыг нэмэгдүүлсэн нь урт, дунд хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хадгалахад эрсдэл үүсгэж болзошгүй байна.

2.ЗГ-аас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх үндэслэлээр боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Уг төсөлд нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31 их наяд 930 тэрбум төгрөг, нийт зарлагын дээд хэмжээг 33 их наяд 978 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2 их наяд 48 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцжээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан эсэхийг аудитаар дүгнэхэд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын шаардлагыг хангасан. Нэгдсэн төсвийн урсгал зарлага 26 их наяд 54 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 25.4 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасан 30 хувийн дээд хязгаарыг хангасан. Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.3.1, 17 дугаар зүйлийн 17.2, 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан өрийн зохистой түвшнийг хангасан байхаар заасан бөгөөд төсвийн тодотголын төсөл ЗГ-ын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг ДНБ-ий 44.5 хувьтай байхаар тооцоолсон нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн 6.1.4-д заасан 60 хувийн хязгаарыг тус тус хангаж байна.

Харин Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн суурь тэнцэл 399.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.4 хувьтай байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэсэн шаардлагад нийцээгүй байх бөгөөд уг асуудлыг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах санал болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох хэсгийг өөрчлөх замаар шийдвэрлэхээр тусгасан байна. Энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал хэдий ч цаашид төсвийн тогтвортой байдлын зорилт хангагдахгүй байх, дунд хугацааны төсвийн төлөлтийн ач холбогдол буурах, төсвийн удирдлагын зарчим алдагдах эрсдэлийг дагуулж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

3.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ахмад настны орлогыг дэмжих, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зөрөөг арилгах, хүнс, эрчим хүчний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь нийгэм, эдийн засагт эерэг үр нөлөөтэй боловч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг нэмэгдүүлэхгүйгээр нийт зарлагыг 998 тэрбум төгрөгөөр өсгөж, төсвийн алдагдлыг 2 их наяд 48 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2 хувьд хүргэхээр байгаа нь төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрч бүрдээгүй тохиолдолд төсвийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй байна. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуульд заасан хүрээнд өгсөн дүгнэлтийг үүгээр товчлон танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Магнайсүрэн даргад баярлалаа. Төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Дэлгэрсайхан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 8 сарын 20-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулж байна.

2026 оны төсвийн тодотголын төсөл нь үндэслэл, шаардлагаа иргэдийн амьжиргааг хамгаалах, стратегийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх хэмээн тодорхойлсон нь гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, иргэдийн орлого огцом буурч байгаа өнөөгийн цаг үеийн бодит шаардлага гэж харж байна. Мөн төсвийн зардлаа хэмнэх, төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах арга замыг сонгосон нь эерэг хандлага мөн юм. Харин энэхүү зорилгоо хэрэгжүүлэхдээ төсвийн зарлага, алдагдлыг нэмэгдүүлэх, төсвийн эрх зүйн орчныг өөрчлөх арга замыг сонгосон нь төсвийн бодлогоор дамжуулан эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэж зорьсны улмаас төрийн оролцоо нэмэгдэх, хувийн хэвшлийн орон зай хумигдах, төсвийн зарлагын бүтэц алдагдаж урсгал зардлын цаашдын дарамт өсөх зэрэг алдааг давтаж болзошгүй байгааг анхаарах хэрэгтэй.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс төсвийн бодлогоор бүхнийг шийдвэрлэхийг зорьж ирсэн энэхүү алхмыг цаашид үргэлжлүүлэх нь зохисгүй гэж үзэж байгаа бөгөөд үүний шалтгаан, цаана нь гадаад, дотоод орчны нөлөөлөлд өртөмхий эмзэг эдийн засгийн бүтэцтэй болсон олон жилийн улбаатай бүтцийн гажуудал юм хэмээн үзлээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс төсвийн тодотголын төсөлд шинжилгээ хийсний үр дүнд дараах гол дүгнэлтүүдийг хийлээ.

1.Төсвийн тодотгол хийх шаардлагыг макро эдийн засгийн тулгамдсан асуудлуудад чиглүүлсэн нь өнөөгийн үүсээд байгаа хүндрэлийг давах бодлогын сонголт байж болох ч бодлогын эрсдэл өндөр байна.

2.Төсвийн хэмнэлтийг төсвийн бодлогын арга хэрэгсэл болгоход чиглүүлж буй нь сайшаалтай ч хэмнэлтийг үргэлжлүүлэх төсвийн бодлогын орон зайг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна.

3.Төсвийн бодлогоор нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг бүхэлд нь шийдвэрлэхийг зорих нь бололцооны хувьд хязгаарлагдмал төдийгүй сөрөг нөлөө өндөртэй байж болохыг өмнөх бодлогын сургамж харуулж байна.

4.Хувийн хэвшлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлт татварын суурийг өргөтгөх бодлогыг бодитой хэрэгжүүлэх асуудал үгүйлэгдэж байна.

5.Татварын орлого сүүлийн 2 жил тасалдаж, татварын бус орлогоор орлуулах шаардлага гарч байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй байна. Төсвийн татварын орлогын 1 их наяд 20.2 тэрбум төгрөгийн бууралтыг татварын бус орлогоор нөхөхөөр төлөвлөсөн нь үүний нотолгоо юм.

6.Тодотголын хүрээнд шинээр нэмэгдэж буй зардлуудын дийлэнх нь хуульчлагдсан гэсэн тодотголтой зардлууд байна. Төсвийн тодотголоор цалин, тэтгэвэртэй холбоотой зардал нийт дүнгээр 1 их наяд 40.9 тэрбум төгрөгөөр

нэмэгдэж байна. Энэхүү нэмэгдлийн 366.4 тэрбум төгрөг нь шинэ бодлогын шинжтэй нэмэгдэлд, 674.5 тэрбум төгрөг нь өмнөх шийдвэртэй холбоотой санхүүжилт байна.

8.Төсвийн зарлагын өсөлт, урсгал зардлын өсөлт нь олон эрсдэлийг дагуулж, төсвийн бодлогын орон зайг улам багасгаж байна. Төсвийн зарлагын өсөлт нэмэгдсэнээр орлого нь зарлагаа гүйцэхгүй болох талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өмнө өгч байсан нөхцөл байдал хэдийнээ бий болоод байна. Мөн урсгал зардлын өсөлт нь төсвийн бодлогын орон зайг багасгахын зэрэгцээ төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, хууль, эрх зүйн орчныг өөрчлөх замаар төсвийн хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх нөхцөлд хүргэж байгааг бид буруу гэж үзэж байна.

9.Төсвийн зарлага, санхүүжилтийн зохистой бүтэц алдагдах нөхцөл байдал бий боллоо. Төсвийн тодотголоор төсвийн зарлагыг 998 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, 1.4 их наяд төгрөгийн зардлыг танах байдлаар зардлын бүтцэд өөрчлөлт оруулсны улмаас урсгал зардал 1 их наяд 152 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь алдагдал санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд томоохон бүтцийн өөрчлөлтийг бий болгож байна.

Эцэст нь зөвлөлийн зүгээс 2 зүйлийг онцлон хэлэхийг хүсэж байна. Төсвийн бодлогод дорвитой өөрчлөлт хийх шаардлага нэгэнт бий болжээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс төсвийн тодотголын шаардлага, зорилгыг өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн амьжиргааг хамгаалах, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулахад чиглэсэн бодлогын зөв сонголт хэмээн үзэж байгаа ч төсвийн зарлага, алдагдлыг нэмэгдүүлэх байдлаар цаашид энэхүү бодлогыг үргэлжлүүлэх нь эрсдэлтэй гэдгийг сануулж байна.

Хууль, эрх зүйн орчны өөрчлөлт нь төсвийн зарлагын өсөлтийн гол шалтгаан нөхцөл болж байгааг анхаарах хэрэгтэй байна. Мөн эрх зүйн орчны өөрчлөлт, хуульчлагдсан гэх тодотголтой зардлууд нь төсвийн зарлагад хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд цаашдын бодлого, эрх зүйн орчны өөрчлөлтийн хүрээнд анхаарах хэрэгтэй гол хүчин зүйл болж байна. Төсвийн орлогын бүтцийн эмзэг байдал нэмэгдэж байгааг анхаарч зарлагын бодлого, эрх зүйн орчны өөрчлөлтийг хийхдээ төсвийн зарлагад өнөө болон ирээдүйд үзүүлэх нөлөөллийг тооцож шийдвэрлэдэг байх хэрэгтэй байна.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

та бүхэнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн зөвлөлийн дүгнэлтийг товч танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан даргад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын Ерөнхий сайд, Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Нямтайширийн Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Сайнбуйангийн Амарсайхан ХЗДХ-ийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,

Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Цагаанхүүгийн Идэрбат ХХААХҮ-ийн сайд, Чинбатын Номин Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Бадрахын Найдалаа Эрчим хүчний сайд, Энхбаярын Батшугар Эрүүл мэндийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн ТАЗ-ийн дарга, Пунцагийн Золзаяа ШЕЗ-ийн дарга, Сономдовчингийн Энхтөр Шүүхийн сахилгын хорооны дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Нэргүйн Мягмар СЕХ-ны дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Түндэвийн Жамбаажамц СЗХ-ны дарга, Батмөнхийн Батдаваа ҮСХ-ны дарга, Дугарын Сүнжид ХЭҮК-ын дарга, Ганбаатарын Билгүүн Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Содномцэрэнгийн Заяадэлгэр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Дэмбэрэлдашийн Баярсайхан Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх, Шаравдэмбэрэлийн Энхтуул Шадар сайдын ажлын албаны дарга, Дамдины Чулуунбат УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга. Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Дашживаагийн Ариунболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга, бригадын генерал, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор, Найдангийн Цэвэлмаа Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Даваасамбуугийн Баярсайхан Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Баатарын Лхагвасүрэн УИХ-ын Тамгын газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга, Ганболдын Нандинжаргал нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Адъяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Мягмарсүрэнгийн Баярмагнай ЗТЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД, Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүнрэвийн Ганбямба ЗХЖШ-ын дарга, Басангийн Батжаргал НДЕГ-ын дарга, Зайтений Бауыржан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Баттулгын Дөлгөөн СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Төмөрбаатарын Сумъяа ЗТЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэен-Ойдовын Ариунсанаа Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганболдын Аззаяа АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх

хэлтсийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Ваанчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Галбадрахын Гантулга Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чадраабалын Сугармаа Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү төсвийн хэлтсийн дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

УИХ-ын тухай хуулийн 21.24-т нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан УИХ-д үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд худал мэдээлэл өгч дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг болохыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон албан тушаалтнуудад сануулъя.

Танилцуулга, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Сайд нарыг дуудаарай, сайд нар байх ёстой шүү. Мандхай гишүүнээр тасаллаа, одоо эрэмбэлэгдэх байх. Хэрлэн гишүүн, Ариунзаяа гишүүнийг оруулъя, Гомбын Ганбаатар гишүүнийг оруулъя, Жаргалсайхан гишүүнийг оруулъя. Өөр болсон уу? Хэрлэн гишүүн орсон байна, ингээд тасаллаа. Хэдэн гишүүн байна вэ, 20 гишүүн асуулт асуух нь, дараа нь үг хэлнэ. Чуулганыг түр завсарлуулъя, бие засах, ойр зуурын шаардлага. 20 минутын дараа асуултаар чуулганаа эхлүүлъя.

Хуралдаан 19 цаг 20 минутаас 19 цаг 50 минутад завсарлав.

Сайд нар, ажлын хэсгийн гишүүдийг дуудъя. Гишүүд асуултаа асууна. Хуралдаанаа үргэлжлүүлъя. Одоо гишүүд асуулт асууна. УИХ-ын гишүүн Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Төсвийн тодотгол хийхээс өөр арга байхгүй л дээ. Миний хувьд өнгөрсөн оны 11 сард яг энэ төсвийг хэлэлцэж байхад хамгийн их шүүмжилж байсан хүний нэг. Тэгээд зүгээр шүүмжилъё гэж шүүмжилдэггүй, угаасаа асуудал байгаа учраас шүүмжилж байгаа гэдэг нь үнэнд гүйцэгдэж төсвийн тодотгол орж ирж байна. Нөгөө улаан, ногоон лаазаар батлаагүй юу, санаж байна уу?

Хамгийн гол асуудал нь юу байсан юм бэ гэхээр ЗГ-ын өргөн бариагүй маш олон төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцүүлгийн явцад оруулж ирсэн. 5 сарын 31-нээс өмнө зураг, төсөв, төлөвлөгөө байхгүй юм чинь тэгээд худалдан авах ажиллагаа эхлээгүй учраас зогссон. Ийм 32 төсөл, арга хэмжээний 118 тэрбум төгрөгийг татсан байна. Энэ нь хэмнэлтэд орж ирж байгаа, гэрээ байгуулаагүй багц байна, зохион

байгуулах ажлууд нь дутуу дулимаг байгаа гээд нийтдээ 272.5 тэрбум төгрөг хэмнэлтэд орж ирж байгаа.

Боловсролын салбар дээр би ч гэсэн тухайн үед нь хэлж байсан юм. Боловсролын салбар уг нь яг л багш нарын цалинг нэмэх гээд байсан байхгүй юу. Багшаар ажиллах үнэ цэн, багшийн цалинг нэмэх, тэгээд боловсролын салбарын багш, ажилтан гэхчээр яалт ч үгүй 674.5 тэрбум төгрөг дутуу төсөвт суусан. Тэгээд төсөвт батлагдаагүй байгаа цалин хөлсийг олгоод эхэлчихсэн, тэгээд яг одоо энэ төсвийн тодотголыг хийхгүй л байвал угаасаа боловсролын салбарын цалинг нь өгч чадахгүйд хүрнэ. Ингээд 674.5 тэрбум төгрөгийг яг энэ багш нарын буюу боловсролын багш, ажилчдын, боловсролын салбарын цалинг 50 хувиар нэмэгдүүлсэн бүтэн жилийн санхүүжилтийн дутууг нь баталж оруулж ирж байна гэсэн үг.

Эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн салбарын цалин хөлсийг мөн түүнчлэн нэмэгдүүлэх ийм шийдвэрийг гаргасан. Гэхдээ төсөвт нэг ч төгрөг суулгаагүй. Яагаад гэхээр эрүүл мэндийн салбарын урсгал зардал нь ЭМД-ын сангаас явдаг байхгүй юу, нэг худалдан авалт гэдгээр. Тэгээд яг энэ 90 тэрбум төгрөгийг оруулж ирж байгаа нь өөрөө цаашид ЗГ эрүүл мэндийн салбарын цалин хөлсийг төсвөөсөө шийддэг болох гэж байгаа юм уу? Энэ бол маш сайн, ингэх ёстой. Яагаад гэхээр төрийн албан хаагчдын цалинг төр өөрөө хариуцах ёстой, тэрнээс биш ЭМД-ын шимтгэл төлөгчдийн нуруун дээр энийг үүрүүлж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ 90 тэрбумыг яаж тусгасан юм бэ гэдэг нэг ийм асуулт байна?

Тэтгэвэртэй холбоотой маш олон асуултууд надад ирж байгаа. Тэгээд яг энэ тэтгэврийн шинэчлэл, реформ дээр бол би Учрал сайдыг маш их дэмжиж, үнэхээрийн алга ташмаар байна. Тэгэхээр бидний огт хэрэгжүүлж чадахгүй байсан, он удаан жил төсөвтөө баригдаад суурь тэтгэврийн асуудлыг, тэтгэврийн реформыг хийж чадахгүй байсан энэ асуудлыг оруулж чадсан. Тэгэхээр энэ бол маш том дэвшил. Яахын аргагүй 2019 онд яг энэ тэтгэвэртээ гарчихсан тэтгэврийн санг шинэчлэх хэрэгтэй гэдэг ийм асуудлыг УИХ-ын гишүүн байхдаа хөндөж байсан. Ингээд олон давхаргат тогтолцоонд шилжүүлж, суурь тэтгэврийг оруулсан нь маш сайн хэрэг. Энэ суурь тэтгэвэр гэдэг нь өөрөө улсын төсвөөс олгогддог. Тэгээд улсын төсвөөс олгогдохдоо 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэй, тэгээд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа, цэргийн тэтгэвэр ч авч байгаа энэ хүмүүст хамааралтай 100-аас 300 мянган төгрөгийн тэтгэвэр авах ийм хүмүүсийн асуудлыг оруулж ирж байгаа нь маш сайн хэрэг байна. Минут дуусаж байгаа урчаас би эхний ээлждээ эрүүл мэндийн салбарын ажиллагсдын 90 тэрбумын асуудлыг ямар зардлаар оруулсан юм бэ гэдэг асуултад хариулт аваад.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ, ЭМЯ, Сангийн сайд хариулах уу? Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байхад цалин нэмэгдсэн нь үнэн. Тэгэхээр Ариунзаяа гишүүн үндэслэлтэй зүйл хэлээд байна л даа. ЗГ төсвөөрөө бодлогоо оруулж ирдэг. Тэр бодлого нь Их Хурлаар батлагдсаны дараа Их Хурал өөрөө хяналтыг тавьдаг ЗГ-т. Боловсролын салбарт дутагдсан цалингийн зардал 674,5 тэрбумыг тодотголоор тавихгүй бол энэ онд бид багшийн цалинг 50 хувь нэмсэн энэ цалин хөлс, нэмэгдлээ тавьж чадахгүйд хүрнэ. Эрүүл мэндийн салбар дээр бид төсвийн тодотголоор эрүүл мэндийн салбарын цалин хөлсийг 11

сараас 20 хувь нэмэгдүүлээд боловсролтой адилхан 50 хувь нэмэгдүүлэхээр тооцож байна.

Тэгэхээр төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний шилжүүлэх хэлбэрээр ЭМД-ын сан руу цалин нэмэх эх үүсвэр дээр нь нэмэгдүүлнэ гэсэн үг. Ингэснээрээ эрүүл мэндийн салбарын гол онцлог өөрөө шимтгэл төлдөг эрүүл мэндийн салбар нэг гүйцэтгэлээрээ санхүүждэг. Тэгэхээр гүйцэтгэлээрээ санхүүжүүлэхээр төсөв дээрээс ямар хэмжээний татаас авах вэ гэхээр 90 тэрбум төгрөгийг энэ ЭМД-ын сан руу дамжуулж олговол хувь хүн өөрөө төлж байгаа тэр ЭМД-ын шимтгэлдээ нэмэх нь төсвийн татаастайгаа нийлүүлэхэд эрүүл мэндийн салбарын цалин 11 сарын 1-нээс авхуулаад яг 50 хувьдаа нэмэгдээд явах бололцоо бүрдэнэ гэсэн үг.

Ирэх онд инфляцтай нэмэгдүүлж эрүүл мэндийг ч тэр, боловсролыг ч тэр нэмэгдүүлсний дараа цалин 65 хувьд элбэг хүрнэ. Хэрвээ өмнөх нөгөө батлагдсан байдлаар яаж байсан бэ гэхээр цалингийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нэмэгдлийг нь хуучин цалин дээр нь тооцоод байснаар энэ бараг 75 хувь руу хүрчхэж байгаа юм. Тухайн үеийн хэлэлцээрээр. Одоо бид хувь хэмжээг нь нэмэгдүүлчхээд дээр нь нэмэгдлийг нь бодож байгаа нэмэгдлийг нь тэрүүгээрээ ялгаатай. Тэгэхээр ЭМД-ын сан руу энэ 90 тэрбум төгрөг шилжинэ гэсэн үг. Тэгээд өөрөө төлж байгаа шимтгэл дээр нэмэх нь татаастайгаа явахад эрүүл мэндийн салбар энэ 50 хувийнхаа цалинг тавиад явах бололцоо бүрдэнэ. Ингээд нөгөө бусад ТҮ-г төрийн үйлчилгээний албан хаагчдыг нь яг шударга байдлаар адилхан нэмэгдүүлээд явчихвал бүгдээрээ 50, 50, 50 хувь болоод он гарангуутаа 4 дүгээр сарын 1-нээс инфляцтайгаа уялдуулаад нэмээд явчихъя гэдэг ийм шинэчлэлийг тусгасан. Тэгээд Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийн зөвхөн суурь тэтгэврийн заалтыг 11 сарын 1-нээс хэрэгжүүлэхээр хугацааг нь нааш нь татаж байгаа юм. 27 оны 1 сарын 1-нээс Нийгмийн даатгалын батлагдсан багц хууль бүхэлдээ хэрэгжинэ. Нөгөө 140 мянган ахмадын тэтгэврийн зөрүү багасгах концепцууд амилаад явна гэсэн үг.

С.Бямбацогт: Тодруулъя, Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Ямар ч байсан эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин дээр нь төсвөөс 90 тэрбумын татаас өгч байгаа юм байна. Ирэх онд ЭМД-ын санд цалин хөлсний ачааллыг үүрүүлэх биш, УИХ-ын гишүүд цалинг нь нэмэх тухай ярьж байгаа бол төсөвтөө суулгаж яваарай. ЭМД-ын шимтгэл төлөгчид эрүүл мэндийн үйлчилгээ бүрэн дүүрэн авах ёстой болохоос биш энэ цалин хөлсний попролыг даах ёсгүй гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

Мөн түүнчлэн би ЗГ-т нөгөө дараагийн 7 хоногт төсөв хэлэлцсэн л дээ. Гэхдээ нэгэнтээ хүмүүс асуулт асуугаад байгаа учраас хариу хэлчихмээр байгаа юм. Төрийн албан хаагчдын 36 сарын тэтгэвэртээ гарахад 36 сарын тэтгэмж авдагтай холбоотойгоор Учрал Ерөнхий сайдын ЗГ ирэх онд энэ оны 18 сарын үлдэгдэл, дээрээс нь нэмээд 36 сарыг нь бүтнээр нь тавьсан байна лээ. Энэнд би баярлалаа гэж хэлмээр байна. Яагаад гэхээр бид төсвийн энэ хэмнэлтийг, нэг минутаа авчихъя дарга.

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя.

А.Ариунзаяа: Төсвийн хэмнэлтийг төрийн албан хаагчдынхаа нуруун дээр хуулиар авах ёстой асуудал дээр нь огтоосоо хүрч болохгүй. Тэгэхээр 524 тэрбум төгрөг суулгасан байна лээ, ялангуяа төрийн тусгай албан хаагчид асуугаад байна лээ 36 сарын тэтгэмж дээр ямар нэгэн өөрчлөлт ороогүй шүү хэвээрээ байна лээ. Тэгээд дараа оны төсөв дээр суусан байна лээ гэдгийг онцлон дурдмаар байна.

141 мянган ахмадууд энэ 2.4 саяар хязгаарласан нь эрхийг маань зөрчсөн гэж их гомдол мэдүүлж байгаа. Тэгэхээр энэ 1 сарын 1-нээс эхлээд зөрөөг нь арилгаад, тэгээд тэрэн дээрээ арилсан зөрөө дээрээ 10 хувийн нэмэгдлийг тооцсон байна лээ гэдгийг тодруулж хэлье. Тэгэхээр энэ дээр зөрөө дээр 328.5 тэрбум, тэгээд дээрээс нь 10 хувийн нэмэгдэл нийтдээ 654 тэрбум байна лээ. Тэгээд үүн дээрээ бүгдийг нь зүгээр 10 хувиар биш, харин ижил дүнгээр, энэ жилийнх шиг байвал илүү сайн байх болно гэдгийг ташрамд хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Гишүүддээ оройн мэнд хүргэе. МАН-ын гишүүддээ уриалмаар байх юм. Бид ингээд төсвийн тодотгол төсөв ярих болгонд энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн, мөн дээрээс нь Аудитын газрын дүгнэлт, зөвлөмж гардаг. Энэ тодотгол дээр энэ хэдийнхээ нэг өгөөд байгаа зөвлөмжийг, гаргаад байгаа дүгнэлтийг дагаад явчихъя тэгэх үү манайхан. Монголын ард түмэн харж байгаа байх. Хэн нь яг ямар байр суурьтай үг хэлж байгаа юм. Яагаад энэ аудитынхан чинь дүгнэлтээ гаргаж ирчхээд байна шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангаагүй гэж 6.1-д заасан шаардлагууд нь нэгэн зэрэг хангасан байх шаардлагыг хангаагүй байна. Тэгээд энийгээ больчихъё л доо. Ер нь энэ төсвийн тодотгол ярьж байгаа бол хөлөөрөө толгой толгойгоороо хөл хийгээд байгаа шүү дээ.

Тодотгол орж ирж байхад яахаараа бид эхлээд энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа яриад, Төсвийн тухай хуулиа ярьчихаад, дараа нь хүрээгээ яриад, тэгээд тодотгол ярих ёстой биз дээ төсөв. Тэгэхгүй тодотгол дагуулж ирж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг хүчингүй болгоно гэдэг бол энэ чинь байж болшгүй зүйл болоод байна шүү дээ. Тэгээд олонхоороо төрөөд л явах байх. Тэгээд ямар ч байсан та хэддээ хэлчихье. Дараа нь ингээд нэг үлдэх байх.

2-т гэх юм энэ АН-аас гаргаж байгаа санал, санаачилгыг аваач Ерөнхий сайдаа. Энэ сайд нараа танаад нэг урсгал зардлаа нэг танасан шиг танаад нэг та эр хүн шиг нэг бүсээ нэг сайхан Монгол хүн чинь бүсээ нэг сайхан татдаг шүү дээ. Тэгээд нэг татаад өг л дөө. Тэгэхгүй юм. Тэгээд энэ би дахиад энэ аудитын дүгнэлтийн 8 дээр байгаа юм л даа, ААНБ-ын 2026 оны орлогын албан татварыг 2025 онд урьдчилан төлөвлөсөн нь тухайн онд төвлөрүүлэх орлогыг бууруулж, татварын орлогын бүрдүүлэхэд нөлөөлсөн байна гээд байгаа шүү дээ. Тэгээд энийг юу гэж хэлээд байгаа гэхээр 2025 оны төсвийг тодотгол хийхгүйгээр тухайн үеийн та ч засагт нь байсан Ерөнхий сайдаа, энэ олон сайд нар засагт нь байсан улирч байгаа. Тухайн үеийн ЗГ чинь алдаа гаргаад, тодотгол хийхгүйгээр татвар төлөгч нарын мөнгийг аваад 26 онд төлөх ёстой байсан татварыг урьдчилж авч байгаа шүү дээ 1.2 их наяд төгрөг. Тэгээд энэ дээрээ яг хариулт авчихмаар байгаа байхгүй юу. Аль компани яаж төлсөн юм бэ, хэзээ авсан юм бэ, яагаад авсан юм бэ гэдэг дээр би өдөр асуултаа асуугаад хариултаа авч чадаагүй. Энэ аудитуудад дүгнэлтээ

гаргаад байна. Энэ дээр Ерөнхий сайд болон аудитынхан дахиад нэг сайхан хариулаад өгөөрэй.

Дараагийнх нь 2025 оны төсвийн гүйцэтгэл дээр аудит ороод энэ 20 асуудлыг дэвшүүлсэн байгаа. Энэ акт тавьсан, тусгай шаардлага хүргүүлсэн, албан шаардлага хүргүүлсэн гээд энэ шаардлагын хариунууд яг ирсэн үү Магнайсүрэн дарга? Та энэ индрийг ашиглаад ард түмнийхээ өмнө ил хэл, би аудитынхныг сайн ажиллаж байгаа гэж харж байгаа. Сүүлийн үед бүр чамбайрч байгаа, бүр тодорхой гаргаж ирж байгаа. Тэгээд энэ шаардлагуудыг биелүүлээгүй нөхдүүд дээрээ энэ төсвийн тухай хуулийн 70.3, 70.4-өөр нь хариуцлага тооцъё л доо. Хариуцлагын тогтолцоо байхгүй болчихсон болохоор өнөөдөр Монгол Улсын энэ төсөв чинь хүнд байдалд орж байгаа. Төсвийг чинь дагасан асар их зардал орж ирнэ тэрийг зүгээр зах зээл рүү мөнгөний нийлүүлэлт ингээд хийчихдэг, эргээд инфляц өсдөг тэрийгээ дааж чаддаггүй. Тэгээд нэг иймэрхүү байдалтай өнөөдөр инфляц чинь 13 хувьтай байгаа, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнүүд чинь намар болоод бууна л гээд л, бууна л гээд байсан одоо тэр махны үнэ бууж байна уу? Өчигдөр би зах ороод үзэхэд буугаагүй л байх шиг байна лээ. Ингээд асуудлууд зөндөө байна. Энийг ул суурьтай хараад, хэдүүлээ цаашаа урагшлах хэрэгтэй байна. Тэгэхээр үндсэн нэг ийм аудиттай холбоотой 1-д. 2-т гэвэл Ерөнхий сайдтай холбоотой энэ 2 асуулт байна. Тэгээд энэндээ хариулчхаад хариултаа авчхаад, тэгээд тодруулъя, тэгэх үү?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Цаг үеэ нөхцөл байдлаа бодитойгоор дүгнэх хэрэгтэй байгаа юм. Энэ олон улсын геополитик дэлхий дахины нөхцөл байдлыг хараад үзэхээр энэ бензин шатахууны хомсдолтой холбоотойгоор энэ өөрөө хувийн хэвшилд ч тэр бүх шатад маш өндөр эффект /effect/ үзүүлж байна. Тэгээд ийм үед иргэдийнхээ орлогыг хамгаалах л ёстой. Зайлшгүй асуудал, зайлшгүй асуудал. Тэгэхээр нөгөө татварын болон татварын бус орлого 90х10 харьцаатай байсан нь ТӨК-удын ногдол ашгийг аваад, үүн дээр тэтгэвэр болоод энэ шаардлагатай асуудлуудаа шийдвэрлэснээрээ 80х20 луу шилжиж байна. Тэгэхээр төсөв чинь өөрөө эдийн засаг дахь харьцаа нь ТӨК татвар орлого 2 л байхгүй юу. Тэгэхээр энэ чинь 61 хувь хүрчихдэг.

Тэгэхээр бид яах вэ гэхээр боловсролын салбарын 674-ийг яах вэ, эрүүл мэндийн салбарын 90 тэрбумыг яах вэ, тэтгэврийг тодорхой хэмжээнд энэ хуулиа хэрэгжүүлэхэд яах вэ гэхээр нэг л зам эсхүл татвараа нэм л гэдэг төсөв өөр яаж бүрдэх юм. Татвараа нэм. Тэгэхээр татвараа нэмэхээр нөгөө хувийн хэвшил ААН-үүдийнхээ үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө шүү дээ. Тэгэхээр бид нөгөө зам нь юу юм бэ гэхээр тэр дэмий зүйлд зарцуулаад байгаа тэр ТӨК-ийн ногдол ашгаа аваад энэ эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, энэ тэтгэврийн ахмадуудыгаа шийдэх нь төрийн үүрэг байхгүй юу. Төрийн үүрэг. Та хэлж байна. Би өвлийн ид хүйтэнд нэг сандал суудал болгоод баахан хүн халж сэлгээд бүтцийн өөрчлөлт нэрээр үндэсний хэлмэгдүүлэлт хийхийг хүсээгүй. Яг үнэндээ, нэг хүнийг ажилгүй болгоно гэдэг тэр өрх айл маш хүндээр тусах байхгүй юу. Нэг хүнийг яаж цалинтай орлоготой байлгах вэ. Одоо ингээд төрийн албан хаагч нарыгаа ч чичлээд байх юм байхгүй. Энэ чинь бүгдээрээ л ахуй амьдралаа аваад л явж байгаа хүмүүс. Энэ хүмүүсийг ажилтай орлоготой, тогтвортой яаж ажиллуулах вэ төр үүрэг шүү дээ. Бүсээ чангалаад ингээд аваад даваад туулах ёстой.

Тэрнээс биш хэн нэгнийг хэлмэгдүүлээд баахан нөгөө 9 хувийн хэмнэлт шиг ингэж цавчиж хаяад ингээд явдаг тийм цаг үе нь биш байгаад байна л даа Очирбат гишүүнээ. Харин ч энэ хувийн хэвшил дээрээ татварын орлогоор орлого бүрдүүлж, нөгөө нэг цалин хөлс тавих руу шилжүүлэхгүйгээр бид хэд хүнд цаг үеийг ТӨК-удыг үүрэгжүүлээд тэр батлагдсан хуулийнх нь дагуу аваад гарч байгаагаараа цаашаа бол энэ том боломжийг үүсгэнэ. Түрүүн тэр Ариунзаяа гишүүний үгэнд ч гарч байсан. Тэр 36 сартай холбоотой бүх тэтгэвэр тэтгэмжийг ийм цаг үеийг тавиад л явж байгаа. Тэгэхээр нөгөө эдийн засаг тэлээд хуримтлал бий болох үедээ хуримтлуулж чадаагүйн хор гай. Тэгэхээр одоо ийм үед ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд жинхэнэ мөчлөг сөрөх ёстой. Тэгэхээр энэ мөчлөг сөрж байгаа зөв бодлого л гэж бодож байна.

С.Бямбацогт: Аудит Магнайсүрэн дарга 4 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. 2025 оны ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийг бид сая хаврын чуулганаар хэлэлцэн баталсан. Энэ хүрээнд ингээд тавьсан асуудлуудаас яг өнөөдрийн байдлаар хэрэгжилтийг нь авч үзвэл одоо жишээлбэл хууль хяналтын байгууллагад яг өнөөдрийн байдлаар өмнөх онуудын үлдэгдлээр хууль хяналтын байгууллагад бидний шилжүүлчихсэн 81 асуудал байсан. Одоо 65 асуудал нь үлдсэн, 137.9 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа. Шүүхийн шатанд 7 асуудал 634.2 сая төгрөгийн шүүхийн шатанд шилжсэн байна. Төрийн албан хаагчдын төрд учруулсан хохирол гэвэл жишээлбэл үлдэгдэл нь 131 асуудал 7.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байж байгаа. Ингээд энийг бид УЕП, ТАЗ-тэйгөө хамтраад энэ дээр бид нэлээн шуурхай арга хэмжээ авч ингэж ажиллаж байгаа. Төсвийн хууль.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 4 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Төсвийн хуулийн 70 дугаар зүйлтэй холбоотой 4 заалтаар хариуцлага хүлээлгэх, албан тушаалаас чөлөөлөх ийм үндэслэл болох ийм хуулийн зохицуулалттай. Зарим нь сая үйлчилж эхэлсэн ийм зохицуулалт байж байгаа. Энэ хүрээнд бид нийтдээ 2915 ийм зөрчил байна гэж үзээд, төсвийн 53 ерөнхийлөн захирагчид шилжүүлсэн байгаа. Өөрөөр хэлбэл хариуцлага хүлээлгэх асуудлыг жишээлбэл Боловсролын сайд дээр хамгийн их буюу сургууль, цэцэрлэг, бусад байгууллагууд, харьяалах байгууллагуудад нийтдээ бид 752 этгээд хувь албан тушаалтан этгээдэд хариуцлага хүлээлгэж, мэдэгд гээд явуулчихсан. Доод тал нь 1, тэгээд зарим аймгуудад 200 гаруй жишээлбэл Өмнөговь, Говь-Алтай аймагт 200 гаруй ийм зөрчил байна гээд эрх бүхий албан тушаалтнуудад нь шилжүүлсэн. 9 сарын 15-ны дотор бидэнд буюу чуулган эхлэхээс өмнө ингээд ирүүлэх ийм хугацаатай.

С.Бямбацогт: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Энэ тодотголын төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг 998 тэрбум төгрөгөөр тооцсон байгаад байгаа юм. Энэ ДНБ-ий 2 хувь хүртэл ингээд алдагдлаа нэмчихсэн байгаад байгаа юм. 998 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа. Энэ Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3-аар зохицуулагдахаар, дээрээс нь энэ төслийн танилцуулга дээр байгаа засгаас өргөн барьсан, тэгээд энийгээ яаж шийдэж энийг оруулж ирсэн юм бэ, хуучнаар нь явах гэж байгаа юм уу, ингээд

орхиод явах юм уу? Тэгвэл энэ чинь хууль зөрчих гээд байна шүү дээ. Хууль хоорондын энэ зөрчилтэй асуудал үүссэн. Энэ дээр нэг тайлбар авчихъя.

2-т гэвэл төсвийн энэ зардлын таналтаа 1.4 их наяд гэж байгаа. Эндээс гол анхаарал нь татаад байгаа юм бол 1 их наяд 20 тэрбум төгрөг байгаад байгаа юм. Тэгээд энийг ногдол ашиг хэлбэрээр авна гэж байгаа. Урьд нь ямар байсан юм бэ, Учрал сайд урьд нь юу байсан, нэг минутаа нэмээд авчихъя.

С.Бямбацогт: Асуултаа дуусгаж асууя, нэг минут.

Г.Очирбат: Учрал сайд Хэрэг эрхлэх газрын дарга байсан Тэргүүн шадар сайд байсан, энэ Сангийн яамныхан байна, Эдийн засаг, хөгжлийн яамныхан байна. Ер нь энэ ЭТТ дээр чинь жил болгон хэдэн их наяд төгрөг яаж яваад байсан юм, энийгээ нэг ард иргэддээ нээлттэй хэлчихмээр юм. Хэдэн дарга нар, хэдэн эрхтэн дархтнууд зүгээр ингээд үрчихдэг байсан гэдэг л юм одоо тайлбарлаад байна шүү дээ. Тэгдэг байсан юм уу, энэ Сангийн яамныхан мэдэж байгаа байлгүй дээ. Нарийн бичгийн дарга нь нэг хариулт өгье энэ дээр тэр 1 их наядын асуудал. Юуныхан төсвийн тогтвортой байдлынхан нэг хариулчихвал их зүгээр байгаад байна 1 их наяд төгрөг яригдаж байгаа шүү дээ одоо. Цаашдаа дараагийн 2027 оны төсөв дээр ч их сонин, сонин юм орж ирж байгаа. Тэрийг нь орж ирэхэд нь тухтай ярья. Тэгээд энэ 2 асуултад хариулт авчихъя. Нэг нь 998 тэрбум, нэг нь 1 их наяд төгрөгийн асуудал.

С.Бямбацогт: Эхлээд Ерөнхий сайд хариулъя. Дараад нь аудит, төсвийн тогтвортой байдлын зөвлөл бэлдэж байгаарай.

Н.Учрал: Улсын төсөв батлагдсаны дараа орон нутаг төсвөө Иргэдийн хурлаараа баталдаг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн дагуу алдагдалгүй төсөв баталбал болно гэдэг заалт хийснээс болоод улсын төсөв батлагдсаны дараа аймаг, нийслэл төсвөө батлаад, орлогоо хий тавиад зарлагадаад явчхаад байна. Түүнээс нь болоод 2 их наяд төгрөгийг нэмж баталчхаад, түүнийгээ хэрэглэх гэхээр төсвийн хязгаарт тулчихсан. Тэгэхээр 2 хувийн алдагдлын орон зай дээр тэр нийслэл 998 тэрбумаа гаргаж, түүн дээрээ тэр түлшээ авч өвөлжилтөө бэлтгэе л гэж байгаа юм. Шинэ эх үүсвэр биш байгаа мөнгө нь, гэтэл орон нутаг давуулаад баталчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр төсөв өөрөө нэгдсэн бодлоготой байх ёстой гэдэг утгаар оруулж ирсэн.

24 оноос өмнө Баялгийн сангийн хууль батлагдаагүй байхад ТӨК-уд ногдол ашгаа төлдөг байсан. ЭТТ компани 5 удаа ногдол ашиг тараасан, 1072 хувьцаа эзэмшигчид дээр жил болгон тараадаг байсан. Гэтэл 26.5-ыг нь иргэд эзэмшдэг үлдсэн хувийг нь төр эзэмшдэг мөртөө тэр ногдол ашгаа 5 удаа өгөөгүй.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Ерөнхий сайд.

Н.Учрал: Яагаад гэвэл 24 оны Баялгийн сангийн хууль дээр төрийн эзэмшлийн уул уурхайн компаниуд 34 хувийн хуримтлалын санд өгөөд, үлдсэн 66 орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд дээр өгнө, төвлөрсөн мөнгийг нь төсөл хөтөлбөрт зарцуулна гэдэг заалттай. Тэгэхээр Эрдэнэс Монгол өөрөө төсөвт ногдол ашиг өгье гэхээр хуулийн заалт байдаггүй байгаа байхгүй юу. Тэгэхээр хуулийн заалтыг нь энд хийж өгснөөрөө тэр хүмүүс ногдол ашгаа давах үүргээ хүлээлгэж байна. Тэгэхээр иргэн яадаг вэ гэхээр төсвөөр дамжуулж ногдол ашгаа хүртдэг, энэ

хүн төрөлхтний энэнээс өөр шийдэл олсонгүй шүү дээ. Тэгэхээр ТӨК-ийн ногдол ашгаа иргэддээ хүртээх энэ зам нь өөрөө төсөв байхгүй юу. Тэгэхгүйгээр одоогийнхоороо явбал би ногдол ашгаа өгье гэнэ. Гэтэл тэр чинь хуулиараа төсөл хөтөлбөрт зарцуулах заалттай байхгүй. Тэгээд тэрийг нь энд нээж өгснөөрөө жил болгон цэвэр ашгаа ногдол ашгаа хуваарилаад л явна тэр компани. Тэгээд л тэр нь энэ жил төсвийн тодотголоор ийм байна, ирэх жил 3.5 байна. Дараа жил хэд болох юм, энэ чинь ногдол ашгаа өөрөө хуваарилаад л явна ТУЗ нь хуралдаад л хувьцаа эзэмшигчид нь төр юм чинь.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулах уу, хэн хариулах вэ, аудит хариулах уу? 3 дугаар микрофон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.

Ж.Дэлгэрсайхан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголын хүрээнд төрийн өмчийн хувьцаат ТӨК-удаас төвлөрүүлэх нийт ногдол ашгийг 1.61 их наяд төгрөгт хүргэсэн. Үүнээс уул уурхайн салбарын ТӨК-удын ногдол ашгаас 372.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлж, үлдсэн 1 их наяд төгрөгийг улсын төсөвт ногдол ашиг болгож үлдээсэн. Үлдсэн хэсгийг нь Чингис хаан баялгийн сан ХХК-д стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр зарцуулсан ийм байдалтай тусгасан. Тэгэхээр эндээс үүсэж байгаа яах вэ үр дүн нь төсөв дээр 1 их наядыг аваад, Эрдэнэс Монгол нэгдлийн 2026 онд санхүүжүүлэх байсан 3 их наяд гаруй төгрөгийн санхүүжилтийн 30.8 хувьтай тэнцэх мөнгийг ингээд улсын төсөв рүү татаж байгаа гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа юм.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ өргөн барьсан төсвийн тодотгол, түрүүн бид хэлэлцсэн Төсвийн хүрээний мэдэгдэл болон дагаж өргөн барьж байгаа хуулиудыг харахаар бид буруу л хэлэлцэх ёсгүй хууль зөрчиж хэлэлцэж байгаа юм шиг л иймэрхүү дүр зураг харагдаад байна л даа. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр хэрвээ өргөн барьж байгаа төсөл нь шаардлага хангахгүй бол тэрийг хэлэлцэхгүй ЗГ-т нь буцаана. Хэрвээ гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагуудыг хангахгүй бол ЗГ-ыг нь огцруулах хүртэл арга хэмжээ авна гээд ийм 2 л гол хариуцлагын заалт. Өөрөөр хэлбэл хариуцлагатай, сахилга баттай, төлөвлөгөөтэй байх үүднээс ийм 2 заалт байдаг. Тэгэхээр энэ 2 заалт хоёулаа амьдрал дээр биелэхгүй байна.

Тэр гүйцэтгэл нь Үндсэн хууль зөрчвөл гэдэг заалт нь Үндсэн хууль дээр байхгүй заалтыг эшилчихсэн байгаа энийг өөрчлөхөөр хуулийн төсөл бэлдэж байгаа. Энэ дээр ингээд төсвийн хүрээнд аудитаас энэ шаардлагыг хангахгүй байна гэдэг мэдэгдэл гаргачихсан байхад энэ хуулийг хэлэлцэж байгаа нь энэ 18.2 дээр болохоор тусгай шаардлагыг хангаагүй тохиолдолд төсвийн төслийг буцаана гээд ийм заалттай. Тэгээд ийм асуудлыг бид ингээд хэлэлцэх гээд байж байна. Мэдээж яах вэ сайн сайхан, мэдээж ЗГ-ын хувьд чухал цаг нартай ийм асуудлууд байгаа. Гэхдээ энийгээ зөв болгож хийвэл энэ уул нь хуулийнхан тайлбар өгнө биз, яг энийг яаж зөвтгөж байгаа юм. Уул нь зүй нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа эхэлж хэлэлцээд, тэр хүрээндээ нийцүүлж Төсвийн хүрээний мэдэгдлээ засаад, тэр суурь тэнцлийг 2 хувь ашигтай гэдгийгээ тэнцвэржүүлсэн тэнцэл гэдгийгээ болгочхоод, тэр хүрээндээ нийцүүлж төсвийн хүрээгээ яриад, энэ хүрээндээ нийцүүлж өргөн барих ёстой. Тэгэхээр яах вэ Энэ хууль зөрчсөн төсөл өргөн барьж

хэлэлцэж байгаа нь өөрөө бид хууль тогтоогч хуулийг сахиулах УИХ маань ийм хууль зөрчсөн юм хийгээд байгаа харагдаж байна.

Дээр нь энэ зөвтгөж байгаа тайлбар нь юу байж магадгүй байх л даа. Төсвийн энэ Тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн хүрээний мэдэгдэл 2-ын дагаж мөрдөх хугацаанууд нь болохоор яг нэг дор эхлээд энэ нөгөө жижгийг нь, том нь жижгийгээ дагачихсан байгаа учраас Төсвийн хүрээний мэдэгдэл нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно. Төсвийн тогтвортой байдлын тухай буюу энэ суурь дүрэм маань өөрөө болохоор энэ төсвийн төсөөллийн энэ Төсвийн хүрээний мэдэгдэл хүчин төгөлдөр болох үед дагаж мөрдөнө гээд. Тэгэхээр энэ ингээд хоорондоо зөрчилдөж байгаа. Зөрчилдөөд зэрэг хүчин төгөлдөр болдог байна гэж бодоход энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.5 дээр энэ 6.1.2 буюу энэ 2 хувийн энэ шаардлагыг өөрчилж болохгүй гэсэн ийм заалт байгаа. Тэгээд энэ заалтаа хууль өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өргөн барихдаа энэ заалтыг нь хөндөөгүй байна. Тэгэхээр өөрөөр хэлбэл хууль хоорондын зөрчил үүсээд, тэгэхээр энэ нь өөрөө бидний энэ хэлэлцэж байгаа, хэлэлцэх гээд байгаа төсвийн тодотгол маань өөрөө ингээд хуулийн үндэс суурьгүй, хууль, хүчин төгөлдөр хууль дээр суурилж биш, энэ өөрчлөгдөж магадгүй энийг өөрчилчихнө гэсэн ассамшн /assumption/ дээр, ийм төсөөлөл дээр үндэслэж орж ирсэн. Тэгээд энийг нь бид хэлэлцэх гээд байгаа нь ингээд хуулийн хувьд болж байна уу? Миний зүгээр хувьд харахад болохгүй бид энийг хэлэлцэх нь өөрөө хууль зөрчиж байгаа юм шиг иймэрхүү л дүр зураг харагдаад байна л даа. Энэ дээр тайлбар өгөөч.

С.Бямбацогт: Энэ дээр би тайлбар өгчихье, энэ асуудал урьд нь яригдсан. Төсвийн болон төсөв дагасан хуулиудын хоёр дахь хэлэлцүүлэг ирэх 7 хоногийн нэг дэх өдөр хийгдэнэ. Энэ үед санал хураалт явагдана. Хэрвээ хууль зөрчиж байна гэж үзэж байвал мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсөвт тусгайлан тавих шаардлагуудыг зөрчиж байна, хангахгүй байна гэж үзвэл УИХ-аас ЗГ-т хууль санаачлагчид нь буцаах эрх нь байж байгаа. Тийм болохоор Их Хурлын тухай болон Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль төсөв хэлэлцэх энэ процессоо манай гишүүд өөрсдөө сайн судалмаар байгаа юм. Одоо бол нэг дэх хэлэлцүүлэг явж байна. Одоо хөндөж байгаа асуудлууд зөв. Энийгээ 7 хоногийн дотор судал, тэгээд үндсэндээ 7 хоногийн дараа санал хураалтаар энэ асуудал шийдэгдэнэ.

Бусдаар хууль санаачлах, ялангуяа төсвийн хууль санаачлах онцгой бүрэн эрх ЗГ-т байдаг. ЗГ энэ бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжуудынхаа бүрдлийг хангасан эсэхийг нь УИХ-ын Тамгын газар хянадаг. Бүрдэл гэдэг маань юу юм бэ гэхээр хуулийн төсөл өргөн мэдүүлэх албан бичиг, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулга, хуулийн төсөлтэй холбогдох бусад хуулиудын нэмэлт, өөрчлөлт, мөн зардлын болон үр өгөөжийн, үр нөлөөний судалгаа, хэлэлцүүлэг хийсэн бол олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн тайлан энэ бүгдийг л хангаж уу, хангаагүй байна уу гэдгийг л Их Хурлын Тамгын газар хянадаг. Бусдаар хуулийн төсөл нь хууль зөрчсөн эсэх, тэгээд дээрээс нь тэр агуулгыг нь ерөөсөө хянадаггүй.

Урьд нь агуулгыг нь нэг удаа хянаж үзсэн юм байна лээ. Тэгээд энэ болохгүй юм байна гээд хууль санаачлагчийн бүрэн эрх рүү халдаж байна гээд больсон юм байна лээ. Ийм л дэгээр явж байгаа. Тэгээд энэ Дэгийнхээ хуулийг манай гишүүд маань сайн уншаад судалмаар байгаа юм. Тийм болохоор өнөөдөр хэлэлцүүлэг хийж байгаа нь хууль зөрчиж байгаа зүйл байхгүй. Хууль зөрчиж байна, хуулийн

шаардлага хангахгүй байна гэж үзвэл ирэх 7 хоногийн нэг дэх өдөр санал хураалтаараа л асуудал шийдэгдэнэ. Тэр болтол энэ бүгдийгээ сайн судлаарай гэдгийг хэлье. Ерөнхий сайд нэмж хариулах уу? Ерөнхий сайд.

Н.Учрал: Яах вэ ер нь жил болгон л Төсвийн хүрээний мэдэгдлийг төсөвтэйгөө хэлэлцээд явдаг байсан ийм жишигтэй л дээ. Тэгэхдээ би өөрөө хууль тайлбарлах субъект биш. Энийг Улсын дээд шүүх тайлбарлах нь зүйтэй байх. Их Хурлын Тамгын газар бүрдүүлбэрийг хянаад л хүлээж авсан. Тэгэхээр хуулийнхаа хүрээнд танилцуулгаа ЗГ хийж байна. Төсвийн хүрээний мэдэгдэл энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг батлаад араас нь Төсвийн хүрээний мэдэгдлээ оруулаад ингээд явбал энэ 11 дүгээр сарын 1-нээс энэ тэтгэвэр тэтгэмж, энэ цалин хөлс, энэ боловсролд үүсчхээд байгаа зардал мөнгө гээд бүх юм хоолойд тулчихсан байгаа шүү гэдгийг хэлье. Тэгэхээр энэ цаг үетэйгээ нэлээн шахагдаж байгаа.

2-т УИХ-ын гишүүн Тэмүүлэн нарын санаачилсан хууль шаардлагатай бол энэ хуулийг хэлэлцээд баталчихвал манай энэ дагалдуулан бариад байгаа энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол яг 24 оны өмнөх рүү л аваачиж байгаа. Харин ч энэ төсвийн сахилга бат, хариуцлага илүү ойлгомжтой болж байгаа. Тэгэхээр тэр Тэмүүлэн нарын гишүүдийн санаачилсан хуультай манай ЗГ-ын хууль нэгтгэгдээд, хэрвээ хэлэлцээд батлагдчихдаг бол бүр л илүү хурдан хугацаанд явах нь чухал байна. Тэгээд төсөв нь өөрөө цаг үетэйгээ нийцэж явах ёстой гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Энхтүвшин гишүүний би саналыг ойлгож байна. Тэр гишүүдийн санаачилсан хуультай зэрэгцүүлээд явбал илүү хурдтай шуурхай хэлэлцээд явах болов уу гэж бодож байна. ЗГ хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд бид төсвийн тусгай шаардлагуудыгаа илүү ойлгомжтой л болгож байна гэсэн үг шүү дээ. Нэг төсөвтэй болох зарчим руугаа л алхам алхмаар явж байна. Тийм ч учраас түрүүний тэр манай ажлын хэсгийнхний хэлээд байгаа энэ төсвийн реформ /reform/ одоо эхэлж байна, тэр GFS стандарт руу чинь одоо бид ингээд шилжих эхнийхээ гарааг тавьж байна.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тэгэхээр яах вэ хэн нэгэн хүнийг буруутгах гэхээсээ илүү зөв байгаасай л гэж бодоод байгаа юм. Аудитын дүгнэлтээр энэ хууль зөрччихсөн байна, төсвийн тусгай шаардлагуудыг хангаагүй байна гээд дүгнэлт гарчихсан байхад УИХ жишээлбэл энийг дүгнэсэн байна гэж гаргахад тэрний төлөө жишээлбэл хуралдаж, энэ олон хүмүүс хуралдаж ингэж цаг үрэх шаардлагагүй байсан санагдаад байгаа байхгүй юу. Энийг тэртээ тэргүй нийцэхгүй байгаа учраас тусад нь горимоо өөрчлөөд ч юм уу, яаралтай горимоор энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг дагасан хуулиудыг ярьж баталчхаад, энийгээ өөрчлөхгүй бол дахиад бид яараад, жишээлбэл энэ дээр бол УИХ хууль энэ төсвийн тусгай шаардлагуудыг хангаагүй байна гэдэг аудитын дүгнэлтийн эсрэг хангачихсан байна гэдэг дүгнэлт гаргах нь өөрөө боломжгүй зүйл харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм цаг хугацаа уралдаж байгаа учраас уул нь зөв хийсэн бол гаргалгаагаа зөв хийсэн гэсэн бол тийм л үүднээс асуугаад байгаа юм. Миний ойлгож байгаагаар энэ угаасаа хангаагүй байна гэдэг бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Төсвийн хүрээний мэдэгдлээ түрүүн бид ярьчихсан шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл болон бусад хуулиудаа эхэлж хэлэлцээд батлаад, араас нь түүндээ нийцүүлж төсвийн тодотголоо хийх яг ийм л дэгээр явж байгаа. Яг л ийм дэгээр явж байгаа. Тийм болохоор би түрүүн хэлсэн ирэх 7 хоногт та бүхэн

энэ дээр 7 хоногийн хугацаа байна. Урьд нь бол төсвийг шууд хэлэлцээд явчихдаг байсан. Одоо бол эхлээд эхний хэлэлцүүлэг хийгээд, асуулт асууж, үгээ хэлчхээд, 7 хоногийн дараа буцаах уу, буцаахгүй цааш нь хэлэлцэх үү гэж санал хураадаг болсон. Илүү сайжирч байгаа. Тэр үед та бүхэн судлаад байр сууриа илэрхийлэх нь нээлттэй байгаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Төсвийн тодотголыг дэмжиж байгаа зарчмын хувьд, үзэл санааны хувьд. Аудитын болон төсвийн тогтвортой байдлын дүгнэлтүүдийг ч гэсэн тодорхой хэмжээнд анхаарах ёстой. Гэхдээ инфляц гэж гол юу яриад байх шиг байна. Түрүүн Монголбанк 0.7 орчим хувийн нөлөөлөл үзүүлнэ гэж дүгнэлт хэлэх шиг боллоо. Тэгэхээр ер нь инфляц огт цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмээгүй үед ч гэсэн өсөж л байдаг. Энэ жилийн инфляцын түвшнийг аваад үзэхээр нэг их айхтар цалин тэтгэвэртэй холбоотойгоор ч нэмчихсэн юм байхгүй. Махны нийлүүлэлт, гадаад нөхцөл байдлын, шатахууны үнийн өсөлт, төмс, хүнсний ногоотой холбоотой зарим өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний энэ юутай холбоотойгоор нэмэгдсэн гэдэг дүгнэлтийг гаргасан. Тийм учраас түрүүн ингээд инфляц өснө, тэгээд дээрээс нь бид чинь түрүү жил ярилцаад энэ оны эхэнд ахмадынхаа суурь тэтгэвэр баталгаат тэтгэврээ ярья, 11 сар гэдэг чинь өвөлд бэлтгэдэг цаг. Тийм учраас иргэдийнхээ бодит орлогыг нэмэх гэж тодорхой хэмжээний 2 сарын өмнө ч гэсэн нэмэр больё л гэдэг ийм төсөв оруулж ирж байгаа. Ахмадууд ч гэсэн яг ний нуугүй хэлэхэд маргааш биш, бараг өчигдөр нэм гээд байгаа шүү дээ ер нь. Үнэ ханш биднийг хүлээгээгүй гэдэг ийм асуудлыг тавиад байгаа юм.

Тийм учраас ЗГ журмаар нь хуулийнх нь төсөлтэй юутай ийтэй нь оруулж ирье гэж байгаа. Би бол ингэхээс өөр арга байхгүй. Бид нийгмийн даатгалынхаа хуулийг батлаад, суурь тэтгэвэр олгоно, баталгаат тэтгэвэр олгоно гээд баталчихсан. Ер нь яах вэ зүгээр яг олон улсын жишгээр нь ч гэдэг юм уу аваад үзвэл баталгаат тэтгэвэр гэдэг бол амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдах ёстой. Статистикийн төв газар амьжиргааны баталгаажилт доод түвшин ер нь хэд болох гэж байгаа гэдэг талаар мэдээлэл байвал та бүгд маань прогноз /prognosis/ тооцоо байвал хэлээч гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар тэр хэрэглээг дэмжинэ гэж. Одоо эргэн тойрон улс орнуудыг ингээд харж байхад хэрэглээ нэлээн буурчихсан, үнэ нэлээн өсчихсөн байгаа үед юу хийж байна вэ гэхээр ерөөсөө л яг бодит орлогыг нэмэгдүүлэх юм руу л илүү их төсвийн бодлогоо хийгээд байгаа юм байна лээ. Тийм учраас бид нэг их төсвийн зарлагыг тэлээд үнэ инфляц өсчихлөө. Тэгээд дээрээс нь эдийн засгаа бодъё, хувийн хэвслээ дэмжье гэж өөрийнхөө хэрэглэгч нарын орлогыг битгий нэмэгдээсэй гэж боддог бизнес эрхлэгчид би байхгүй болов уу гэж бодож байгаа. 100 мянган төгрөгийн тэтгэвэр авна, 200, 300 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл авлаа гэж бодоход тэр хүмүүс чинь нөгөө л бизнесийн бараа бүтээгдэхүүнүүдийг л тодорхой хэмжээнд худалдаж авна. Нөгөө өссөн инфляцыг чинь л хаана гэдэг энэ утгаар нь би хараад байгаа шүү. Тэгээд юм болгон дээр яах вэ зүгээр тэр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж дээр субъектив талаас битгий хараасай гэж би харж байна. Яг гудамжинд гараад жирийн ахмадтай очиж уулзаад, тэтгэврийг нь аваад, дэлгүүр хамт яваад үзвэл нэг арай өөр дүр зураг харагдаж байгаа. Тэгэхээр энэ санал шаардлага бол манай гишүүд дийлэнх нь мэдэж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Боловсрол, эрүүл мэнд, бусад салбарын ажилчид гээд. Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр цалин хөлс нэмсэн тэр энэ зунжингаа л маргаан болох байсан шүү дээ тэрийг шийдээгүй байсан бол, шинэ, хуучин цалин, хичээл эхлэх ч байсан

юм уу, үгүй ч байсан юм уу. Жагсаал цуглаан хийсэнд л нэмээд байна энэ тэр гээд хэт битгий тэгж яриарай. Би олон жил яагаад жагсаал цуглаан хийдэг юм нөгөө амласан гэрээ хэлэлцээр юмандаа хүрэлцэхгүй ойлголцлын зөрүү гараад л энэ чинь маш олон хуулийн процесстой 4, 5. Ийм, ийм зүйл болонгуут нь тэгээд л засаг маань тодорхой хэмжээгээр нэмж байгаа. Зүгээр овоо оцойтол аймаг нэмчихсэн юм бол нэг их айхтар байхгүй шүү дээ. Гэхдээ энэний цаана боловсролын салбарт хүний нөөцийн дутагдал арилж байгаа, эрүүл мэндийн салбарт нааштай үзүүлэлтүүд хөдөө орон нутаг руу боловсон хүчингүүд явж байгаа гээд өөр олон дүр зургийг та бүхэн маань нөгөө талаас нь хараасай гэж хүсэж байгаа юм, нэг минутаа авчихъя даргаа.

С.Бямбацогт: Асуултаа асууя, нэг минут.

С.Эрдэнэбат: Тийм учраас энэ боловсрол, эрүүл мэнд, соёл гээд үлдсэн 20 гаруй орчим мянга л цөөхөн хүн л дээ. Төрийн захиргааны албан хаагчид ч гэсэн сая ингээд л гадуур хөдөө явж байхад бид 1 сая 200 мянган төгрөгийн л цалин авдаг шүү дээ. Бидний цалин хөлс яах вэ жоохон хойшоо байна. Гэхдээ бидэнд үр дүн ажиглагдаж байна. Ядаж энэ эмнэлэг, суманд маань 1 эмч тогтвортой ажиллах юм. Багш нар маань олддоггүй байсан чинь хүрээд ирлээ гэдэг ийм зүйлийг яриад байгаа. Тийм учраас би болж өгвөл тэр хамтын гэрээ хэлэлцээрийнхээ амлалтад энэ жилдээ биш юм гэж бодоход ямар ч байсан төсвийнхөөрөө би хүрэх ёстой гэдгийг хэлмээр байна.

Мах, гурил, ногоо, түлш, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах дээр нийтдээ 200 орчим тэрбум төгрөг байх шиг байна. Махны нөөцөө бэлтгэх, гурил ногоо, түлшнийхээ нөөцийг бэлдэхээс өөр аргагүй байгаа. Энэ жилийн хамгийн том асуудал махны л асуудал байсан. Тийм учраас энэ хэчнээн тонн мах хаанаас, яаж бэлдэх юм, хэн бэлдэх юм гэдэг дээр нь тодорхой мэдээлэл өгөөч гэдгээ хэлмээр байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Эрдэнэбат гишүүн их чухал асуудлыг хөндлөө л дөө. Тэгээд энэ үнийн өсөлт, өвөлжилт. 2023 оноос хойш анх удаа өрхийн орлого энэ 4.9 нэгж хувиар буучихсан. Ийм цаг үед тэр засаг иргэдийнхээ орлогыг баталгаажуулахын төлөө дорвитой хөдөлгөөн хийх ёстой л дөө. Энэ бидний үүрэг. Тэрнээс биш хэдүүлээ энд нэг тийм зүйл заалт яриад, хэн нь цэцэн мэргэнээ үзээд би тэгж ер нь хүсэхгүй байгаа. Би төлөв даруу, тэгээд ажлаа л хийж байгаа. Тийм учраас төсвийн тодотгол хурдан батлах хэрэгтэй. Энэ нийгмийн хэрэгцээ шаардлага, иргэдийн хэрэгцээ шаардлага. Маш тодорхой хэдхэн зүйл байгаа юм. Инфляц 13 хувьд хүрсэн, түүний 7 хувь, 7 нэгж хувь нь мах, хүнсний ногоо, тэр дотроо төмс, тэр шатахуун хэдхэн зүйл байгаа юм. Тэр стратегийн нөөц. Дэлхийн бүх улс орнууд стратегийн нөөцийг бүрдүүлдэг. Тэгэхээр бид стратегийн нөөцийг бүрдүүлэх дээр мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулах чиглэлээр татааснуудыг энэ тавьсан байх.

Ингээд энэ дээр бол үнийг тогтворжуулах бодлого, дээрээс нь хүнд байгаа цаг үе. Тийм учраас эрчим хүчний тарифыг энэ өвөл нэмж чадахгүй. Тийм учраас энэ дээр татаас олгох дээр 107 тэрбум төгрөг тавиад, тэгэхдээ эрчим хүчний салбарыг өөрөө либералчлах /liberalization/ бодлогынхоо хүрээнд бид татаасыг нь өгөөд, дотроо цалинг нь нэмээд явна. Эрчим хүчний салбарын их засвар, тоног

төхөөрөмжийн шинэчлэл 92 тэрбум хэрэгтэй байгаа. Хэд хэдэн уурын зуух шинэчлэхгүй бол энэ өвөл хүнд байгаа. Сургууль шинээр барихгүй гэдэг бодлогын хүрээнд сая гэрт ойр сургууль гээд 50 тэрбум тавьсны хүчинд өнөөдөр анги дүүргэлт 65 хувиар 35-аас доош багасчхаад байна нэг анги дүүргэлт, бодит ажил яг цэцэрлэг шиг.

Өнөөдөр боловсролын салбарт 50 хувь нэмээд явж байгаа. Тэгэхдээ оныг дуусгаж чадахгүй, тодотгол хийхгүй бол, энэ 670 тэрбумыг хийхгүй бол. Эрүүл мэндийн салбарт 20 хувь нэмэхийн тулд заавал ЭМД-ын сан дээр 90 тэрбум төгрөг хэрэгтэй. Бусад тэр ТҮ-г хүн биш гээд хаяж болохгүй байна шүү дээ. Төрийн үйлчилгээний албан хаагчдын тэр цалин хөлсийг 50 хувьд нь хүргэх хэрэгтэй. Тэр 769 мянган төгрөгийн бага тэтгэвэр авч байгаа хүмүүс 1 сая 77 мянга л болно шүү дээ. Тэр инфляц гэж юу яриад байгаа юм. Наадах чинь 0.5 хувийн нэгж хувь нэмэгдэнэ шүү дээ 1 их наяд дээр. Яг Эрдэнэбат гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Иргэдээ бодохгүй байж болохгүй шүү дээ, хүнээ бодоогүй ингээд агаар дэлхийн юм ярьсаар байтал амьдралаа гэр орноо эргээд хар л даа. Гоё, гоё юм яриад явж байсан чинь гэр орноо хар л даа. Түлэх түлш байхгүй, цалин хөлс нь байхгүй, тэтгэвэр тэтгэмж нь нэмэгдээд ард түмнээ ингээд бодох цаг ирчхээд байна шүү дээ.

С.Бямбацогт: Лутаагийн Энхнасан гишүүн асуултаа асууя.

Л.Энхнасан: Оройн мэнд. Энэ удаагийн төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Ялангуяа тэвчиж болох зардлуудыг бууруулж байгаа, хүнсний нөөцийг бүрдүүлэх, эрчим хүчний тарифын алдагдлыг шийдвэрлэх, тэгээд энэ эрчим хүчний станцуудыг шинэчлэлийг хийх гэж байна гээд энэ чиглэлээр чиглэгдэж байгаа гэдгийг ойлгож байгаа. Тэгэхдээ харин энэ тодотголын санхүүжүүлэх арга хэмжээ, арга хэлбэр энэ орлого дээр анхаарах шаардлагатай байна. Энэ төсөвтэй дагалдаад орж ирж байгаа энэ боловсруулсан хууль тогтоомж дээр би асуухад асуумаар байна.

1 дүгээрт энэ ЗГ-ын үнэт цаас гаргах эрх олгох тухай тогтоолд өөрчлөлт оруулж ирж байгаа юм байна. Тэгээд энэ үнэт цаас гаргах хэмжээг 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэхээр энэ орж ирж байна. Тэгэхээр ЗГ дотоод зах зээлийн нэмэлтээс энэ 1 их наяд төгрөгийг татах юм байна. Энэ эх үүсвэрийг хаанаас яаж бүрдүүлэх гэж байгаа юм бэ?

Монголбанк энэ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй юм байна гэж ойлголоо. Тэгэхээр ягаад асуугаад байна гэхээр энэ хэрвээ дотоодын энэ арилжааны банкууд эсхүл бусад дотоодын хөрөнгө оруулагчид энэ худалдан авбал төр санхүүгийн зах зээл дээр эх үүсвэрээ өөртөө татаж байна л гэсэн үг л дээ. Тэгэхээр ингэснээр бол хувийн хэвшил ялангуяа жижиг, дунд бизнест очих энэ зээлийн эх үүсвэр хумигдана. Зээлийн хүү болон санхүүжилтийн өртөг нэмэгдэхээр ийм эрсдэлтэй байна. Энэ дээр Сангийн яам болон Монголбанк юу гэж бодож байна вэ?

2 дугаарт энэ ЗГ-т чиглэл өгөх тухай тогтоолын төсөл дээр энэ төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах зорилгоор энэ төрийн эзэмшлийн хувьцааг шилжүүлэх зорилготой зарим арга хэмжээнүүдийг тусгасан байна. Энэ 1.1 дээр энэ 2 тэрбум ам.доллараас доошгүй хөрөнгийг яг ямар эх үүсвэрээр бүрдүүлэх гээд байгаа юм бэ? Энэ чинь улсын төсөвт шууд ачаалал үүсэхгүй юу? 2 дугаарт нь ямар

компаниудын хувьцааг санд шилжүүлэхээр төлөвлөж байгаа юм бэ? Энэ дээр мэдээлэл авмаар байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төсвийн тодотгол бол бид махтай, гурилтай, гэрэлтэй, дулаантай байя л гэсэн төсвийн тодотгол. Бид их агаар дэлхийн юм ярьсаар байтал гэр орноо хар. Энэ ард түмнийхээ ахуй амьдралыг хар, 2023 оноос хойш өрхийн орлого 4.9 нэгж хувиар буучхаад байхад тэтгэвэр нэмэхгүй инфляц өдөөнө. 769 мянган төгрөгийн бага тэтгэвэртэй хүнийг 1 сая 77 аваа л биз дээ энэ чинь. Тэгэхээр энэ өрхийн орлого гэдэг зүйл чинь бид нарын гол толгойны өвчин болчихоод байгаа юм. Тэгээд энэ эдийн засаг чинь өөрөө банкны тулгуурт, бүгдээрээ арилжааны банкандаа очоод барьцаалагдчихаад байна шүү дээ яг үнэндээ. Зээлээс зээлийн хооронд арилжааны банкнууд чинь бүх салбарт бизнес эрхэлж байна. Энэ эдийн засаг чинь 2 тулгууртай болох ёстой, энэ бол өөрөө санхүүгийн захыг дэмжих ёстой.

Тийм учраас энэ төсвийн тодотголоор би энэ үнэт цаасны хуулийг оруулаад, ЗГ-т чиглэл өгүүлж байгаа. Өнөөдөр энэ Азийн хэдэн орнуудыг хар, өнөөдөр энэ хууль дээр байгаа нөгөө депозиторын ресейпт /depository receipt/ билүү хадгаламжийн бичиг. Яг энэ зарчмаар өнөөдөр бүх салбаруудын ТӨК-удыгаа нэгтгээд, хөрөнгө оруулалтын багц болгоод олон улсад хөрөнгө босгож байна. Яг энэ зарчмаар бид төрийн өмчит уул уурхайн болон уул уурхайн бус компаниудынхаа хувьцааг нийлүүлээд 15-аас 20 компанийг бид бирж дээр олон улсад гаргана. Тэр гадаад хадгаламжийн бичгийн тусламжтайгаар. Ингэсний дараа хөрөнгө босгох ажлыг хийнэ. Ингээд энэ санхүүгийн захыг идэвхжүүлэх ёстой. Үүний хамгийн эхний бодит үр дүн бол яг энэ Үнэт цаасны хууль та бүхэн баталж өгвөл би энэ ондоо багтаагаад ЭТТ компанийг 2 дахь зах зээл дээр бүртгэнэ, 1072 хувьцааг амилуулна, тэгээд үлдсэн дээр ЗГ 15 хүртэлх хувиа олон улсад гаргана. Шаардлагатай бол би яг олон улсын дижитал биржүүдээр ч гаргана. Одоо нэг жоохон унхиаатай урагшаа харж амьдаръя л гэж бодож байгаа.

Тийм учраас хөрөнгийн зах, санхүүгийн захыг босгох бодлого энэ төсвийн тодотголын үр дүн. Тэгж байж төрийн өмчийн компаниудын ногдол ашиг нэмэгдэнэ. Тэгж байж ашиггүй ажилладаг ТӨК гэж байхгүй болно, 27 оны 1 сарын 1-нээс ТӨК-удыг шинэ хуулийн дагуу бүгдийг нь сонгон шалгаруулалтыг нь зарлахаас өөр зам байхгүй. Энд тэнцдэг мэдлэг, ур чадвартай хүмүүсийг татаж авна. Саяын тэр үнэт цаас бол Сангийн яам нэмж хариулах нь зүйтэй. Тэр 1 их наяд төгрөгийн дийлэнх хэсгийг бол Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгө татахад зарцуулж байгаа, арилжааны банканд оруулдаг нөгөө олон жилийн хэл ам, нөгөө эрсдэлд оруулах асуудлыг давхар хааж байгаа.

С.Бямбацогт: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Оройн мэнд. Үгүй ээ, 12 жил 14 оноос хойш, 16 оноос хойш 12 жил тасралтгүй засаглагчаад хүнээ бодсон төсөв төсвийн тодотгол оруулж ирж байгаад баярлалаа гэх үү. Өмнөх 10 жилд нь яасан юм бэ хүнээ бодоогүй байсан юм уу, та нар 14 оноос хойш үндсэндээ 12 жил тасралтгүй засаглаж байгаа шүү дээ. Та ч жоохон поп, поп гэхэд арай дэндүү поп уу, үгүй юу Ерөнхий сайдаа. Мэдээж энэ төрийн албан хаагчид, ахмадуудын тэтгэврийг нэмэхэд хэн дургүйцэх вэ, татгалзаад байгаа юм байхгүй шүү дээ. Хуулийнхаа хүрээнд оруулж ир л гэж байгаа юм. Ер нь эрсдэл ямар өндөр байгаа билээ. Ийм үед урсгал зардлаа ингэж нэмсээр

явж байгаад хэдүүлээ хаа очиж хад мөргөх юм доо улсаараа. Ний нуугүй хэлэхэд ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө л та нар ахмадуудаа гэнэт бодсон, хайр зарласан юм л оруулж ирж байна шүү дээ. Төрийн албан хаагчдад зориулсан төсөв оруулж ирж байна шүү дээ.

3 асуулт байна. Энэ тодотголоо нийслэлийн бондоос тэр 1758 тэрбум төгрөг, энэ бонд чинь бид 24 онд нийслэл муу хэлэгдээд байсан муу Нямбаатар 500 сая долларыг 7.75 хувийн хүүтэйгээр мөнгө босгосон шүү дээ, яаж байгаа юм төсвийн тодотголоо хүүтэй бондоор санхүүжүүлэх гэж байгаа юм уу? Тэгэхээр энэ шинээр гаргаж байгаа бонд төсөл хэрэгжүүлэхээ, одоо төслөө хэрэгжүүлэхээ больж байгаа юм уу, эсвэл шинээр бонд гаргаж санхүүжүүлэх гэж байгаа юм уу? Өмнө нь авсан тэр бондынхоо санхүүжилтийг эсвэл хойшлуулж байгаа юм уу? Энэ 758 тэрбум төгрөгийн, энэ чинь хэмнэлт биш шүү. Одоо ингээд 1.4 их наядыг хэмнэлээ гээд байна. Тал нь энэ чинь хэмнэлт биш шүү дээ. Яагаад ийм худлаа юм яриад байдаг юм бэ?

2 дахь нь энэ 24 онд нийслэлийн босгосон энэ 500 сая долларын бондын мөнгөөр Сэлбэ хорооллыг бариад, 27 оны буюу дараа жил олсон орлогоороо энэ бондоо төлөхөөр анх орж ирж байсан шүү дээ. Би чинь Төсвийн байнгын хорооны гишүүн энэ нэг хэдэн тоог чинь ямар хүүтэй, хэзээ, хаана босгосныг нь гадарлаад байна л даа. Ирэх онд дахин бонд гаргаж энэ өрөө өрөөр хаах юм уу? Сэлбэ хороолол дээр 28 онд баригдаж дуусаад, 29 онд мөнгөө олно гэж төсвийнхөө төсөлд та нар суулгачихсан байна шүү дээ. Ингэж хугацаа алдсанахаа зөрөөнд нийслэлийн бондын хүүгийн төлбөрт хэдий хэмжээний алдагдал хүлээж байгаа юм бэ? Энэ тоог надад нэг хэлж өгөөрэй.

Ахиад 500 сая долларын бондын эх үүсвэрээр 16 мянган ипотекийн зээл өгнө гэж Ерөнхий сайд та мэдэгдэж байсан. Хэдэн хувийн долларын хүүтэй, ямар эх үүсвэрээс бонд босгоод, 6 хувийн хүүтэй ипотекийг өгөхөд зөрүүд нь хэдэн төгрөгийн зардлыг хаанаас гаргахаар тооцсон юм бэ?

Сүүлийнх нь асуулт. Энхбаяр сайд нэг мэдэгдэл хийж байсан биш ээ нөгөө өндөр Энхбаяр нь. Тэр Энхбаяр сайд юу ярьсан гэхээр 19 оноос 25 оны хооронд бүлэглэлүүд хулгай хийдэг байсан мөнгийг бид энэ удаадаа ТӨК-удын мөнгийг энэ удаадаа төсөв рүү оруулж байна гэж ярьж байгаа юм. 19 оноос 25 он гэдэг хэн юм, хэн удирдаж байсан юм энэ улс орныг одоогийн Ерөнхийлөгч, Оюун-Эрдэнийн ЗГ байсан биз дээ. Тэгээд хэн ямар хариуцлага хүлээсэн юм бэ, ямар их хэмжээний мөнгө хулгайлсан болоод тухай болоод тэр Баттөмөрийн Энхбаяр яриад байгаа юм бэ? Би та нараас нэг л зүйл хүсье. Өмнө нь 16 оноос хойш энэ УИХ, энэ ЗГ-т байгаагүй юм шиг гэнэт сансраас агаараас буусан юм шиг юм битгий ярьж байгаач.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн нэг минут.

Г.Ганбаатар: Одоо болно шүү дээ. Худлаа, үнэн юм ярьж байхаар, дээрээс нь ямарваа нэгэн нэмүү өртөг шингээгүй, бүтээмж байхгүй мөнгийг эдийн засаг руу оруулсаар байгаад энэ инфляц чинь ямар их өсөөд байгаа билээ. Өнөөдрийн төсвийн тодотголоор ахмадуудын тэтгэврийг нэмнэ л гэж байна. Харин азаар 2015 оны 6 сарын 6-нд З.Энхболд дарга УИХ-ын дарга байхдаа Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хүрээнд энэ суурь тэтгэвэр гэдэг ойлголтыг чинь анх бий болгосон юм. Энэний хүрээнд 1-ээс 300 мянган төгрөг нэмэгдэх гэж байгаа юм байна л даа. Энэ мөнгө чинь байна шүү дээ, баярлалаа,

харин энэ 15 жилийн өмнө АН-ын явуулж байсан бодлогыг одоо хэрэгжүүлж байгаад. Энэ мөнгө чинь энэ тэтгэвэр чинь инфляцдаа идэгдээд нэмэгдэл чинь 100-аас 200 мянган төгрөг нэмлээ гээд сүртэй юм болохгүй байна, төрийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ганбаатар гишүүнээ тэгээд танай дарга хийсэн байна уу, хэний дарга хийсэн байна уу ямар ч байсан л ахмадынхаа тэтгэврийг нэммээр байна. Та тэр танайхны хийсэн ажил гэж авторламаар байвал болно шүү дээ. Гол нь, тэгье тэгье та нар өөрсдөө мэд л дээ. Тэгээд та нараар хийсэн үү, надад ер нь тэр нэг хэн нь хийсэн нь биш, тулаад ирчихсэн зовлон байна, тулаад ирсэн зовлон байна. Энэ ЗГ-ын дэвшүүлээд байгаа бодлогыг манай та бүхэн хувааж аваад яриад явах чөлөөтэй шүү дээ. Гол нь энэ өрхийн орлого чинь ийм болчихоод байна л гээд байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ зардлыг хаанаас шийдэх вэ гэхээр татвараа нэмэлттэй биш дээ, ААН-ийн орлого ийм саарчихсан байгаа үед. Тэгэхээр тэр төрийн өмчийн ногдол ашиг л гэж байгаа байхгүй юу. Анх ажил аваад л тэтгэврийг та нар инфляцтай уялдуулж нэмэх ёстой гээд шаардаж байхад би хэлж байсан. Тэтгэврийг тогтолцооных нь хувьд өөрчлөхгүйгээр энийг шийдэхгүй гэж.

Тийм учраас тэтгэврийн реформ хийе гэж шийдээд нийгмийн даатгалын багц хуулийг Их Хуралд оруулаад, өргөн бариад батлуулсан. Одоо зүгээр хоосон тэтгэвэр нэмээгүй шүү дээ. Энэ чинь өөрөө баталгаат тэтгэвэр буюу суурь тэтгэвэр зөрүү арилгах асуудал. Нэг хувийг хуримтлал руу шилжүүлэх асуудал, хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулах асуудал, НДШ-ийг тэр ахмадуудыг чөлөөлөх асуудал, оюутныг НДШ-ийг чөлөөлөх асуудал. Хүн ажил хийвэл 3 газар биш нэг газраа шимтгэлээ төлөөд, бусдаас нь чөлөөлөх асуудал. Энэ дандаа ажлын байр нэмэгдүүлэх рүү чиглэж байгаа байхгүй юу. Энэ тэтгэврийн реформ. Энийг чинь 20 оноос хойш би энэ хууль дээр нь ажилласан юм. Хувийн нэмэлт тэтгэврийн хууль та бүхэн энэ намар батлаад өгвөл тэтгэвэр олон тулгууртай болно шүү дээ. Нэрийн данс чинь бүтэхгүй байсан. Тэрийг энэ хуулиар цуцалсан. Нэгхэн жилийн зөрүү дээр хоорондын зөрөөтэй энэ бүтэхгүй юм байсан, тэгээд явсан байхгүй юу. Тэтгэврийн хуулийг ингээд шийдсэн шүү дээ сая цогцоор нь шийдье гээд.

Татварын багц хууль ч тэр цогцоор нь шийдье гээд манай засаг бариад л Их Хурал баталсан шүү дээ. Одоо энэ 1 сарын 1-нээс хэрэгжинэ. Асуудлыг сууриар нь хийхийн тулд л ингэж авч ирсэн. Ипотекийн зээлийн хөтөлбөр 10 их наядыг зах зээл дээр гаргаж тараасан балаг өнөөдөр хүртэл дуусаагүй байгаа шүү дээ. Намаа яриад би тийм юманд дургүй Ганбаатар гишүүнээ би танай нам гээд би больё тийм юм ярихаа. Надад тулаад ирчихсэн зовлонг авч гарах л асуудал над дээр байна. Би янз бүрийн байдлаар гоншигнохгүй, янз бүрийн байдлаар энэ танай намын балаг гэхгүй. Тэр балаг чинь одоо хүртэл дуусаагүй байхгүй юу. Тийм учраас ипотекийн зээлийн хөтөлбөр дээр янз бүрийн мөнгө төгрөг зах зээл дээр хэвлэж болохгүй. Тийм учраас Монголбанкийг би ямар ч хөтөлбөр хэрэгжүүл гэж би гуйх ч үгүй, шаардах ч үгүй, янз бүрийн байдлаар нөлөөлөхгүй. Ипотекийн зээлийн хөтөлбөр гээд бид нарын оруулаад.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая нэг минут.

Н.Учрал: Гол асуулт чинь юу юм бэ гэхээр ипотекийн зээлийн хөтөлбөр хувьд байгаа 9700 орон сууц хувийн хэвшил барьчихсан байна. Төрд байгаа 6 мянга гаруй орон сууц 4 мянгын shared mortgage яг энэ Европт хийдэг жишгийн дагуу урьдчилгааг нь 15 хувь болгоод, хамтын өмчлөл гэдэг зарчмаар хэрэгжүүлнэ ипотекийн 6 хувь. 9700 хувийн хэвшил барьчихсан байгаа байруудыг бид яаж байна вэ гэхээр 500 сая долларыг босгоод 1.7 их наядыг зах зээл рүү нь оруулаад, долларыг төгрөг болгож оруулж ирэх дээр гараад байгаа свопын /swap/ зардлын энэ 150 билүү тэрбум төгрөгийг төсөв дээр авч байгаа. Ингээд л ипотекийн, 16 мянган айлыг орон сууцад оруулна. Нэг ч төгрөг хэвлэ, мөнгө төгрөг хэвлэхгүй, тийм буруу бодлого байхгүй. Зөвхөн санхүүгийн хэрэгсэл ашиглана санхүүгийн хэрэгсэл. Ингээд энэ мөнгө босно гэдэг чинь өөрөө энэ валютын нөөцөд нэмэртэй байхгүй юу. Ханшаа барихад хэрэгтэй байхгүй юу.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн. Мэндсайхан сайд хариулчихъя. Тэгээд асууя.

3.Мэндсайхан: Гишүүний асуултад нэмж хариулахад тэр 500 сая долларын бондыг ЗГ босгохгүй, хувийн хэвшил өөрсдөө босгоод, ЗГ зөвхөн свопын зардлыг төсөв дээрээ авч орж ирж байгаа юм. Тэгээд доллароос төгрөг болох тэр Монголбанканд дээр сольж байгаа тэр ханшийн зөрүүг л авч орж ирж байгаа юм. Ингэж 16 мянган айлын орон сууцтай болгоё, бага хүүтэй ипотекийн зээлээр иргэдийн тэр орон сууцны бодлогыг хэрэгжүүлэе гэдэг байдлаар оруулж ирж байгаа шүү.

1.4 их наядын таналтыг бодитоор нь хийсэн Ганбаатар гишүүнээ. Энэ дээр таны нэг зөрүүтэй ойлголт нь юу байна гэхээр нийслэлийн 758 тэрбум буюу нөгөө Сэлбэ дэд төв дээр зарах гээд байсан мөнгө байна шүү дээ та энэнийг эх үүсвэрийг нь аваад ашиглачихлаа гэж хараад байх шиг байна. Бид 758 буюу тэр ашиглагдахгүй энэ жил гарахгүй зардлынх нь орон зайг авч байгаа юм. Тэр нийслэлийн босгоод ирчихсэн 500 сая доллар чинь банкандаа байж байгаа, тэрийг бид ашиглахгүй. Ер нь бонд босгож ирчхээд үндсэн үйл ажиллагаандаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариултаа дуусгачихъя, Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Нийслэл мөнгө босгож ирчхээд өнөөдрийг хүртэл үндсэн үйл ажиллагаандаа зарцуулахгүй банканд хадгалаад байж байгаа байхгүй юу, 3 жил дараалан төсөв дээр энэ мөнгийг зарна гэж зардлын орон зай авч яваад байгаа юм. Тэгээд энэ жил нийслэлдээ энэ асуудлыг нь шахаад, Сэлбэ дэд төв дээр 700 орчим гарах юм байна, 758 нь гарахгүй гэдэг тэр гарахгүй гэж байгаа орон зайгаар нь бид зардлын хэмнэлтийг нь аваад, орлогыг нь эх үүсвэр талыг нь ашиглахгүй юм шүү. Та нөгөө эх үүсвэрийг нь ашиглах гэж байна гэж ойлгоод байх шиг байна. Харин эх үүсвэрийг нь ашиглахгүйгээр бид зардлыг нь гаргаж ирсэн орон зай дээр нь энэ ахмадуудын чинь тэтгэвэр цалинг нь нэмье гэдэг энэ шийдлийг гаргаад явж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулъя. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Тэгэхээр ийм шүү дээ, наадах чинь 24 онд наад нийслэлийн 500 сая долларын мөнгөөр Сэлбийг хорооллыг нь уг нь бариулчихаад, ирэх онд тэр орсон орлогоороо энэ бондынхоо мөнгийг төлнө гэж байсан шүү дээ. Зөв биз дээ?

Тэгэхээр энэ чинь ирэх онд ч орохгүй байна. 28 онд ордог юм уу, 29 онд ордог юм уу, төсвийн төсөлд тэгээд суулгачихсан байна лээ шүү дээ. Тэгээд ингээд хугацаа алдсаны зөрүүд нийслэлийн бондын хүүгийн төлбөрт хэдий хэмжээний алдагдал хүлээж байгаа вэ гэж би асуусан?

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Энэ чинь алдагдал гэж бараг банканд хадгалаад хүү болоод байгаа юм байна лээ шүү дээ. Миний ойлгосноор нийслэлийнхэн тэгж хэлсэн шүү дээ 90 тэрбумын ашиг олчихсон явж байгаа гэсэн. Таны хэлээд байгаа үнэн байхгүй юу. Энэ чинь 27 онд оруулна гээд төсөв дээр 1.5-ыг тавьчихсан байхгүй юу. Тэгээд одоо хийж байгаа гүйцэтгэл нь өөрөө энэ дүндээ хүрэхгүй учраас бид зардлын энэ хоосон орон зай авч явж яах гээд байгаа юм гэдэг байдлаар нийслэлдээ энэ оны бүтээн байгуулалтад гүйцэтгэл нь хэд явах юм бэ? Ашиглаж чадахгүй буюу хэдийг гүйцэтгэж чадахгүй гэдгээр нь л гарч ирж байгаа орон зай нь энэ байхгүй юу. Энэ бондын чинь хугацаа ирэх онд дуусна. Тийм учраас 27 он дээр бид дахин санхүүжүүлэхээр 500 сая долларынх нь бонд гаргах тэр эрхийг нь аваад орж байгаа. Тэр зөвхөн энэ нийслэлийн бондыг дахин санхүүжүүлэх зорилгоор оруулж ирж байгаа 27 оны төсөв дээр. Харин би хэлээд байна шүү дээ. Тийм юм мэдэхгүй би.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Төсөв ярихаар сүүлийн жилүүдэд цар тахал ковид /COVID-19/ гэж нэг хэсэг баахан ярилаа, дэлхий нийтийн дайн бүхий байдал, Орос, Украины асуудал, сүүлдээ Ормузын хоолой гээд, одоо ингээд шатахууны үнийн өсөлт гээд. Энэ бүх хүндрэл, бэрхшээл сорилтуудыг Монгол Улсын иргэд маш сайн ойлгож байгаа. Ойлгохын цаагуур ойлгоод зогсохгүй асар тэвчээртэй байгаа. Шатахуундаа дараалж дугаарлаж зогсож байгаа. Монголын хаа ч болсон Монгол Улсын иргэд засаг төрийнхөө хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах итгэл найдвар тээсээр асар тэвчээртэй, хүлээцтэй хандаж байгаа.

Гэхдээ нөгөө талдаа Ромын 500 жил болсон эзэнт гүрэн нэг өдөр унаагүй, 50 жил мөхөл рүүгээ чөлөөт уналтаар унасан байдаг. Үүнтэй адилхан улсын Ерөнхий сайд, эрх баригч намын дарга та надад нам хамаагүй, бид 4, 5-хан сар Ерөнхий сайд хийж байна гэж туйлширч болохгүй. Яагаад гэвэл өнөөдрийн эрх баригч МАН-ыг институт гэж хүмүүс хэлдэг. Маш олон мега /mega/ төслүүд гэж ярьдаг. Нэг мега одоо хотод болж байсан мега гэгдэх төсөл нь Туулын хурдны замыг зогсоогоод, маргааш нь шинээр дарга болсон хүн нь би Дунд голын эрэг дээр тоглож өссөн хүүхэд энэ төслийг явуулахгүй гэдэг ч юм уу. Хөрөнгө оруулалтын асар том, том төслүүдийг явуулахдаа хулгай гарч болзошгүй тэр нүх сүвнүүдийг нь бөглөж чадаагүй, хулгайчтай нь хариуцлага тооцож чадаагүй.

Өнөөдөр нэг аймгийн Засаг дарга 10 сая төгрөгийн авлига авсан хэргээр 10 жилийн ял авч байхад хэдэн их наядын хулгайг манай улсын хамгийн өндөр эрх мэдэл бүхий хүмүүс олон цагаар телевизээр ярьсан боловчиг ямар ч хариуцлага хүлээгээгүй. Үнэн байсан юм уу, худлаа байсан юм уу? Нэг ЗГ-ыг бүрдүүлж, хамтарч засгаа байгуулаад бүгд мартчихдаг, ард түмнээрээ тоглодог. Өөрөөр хэлбэл хүндрэл бэрхшээлтэй байдлыг иргэд ойлгохын цаагуур ойлгоод хүлцэнгүй тэвчээртэй байгаа авч, байгаа хулгайн хамгийн том шалтгаан нь өөрөө төсөв болчихоод байгаа учраас ард түмэн уурлаад байгаа байхгүй юу. Ерөнхий сайд хэлж байна шүү дээ, би бодит байдлыг л хэлж байна, нөхцөл байдлыг сайжруулмаар

байна, засахын төлөө явж байна гэж. Гэтэл энэ хулгайтайгаа зэрэгцээд хуулийг гүйцэтгэх засаглал чинь өөрөө хэрэгжүүлэх үүрэгтэй байтал өнөөдөр авлигын индекс /index/ нь 10, 10 байраар ухардаг болчихсон.

Нэг талдаа орлогоо ахиулъя, амьжиргаагаа өсгөө, иргэдийнхээ амьдралыг аятайхан болгоё гэж байгаа засгийн бодлого байгаад байгаад, нөгөө талд нь хулгайчид нь дотроо ороод суучихсан, хулгайчидтайгаа эвлэрчихсэн учраас ард түмэн ууртай байгаад байгаа байхгүй юу. 10 сая төгрөгийн авлигад холбогдсон хүн 10 жилийн ял авдаг юм бол хэдий их наядаар нь идэж уусан хүмүүс яагаад хариуцлага тооцохгүй байгаа юм гэдэг дээр л иргэд ууртай байгаа. Тэгээд яг таны хэлдэг үнэн шүү дээ. Энэ танхим дотор орж ирээд Мэндсайхан сайдаа, байж байгаач, энэ танхимд орж ирээд бүгдээрээ л цэцэрхэж байна гэж үнэн шүү дээ.

Тэгэхээр манай улсын төсөв бол нэгдмэл улсын төсөв биш, холбооны улсын төсөв шиг эртэй чадалтай нь өөрийн тойрогтоо, салбартаа хүч түрэн төсөв авдаг ийм л болчихсон. 5 жилийн өмнө манай улсын нэг аймгийн төсөв 17 хувьтай, нөгөө аймгийнх нь төсөв 0.3 хувьтай байсан яг энэ шударга бус тогтолцоо яг одоо явж байгаа. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд улсынхаа төсвийг нийцүүлээч гээд Магнайсүрэн даргад 15 сарын өмнө 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдөр та 80.6 хувиар томилогдоход чинь хэлж байсан. Та тэрийг тайлбарлаач. Яагаад энэ одоо хүртэл шийдэгдэхгүй байгаа юм бэ? Өнөөдөр, Их Хурлын дарга нэг минут нэмээд авчихъя.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн нэг минут.

С.Эрдэнэболд: Дарханы Шарын гол дээр эмнэлэг хэцүү байна нурах гэж байна, Сэлэнгийн Сүхбаатар дээр эмнэлэг хэцүү байна. Өнөөдөр жишээлбэл Дархан, Сэлэнгэ, Төв аймагт маш олон газар 48 сум, 74 сумтай тэнцэх нэгжид эмнэлэг, сургуулийн байр асар хүнд болчихсон. Тэгээд Их Хурлын гишүүд рүүгээ ханддаг, нөгөөдүүл нь тойргоос нь сонгогдсон учраас асуудлыг шийднэ гээд явдаг, худлаа хэлдэг нөхцөл байдалтай л болсон. Монгол Улсын өнцөг булан бүрд ийм байгаа. Харин нөгөө анх томилогдоход нь шүүмжилж байсан Батшугар сайдын тэр Си Ди Си /CDC - Centers for Disease Control and Prevention/ гээд өвчний хяналт, урьдчилан сэргээлтийн төв гээд өөрөөр хэлбэл нэг салбар доторх олон, олон давхардлыг хийдлүүдийг арилгаад системийн уялдааг хангах тэр чиглэлийг жишээлбэл яам болгон ЗГ хийх ёстой болчихоод байгаа юм. Тэгэхээр Ерөнхий сайдаа таны ярьж байгаа зүйлийг үгүйсгээгүй. Гэхдээ таны ярьж байгаа үг тунхгийн чанартай үлдэж болохгүй. Аудитаас хариулт авъя. Шударга бустай яаж тэмцэх юм бэ, авлигаа яаж бууруулах юм бэ, төсвийн цоорхой болоод байгаа авлига, хулгай.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараа нь аудит бэлдэж байгаарай.

Н.Учрал: Энэ хоосон тунхаглал болж болохгүй учраас анх удаа яг манай ЗГ-ын бодлого шингэсэн төсвөө Их Хуралд өргөн мэдүүллээ л дээ. Нэг ёсондоо анх удаагаа шүү дээ. Энэ төсвийн бодлогоор бодож байгаа төлөвлөж байгаа ажлуудаа хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг өрхийн хаалга, үүдээр оруулна. Бүх бүлэгт зориулсан бодлогоо шингээсэн. Тийм учраас ирэх оны төсөв дээр та бүхэн нарийн дүгнэж харвал ЗГ-ын энэ чөлөөлье үндэсний санаачилга Ерөнхий сайдын 9 шийдвэр амь орно, амь орно. Төсвийн тодотгол бол тулаад ирсэн зовлонг туулж гарах ийм л бодлого байхгүй юу. Та тунхаглаж байна та ийм юм ярьж байна гээд.

Энэ чинь яг төсвөөр амьдрал дээр илүү хэрэгжиж байгаа байхгүй юу. Тэгээд ер нь Эрдэнэболд гишүүн бид 2-ын чинь нөгөө ингээд ярихаар та 2 чинь их сүртэй ярьж байна гээд байдаг юм шүү дээ та бид 2-ын чинь, тэрнээс биш энэ чинь нөгөө төсвөөр хэрэгжиж байгаа, дээрээс нь Эрдэнэболд гишүүн шиг нэг ийм аливаа асуудлыг сууриар нь хараад цогцоор нь шийдье гэдэг ийм эрүүл бодолтой хүмүүс манай сөрөг хүчин зөндөө байгаа.

Тийм учраас нөгөө асуудлыг шийдэх тал руу нь нөгөө тулаад ирсэн сорилттойгоо бидний асуудал энэ юм шүү гэж харах ёстой болохоос биш энэ нэг АН-ын, Ардын намын зовлон биш болчихлоо л доо. Тэгээд бидний хамгийн том өрсөлдөгч үнийн өсөлт. Тэгээд үнийн өсөлттэйгөө тулаад л зовлонгоо туулаад гаръя л гэж байгаа шүү дээ. Тэгэхдээ би энэ дээр ямар ч агаарын юм яриагүй. Тодотгол сая би үгэндээ ч уншлаа 5 бодлого байна л гэж. Ирэх оны төсөв бүх бүлэгт хүрнэ. Бүх бүлэгт хүрнэ, би төсвийг 9 шийдвэрээ би зарласан. Энэ зүгээр лоозон биш, энэ бодитой арга хэмжээ байхгүй юу. Тэгээд сая хэллээ, тэгээд нөгөө энэ хууль бус зүйлтэй тэгээд эвлэрэхгүй гэдгээ би хэлсэн. Над дээр ирсэн бүх бичиг баримт хууль хяналтын байгууллагаас шалгуулах зүйлүүдийг би шууд шилжүүлж байгаа шууд шилжүүлж байгаа. Тэгэхээр энэ ард түмний амьдрал хүнд байхад үр ашиггүй гүүр, зам, элдэв юм хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзээд би зогсоохыг нь зогсоосон. Үүнээсээ болоод дотоод, гадаадгүй улс төртэй нүүр тулж байгаа нь үнэн. Гэхдээ би энэ дээр нэг тийм хэн нэгэн рүү буруу чихэж хоосон улс төржилт хийрхэл гэхээс илүүтэйгээр яг шийдвэрээ амилуулах ёстой гэдэг утгаараа л олон жил бүх гишүүд л ТӨК-ийн ногдол ашгийг авах ёстой л гэж яриад л байсан. Яг ингээд бодитойгоор орж ирээд санхүүгийн зах зээл амилаад явж байсан тохиолдол тэр бүр байхгүй шүү дээ. Одоо ингээд л хамтдаа хийгээд л гаръя.

С.Бямбацогт: Аудит хариулъя, 4 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газрын нэг үндсэн чиг үүрэг бол төсвийн хууль, төсөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэх, хэрхэн нийцэж байгаа эсэх асуудал байдаг. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дотроо юу гэж заасан бэ гэхээр зэрэг энэ үнэлэх шалгуур үзүүлэлтийг ҮАБЗ боловсруулж батлахаар ингэж заасан. Хаврын чуулган дээр УИХ-ын чуулган дээрээс гарсан саналын дагуу манай байгууллагад тодорхой чиглэл өгөгдөөд, бид энэ талаар судалгаа хийж ажилласан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй санал солилцсон, Үндэсний аюулгүй байдлын ажлын албатай энэ талаар санал солилцсон. Бидэнд ирсэн мэдээллээр бол аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэгдээд үндсэндээ боловсруулагдаад бэлэн болсон, удахгүй батлах ийм хэмжээнд ирнэ гэсэн. Ингэсэн тохиолдолд энэ шалгуур үзүүлэлтийг нэг мөр шинэчилье гэдэг ийм мэдээлэл бидэнд өгсөн. Бид холбогдох мэдээлэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 4 дүгээр микрофон.

З.Мэндсайхан: Бид энэ чиглэлээр өөрсдийнхөө хэмжээнд судалгаа, саналаа зохих хэмжээнд боловсруулаад холбогдох газруудаас саналаа аваад тэгээд Их Хурлын даргад хугацаатай өгсөн үүрэг, чиглэл өгсөн хугацаанд нь бол мэдээллийг хүргээд, Аюулгүйн зөвлөлөөр энэ асуудлыг батлуулах асуудал дээр дэмжлэг үзүүлээч гэсэн ийм байдлаар бид асуудлыг тавьчихсан байж байгаа. Тэгээд аюулгүйн байдлын үзэл баримтлал маань шинэчлэгдсэний дараа энэ асуудал нэг мөр шийдэгдэх ийм хүлээлттэй байгаа.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Манай улсын ярьдаг сэдэв бол ер нь нэг ийм улирлын чанартай, өвөл болохоор утаа, утаанаас үүдэлтэй эрүүл мэндийн хохирол, зун болохоор үер, намар тариа хураалт, өвлийн бэлтгэл, хавар зуд турхан гээд. Бодит амьдрал дээр жишээлбэл түрүүн нэг Их Хурлын гишүүн шүүмжилж байна лээ. Төвийн бүсэд тэр трактор гэж. Яг жишээлбэл 118469 километр квадрат нутаг дэвсгэр дээр оршиж байгаа төвийн бүсийн 5 дугаар тойрог 48 сум нь өнгөрсөн жил 20 хэдэд нь зуд болсон. Яваад очдог онцгойгийнх нь машин хүрэлцээ муутай, сумынхан хувийнхаа машиныг эвдэртэл нь машин чирдэг, бие давхар жирэмсэн хүн хээр цасанд боогдчихсон хүнд нөхцөл байдалтай байдаг. Энийг зүгээр нэг тийм гүехэн трактор төдийхнөөр харах биш цаад талдаа бодит амьдралын ийм шалгуурууд байдаг. Тийм учраас яг энэ төсөв гэдэг бол амьдрал дээрээ хүрсэн байх.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Энэ сүүлийн үед ард иргэдээс манай гишүүд ч гэсэн яваад тойрогтоо уулзалтууд хийгээд, санал аваад, хэвлэл мэдээллээр энэ судалгаануудын дүн гарахад иргэдийн хамгийн их бухимдлыг төрүүлж байгаа асуудал номер нэгд үнийн өсөлт байгаа. Гадуур дэлгүүрүүдээр зөндөө л явлаа. Ер нь энэ хүнснээс бусад барааны дэлгүүрүүдээс бараг хүмүүс ер нь юм авч байгаа нь их цөөхөн байна. Ихэнх түрээсийн лангуунууд хаагдаж байна. Яагаад гэхээр хүмүүс үндсэн хүнснээсээ илүү гарч чадахгүй тэр нь хүрэлцэхгүй ийм болчхоод байгаа. Өмнө нь ажил хийдэггүй хүн ядуурч байсан бол одоо ажил хийдэг нь ч ядуурч байна. Бүгд ингээд хавтгайгаараа энэ авч байгаа цалин хөлс нь төрийнх ч бай, хувийнх ч бай юунд ч хүрэхгүй байгаа. Тэгэхээр энэ үнийн өсөлт ерөөсөө бүх юмны л нэгд хамгийн том шийдэх асуудал гээд яваад байгаа юм.

Тэгэхээр бид энэ тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсийг нэмэхэд АН 100 хувь дэмжиж байгаа. Өнөөдөр зааланд ярихад нэг бид л эсэргүүцээд нэмэхгүй гээд байгаа юм шиг тийм ойлголт төрүүлж болохгүй. Манай бүх л гишүүд энийг нэмэхийн төлөө л байгаа. Гэхдээ ЗГ-аас оруулж ирж байгаа энэ асуудал нь зорилго нь зөв боловч, энэ хэрэгсэл, арга нь алдаатай байна л гээд байгаа юм. Энийгээ засахгүй болохгүй нь л гэж байгаа юм. Би амархнаар энгийнээр тайлбарлая л даа. Бид нэг халаасанд нь 100 мянган төгрөгийн нэмэгдэл хийххээд удалгүй хэдхэн сарын дараа нөгөө халааснаас нь 300 мянган төгрөг суйлах гээд байна, 300 мянган төгрөгийг хүчээр авах гээд байна гэдэг дээр л бид чинь бүгд санаа зовоод байгаа шүү дээ.

Өөрөөр хэлбэл энэ инфляцын чинь өндөр болно, үнийн хөөргөдөл явна энэ дээр л санаа зовоод байгаа юм. Сүүлийн үед тэр Блүүмбергээр /Bloomberg/ эдийн засагчид яриад байна шүү дээ. Энэ инфляц чинь бага орлоготой иргэдэд бүр 25-аас 30 хувь нөлөөлөөд байгаа нь ингээд бүх юугаар ингээд судалгаанууд дээр гаргаад байгаа юм. Тэгэхээр бид бол энэ эдийн засгаа зөв болгоё, эдийн засгаа элгээр нь хэвтүүлчихгүй байя, сүүлдээ бүр нэмэгдэл биш бүр цалин тэтгэврээ ч тавьж чадахгүй хэмжээнд очвол яах вэ гэсэн ийм зүйлд санаа зовоод байгаа юм. Тэгэхээр энийг ойлгож үзэх хэрэгтэй.

ЭМД-ын сангийн тухай ярихгүй бол болохгүй. Би уг нь Батшугар сайдыг их л дэмжээд, зөвлөгөө өгөөд хоёулаа хамтраад яриад байсан. Энэ 71 юм уу 80 тэрбум

төгрөг 71-ээс 80 тэрбум төгрөг ЭМД-ын сангаас гарах гэж байгаа байхгүй юу. Энэ бол эмийг үнэгүй өгнө гээд зарлачихсан. Тэгэхээр энэ үнэгүй гэдэг юм чинь өөрөө асар их олон эрсдэлийг дагуулна гэж хэлэх гээд байна. Энэ төсвийн мөнгө биш байхгүй юу, ЭМД-ын мөнгө гэдэг чинь ЭМД төлж байгаа даатгуулагчдын мөнгө байхгүй юу энэ чинь бүр сан нь тусдаа байдаг мөнгө. Энэ дээр ямар нэгэн цалин, тэр нэмэгдэл энэ тэр өгч болохгүй. Энэ чинь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд, худалдаж авч байгаа мөнгө болохоос биш, өнөөдөр зүгээр төсвийн цоорхой нөхдөг мөнгө биш шүү дээ. Энийг олон жил хэлээд л явж байна. Сүүлийн үед дандаа ЭМД-ын сангаа тонож байгаа шүү дээ. Тэгэхээр сүүлийн хэдэн жилд эрүүл мэндийн үйлчилгээ яагаад муудаад байна вэ гэхээр эмнэлгүүд дээр очихоор “энэ даатгалын мөнгө нь байхгүй, манайх санхүүжилт байхгүй” гээд хэчнээн хүн өнөөдөр өвчин нь хүндэрч байна, хэчнээн хүн бүр эмнэлгээр яваад мөнгө байхгүй болж байна. Зарим нь олон хүн нас барж байна.

Тийм учраас энэ ЭМД-ын сангаараа битгий тоглооч гэж би МАН-ынханд үеийн үед хэлээд дийлэхгүй л байгаа. Та нар энэ санг бүр улам татаж унах гэж байгаа байхгүй юу. Тэр Ли Куан Ю /Lee Kuan Yew/-ийн ном дээр байдаг, иргэддээ нэг хэсэг эмийг нь үнэгүй өгөөд үзсэн юм байна. Тэгсэн чинь хүмүүс ерөөсөө эмээ хаяад.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа асууя, нэг минут.

С.Одонтуяа: Хүмүүс эмээ хаяад эхэлсэн, тэгэхээр Ли Куан Ю ерөөсөө эмийг үнэгүй өгч болдоггүй юм байна гээд тодорхой төлбөртэй даатгалаас нь санхүүждэг болсон. Тэгэхээр энэ бусад орны алдааг битгий давтаач. Эргээд 3.5 сая хүнийхээ эрүүл мэндийг та нар эрсдэлд оруулах гээд байна гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь тэр хөнгөлөлттэй зээл олгоно гэж байгаа. Энэ гоё сонсогдож байгаа. Гэхдээ хэзээ ч эзнээ очиж олоогүй байхгүй юу, өгөөгүй байхгүй юу. 2023 онд баахан зээл өгсөн яг зээлийн мөнгө гарсан хэдэн өдөр хадгаламж өссөн байхгүй юу. Банк бус санхүүгийн нийлүүлэлт ихэссэн, энэ чинь эзэндээ очдоггүй дандаа арын хаалгаар очно, тэр мөнгөтэй хүмүүст ингээд очиж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ санаа зорилго нь зөв боловч арга хэрэгслүүд нь буруу байна гэдгийг би хэлмээр байна. Тэгээд Учрал дарга энэ дээрээ АН ингээд алдаа гаргахгүйн төлөө нэг зөвлөөд байна, энийг нь сонсьё гээд та энэ дээр асуудлуудыг нь сонсохыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ АН-ынхаа саналыг сонсоно, тийм би үргэлж сонсоно. Та бүхэн энэ Монгол төрийн 2 тулгуур баганын нэг. Танай нам чинь эрх барьдаг нам шүү дээ. Тэгээд би хамт шийдлээ ярья, асуудлаа ярья гэхээр огцрох ёстой гээд ингээд тэгдэг байхгүй юу, аягүй тийм ойлгомжгүй. Тэгээд чуулган зарлая гэхээр тэгээд ингээд Их Хурлын дарга зарлачихсан юм шиг байгаа юм. Тэгээд ярья гэхээр өөдөөс ингээд ерөөсөө нөгөө нэг хэл ам нэвтрэхгүй байна л даа яг үнэнийг хэлэхэд. Тэгээд би танай нам дотор хэл ам нэвтэрдэг тан шиг зөндөө хүн байна шүү дээ. Энэ Жаргалан энэ тэр чинь овоо юм уу гэхээр ингээд тэмээ гэхээр ямаа гээд ингээд юм ярихаар өөдөөс инээгээд энэ чинь инээх цаг ерөөсөө биш байна шүү дээ. Тэр асуудлаа ярья, шийдлээ ярья гэхээр төсвийн тодотгол асуудал байна тэгээд бүгдийг нь шингээгээд оруулаад ирлээ. Энэнээс өөр шийдэл байхгүй ингээд оруулаад ирлээ. Харин тийм, тэгээд ингээд оруулаад ирчхээд байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээрээ яриач

гээд байна шүү дээ би. Субъектив байдлаар биш, үгүй ээ харин тийм бид ингээд шийдлээ ярья гэж байна шүү дээ.

Одонтуяа гишүүний ЭМД-ын сан дээр би 9 шийдвэрийн дотор нэг л юмыг ярьсан юм. Тэр нь юу юм бэ гэхээр ЭМД-ын сан дээр эмийн жагсаалтыг шинэчлэх ёстой. Тийм учраас Батшугар сайд энэ дээр ажиллаж байгаа. Яагаад гэхээр хамтын төлбөр гэж байдаг юм байна. Ахмад хүмүүс өнөөдөр чихрийн шижингийн эм, даралтын эмийг авахад 30-аас 50 хувийг өөрөөсөө гаргаад, сангаас нь 50 хувийг нь санхүүжүүлээд явж байгаа. Энэ яг зорилтот бүлэг байхгүй юу. Тэрнээс бүх эмийг үнэгүй олгохдоо биш. Гол нь хөнгөлөлттэй эмийн жагсаалт нүдээ олохгүй байна л гэж байгаа юм. Тэгэхээр хөнгөлөлттэй эмийнхээ жагсаалтыг шинэчлээд, яг тэр өдөр тутам хэрэглэдэг тэр эмүүд дээр нь тэр яг ахмадуудынхаа тэр хамтын төлбөр төлөөд байгаа хэсгийг нь сангаас санхүүжүүлэхэд бид 80, ирэх оны төсөв дээр 78 тэрбум төгрөг тавьж байгаа. Ингэснээрээ тэр жагсаалт шинэчилснээр өдөр тутам авдаг эмүүд дээр хамтын төлбөрийг нь шийдэхэд тэр зөвхөн тэр ахмадуудын зорилтот бүлэгт чиглэж байгаа хамтын төлбөр. Түүнээс бүх эмийг үнэгүй болгох гээд байгаа юм байхгүй.

Гол нь Батшугар сайд тэр хөнгөлөлттэй эмийнхээ жагсаалтыг шинэчлэх хэрэгтэй. Тэгээд одоо ажиллаж байгаа. Дээрээс нь олон улсын стандартын лабораториор шинжилж байгаа хэд хэдэн эм дээр дүгнэлт гарсан. Стандарт нь болохгүй байна гээд. Ингээд цогцоор нь шийдээд хамтын төлбөрийг нь тавиад явъя л гэж байгаа юм. Ийм л юм байгаа шүү дээ. Тэгэхээр Одонтуяа гишүүний хэлж байгаа энэ ЭМД-ын сангийн бие даасан байдлыг илүү авч явахын тулд энэ 20 хувийн цалинг нэмэхийн тулд зүгээр даатгалын сан дээр энэ 80 тэрбумыг нэмсэндээ тэр 50 хувийг цалинг нь энэ ондоо багтаагаад дуусгана л гэж байгаа юм. Ийм л зарчим. Батшугар сайд нэмээд тайлбарлах уу.

С.Бямбацогт: Батшугар сайд хариулъя нэмж.

Э.Батшугар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь манай Монгол Улс бол яг тийм 1990-ээд оны эхээр хамгийн зөв, энэрэнгүй тийм систем угсарсан юм байна лээ Бисмаркийн /Bismarck/ Германыг дуурайж эрүүл мэндийн салбартаа угсарсан. Тэгээд яах вэ мэдээж энд нь тохируулга хийж явах зүйтэй гэж харсан юм. 669 эмийг бол ЭМД-аас хөнгөлдөг. Үүнтэй холбоотой Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авсан судалгаа болон гаднын зөвлөхүүд юу хэлээд байна гэхээр яг ахмад хүний, орлогогүй хүний, нэмэлт орлогогүй хүний халааснаас нь энэ эрүүл мэндийн бүтээгдэхүүнд олгодог эм, эмнэлгийн хэрэгсэл хамгийн өндөр тусаад байна. Тэгэхээр ямар реформ хийх гэж байгаа юм бэ ирэх жил гэхээр тэрэндээ 79 тэрбумыг нэмж гаргаад, төсвөөс аваад тэгээд тэр нь цэвэр зорилтот бүлэг болох ахмадууд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамтын төлбөргүй олгоно.

С.Бямбацогт: Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя, алга байна. Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Хөрөнгө оруулалтын талаар л асуух гээд байна. Бид чинь энэ 26 онд 3 их наядын хөрөнгө оруулалт улсын хэмжээнд зам барина, барилга барина, бүтээн байгуулалт хийнэ гээд 3 их наядын хөрөнгө оруулалт баталсан. Тэгэнгүүтээ Төрийн хэмнэлтийн тухай хууль гээд 5 сарын 31-нээр гэрээ байгуул, гүйцэтгэгч нь шалгараагүй татчихдаг нэг хууль байна. Тэгээд заримдаа зураг төсөвгүй гээд шалтаг хэлдэг юм шиг байна. Тэгээд энэ чинь улсын төсөвт чинь бид зөндөө

хэлэлцүүлэг хийж, маш их шүүлтүүрээр орж, яг зураг төсөвтэй, ТЭЗҮ-тэй ажлуудыг л хөрөнгө оруулалт тусгадаг шүү дээ. Бидэнд ч гэсэн орон нутагтаа юм хийе бүтээе гэхээр тийм л шаардлага тавьдаг. Тэгээд тэр нэг тендер шалгаруулах процесс дээрээ ингээд нэг санаатай ч юм уу, санамсаргүй ч юм уу байлгаж байгаад ингээд гэрээ байгуулахгүй ингээд нэг хэмнэлт үүсгээд байгаа юм шиг юм яриад яваад байх юм. Тэгэхээр ер нь цаашдаа энэ нэг Төрийн хэмнэлтийн тухай хууль дээрээ өөрчлөлт оруулаад, энэ нэг бүтээн байгуулалтын 5 сарын 31-ний дотор гэрээ байгуулаагүй хойшлуулдаг энэ юм хумаа өөрчилж болохгүй юу 1 дүгээрт?

2 дугаарт манай улс өргөн уудам газар нутагтай маш их хийх ажил байна. Ард иргэд маш их ажил хийх бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажил, хэрэгцээ шаардлага байна ард иргэдэд. Өнөөдөр сумдад шугам сүлжээ алга. Мөн сум, аймгийн төвүүдийг холбосон авто замууд хиймээр байна. Сумдад төрийн албан хаагчдын орон сууц баримаар байна, нураад унах гэж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдээ шинэчилмээр байна гээд маш их хийх ажил байдаг. Гэтэл нөгөө талдаа ингээд ажил хийх гэхээр зарим гишүүд хүртэл бараг хэрэггүй байшин барилга, зам, гүүр ярилаа гээд байх юм. Үгүй ээ, тэр хөдөө орон нутагт чинь хүн амьдарч байгаа юм чинь байшин барилга, зам, гүүр хэрэгтэй шүү дээ. Тэрийгээ бид чинь эрэмбэлээд л, тодорхой болгоод л ингээд хийх л ёстой ажил шүү дээ. Тэгэхээр нөгөө төсөв мэдээж хязгаартай гээд ойлгож байна. Тэгээд сүүлийн үед нэг төр, хувийн хэвшлийн түншлэлээр юм хийнэ гэдэг болчихсон. Тэгээд сая өнгөрсөн 25 оны намар 26 оны төсвийг батлахдаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Тэгээд би Эдийн засаг, хөгжлийн сайдаас асуух гээд байгаа юм. Яг ноднингийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд өөрчлөлт орсноос хойш яг ямар дүнтэй, хаанах, хаанахын том төсөл ажил эхлэв? Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эсвэл яриа хэлцэл хийгдэв, яг гараанаас гарсан ажил байна уу гэдгийг асууя?

2 дугаарт нь Зам, тээврийн сайдаас асуумаар байна. Жишээлбэл баруун аймгийг чиглэсэн Монголын ард иргэдийн гол явдаг ч зам байна. Жишээлбэл нэг Лүн хүртэл замыг 4 эгнээ болгоно, 6 эгнээ болгоно ТЭЗҮ хийж байна, зураг хийж байна гээд л 3 жил ярилаа. Тэгээд энэ ажлыг ер нь яг хэзээ хийх юм бэ? Тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр байна уу, эсвэл тэр гаднын хөнгөлөлттэй зээлээр байна уу нэг хиймээр байна шүү дээ. Энэ жил зун гэхэд ямар их энэ баруун тийшээ явсан зам дээр аваар осол болж, хэчнээн ар гэр хагацал зовлон үзэв, хэчнээн ард иргэд эд хөрөнгө, цаг хугацаагаараа хохирч байна. Ямар их эрсдэлтэй нөхцөл байдал байгаа билээ. Тэгээд энийг нэг тооцоод ингээд нэг бүтээн байгуулалт энэ ажил руу нэг жоохон анхаарахгүй юм уу? Тэгээд цалин, тэтгэврийг болохоор ингээд л сүртэй, сүртэй ярьцгаах юм. Бүтээн байгуулалтыг яагаад ярьж болохгүй байгаа юм бэ? Бүтээн байгуулалт чинь цалин хөлснөөс дутахааргүй энэ ард иргэдийн ажил амьдралд нөлөөтэй ийм асуудал шүү дээ. Тэгэхээр ажил хиймээр байна, ажил хийхдээ тэр энэ болохгүй байгаа зүйлүүдээ засаад явмаар байна. Тэр Лүнгийн замыг ямар нөхцөлөөр байдаг юм явуулмаар байна, цаашаа Элсэн тасархай хүртэл тавимаар байна. Энэ дээр нэг Зам, тээврийн сайд ямар боломж, бололцоо байна тэрийг нэг хэлж өгөөч?

С.Бямбацогт: Зам, тээврийн сайд хариулах уу? Дэлгэрсайхан сайд, дээрээс нь тэр Цогтбаатар гишүүн Баянхонгорын нэг говийн юу руу зам бариагүй байгаль

орчин хөрс эвдээд байна гэсэн тэрийг та нэмээд хариулчхаарай. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Мэдээж зам чухал, тэр дундаа Лүнгийн зам баруун тийшээ гарч байгаа 9 аймгийн сая гаруй хүн зорчиж байгаа ийм зам байгаа юм. Тэгээд таны хэлдгээр энэ 101.7 километр замыг бид тавьчихвал цаашаа ингээд 3 тийшээ задраад ингээд ачаалал нь арай гайгүй болох ийм боломжтой гэж үзээд Лүнгийн замыг одоогоос сарын өмнө төр, хувийн хэвшлийн түншлэлээр зарлахаар бэлтгэл ажлыг нь хийгээд, ингээд удахгүй бид Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжүүлэх гэж байна. Яах вэ ер нь аль болохоор ийм том төслийг бид төсөв дээр аваад явахад үнэхээр хүндрэлтэй байдаг. Зөвхөн Лүнгийн замын анхны хийсэн зураг төсөл нь 6 эгнээ 370 сая орчим доллар /USD/ байсныг зургаа, бусад аймаг руугаа энэ Лүнгийн зам өөр Багануур, энэ Төв аймаг руу явах зам гээд олон замуудаа бодолцож үзээд буцаагаад 4 эгнээ болгож зургийг нь өөрчлөөд, одоогийн байдлаар 270 сая орчим доллар руу орж ирж байгаа юм. Тэгээд энэ замыг бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулна. Бид тантай санал нэг байна. Ялангуяа дэд бүтэц хөгжиж байж тэр аймаг, орон нутагт зорчиж байгаа ард иргэдийн аюулгүй байдал, амь нас бүх зүйлийг хангаж ажиллана гэдгийг хэлье.

Дээр нь ер нь дэд бүтцийг аль ч улс орон хөгжихийн тулд эхэлж тавьдаг. Тийм учраас бид нэгэнт төсөв маань өнөөдөр ийм байдалтай байгаа болохоор том хэмжээний зам, дэд бүтцүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр аль болохоор барих ийм зорилтыг нэн тэргүүнд тавьж байгаа. Тэгээд бүр болохгүй гаднын зээл, тусламж ийм асуудлаар шийднэ гэдэг ийм 2 гаргалгаатайгаар л явж байгаа гэдгийг илэрхийлье.

Намайг эзгүйд Цогтбаатар гишүүн асуусан байна лээ. "Сэкер ресорсус" ХХК /Saker Resources LLC/ тэр замаа тавиагүй байж тээвэр яваад байна гэж. Ерөнхийдөө бид ингээд гаднын хөрөнгө оруулагчдыг нааш ир, юм хий, ингээд зам тавиад ингээд яв гээд ингээд урьдаг, тэгээд зам хийдэг. Зам хийж байгаа компани бүрэн гүйцэд хийгээгүй ч гэсэн бололцооны хийж байгаа үедээ мөнгөө эргүүлж олох гээд тээвэр гээд аль ч хөрөнгө оруулагчдад мөнгө төгрөгийн зовлон жаргал байдаг юм. Бид зөндөө олон удаа зогсоосон. Тэгээд ингээд тээврийг нь явуулахгүй гэхээр энэ бүтээн байгуулалт нь зогсчоод байдаг. Уул нь энэ зун тээврийг нь явуулаагүйгээс болоод энэ зам ингээд дэд бүтцийн хучилтаа авч чадаагүй юм.

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Дэлгэрсайхан сайд нэг минут.

Б.Дэлгэрсайхан: Тэгээд энийг зогсоох шиг амархан юм байхгүй, зүгээр аль алинаа бодолцоод, тээвэр нь ч яваад, тэгээд дээр нь замаа ч үргэлжлүүлж барих энэ юмыг нь ингээд хослуулаад хийх нь зөв юм болов уу гэж бодож байгаа. Тийм учраас бид аль болохоор гаднын хөрөнгө оруулалтыг үргээхгүй байх, дэмжих энэ асуудал дээр илүү анхаарч байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Тэгэхдээ үнэхээр ард иргэд бухимдаад тоос шороо босоод ингээд байгаа бол Цогтбаатар гишүүний саналыг хүндэтгэлтэй хандаж бид газар дээр нь ажлын хэсэг ажиллуулаад, тэгээд хаах шаардлагатай бол хаах арга хэмжээ авна гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя, Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай мэдээлэл өгье. Байдрагийн УЦС-ын төрийн түншлэлийн сонгон шалгаруулалт ирэх 7 хоногт эцэслэн шийдэгдэнэ. Тавантолгойн ДЦС-ыг мөн хоёр 7 хоногийн дотор багтааж зарлахаар бэлтгэл ажил дууссан. Тавантолгой-Гашуунсухайтын авто замын концесс 250 километрийн ажил амжилттай явагдаж байна. Эхний ээлжийн Цагаан хаднаас хилийн боомт чиглэсэн, гол ачаалал авч байгаа замынхаа эхний ээлжийг хүлээж авсан. Шинэ нисэх буудал, "Чингис хаан" нисэх буудал мөн концессоор хэрэгжээд менежмент нь Японы талд явж байна. Мөрөн-Улиастайн авто замын асуудал мөн энэ 3 дахийн ЗГ-ын хурлаар ороод эцэслэж байна. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын мөн концесс, хөрөнгө оруулалт, түншлэлээр хэрэгжээд явж байна. Зүүнбаян-Хангийн төмөр замын ажил мөн концесс, түншлэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт нь хийгдээд ажил нь дууссан. Дархан-Алтанбулагийн замын ажлыг шинжилгээ, судалгаанууд.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, Энхбаяр сайд нэг минут.

Ж.Энхбаяр: Дархан-Алтанбулаг чиглэлийн өндөр хурдны замын ажлын тооцоо, судалгааны ажлууд нь, ТЭЗҮ нь дууссан ингээд зарлана. Сонирхогч орж ирэх нь үү харна. Алт цэвэржүүлэх үйлдвэр байгаа мөн төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ асуудал явагдаж байгаа. Лүнгийн зам мөн адил зураг төсөл дууссан, мөн түншлэлээр зарлана. Нэгэнт төсөв дээр манай урсгал зардал маань 80 гаруй хувь гарчихсан энэ цаг үед бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалтыг дэмжиж, томоохон төслүүдийг хэрэгжүүлж барих-ашиглах, тэгээд төрд буцаан шилжүүлэх гэсэн гол үндсэн зарчим дээр энэ арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Ажлууд эрчимтэй явж байна. Гэхдээ хангалттай сайн болоогүй байна. Ялангуяа хөрөнгө оруулалтын орчныг хамгаалах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гээд олон зүйл байна. Түмэн саадууд их байгаа боловч бага багаар нь зохицуулаад ингээд засаг дээр шийдээд арга хэмжээ нь авагдаад явж байгаа.

С.Бямбацогт: Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах уу гэж байна 5 сарын 31-ний нөгөө хөрөнгө хураагаад, гэрээ байгуулагдаагүй хөрөнгө оруулалтуудыг татдаг, тэр одоогоор өргөн барьсан ярьсан юм байхгүй байгаа байх тийм ээ. Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: 5 сарын 31-ний Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу гэж асуулаа тэгээд хариулсангүй. Тэрэн дээр чинь тэгээд зураг төсөвтэй байсан ч тендерт нь орсон нэг компани нь маргаан үүсгээд л асуудлыг сунжруулаад ерөөсөө нөгөө ард иргэдэд хэрэгтэй яг бодчихсон, төлөвлөчихсөн, яг хийх гэж байгаа ажлыг ингээд хойшлуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 5 сарын 31 гэдэг юмаа өөрчилж болохгүй юу гэдэг зүйлийг хэлье.

Дэлгэрсайхан сайдаас дахин дахин л гуйя даа. Та тэр төмөр зам тавиад л байх шиг байгаа юм урдуур сая энэ Хөшигийн хөндийн төмөр зам, Дорноговь руугаа зам тавиад байх шиг байгаа юм. Тэгээд өөрийнхөө тэр тойрог руу болоод байх шиг байна. Энэ Лүнгийн замыг нэг яаж ийж байгаад тэр эр хүний 13 мэхээ ашиглаж байгаад нэг эхлүүлээд, нэг олигтойхон шиг хөрөнгө оруулагч олоод, тэгэхгүй бол таныг төмөр зам тавиад байгааг чадаад байгааг хараад байна. Тэгээд энэ баруун тийшээ тэр 9 аймгийн сая гаран ард иргэд зорчдог зам шүү. Энэ зам дээр нэг онцгой анхаарал тавиарай гэдгийг танай яамны.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүн би ойлгож байна. Тэгээд сая Энхбаяр Тэргүүн Шадар сайд хэлсэн. Ер нь төсөв маань ийм байгаа нөхцөлд бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр л бүх юмыг хийж байгаа. Тэгээд яагаад энэ говь руу төмөр зам гэж байгаа, юу авто зам бүс өөрийнхөө тойрогт гэж буруу бодоод байх шиг байна. Ер нь Замын-Үүд-Улаанбаатарын чиглэлийн авто зам стратегийн ач холбогдолтой нэг номерын зам. Монгол Улсын импортын 84 хувь энэ замаар орж ирдэг. Энэ дээр маш их осол аваар гардаг, тэгээд энэ зам өөрөө ашигтай учраас хөрөнгө оруулагчид орж ирж байгаа юм. Бид ингээд Лүнгийн замыг ашигтай болгох үүднээс ингээд ЗТЯ бэлтгэл ажлыг нь хангаад, тэгээд энэ сонирхсон хөрөнгө оруулагч нарт олон ашигтай болзлуудыг тавьж байгаа юм. Жишээлбэл замын хажуу дахь энэ дэд бүтэц, хоолны газар, энэ юу гэдэг юм цахилгаан машин явуулж.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Тэгээд энэ бүгдийг нь дагуулж өгнө, та нарт ингээд бүх боломжийн нөхцөлийг өгнө, тэгээд тариф ямар байх юм гэдэг хамгийн маш хүнд асуудал. Ер нь хөрөнгө оруулагч нарын орж ирж байгаа ганцхан асууж байгаа юм нь юу гэхээр танай замын тариф ямар байх юм бэ, бид хэдэн жилийн дараа мөнгөө олох юм бэ гэдэг ийм л юм тавьж байгаа. Тэгээд бид мэргэжлийн хүмүүсээрээ ингээд нэлээд судалгаа, тооцоо хийгээд тэгээд тарифыг нь бодоод, тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа хамтраад энэ Лүнгийн зам удахгүй эхэлнэ. Сонирхогч орж ирсэн, ганцхан бид нарын яриа хэлэлцээ их чухал байгаа юм гэдгийг би ташрамд хэлье. Төмөр замын хувьд бүгдээрээ мэдэж байгаа. Хот тойрсон энэ төмөр замыг зайлшгүй хийх ёстой. Энэ Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг, дээр нь Аюулгүйн зөвлөлийн зөвлөмж байгаа. Хүн амын аюулгүй байдал, тухтай ийм орчинд Улаанбаатарын хүн амыг амьдруулах ийм чухал ач.../минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Нэг үг яалт ч үгүй бүр сэтгэлд ингээд буулаа. Сахил аваад шал дордов гэж Монголын ийм сайхан “сахил хүртээд шал дордов” гэж үг байдаг. Тэгэхээр ер нь эрхэм Ерөнхий сайд өнөөдөр энэ төсвийн тодотгол орж ирж байгаа энэ үед их хариуцлагатай гишүүдийн асуултад хариулах ёстой. Тоглоом наадам, янз бүрийн нэг ийм хошин шогийн юм шиг ийм байдалд хариулж болохгүй. Энэ парламентын гишүүд чинь өнөөдөр 3 дахь Ерөнхий сайдынхаа, эрх баригч намын 3 дахь Ерөнхий сайдын царайг хараад сууж байна шүү дээ. Та ер нь нэлээн поп ийм Ерөнхий сайд гэж би хараад байна.

Энэ төсвийн тодотгол хийнэ гэдэг чинь өнөөдөр зардлыг, төсвийн зарлагыг бууруулах чиглэлээр танилцуулга оруулж ирэх ёстой гэж ойлгож байгаа. Гэтэл өнөөдөр төсвийн орлого нэмэгдлээ, тэдэн хувиар өслөө, дагаад зарлага тэдэн хувиар өслөө гэж орж ирж байгаа юм. Тэгээд зарлагаа нэмчихсэн энэ төсвийн тодотгол орж ирчхээд өнөөдөр хэлэлцээд сууж байхаар чинь ер нь энэ тодотгол гэдэг юмыг оруулж ирж ингэж хэлэлцэх хэрэг байгаа юм уу? Энд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн гээд. Тэгэхээр ЗГ-ын төсвийн зарлагыг бууруулах биш, зардлын бүтэц өөрчлөх замаар төсвийн зарлагыг өсгөсөн гэж дүгнэхээр харагдаж байна. Өнөөдөр энд 1.4 их наядыг хэмнэнэ гээд байгаа юм. Энэ 1.4 их наядын хэмнэлтийг яг яаж хэмнэсэн

юм бэ? Төсвийн нийт зарлагыг 2 их наядаар нэмснийг юу гэж ойлгох юм бэ? Яагаад ийм алдагдалтай төсвийг батлуулах гээд ингээд зүтгээд байгаа юм бэ? 2 их наядын алдагдлаар яг юуг санхүүжүүлэх гээд байгаа юм бэ? Ерөнхий сайд та энд хариулаад тодорхой хариулаад өгөөч.

Багш нарын цалингийн дутуу санхүүжилтийн 674.5 тэрбум, ахмад настнуудын суурь тэтгэвэр 196.3 тэрбум, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн 170.1 тэрбум, стратегийн зарим барааны нөөц хангамж 150 тэрбум, эрчим хүчний салбарт 107.3 тэрбум, боловсролын салбарт 50 тэрбум энэ бүгд чинь ингээд харахаар энэ зардлуудыг чинь яаж 1.4 их наядыг энд ингээд юу яачихсан гэж ойлгох юм уу? Баахан томилолт, сургалт, эд хогшил, тавилга, автомашин, энэ тээвэр, шатахуун, тэгээд л урсгал засвар, зөвлөх мэргэжлийн үйлчилгээний энэ зардал, тэтгэмж, форм, хурал, баяр, ёслол, олон нийтийн арга хэмжээ, сургалт сурталчилгаа гээд энэ бүх зардлуудыг бууруулна гээд нийтдээ 1.4 их наядын хэмнэлт хийгээд тусгачихсан гэчихсэн мөртөө буцаагаад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаа өсгөчихсөн, эд хогшил, урсгал засвар дахиад зардлаа өсгөчихсөн, томилолт, зочны зардлаа өсгөчихсөн, хангамж, бараа материалын зардлаа өсгөчихсөн. Үгүй ээ энийг яаж хэмнэж, хаанаас энэ 1.4 их наядыг хэмжсэн юм бэ? Ийм зальтай ийм төсвийн тодотгол оруулж ирчхээд тулгаад заавал батал гээд, одоо хэлэлц гээд ингээд суулгачихсан.

Өнөөдрийн ард түмний амьдралын энэ ядуу байгаа, энэ хэцүү байгааг энэ дээр ингэж зоолж болохгүй шүү дээ. Ярихаараа гоё яриад байна л даа, АН-ын гишүүд ингээд ойлгохгүй ингээд байна гээд, АН-ын гишүүд ажил хийдэг, сэтгэдэг болоод илүү сэтгэдэг болоод өнөөдөр харин ч илүү яриад энд бүгдээрээ яриад суугаад байгаа. Юм бол баруун талын хар овоохой гэдэг шиг ингэж юу яаж болохгүй шүү дээ, АН-ын гишүүд рүү сөрөг хүчний гишүүд рүү ингэж бас.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд. Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Төсвийн тодотголыг өргөн барьсан. Би эхнээс нь л ярья даа, 1.4 их наяд урсгал зардлаас 433.4 тэрбум төгрөгийг хэмнэсэн, Нийслэлийн үнэт цааснаас 758 тэрбум төгрөгийг хэмнэсэн, хөрөнгийн зардлаас 249.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн. Энэ 1.4 их наядын хэмнэлт. Энэ чинь нөгөө цагаан дээр хараар бичсэн байгаа шүү дээ. Тийм.

Төсвийн тодотголоор юу шийдэж байна вэ гэхээр боловсролын салбарт дутагдаад байгаа цалингийн зардал 674.5 тэрбум төгрөгийг шийдэж байна. Он дуустал багш нарын цалин 50 хувь, 90 тэрбум төгрөг эмч нарын цалингийн 20 хувийн нэмэгдэл шийдэж байна. Дээрээс нь 80 тэрбум төгрөг соёл, спорт, байгаль орчин, хөдөө аж ахуй гээд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 50 хувь хүргэх гэж байгаа юм. 2023 оноос хойш анх удаа өрхийн орлого 4.9 нэгж хувиар буучхаад байна шүү дээ. Тийм учраас орлогыг баталгаажуулахын тулд.

Та бидний баталсан ЗГ-ын өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын хууль, суурь тэтгэвэр, 430 мянган ахмадын суурь тэтгэврийг 100-аас 300 мянга нэмэгдүүлэх юм. 430 мянган ахмадын чинь 1/3 нь 20-оос дээш жил ажилласан ахмадууд эзлээд байгаа юм. Түүний чинь 769 мянга буюу бага тэтгэвэр авдаг байхгүй юу. Түүнийг 300 мянгаар нэмэгдүүлэхээр 1 сая 77 мянга болох юм.

Дээрээс нь эрчим хүчний салбарт энэ засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэлд бид 92 тэрбум төгрөгийг тавьж байгаа юм. Ийм хүнд үед эрчим хүчний салбар дээр дулаан, цахилгааны үнийг нэмэхгүйн тулд 177 тэрбум төгрөгийг тавьсан байхгүй юу. Сая 9 сарын 1-нд хичээл эхлэхэд гэрт ойрхон сургууль хөтөлбөрийг 50 тэрбумаар санхүүжүүлсэн юм. Стратегийн нөөцүүдийг бүрдүүлэхийн тулд улаан буудайн дээр 100 мянган тонн, тантай хамааралтай компаниуд ч гэсэн энэ зовлон жаргалыг ярьдаг. Би тантай ч энэ асуудлаар ярьж байсан ийм л юм байгаа юм. Хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэхийн тулд 12 мянган тонныг авах гээд байгаа юм ногоог, махны нөөц дээр 20 мянган тонныг авах гээд байгаа юм. Зоорь, агуулах, нөөцүүдийг нэмэгдүүлэх гээд байгаа юм.

Шатахууны нөөцийг нэмэгдүүлэхийн тулд агуулах, савуудыг барих гээд байгаа юм. Жишээ нь үндэсний том ААН, байгууллагууд Шунхлай шиг том компаниудыг бид дэмжиж явж чадвал олон, олон нөөц савууд барих юм байна лээ. Би өөрөө ч Рашаант дээр очиж үзсэн, тийм агуулах, нөөц савуудыг бариад 150 мянган метр куб ашиглалтад намар оруулж байна шүү дээ. Энэ чинь бодит ажил шүү дээ. Нэмэлт нэг минутаа авъя.

С.Бямбацогт: ЕС хариултаа дуусгая.

Н.Учрал: Тэгэхээр таны ч, миний ч, АН-ын ч, Ардын намын ч хамгийн том дайсан бол энэ үнийн өсөлт. Төсвийн тодотгол дээр бодитой өөрчлөлтийг хийж байгаа. ААНОАТ 700 гаруй тэрбум төгрөгөөр тасарчхаад байна. Энэ юунаас болоод байна гэхээр бензин шатахуунаас болоод энэ худалдаа, үйлчилгээний салбарууд ингээд саарсантай холбогдуулаад энэ 700 гаруй тэрбум төгрөгийг татвар дээр татварын орлого багасчхаад байгаа байхгүй юу. Үүнийг ТӨК-удын ногдол ашгийг нэмэгдүүлснээрээ шийдвэрлээд явъя гээд эх үүсвэр нь тодорхойгүй цалин нэмсэн зардлуудыг эх үүсвэрийг нь нэмээд явъя гээд тоотой, үндэслэлтэй, ард иргэддээ хандсан, иргэдээ бодсон төсвийн тодотголыг л өргөн мэдүүлсэн. Түүнээс улс төр гэдэг зүгээр л эсэргүүцэж байхын тулд эсэргүүцдэг юм байдаггүй юм Батчимэг эгчээ та анхаар.

С.Бямбацогт: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Тэр хойгуур битгий үймүүлээд байгаарай, энэ хурал явж байна шүү. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Ерөнхий сайд та ингээд өөрийнхөө суудал дээрээс эгч гэж яриад байх юм, би ерөөсөө ойлгохгүй байна. Би энд гишүүнийхээ хувиар асуудалд хандаж байна шүү. Та ингээд намайг асуулт асуухаар эргүүлээд миний яг асуучихсан асуулт дээр хариулт өгөхгүй, өөр тойроод өөр том компаниуд, энээ тэрээ юм яриад байх юм. Та жоохон ёс зүйтэй байсан нь дээр байх. Төсвийн тодотгол яг энэ багш, эмч нарын цалин өсөх бүрд энэ төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг ингээд өсгөөд байх юм уу цаашдаа? Яг энэ тодотголоор заавал энэ төрийн бүх үйлчилгээний албан хаагчдын цалинг ижилсгэж ингэж багш, эмч нарын цалинтай зэрэгцүүлж орж ирэх нь зөв байсан уу?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би ард түмэндээ ТӨК-удын ногдол ашгийг хүргэнэ. Цаашдаа ТӨК-удыг уул уурхайн компаниудыг бүр илүү ашигтай ажиллуулна. Санхүүгийн зах

зээлийг бүр их идэвхжүүлнэ. Тэгснээрээ би тэтгэврийг бүр их нэмэхийн төлөө л байна. Төрийн албан хаагчдаа би цомхон, чадварлаг, өндөр цалинтай болгохын төлөө байгаа цагтаа би зүтгэнэ, бүр их нэмнэ шүү харин. Уул уурхайн компаниудынхаа ашгийг нэмэгдүүлээд бүр л илүү их боломжийг олгохын төлөө би зүтгэнэ. Тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс, орлогыг нь нэмэгдүүлэхийн төлөө байна. Дээрээс нь хувийн хэвшил дэх орон зайг илүү их нээхийн төлөө ажиллуулна. Тийм учраас ирэх онд бараг 2.6 их наядын татварын ачааллыг бууруулж байгаа, олон, олон хувийн хэвшлийн татварын ачаа барааг багасгахын төлөө ажиллана.

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: 2024 онд сонгуулийн дараа намууд хамтарсан. Тэгээд ЗГ-ын мөрийн хөтөлбөрийг Тогтвортой хөгжлийн төлөөх зориг гээд энэ засагт хамтарсан намуудын мөрийн хөтөлбөрөөр ингээд хийгээд явсан. Тэгээд энэ мөрийн хөтөлбөр дотор ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх, багш, эмч, ажилчид, бусад соёл, цаг уур гээд энэ ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх гэдэг ийм мөрийн хөтөлбөр орсон. АН-ын гишүүд бид ард иргэдийнхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж тэдний орлогыг нэмэгдүүлэх тал дээр хамтарч ажиллаж, энэ төрлийн хууль, нийгмийн даатгалын хууль, бусад хуулиудыг, татварын реформын шинжтэй хуулиудыг дэмжиж ирсэн гэдгийг энэ ташрамд хэлье. Тэгэхээр иргэдийн орлого нэмэгдүүлэх, амьжиргаа, амьдралыг сайжруулах тал дээр хамтраад зүтгэж байгаа.

Төсвийн тодотголтой холбоотой энэ стратегийн нөөц бүрдүүлнэ гээд стратегийн нөөц дотор стратегийн хүнс байгаа. Мэдээж энэ дотор мах орж байгаа, улаан буудай орж байна. Энэ дээр би талархалтай хандаж байгаа нэг зүйл нь энэ ялангуяа манай энэ тариаланчид намрын намарт нэг ган гачиг тэгээд л 2 жилийн уринш гэж явж байгаад нэг жоохон юм хураагаад авдаг, тэгээд яг борлуулах болохоор борлуулалт дээрээ маш их хүндэрдэг. Тэгэхээр энэ 100 мянган тонны стратегийн нөөц улаан буудайнаас бүрдүүлнэ гэдэгт манай тариаланчид баяртай байгаа. Тэгэхээр энийгээ худалдаж авч энэ ажлаа зохион байгуулахдаа ил тод, жигд байдлаар аваарай гэдгийг хэлье. Хүнсний ногоон дээр нэлээн хүнд шүү. Энэ стратегийн хүнс биш, тэгээд өөрөө амархан муудаж гэмтдэг. Тэгээд ил тод ногоочдоос, ногоочид маань Монголд маш олуулаа, 30, 40 мянгуулаа, тэгээд хэдэн ... газраас өгсүүлээд хэдэн га хүртэл талбайтай улсууд байдаг. Тэгэхээр эндээс тариад ургуулчихсан жоохон юмаа нэг борлуулалтыг нь л боддог. Тэгэхээр энэ дээр их сайн ил тод, зөв менежмент ашиглаж, тэр агуулахад оруулаад санхүүжилтийг нь өгдөг байдлаар явуулаарай. Мэдээж үнийн хувьд төр авч байгаа гээд тийм хямд үнээр авахгүй байх тал дээр нь анхаараарай гэдгийг энэ ташрамд хэлчихье.

Төсөв дээр янз бүрийн хэмнэлтүүд гарч байгаа. Түрүүн Хосбаяр гишүүний үгэнд гарсан Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр 5 сарын 31-нээр гээд нэлээдгүй зүйлүүд амжаагүй, ингээд тендер зарлаад компаниуд нь янз бүрийн өргөдөл, гомдол гаргаж байгаад энэ хугацаа даваад явчихдаг. Энэ хэрээр нөгөө төсвийн бодлого хойшлоод явчихдаг. Тэгэхээр энэ дээр жишээ нь төвийн бүс дээр зүрх судасны тоног төхөөрөмж дээр 3.5 их наяд байж байгаад ингээд 5 сарын 31 болсон гээд ингээд амжаагүй. Тэгэхээр энийгээ бид ирэх Монголчуудын эрүүл мэнд, нас баралтын гол шалтгаан зүрх судасны өвчин байгаа учраас энэ зүйлээ ирэх жил дахиад оруулна гэж ингэж зорьж байгаа. Тэгэхээр энэ төсвийн зохицуулалтаар ер нь яг иймэрхүү байдлаар хэдэн төгрөгийн төсөв хэмнэгдсэн бэ? Бидний нөгөө 26 оны батлагдаж өгсөн төсөв дээрээс энэ асуултыг асууя.

Дээрээс нь, даргаа дэг үргэлжлүүлээд нэг минут авчихъя. Дээрээс нь түрүүн аудитын дүгнэлтэд гарч байна бид хэд энэ төсвийг яг ингээд ороод ирсэн тодотгол нэлээн яаруу орж ирсэн учраас бүрэн гүйцэт уншиж танилцаагүй байна. Хөрөнгө оруулалт талдаа нэлээн хасалтуудыг хийгээд, урсгал зардал талдаа нэлээн нэмэгдлүүд явчихсан гэж аудитын дүгнэлтэд гарч байна. Тэгэхээр би харж амжаагүй учраас, ялангуяа ЗТЯ-ныхнаас энэ хэдэн хөрөнгө оруулалтыг тодруулаад асуучихъя. Төв аймгийн Мөнгөнморьтын зам, Угтаал, Цээл, Заамарын зам, Батсүмбэрийн асрамжийн газар луу явж байгаа зам, Төв аймгийн Баянцогт сумын зам, Орхонтуул, Цээлийн замуудаас эд нараас энэ хөрөнгө оруулалт тавигдсан байгаа зүйлээс хасагдсан зам байгаа юу? Энийг нэг тодорхой хариулаад өгөөч. Дээрээс нь энэ Төв аймгийн Лүн сумын үерийн далангийн асуудал байгаа юу. Энэ хөрөнгө оруулалтын хасагдалт гэдэгт хасагдаагүй биз дээ. Энэ дээр тодорхой хариултыг салбарын яамныхнаас нь авахыг хүсэж байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараа нь Зам, тээврийн сайд.

Н.Учрал: Туваан гишүүний асуултад хариулъя. 5 сарын 31-нээр 252.5 тэрбум юм байна. Энэ сая та бүхэнд өгсөн танилцуулга дээр бичсэн байгаа нөгөө гэрээ байгуулагдаагүй хувь татагдсан байгаа 252.5 тэрбум юм байна. Гэрээ байгуулагдсан тохиолдолд ирэх жил тэр хөрөнгө оруулалтын ажлууд үргэлжлээд л явна гэсэн үг. Тийм. Тэгэхээр энэ шаардлагатай хөрөнгө оруулалтууд санхүүжих дүнг бол ирэх онд үргэлжлүүлээд явуулна. Энэ хөрөнгө оруулалтын зардлыг нь хэмнэлтийн 1.4 их наяд дотор ингээд багтаад явсан гэсэн үг.

Түрүүн та дурдсан энэ стратегийн нөөцүүдийг бүрдүүлэх чиглэлээр мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахаар 150 тэрбум төгрөг тавьж байгаа. Улаан буудайн нөөц бүрдүүлэхэд 100 мянган тонныг худалдан авахаар төсвийн тодотголд тусгасан. Энэ жил бол баланс их сайн гарч байгаа, энэ жил ургац их сайн авах ийм төлөвтэй байна. Би сая тариалангийн бүс нутгаар очиж ажилласан. Тэгэхээр 100 мянган тонныг тариаланчдын намрын ургацаас бид худалдан авалт хийнэ. Хүнсний ногоон дээр анх удаа худалдан авалт хийх гэж байна, 12 мянган тонн. Сая Идэрбат сайд уулзалтуудаа хийгээд, хувийн хэвшилтэйгээ энэ хүнс, ногоо худалдан авах, нөөц бүрдүүлэх чиглэлээр үнийг нь эцэслэн тохирсон. Тэгэхээр энэ удаа бид энэ жил анх удаа хүнсний ногоо нөөцлөх гэж байгаа. Энэ болгоныг хийхийн тулд эхлээд бид өмнө нь нөгөө И-баримт /E-barimt/ дээр Сангийн яамны санхүүгийн, нөгөө И-баримтынхантай хамтраад яг бүх процессыг цахимжуулах ажлыг хийж дуусгасан.

Өмнөх жил бол 5 мянган тонн л нөөцөлсөн байхгүй юу. Түүн дээр төсвөөс татаас өгөөгүй юм байна лээ. 5 мянган тонн нөөцлөхөд яасан бэ гэхээр яг нөөцөлсөн мах нь яг иргэддээ хүрсэн эсэхийг хянахад нөгөө И-баримтын яг бүртгэлжүүлснийг харвал энэ чинь бараг 2500 орчим тонн л гарч ирээд, бусад нь яг иргэдэд шууд хүрээгүй байсан. Тэгэхээр энэ удаа агуулахуудыг барьсан компаниуд дээр зээлийн шугам үүсгээд, хянаад явж байгаа. Иргэд очоод шууд махаа тэдэн килограмм, тэдэн тонн махаа ингээд өгье гэвэл шууд мөнгө нь төлөгдөөд, агуулах барьсан компаниуд дээр зээлийн шугам үүсээд явна. Тэгэхээр энэ нийтдээ 20 мянган тонн махны нөөц бүрдүүлэхэд тэр нь яг иргэддээ хүрэх ёстой, хүнсний ногоон дээр хянаад явж байна гэсэн үг. Тэгээд Туваан гишүүний асуултуудад Сангийн яам нэмж саяын хөрөнгө оруулалтаа нэмж хариулъя. Төрийн ажил мэддэг яг энэ дээр тухайлан асууж байгаа учраас Туваан сайдын асуусан.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Лүн сумын үерийн асуудалд нийтдээ Туваан гишүүнээ 4.7 тэрбумын өртөгтэй УИХ дээр нэмэгдсэн, гэрээ байгуулсан тул энэ хэмнэлтэд ороогүй. Түрүүн таны дурдсан замууд хэмнэлтэд ороогүй хасагдаагүй гэсэн үг. Бүгдээрээ үргэлжлэх хөрөнгө оруулалтуудаас үргэлжлээд явж байгаа. Төсвийн тодотголоор гэрээ байгуулсан, хэрэгжиж байгаа төслүүдээс санхүүжилтийг нь хасахгүй. Хуулиараа ийм заалттай зохицуулалттай учраас энэ дээр ямар нэгэн таналт, хасалт хийгдээгүй. Төв аймгийн Угтаалцайдам, тэр Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай зам дээр 22 онд эхэлсэн, 26 онд ашиглалтад орохоор гэрээний үлдэгдэл батлагдсан байгаа. Нийт өртөг нь наадах чинь 182 билүү тийм дүнтэй юм байна лээ. Тэгэхээр энэ ажлууд маань үргэлжлээд явж байгаа гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Энэ үнийн өсөлт, шатахууны үнэ, үнийн өсөлтөөс болоод энэ компаниудын зам дуусахад жоохон төвөгтэй болчихсон юм байна лээ. Батжаргал гишүүн бид хамт явж газар дээр нь очиж үзсэн. Зөвхөн энэ замууд ч биш ер нь Монгол Улсын хэмжээнд энэ юмны үнэ, шатах тослох материалын үнээс болоод энэ замын салбарт, бусад салбарт үнийн зөрүү нэлээн яригдах, тэгээд энэ асуудлаа төсөв дээр хэрхэн яаж шийдэх юм бэ төсвийн тодотголоор. Энийг манайхан хариулчхаарай. Туваан гишүүн нэмж асууя.

Ц.Туваан: Баярлалаа. Тэр хөрөнгө оруулалтууд хасагдаагүй юм байна. Стратегийн хүнс бүрдүүлэлт дээр, хүнсний ногооны нөөц бүрдүүлэлт дээр ХАА-н сайдаас та сая тодорхой ажлууд хийгдсэн гэж байна. Энэ талаараа нэг тодруулаад, нэмээд ямаршуу байдлаар хийх гэж байгаа юм бэ, тэр зоорь санхүүжүүлэх байдлаар л хийнэ гэж Ерөнхий сайдын үгнээс ойлголоо. Тэгэхээр энийг нэг хэлээд өгөөч?

Дээрээс нь тэр хүнсний ногоотой холбоотой асуудал дээр тэр манжингийн урамшуулал юу болсон бэ? Энэ нөгөө нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг яг зөв ингээд явж байсан юм нэг хэсэг хүмүүсийн тэр И-баримттай холбоотой нэг ийм зөрчилд ороод, жирийн манжингаа тариад, нийлүүлэлтээ хийгээд явж байгаа хүмүүсийн хүнсний ногооны хуулиар олгогдсон урамшууллаа авах эрх нь зөрчигдөөд явчхаж байгаа. Энэ дээр нэг та багцлаад хариулт өгөөч.

С.Бямбацогт: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Туваан гишүүний асуултад хариулъя. ЗГ-аас энэ газар тариалангийн салбар дээр хаврын тариалалтаас нь авхуулаад анхаарлаа хандуулж байгаа. Яагаад гэвэл 2026 он энэ газар тариалангийн салбарын нийт энэ салбарынханд их чухал он. 2025 он маш их ган болсон, үүнээс шалтгаалаад тариалангийн энэ салбарын ААН-үүд, хувь иргэд маш хүнд байдалд орсон санхүүгийн. Тэгээд хавраас авхуулаад энэ бензин тосны дэмжлэг, дээрээс нь санхүүгийн дэмжлэгүүд ингээд амжилттай хийгдсэний үр дүнд ингээд намрын тариа хураалт өнөөдөр баланс маш сайхан гарч байгаа. Ойрын хэдэн жил аваагүй ургацаа авахаар байгаа.

Нөгөө талдаа ЗГ-ыг та зөв анзаарсан байна. Хаврын тариалалт, намрын хураалт, ард нь орхигддог байсан энэ борлуулалт, зах зээлийн эргэлт рүү гол анхаарлаа хандуулж байгаа. Энэ 3 нийлж байж тариалангийн салбарт бодитой дэмжлэг болно гэж ингэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Хариултаа дуусгая.

Ц.Идэрбат: Улаан буудайг ХАА-н корпорац худалдаж авна, гурилын үйлдвэрүүд өөрсдөө санхүүжилтээрээ авна, дээрээс нь банкны хөнгөлөлттэй зээлүүдээр бид урамшуулна. Энэ анх удаа энэ хүнсний ногоон дээр нөөц бүрдүүлэх гэж байгаа, таны хэлж байгаа зөв, нөөцийг бид хаана хийх вэ гэхээр яг стандартад нийцсэн зоринуудад хийнэ. Төмсний зоорь өөр, сонгинын зоорь өөр, яг ийм байдлаар явна. Сонгон шалгаруулалтын хувьд бүгд ил байна, ХАА-н биржээр дамжаад, бирж хаана очиж ажиллах вэ гэхээр энэ газар тариалангийн бүс нутаг, хүнсний ногооны төв бүс нутгуудад ажиллана. Борнуур дээр, Жаргалант дээр гэх мэтчилнээр яг газар дээр нь очиж ингэж ажиллана. Маргаашаас энэ бүс нутгуудад яг тариалан эрхэлсэн, хүнсний ногоо тариалагчид дээр шатахуун очих гэж байгаа гэж ингэж ойлгож болно. Энэ мэтчилнээр ингээд дэмжээд ингээд ажиллана. Гол юм төмс зооринд байна уу, үгүй юу гэдэг л гол.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: 26 оны төсвийн тодотгол ер нь хөрөнгө оруулалтаа танаж, илүү ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ялангуяа энэ хүнсний хангамж, нөөцийг бүрдүүлж, энэ үнийг тогтворжуулах ийм зорилготой оруулж ирж байгаа нь сайшаалтай. Гэхдээ энэ төлөвлөгөө, тооцоо хоёр өөрөө яг мөргөх ёстой. Тэгэхээр би энэнтэй холбоотойгоор хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Монгол Улсын малын тоо 2025 оны байдлаар 58 сая гэдэг статистик тоо байдаг. Монгол Улсын хэмжээнд ХАА-гаас 20 сая орчим малыг бид заазлаад зах зээлд нийлүүлдэг. Тэгэхээр нийгэмд нэг ийм мал тооллогын талаар асар их хардлага байна. Тэгэхээр энэ дээр Үндэсний статистикийн газраас хариулаад өгөөрэй. Мал тооллого хийгээд очих гэхээр малчны яамнаас нэг тоо хэлэнгүүт нь бүртгэгчид, яг биетээр нь очоод тоолъё гэхээр хажуу айлынхаа малыг тоолоод нэг бүртгүүлчихдэг гэсэн нэг ийм хардлагууд хаа сайгүй яригддаг. Тэгэхээр энэ мал тооллогод бид бүрэн итгэж болох уу? Мах бэлтгэлийн энэ статистикт бид ер нь итгэж болох уу? Өнөөдөр УИХ төсвийн энэ тодотгол, энэ төлөвлөгөөтэй холбоотой бид тоон дээр суурилж шийдвэр гаргах гэж байгаа энэ цаг үед энэ тоон дээр бид итгэж болох уу гэдгийг 1 дүгээрт асууя.

Сүүлийн жилүүдэд махны экспорт /export/ өсөж байгаа, энэ талаар нэг талдаа мэдээж сайшаалтай. Тэгээд энэ статистик тоотой холбоотой юм асууя. 25 оны байдлаар ҮСХ-ны тайлангаар 57.5 мянган тонн махыг экспортолсон гэдэг тоо байгаа, ГЕГ-ын статистикаар болохоор 62.7 мянган тонн махыг экспорт хийсэн, яамны албан ёсны сайт дээр 85 мянган тонн мах экспорт хийсэн гэдэг мэдээлэл байна. Үндсэндээ ингээд нэг тоо байхгүй, 3 өөр тоо байдаг. Ингээд байгууллага хоорондын тоо бараг 1 сая бог малын ийм хэмжээний зөрүүтэй тоо байгаа юм. Тэгэхээр 20 мянган тонн махны зөрүү гэдэг чинь өөрөө маш их хэмжээний цаана нь орлого явж байгаа, мөнгө яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр яг аль тоог УИХ шийдвэр гаргахдаа ашиглах юм бэ? Аль нь эцсийн тоо гэж үзэх юм бэ? Энэ дээр ҮСХ, ГЕГ, яам яг хариулт өгөөрэй гэж хэлмээр байна.

Ер нь энэ махны экспортыг өсгөсөн нь өөрөө энэ махны үнийг нэмэгдүүлж байгаа нэг хүчин зүйл гэж харж байгаа. Мэдээж нэг талдаа малчдын өнөөгийн орлогыг бид нэмэгдүүлж байгаа ч гэсэн, нөгөө талдаа нийт ард иргэдийн бодит худалдан авах энэ чадварыг бид ерөөсөө нэмж чадаагүй, эсрэгээрээ дордуулсан бодлого байсан юм байна гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ махны үнэ 40 хувь гаруй өсчихлөө, ХАА-н сайдаас асууя. 2026-аас 2027 онд хүнсний махны үнийг ер нь бид хэрхэн зохицуулах юм бэ? Энэ өсөлтийг сааруулах ямар бодлогыг яам хэрэгжүүлж байгаа юм бэ? 2 дугаарт, 26-аас 27 оны энэ махны нийлүүлэлтийг хэдэн сая толгойгоор төлөвлөж байгаа вэ, энэ төлөвлөлтийн яг өөрөө гол үндэслэл нь юу вэ гэдгийг би яг бодитой тоо асууж байгаа шүү. Тэгээд хариулаад өгөөрэй. Хэдэн тонн махыг экспортолно гэж тооцож байгаа вэ? Би хариултаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Мандхай даргын асуултад хариулъя. Малын тоон дээр эргэлзээ байгаа юу гэвэл байгаа. Аль социализмын үед л 12 сар дүн өвлөөр, цаснаар малын тооллого явуулдаг. Энэ нь манайх шиг ийм газар нутагт зохимжгүй маш их зардал гардаг, үр дүн муутай байдаг нь нууц биш. Тийм ч учраас ЗГ-аас энэ мал тооллогын асуудал дээр уламжлалт энэ нэг аргаа өөрчлөөд, нийт малынхаа тоог үнэн зөв гаргадаг дээр Шадар сайдад тодорхой үүрэг өгсөн. Тэнд асуудлууд боловсруулагдаж байгаа гэж ингэж хэлье.

Мах бэлтгэлтэй холбоотой асуудал байна, ялангуяа энэ экспорт буурч байна, эсвэл экспортын тооны эх сурвалжууд зөрөөтэй байна гэсэн ийм зүйл ярьж байна. Үндсэндээ дотоодын махны бэлтгэлийн тоо төдийлөн үнэн зөв гарахгүй байх магадлалтай. Харин яг хилээр гарч байгаа килограмм мах болгон бүртгэгдэж байгаа учраас ХААЯ гаалийн мэдүүлэг дээр үндэслэн энэ тоогоо гаргадаг. Экспортын хувьд өнгөрсөн жил 82.5 мянган тонн мах гаргасан гэсэн ийм статистик тоотой. Энэ жилийн хувьд яг 2026 оны 7 сарын 17-ны өдрийн байдлаар 22.8 мянган тонн мах гаргасан ийм статистик үзүүлэлттэй байгаа гэдгийг хэлье.

Махны үнийн асуудал инфляцад маш өндөр хувиар яригдаж байгаа. Энд олон хүчин зүйлүүд нөлөөлж байгаа. Энэ жилийн хувьд энэ төсвийн тодотгол дээр 10 орчим тэрбум төгрөгийг нийслэлийн махны хангамж дээр тавьж байгаа. Аймгийн удирдлагууд тухайн орон нутагтаа махны үнээ зохицуулах зохицуулалтуудаа өөрсдөө хийх хуулийн үүрэгтэй. Энэ дагуу ажиллана. Махны үнийг өнөөдөр яг чуулганы энэ танхим дээрээс тэд эд байна гэж хэлж өгөх боломжгүй. Энэ боломжгүй юм та асууж байна. Нөгөө талдаа энэ махны нийлүүлэлтийг хөнгөлөлттэй зээл гарсан тэр зээлийн нэг төгрөг болгон мах болж чадаж байна уу, үгүй юү гэдэг дээр л хяналт тавих И-баримтын тогтолцоог л сайжруулж байгаа юм. Үүгээрээ бид 3 сарын 15-наас 6 сарын 15 хүртэлх энэ 3 сарын хугацаанд махны үнэд интервенц хийх бүрэн бололцоотой байгаа юм гэж үзээд, арилжааны банкнуудаас энэ ААН-үүд нь зээлээ аваад, үйл ажиллагаа руугаа мах, малаа худалдаж авах энэ зүйл рүүгээ эхлээд явж байгаа гэдгийг хэлье.

Ер нь ХАА-н салбар дээр манай малчдын тоо буурч байна, залуу малчдын халаа байхгүй боллоо гээд л ингээд маш их яригдаж байгаагийн гол шалтгаан хөдөө байсан тэр малчны орлого бодитойгоор нэмэгдэхгүй байгаатай л холбоотой байгаа юм. Орлого нэмэгдэх тусам олон.../минут дуусав/

С.Бямбацогт: ҮСХ асуултуудад хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Батдаваа: ҮСХ Батдаваа, гишүүний асуултад хариулъя. Мал тооллогын хувьд үндсэн асуулга, маягт, аргачлалыг бид ҮСХ-ноос батлаад, орон нутгийн Засаг даргын удирдлага доор аймаг болгон мал тооллогыг зохион байгуулдаг. Мал тооллогын ерөнхий хяналтыг хэлбэл бид орон нутаг дээр нийт тооллогын 10 хүртэлх хувь, ҮСХ-ноос тухайн жилээс хамаараад нэг 4-өөс 5 аймаг дээр хяналтыг хийдэг. Зөрүү 0.9 хувьтай гардаг. Мөн бид давхар толь статистикуудыг ашигладаг, жишээлбэл шүлхийн вакцинтай, мөн ноолуурын үйлдвэрлэлтэй харьцуулж энэ тоог баталгаажуулдаг. Статистикийн хувьд том үйлдвэрлэлийн зөрүү гаргах тийм зөрөө байхгүй. Махны экспортын тоо ганцхан эх үүсвэртэй энэ ГЕГ-ынх, зөрөө зөвхөн.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултыг дуусгая, 4 дүгээр микрофон.

Б.Батдаваа: Махны экспортын дүн дээр ХААЯ, ҮСХ, бусад бүх байгууллагуудын анхан шатны мэдээллийн эх үүсвэр ГЕГ-ын статистик байдаг. Таны түрүүний хэлдэг энэ тоонууд бид цэвэр жин яриад байна уу, каркасны жин яриад байна уу гэдэг зөрүүнүүд гол зөрүүг тайлбарлаж байгаа.

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Би түрүүн хэлсэн. Ер нь 22, 23 оны статистик ч тэр бид энэ ХАА-н салбараас нийт 20 сая орчим малыг зах зээлд нийлүүлдэг. Тэгэхээр энэ нь өөрөө малчид нийт малынхаа 36 хувийг хүнсэнд үндсэндээ бэлтгэдэг гэсэн үг. Тэгэхээр бид ер нь энэ махны нийлүүлэлтийн тоо, экспортын хэмжээ, бодлогыг гаргахын тулд энэ эрэлт, нийлүүлэлтийн суурь тоо, тооцоонуудыг бодитойгоор харж байж төлөвлөх ёстой. Энийг бодлогын яам зайлшгүй мэдэх ёстой юм байгаа юм, мэдэхгүй гэж хэлж болохгүй. Үнийг зохицуулалтыг нь гаргаж өгөх гол бодлогын яам бол ХААЯ. Тэгэхээр бид 26-аас 27 оны ХАА нийлүүлэх хэмжээг хэрвээ өндрөөр тооцож, энэ экспортод хүргэж чадна гэж бодож байгаа бол энэ биелэх боломжгүй тоо байгаад байгаа юм. Би нэмээд минутаа авчихъя.

С.Бямбацогт: Мандхай гишүүн асуултаа дуусгаж асууя.

М.Мандхай: Тэгэхээр бид ХАА-гаас гаралтай бүтээгдэхүүний экспортыг 715 сая долларт [USD] хүргэнэ гэдэг ийм өндөр амбицтай төлөвлөгөө тавьчихаад үндсэндээ хэдэн төгрөгөөр, хэчнээн малыг бид зах зээлд нийлүүлэх тоогоо тодорхой болгохгүй бол энэ ерөөсөө зүгээр л хийсвэр ийм төлөвлөгөө байна гэж би хэлэх гээд байгаа юм. Өнөөдөр энэ Улаанбаатар хотын сарын махны хэрэглээ 20-оос 30 мянган тонн байгаа. Тэгэхээр ингээд төлөвлөгөө дээр 20 мянган тонныг махны нөөцөд нийлүүлнэ гээд тавьчихсан байгаа. Тэгэхээр энэ чинь Улаанбаатар хотын сарын хэрэглээгээ хэдүүлээ нөөцөд авчихсан. Тэгэхээр махны үнийн өсөлт ер нь тогтворжих ямар ч тийм бодлогын төлөвлөгөө харагдахгүй байгаад байгаа юм. Тийм учраас би ингээд төлөвлөгөөг чинь эргүүлээд тоотой нь ингэж дүйцүүлж баталгаажуулж асуух гээд байгаа юм. Тэгж байж үндсэндээ бид энэ төсвийг батлахад, шийдвэр гаргахад ийм учиртай юм 1 дүгээрт. 2 дугаарт бид улсын дундаж инфляц 12 хувьд.../минут дуусав/

С.Бямбацогт: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: ХААЯ-ны хувьд малаас гарч байгаа түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах ганц махнаас бусад, ганц мах биш, ингэж байж бид энэ малтай байна, малчинтай байна, махтай байна, энэ тал дээрээ гол анхаарлаа хандуулна. Махны экспортын хувьд бид малын эрүүл мэндийн асуудал дээр онцгой анхаарлаа хандуулж байгаа. Энэ Биокомбинатын асуудал байна. Энэ вакцин [vaccine], шүлхийний асуудал байна. Энэ мал эмнэлгийн тогтолцооны асуудал байна, боловсон хүчний асуудал байна. Бид энэ малтай байх, махтай байх энэ гол хүчин зүйлүүдээ эхлээд хийх ёстой болчихоод байгаа юм. Тэрнээс малыг нь тоолоод, махыг нь хэмжээд, үнийг нь тогтооно гэдэг ийм юм байж болохгүй, ийм боломж ч байхгүй. Нөгөө талдаа нийслэлийн 2 сая хүнийг 12 сарын турш хямд үнээр махаар хангана гэдэг ийм боломж ч байхгүй. Яг өсдөг.../минут дуусав/

С.Бямбацогт: 25 онд нийслэл хот 10 мянган тонн мах бэлдээд борлохгүй, түүнээсээ болоод 26 онд бага бэлдээд махны үнэ өссөн, энэ жил 20 мянган тонн бэлдэх гээд байна шүү дээ. Мандхай гишүүн бол 20 мянган тонн чинь бага юм биш үү л гэж асуугаад байна л даа. Энэ дээр ямар тооцоо, судалгаа байна вэ гэсэн. Нөгөө зах зээл, экспорт, мөн махны нийлүүлэлт энэ бүгдээс хамаарч бодлого, төлөвлөлтөө зөв хийх ёстой л доо. Заримдаа болохоор махны нийлүүлэлт ихтэй, экспорт багатай үедээ их төл бэлдээд борлодоггүй, экспорт ихтэй махны үнэ өсөж байгаа үедээ бага бэлдээд өнгөрсөн жил махны үнэ өсчихлөө шүү дээ. Тэгэхээр ямархуу прогноз /prognosis/ байгаа, 20 мянга чинь яг ямар үндэслэлээр бэлдсэн юм бэ гэдгийг хариулаад өгөөч. Идэрбат сайд.

Ц.Идэрбат: Махны экспортын хувьд өнөөдөр 9 сарын 10-ны байдлаар 23 мянган тоннтой л бид байж байгаа. Тэгэхээр экспортын хувьд энэ ялангуяа Ойрх Дорнод руу гардаг тэр 20 гаруй мянган тонн мах 5 мянга болтлоо буучхаад байгаа. Нөгөө талдаа нийслэлийн махны асуудлыг бүхлээр нь ингэж 2 сая хүнийг жилийн турш хямд махаар хангана гэсэн тийм төлөвлөгөө байхгүй. Энэ төлөвлөж байгаа 15-аас 20 мянган тонн мах яг мах өсдөг тэр хаврын улиралд зорилтот бүлэг рүүгээ гаргаж байгаа л мах байгаа. Тэрнээс бүгдийг ингээд хангах гээд байгаа юм биш. Энэ зах зээлийнхээ зарчмаар ингээд л явна. ЗГ-ын хувьд экспортыг ямар нэгэн байдлаар хязгаарласан, хорьсон, хаасан ийм зүйлүүд байхгүй. Харин махны нэр хүндийг хадгалах, өсгөх энэ тал дээр яам арга хэмжээ аваад явна л гэж хэлье.

С.Бямбацогт: Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Оройн мэнд хүргэе. 2026 оны төсвийн тодотголын төслийг ерөнхий зургаар нь дэмжиж байгаа. Тэгээд энэ хэлэлцүүлгийн явцад илүү сайжрах байх гэж найдаж байгаа. Гэхдээ 3 асуулт байна. Заавал тодруулаад мэдээллийг хүргэе гэж бодож байна. 2026 оны төсвийн тодотголд татварын орлого буурч орж ирж байна. Орлогын албан татвар, Хөрөнгийн албан татварын орлого, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Онцгой албан татварын орлого гээд. Яагаад гэвэл ер нь түрүүний тайлбарууд ЗГ-аас, сайд нараас, Ерөнхий сайдаас өгч байгаа тайлбаруудад худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил сул байна, үүнтэй холбоотойгоор орлого буурсан байна. Энийг яаж засаж залруулах вэ гэдэг талаар тодотгол орж ирж байна. Тэгэхээр ер нь асуух гээд байгаа асуулт маань юунаас болоод худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил сул болсон гэж үзэж байна вэ? Ямар нэгэн бодлогын түвшинд өөрчлөлтүүдийг Их Хурлаас ч юм уу авах шаардлага байгаа юу? Ямар арга хэмжээнүүдийг яг энэ 26 оны төсвийн тодотголд авч суулгаж байна, 2027 онд хэрхэн үргэлжлүүлэхээр харж байна вэ? Ер нь яаж худалдаа, үйлчилгээний салбараа эргээд сэргээх вэ эхний асуулт.

2 дугаарт нь болохоор "Гэрт ойрхон сургууль хамгийн сайн сургууль" гэдэгтэй бүрэн санал нийлдэг. Тэгээд 2026 онд төсвийн тодотгол дээр 50 тэрбум төгрөгийг тавьж өгч байгаа юм байна. Тэгээд ер нь 2026 оны төгсгөл гэхэд энэ хөтөлбөрийн хүрээнд ямар үр дүнд хүрсэн байна вэ гэж харж байна. Цаашдаа яаж өргөжүүлнэ гэж төлөвлөж байгаа талаар хариулт авъя?

Сүүлд нь сая бүгдээрээ шатахууны хомсдолын асуудалд нэлээн орсон. Тэгээд цаашдаа ч гэсэн нэг хэсэг үргэлжлэх вий гэж санаа зовж байгаа. Геополитикийн том асуудал. Тэгэхээр 20 тэрбум төгрөг төсвийн тодотгол дээр нөгөө хямдралтай, хөнгөлөлттэй зээлээр агуулах бариулна гээд орсон хэвээрээ байна. Тэгэхээр одоо байгаа гүйцэтгэлийг нь салбарын яамнаас асуумаар байна. Хэчнээн метр куб сав баригдчихав, ямар, ямар компаниуд барив, эдгээр компаниуд маань хөнгөлөлттэй зээлээр барьж байгаа гэдгээ ер нь мэдэж байгаа болов уу? Цааш цаашдаа нөөцөө бүрдүүлэх дээр хамтарч ажиллах энэ баталгаа нь суугдаж байгаа байх гэж найдаж байна. Тэгэхээр салбарын яамнаас энэ мэдээллийг тодруулъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Уянга гишүүний асуултад хариулъя. Ер нь түрүүн би үгэндээ хэлсэн энэ татварын орлого буурсан. Тэгэхээр энэ худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил саарчхаад байна. Тэгэхээр энэ бол мэдээж энэ бодлогын хүүг Монголбанк мэдээж өсгөсөн, түүнтэй холбогдуулаад хэрэглээний зээл багассан. Тэгэхээр энэ худалдаа, үйлчилгээний салбар бол ингээд бас гадна нэлээн саарах ийм нөхцөл байдал, төлөвтэй байна. Энэ бол бензин шатахууны энэ хомсдолтой ч гэсэн шууд холбоотой. Тийм ч учраас бид цаашдаа түүний эсрэг арга хэмжээнүүдийг авах хэрэгцээтэй байгаа.

Тэгэхээр уул уурхайн салбарт бол мэдээж экспорт нэмэгдээд байгаа сайн мэдээ байгаа хэдий ч энэ үйлчилгээний салбарууд дээр татварын орлого буураад эхлэхээр цаашдаа үүнийг яаж нөхөх вэ гэдэг асуудлууд гарч байгаа. Ялангуяа 2027 оны 1 сарын 1-нээс тэр 2.6 их наядаар татварын хуультай холбогдуулаад хөнгөлөлт бий болоод эхлэхээр хувийн хэвшилд байгаа бизнесүүдийн нэг талаасаа бол идэвхжил нэмэгдэх, ажлын байр шинээр нэмэгдэх бололцоо үүсэх ийм 2 талын ач холбогдол байна гэж харж байна. Бензин шатахууны хомсдолтой холбогдуулаад 2 арга хэмжээ, урт болон дунд хугацааны аль аль бодлогоо зэрэг хэрэгжүүлээд явж байна. Мэдээж ОХУ-тай тэр тусгай хөнгөлөлттэй, тогтвортой гэрээгээ үргэлжлүүлээд явна. Мөн дунд хугацаандаа бид энэ газрын тосны үйлдвэрийг ашиглалтад оруулах чиглэлээр гол анхаарлаа тавиад, одоо гүйцэтгэлийнх нь санхүүжилтүүдийг нь Гадаад зээлийн ашиглалтын хуультай холбогдуулаад гаргаад явж байна. Ямар нэгэн гацаа, саад тотгор учруулахгүйгээр үүсээд байгаа асуудлуудыг Ерөнхий сайдын дэргэд аваад хяналтаа тавиад ингээд шахаад явж байна.

Урт хугацаандаа бол энэ түлшний хараат байдлыг бууруулах чиглэлээр энэ ногоон бодлогыг хэрэгжүүлж байгаа. Ирэх оны төсөв дээр энэ ногоон санхүүжилт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, энэ ногоон өртөөнүүдийг барьж байгуулах, цахилгаан машины хэрэглээг нэмэгдүүлэх бүх талын арга хэмжээг авч байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад энэ цахилгаан машин, ногоон өртөө, энэ ногоон дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр гааль, онцгой албан татварыг бүрэн чөлөөлсөн гээд арга хэмжээнүүдийг авч байгаа.

С.Бямбацогт: Тодруулах уу? Гэрт ойрхон сургууль, Боловсролын яамны ТНБД. Индрийн 4 дүгээр микрофон Ням-Очир дарга. Гэрт ойрхон сургууль.

Т.Ням-Очир: Боловсролын яамны ТНБД Ням-Очир. Уянга гишүүний асуултад хариулъя. Бид 3Г-аас ачаалал өндөртэй хотхон, хорооллуудад гэрт ойр бага сургуулийн бүлэг, ангиудыг зохион байгуулж байгаа. 2026 оны 9 сарын 1-ний байдлаар бид 21 байршилд 8600 хүүхдийг өнөөдөр яг хотхон, хороолол дотор нь яг тохижуулсан сургалтын зориулалттай анги бүлгүүдэд хичээллүүлэх энэ боломжийг олгож байгаа. Гэхдээ энийг бид зөвхөн 9 сарын 1 гээд зогсохгүй, цаашаа 10 сарын 1, 11 сарын 1-нд үргэлжлүүлэн зохион байгуулж, ерөнхийдөө 38 байршил дээр бид 20 орчим мянган хүүхдийг хамруулах боломжтой гэж тооцоо, судалгаагаа хийж үргэлжлүүлж байгаа.

Мөн дараагийн дугаарт дүүрэг бүрд төрөлжсөн ахлах сургуулиудыг байгуулах төлөвлөлтүүд үргэлжлээд явж байгаа. Өнөөдрийн байдлаар 3 төрөлжсөн ахлах сургууль 9 сарын 1-нд үйл ажиллагаагаа эхэлсэн, 2 мянган хүүхэд энэ сургуулиудад хамрагдсан, үргэлжлээд мөн ондоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Ондоо багтаад дүүрэг бүр дээр төрөлжсөн ахлах сургуулиуд байгуулагдаад явна. Мөн энэ зөвхөн нийслэлд биш 21 аймагт төрөлжсөн ахлах сургуулиудыг байгуулах төлөвлөгөө, тооцоонууд хийгдсэн. Энэ хичээлийн жил болон ирэх хичээлийн жилдээ 20 ахлах сургууль байгуулагдах ийм тооцоо, судалгаа хийсэн байгаа.

С.Бямбацогт: Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд үдшийн мэнд хүргэе. Яг нэг жилийн өмнө яг төсвийн үеэр ахмадууд талбай дээр гарч ирж байсан тэтгэвэр нэм гэж. Тэгээд энэ ордны баруун хаалган дээр би яг ахмадуудтай гарч уулзаад, миний мөрөөдлөөр болдог бол 1.2-оос 1.5 сая төгрөг болгох боломж, нөөц байна. Энэ Төрийн банк гээд хэдэн сэтгэлгүй шахааны удирдлагуудтай ийм төрийн өмчит ААН-үүдээс бид ингээд шахаж шаардаад явбал боломж нь байна гэдгийг хэлж байсан юм. Сангийн сайд тухайн үед байсан хүмүүс энэ дотор сууж байна. Бид байгаад ч ямар ч боломж байхгүй үнэнийг нь хэлье л гээд байсан юм. Одоо боломж нь гараад ирчихсэн нэмж байна. Тухайн үеийн Нийгмийн халамжийн сайд байсан Аубакир сайд бас л үнэнээ хэлье, бирд байгаад чадахгүй л гээд байсан, одоо чадаад байна шүү дээ.

Ерөнхий сайд, энэ Н.Учрал Ерөнхий сайдыг бол ард түмнээсээ юуг нь харамлаад байгаа юм, боломжийг нь гаргаж ирээд өгье гэж байгаад нь дэмжиж байна. Тэгээд юм л бол бид нэг гарц байхгүйгээр улс төржиж огцруулдаг гэдэг биш, яг жилийн өмнө гарцыг нь гаргаж ирээд хэлж байсан үгийг одоо та хийж байгаа нь сайн байна. Тэрийг хэлчихье, дахиад нөөц байна. Цагаан намын, улаан байрны хулгайчдынхаа хулгайг илрүүлээд, Алтангэрэл гишүүний хууль бус хөрөнгийг хураах хуулийн төслийг оруулж ирээд хэлэлцээд баталчихвал дахиад нөөц байна. Энэ чиглэл рүү ажиллавал сайн байна.

Тэгээд энэ юу байна, 2020 онд 2.6 их наяд төгрөгийн цалингийн зардал өгч байсан Монгол Улс, 2026 онд төсвийн тодотголын өмнөх дүнгээрээ 6.9, одоо тодотголын дараах дүнгээрээ бол 7.7 их наяд төгрөг төрийн албан хаагчдад цалин гэж өгч байна. Гэтэл өнөөдөр төрийн албан хаагч үнэхээр сайхан, хангалттай

хэмжээний цалин авч байгаа нэг ч хүн алга буюу байгаа онохгүй байна. Та УИХ-ын дарга болоод сууж байхдаа хэлж байсан, 9 хувиар цомхотгол хийнэ, тэгээд би тантай цуг Баянхонгор аймаг, Өвөрхангай аймаг, Архангай аймагт очиж ажиллаж байхад байгаа онохгүй байна гэдгийг яг энэ тойргийн гишүүд, иргэд нь та бид хоёрын нүдэн дээр хэлж байсан. Тэгэхээр энэ ажлаа эхлүүлмээр байна. Шал дэмий ингээд л 200, 300 мянган төрийн албан хаагч хувийн хэвшлийнхэнтэй булаацалдаж авчирч төр тэжээхийнхээ оронд энэ хувийн хэвшилдээ тэр ажиллах боломжийг нь гаргаж өгөөд л, урсгал зардлуудаа яг шаардлагатай төрийн албан хаагчид руугаа чиглүүлээд, тэгээд авъя гэсэн цалинг нь өгөөд ажиллуулах юм бол төрийн бүтээмж ч сайжирна. Ямар ч бүтээмжгүйгээр байгаа онохгүй, зүгээр элсэн дээр нь нөгөө ус цацаж байгаа юм шиг л ажил хийгээд байна гэдгийг анхаараад ажиллаасай гэж бодох гэсэн юм.

Тэгээд энэ танай Сангийн сайд Мэндсайхан сайд, энэ Аубакир сайд хоёр хэзээ таны араас юу гэж ярих юм, энэ сайд нарын амнаас гарч байгаа үг хариуцлагатай баймаар байна. Бирд байгаад боломжгүй гэж байсан үг өнөөдөр боломжтой болчихсон, хэдэн төрийн өмчит ААН-үүдээ дарамталж байгаад ногдол ашгаас нь тэтгэвэр нэмнэ, цалин нэмнэ гээд сууж байна. Энэ боломж дахиад хулгайчдын чинь хөрөнгөд нуугдчихсан байгаа гэдгийг давхар хэлэх гэсэн юм. Энэ дээр Ерөнхий сайд нэг саналаа хэлээрэй гэж бодож байна.

Тэгээд энэ Дэлгэрсайхан сайд сая хэлээд байна, гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй гээд, хэрэгтэй үнэн, бүгд мэдэж байгаа, манай Баянхонгор аймгийн говийн малчид хүртэл мэдэж байна. Гэхдээ говийн байгаль нөхөн сэргээгдэхгүй гэдгийг та ойлгож байгаа байлгүй дээ. Өөрөө та чинь Дорноговиос гарсан Их Хурлын гишүүн шүү дээ. Тэгээд тэнд байгалиа хамгаалъя л гээд байгаа юм. 1 сая 900 мянган квадрат километр газар нутаг дээрээ эзэн байхын тулд малчид говьдоо малаа маллаж л амьдарна. Хангайд очиж амьдарч чадахгүй, эсхүл Улаанбаатарт ирж чадахгүй, говийн хөрс эмзэг, нэг эвдэгдчихвэл нөхөн сэргээгдэхгүй. Энийг зөв талаас нь хараач тэр Алтаргана гэдэг компани, тэр Сэкер ресурс ХХК гэдэг компаниуд төрийн дээр, та нарын дээр гарч суучхаад замгүйгээр хүнд даацын тийм даацын авто зам хийчхээд нүүрс зөөнө гэсэн, одоо болтол байхгүй ганц нэг кольцо хийсэн тэрэн дээрээ нүүрс зөөнө гээд тэнчээ хэрүүл, зодоон болоод явж байна. Дахиад дээрээс нь хятадууд ажил хийнэ гээд ирчихсэн хөрсөн дээрээс дуртай ургамлаа ухаж аваад сууж байна. Энд тэр малчин.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт нэг минут, асуултаа дуусгая.

Да.Цогтбаатар: Энд тэнчээ байгаа малчид эсэргүүцээд байгаа юм. Тэгээд энэ хоёрын алтан балансыг нь олоод, яг та нар гэрээ байгуулсан бол гэрээнийхээ дагуу ажилла гэдэг шаардлагыг нь тавихгүй бол тэнчээ гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй гээд нэг хэдэн нөхдүүд та нарын толгой дээр гарах гээд байна гэдгийг хэлэх гэсэн юм. Тэгээд хэдхэн хоногийн өмнө КОП гээд л цөлжилтийн эсрэг гээд л ёстой нээрээ чухам Монгол Улс ёстой алж байна, шулж байна, байгалиа хамгаалж байна гээд байсан бодит байдал дээрээ малчид л хамгаалж байна шүү дээ. Энэ рүү анхаармаар байна. Тэгээд Дэлгэрсайхан сайдад хандаад хэлэхэд дахиад Баянхонгор аймгийн тээвэрчин хоршооны жолоочид хандаад байна. Энэ Драгон бүр учраа олдохоо байлаа, бараг л хүн амины хэрэг гарах нь. Ямар ч эмх замбараагүй, зам харгуйгүй тэнчээ ерөөсөө ширэнгийн хуулиар асуудлууд шийдэгдэж байна энэ дээр нэг анхаарлаа хандуулаач гэж байна. Энэ дээр нэг анхаарлаа хандуулаад, тэгээд тэр говь, Баянхонгорын Баян-Өндөр, Шинэжинст холбоотой асуудал дээр та

бүр болдог бол надад албан бичгээр хариу өгчихмөөр байна. Тэгээд гэрээтэй, албан бичигтээ тулгаад иргэддээ үнэнээ хэлмээр байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя, дараа нь Дэлгэрсайхан сайд.

Н.Учрал: Цогтбаатар гишүүнд баярлалаа. ТӨК-удынхаа ногдол ашгийг нэмэгдүүлэхийн тулд бид нэг зүйлийг хийх ёстой юм байна лээ. ТӨК-уд дээр улс төрийн нөлөөлөл байхгүйгээр чөлөөтэй, хараат бусаар ажиллуулах бололцоог хангуулах ёстой, та нар ажлаа сайн хий, ногдол ашгаа л өг, та нарын үйл ажиллагаанд бид оролцохгүй. Үүн дээр харин улс төрчид хамт байх ёстой юм байна лээ. Тэгж чадаад араас нь ногдол ашгаа шахаад ирэх жил 3.5 их наядын ногдол ашиг та нар өгнө шүү, бусдаар бид та нарын үйл ажиллагаанд оролцохгүй гэдэг байдлаар хандах ёстой. Тэрнээс биш тэгээд үйл ажиллагааг удирдаж чадахгүй хэрэгтэй, хэрэггүй баахан томилгоо хийхчээд араас нь шахалт үзүүлнэ гэвэл худлаа. Тэгэхээр тэр ТӨК-удын ногдол ашгийг ирэх жил 3.5-ыг өг гээд. Тэгээд тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс, ахуй амьдралыг нь дээшлүүлэхийн төлөө байа л даа.

Дээрээс нь ЗГ бол тэр хөрөнгө хураах хуультай холбогдуулаад Хууль зүйн яам дээр ажлын хэсэг байгуулагдаад ажилласан. Би ирэх 7 хоногийн 3 дахид ЗГ дээр Амарсайхан сайдыг энэ хуулиа оруулж ир гэсэн, тэгээд хуулиа өргөн мэдүүлнэ гэсэн. Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байгаа.

Төрийн албан хаагчид дээр ер нь ингээд улс төрчид бид бүгдээрээ ер нь энэ төрийн албан хаагчдынхаа нурууг хэтэрхий их авлаа шүү. Яг үнэндээ 210 гаруй мянган төрийн албан хаагчид чинь бараг 150 гаруй мянга нь л энэ төрийн үйлчилгээ шүү дээ. Боловсрол, эрүүл мэнд, тэр сургууль, соёлд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид байгаа байхгүй юу. Яг энэ бараг 45 мянга орчим нь хил, цагдаа, онцгой гээд төрийн тусгай албан хаагчид байгаа. Бусад нь тэр 22 мянга гаруй нь нөгөө газрын харилцаа, зам, ЗДТГ, яам, агентлаг, татвар, улсын бүртгэл гээд ерөөсөө л 20 гаруй мянган л албан хаагч байгаа. Төрд байгаа чадварлаг албан хаагчдыгаа бид нэг тийм хамгаалах сэтгэл зүй рүү очихгүй бол бүгд л хулгайч, дээрэмчин юм шиг ингэсээр байгаад төрд чинь хүн үлдэхгүй нь байна шүү. Төрийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, хангамж, баталгааг бид илүү их баталгаажуулахын төлөө хамт байх ёстой. Энэ Занданшатар даргын үед харин тэр янз бүрийн үндэсний хороо, зөвлөл ямар, ямар юм ч билээ тэд нарыг татан буулгаад, ингээд харин нэг хэмнэлт хийсэн тэр сайн хэрэг. Одоо байгаа цөөн төрийн албан хаагчдаа хамгаалаад цомхон, чадварлаг болгохын төлөө бид хамт байх ёстой. Тийм ч учраас сая ЗГ.../минут дуусав/

С.Бямбацогт: ЕС гүйцээгээд хариулъя, нэг минут.

Н.Учрал: Тодотголыг оруулж ирэхдээ бид ерөөсөө энэ төрийн албан хаагчдынхаа баталгааг нь хангуулах, боловсрол, эрүүл мэндийн салбарынхны цалин хөлсийг яг шударгаар нэмэх зарчим руу илүү хандуулсан. Ингээд ТӨК-удыг ч гэсэн нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах ажил засаг дээр явагдсан. "Эрдэнэс Монгол" нэгдэл ч гэсэн Чингис хаан баялгийн сан гээд нөгөө хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх чиглэл рүү ажилладаг болсон. Тэгээд олон улсын менежмент орж ирсэн, зөв зам руугаа явж байгаа, зөв зам руугаа. Ингээд бүгдээрээ зөв зам руугаа явъя, байгаа төрийн албан хаагчдаа хамгаалъя, дэмжье, улс төрийн нүдээ энэ ТӨК-аас ч холдуулъя. Тэгээд ингээд зөв зам руугаа хамтдаа явъя.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь та нэг биш удаа энэ Шинэжинст Баянхонгорын Шинэжинстийн замын тухай ярьж байгаа. Таны хэлж байгаатай би санал нэг байна. Говийн байгаль, хөрс эмзэг. Тэгээд бид энэ Алтаргана, энэ Сэкер ресорсус гээд компаниудын газар дээр нь ажлын хэсэг томилоод, яг малчидтай уулзаад өнөөдөр яг та таны хэлж байгаа яг ингээд баталгаажвал энэ замыг зогсооно, тээвэр хийх асуудлыг зогсооно, тэгээд энэ компаниудыг замаа тавиад, тээврээ хий гэдэг ийм шаардлага тавина. Тэгээд би танд бичгээр албан ёсоор хариу өгье гэж ойллоо. Драгон төв дээр анхаарал хандуул гэж би тантай санал нэг байна.

С.Бямбацогт: Тодруулж асууя, Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Ерөнхий сайд бид 2 энд нэгнийгээ магтаж цаасан малгай өмсүүлээд ч яах вэ. Ер нь бол ТӨК-уд дээр нээлттэй сонгон шалгаруулалт л хэрэгтэй байгаа юм. Чадварлаг залуучуудыг урьж авчирмаар байгаа юм. Тэрнээс Монголбанкны та нар долоосоор байгаад л томилоод явуулчихсан Тэргүүн дэд ерөнхийлөгч шиг энэ нэг үр удам дамждаг энэ нэг муйхар системээсээ салмаар байна. Ингээд ийм муйхар системээр яваад байхаар чинь Монголын төр лүү хэн ямар чадварлаг залуучууд орж ирэх юм. Орж ирэх боломжгүй байгаа. Одоо байгаа ТӨК-удынх нь удирдлагуудыг та нар яг бодит байдал дээр очоод хар, манай намын нэг ч томилгоо байхгүй. Бүгдээрээ танай намын сэтгэлгүй, шахааны энэ нэг цаг аргацаасан, хамгийн өндөр цалинг авдаг нэг ийм л бүлэг этгээдүүд сууж байгаа байхгүй юу урт гартнууд. Тэгээд энийг цэгцэлчих юм бол бидэнд дахиад боломж байна. Би нөгөө цагаан байр гэж ярихаа больё, зарчимлаг байя. Тэгэхээр энэ дээр аль болох нээлттэй байх л хэрэгтэй байна. Хэдхэн хоногийн өмнө энэчээнээс чуулганы индэр дээрээс.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Цогтбаатар гишүүнээ манайх ч байгаа, танайх ч байгаа. Хоёулаа худлаа яриад яах вэ, тэр дотор танай бүтээмжийн менежерүүд ч байгаа, манай менежерүүд ч байгаа. Тэгэхдээ нэг аюултай юм нь юу вэ гэхээр Франклин Темплтон [Franklin Templeton] саналаа боловсруулж байгаа, 3 дахид тэр Блэкрот [BlackRock] ирнэ, 1 сарын 1-нээс хууль хэрэгжинэ бүгд сонгон шалгаруулалтаар явна. Тэгээд их өөр болно шүү, шалгуур их өндөр болно. Тэгэхээр одоо бүгдээрээ засаглалыг нь бие даалгаад, тэгээд та нар ногдол ашгаа өгөөрэй гэдэг зүйлээ хэлээд л бие даагаад үйл ажиллагаа явуулах бололцоогоор нь хангуулаад л явахад ТӨК-уд дээр илүү боломж байгаа. Тэгээд энэ нь энэ төсвийн тодотгол болоод ирэх оны төсөв дээр тэр ногдол ашгийг шахаж байгаагаас ч харагдаж л байгаа юм.

С.Бямбацогт: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Бадарчийн Хэрлэн гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би яг энэ бидэнд тарааж өгсөн энэ материалын энэ Хавсралт 16, Хавсралт 17 гээд эдгээр хавсралтаас тодруулъя. Яагаад эдгээрийг тодруулж байгаа гэвэл бид таналт хийгээд байгаа, хэмнэлт хийж байгаа гэж байгаа боловч зарим зардлууд өсөж орж ирсэн. Эдгээр зардлууд их анхаарал татаж байгаа. Тийм учраас тодруулж байгаа. Энэ Хавсралт 17 дээр өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс 8.9 тэрбумаар батлагдсан төсөв дээр 0 байсан, уран бүтээл

хийлгэх тэг байсан, орж ирэхдээ 288.6 сая, эрдэм шинжилгээ, судалгааны ажил 946 сая, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хэсэг 377 сая, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал 2.4 тэрбум. Үүнээс гадна энэ хүнс, хөдөө аж ахуй дээр малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4.7 тэрбум, дахиад малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 9.3 тэрбум, малыг архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх нь 4 тэрбум, мал амьтныг эрүүлжүүлэх нь 3.6 тэрбум. Ингээд хоорондоо юугаараа ялгаатай байна мэдэгдэхгүй, маш олон юм давхардсан.

Тэгээд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал 5.8 тэрбум, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөрүүд 8.5 тэрбум, боловсролын салбар дээр "Шинэ эрин" олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит сургуульд 1 тэрбум төгрөг нэмж, "Шинэ эхлэл" олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит сургуульд 975 сая төгрөг нэмж, "Монгол тэмүүлэл" олон улсын хөтөлбөртэй сургалттай төрийн өмчийн сургуульд нэмж 985 сая, өөрөөр хэлбэл гуравхан олон улсын хөтөлбөртэй гэх улсын сургуульд нийтдээ 3 тэрбум төгрөг нэмчхэж байна. Гэтэл өнөөдөр бидний хүүхдүүд, 1 дүгээр ангийн хүүхдүүд сурах бичгээ аваагүй байна. Нэг ангид 20 сурах бичих тарааж байна, 2 хүүхэд дундаа, 3 хүүхэд дундаа сурах бичигтэй явж байна гээд энэ олон улсын сургалт хөтөлбөртэй сургуулиудынх нь зардал нь нэмэгдээд байдаг. Ерөөсөө гуравхан сургуулийн зардал 3 тэрбум төгрөгөөр нэмэгдээд явж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрынх 69.1 тэрбум, Хархорин хотын зөвлөлийн ажлын алба 1.5 тэрбумаар дахиад төсөв нь нэмэгдэж байна. Ерөнхийлөгч нарын спортын цогцолбор 3 тэрбум 26 оны батлагдсан төсөв дээр огт байгаагүй. Ингээд ийм зардлууд нэмэгдэж орж ирээд байгаа дээр тайлбар өгөөч гэсэн ийм хүсэлтэй байна.

С.Бямбацогт: Сангийн сайд эхлээд тайлбар өгье Идэрбат сайд.

Ц.Идэрбат: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Малын гоц халдварт өвчний зардал нэмэгдэж байгаа асуудал байгаа, энэ бодитой нэмэгдэхээс ч өөр аргагүй л нөхцөл байдалд орчхоод байна. Задаргааг нь бүр тодруулж ярих юм бол малын шүлхий өвчний асуудал байгаа, шүлхий өвчин 7 хэвшил байдаг. Урьд нь Монгол Улсад хэвшил А гараад дарагдсан, сүүлийн энэ хэдэн жил тасралтгүй гараад байгаанууд нь дан О хэвшлийнх байлаа. Ингээд 5 сарын 20-ноос хойш Монгол Улсад энэ эргэн тойрон гараад байгаа Сат 1 хэвшил орж ирсэн. Үүнтэй уялдуулаад вакцины зөвхөн О хэвшлийн вакцин авч тарьдаг байсан бол О, Сат 1 гэсэн 2 хэвшлийг нэгтгэсэн вакцин тарих шаардлага үүссэн. Үнийн хувьд бараг нэг дахин илүү үнэтэй ийм л нөхцөл байдал үүсээд байгаа. Тэгэхээр энэ хоёрын аль нэгийг нь тариад үр дүнгүй. Тийм учраас О, Сат 1 хэвшлийг тарихаас өөр аргагүй байдалд орж байгаа юм.

Тийм учраас энэ тарилгын тоо нь хэвээрээ байгаа хэр нь зардал нь өсөж байгаа гэж ингэж ойлгож болно. Тийм учраас нөгөө энэ зардал нэмэгдсэн, цаашдаа ч ер нь бид дотооддоо энэ вакцин савлах энэ Биокомбинатын үйлдвэрлэлийг 2027 оны төсөв дээр дэмжих төсөв тавигдаад явж байгаа. Ийм байдлаар бид ингээд дотоод асуудлаа шийдэхгүй бол бүгдийг ингэж худалдаж аваад ингээд явна гэдэг зардлыг бүр даблдаж [double] өсгөөд байгаа ийм хүндрэлтэй байдалд ороод байгаа гэдгийг тодруулж хэлье.

С.Бямбацогт: Сангийн сайд сая бусад зардлууд яагаад нэмэгдсэн бэ гэдэг дээр хариулт өгье.

3.Мэндсайхан: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Саяын зардлууд өссөн гэдэг чинь энэ тодотголоор бид төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингаа боловсрол, эрүүл мэндийн салбартайгаа тэгшитгээд оруулаад ирж байгаа шүү дээ, 50 хувь өсгөөд тэр зардлууд чинь цалингийн урсгал дээр нэмэгдээд явж байгаа. Түүнээс биш хөрөнгө оруулалт болон элдэв хурал, зөвлөгөөний зардал нэмэгдэж байгаа, хөрөнгийн зардал нэмэгдэж байгаа асуудал байхгүй. Олон улсын хөтөлбөртэй 3 сургуулийн чинь багш нарын цалин илүү өндөр байгаа. Тэр яг цалингийн өсөлтөөрөө л бүгд урсгал зардал дээрээ нэмэгдэж орж ирж байгаа.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Энэ өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс 8.9 тэрбум. Өөрөөр хэлбэл энэ дээр мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн задаргаа гээд цалин биш, бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал гэж нэмэгдэж орж ирээд байгаа байхгүй юу. Тийм учраас тодруулаад байгаа гэсэн үг. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх гээд л дахиад нэмэгдээд. Ардчилсан засаглалын судалгаа 22 сая, хэрэглээний үнийн судалгаа 56.7 сая, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгаа 373 сая гээд бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний хөлс, төлбөрийн задаргаа гэдэг энэ задаргаанууд чинь нэмэгдэж орж ирээд байгаа гэсэн үг. Тэгээд кино үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааны зардал дахиад 1 тэрбум, Хархорин хотын зардал дахиад өсөөд ороод ирсэн ч гэдэг юм уу ингээд эдгээр зардлыг тодруулж асуугаад байна л даа. Тэгээд би нэг бүрчлэн энэ дээр тэмдэглэхчсэн байгаа учраас Байнгын хороогоор хэлэлцэх дээр энэ дээр Байнгын хороон дээр бэлтгэлтэй орж ирээрэй гэж хүсье. 16, 17 дугаар хавсралт.

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя.

3.Мэндсайхан: Сая гишүүний ярьсан салбаруудын бусад зарлагын өсөлт 26 оны төсөв батлагдсаны дараагаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналуудын дагуу төсөвт зохицуулалт хийх замаар эдийн засгийн ангиллын хооронд нь зохицуулсантай холбоотой зардлууд байгаа. Гол юу чинь болохоор нөгөө КОП-17 хурлын урлаг, соёлын арга хэмжээний зардлыг хэрэгжүүлэх байгууллагууд руу нь шилжүүлээд уран бүтээл хийлгэх гэсэн тохирох ангилал руу нь төлөвлөсөнтэй холбоотойгоор ингэж гараад байгаа юм. Бид нөгөө КОП-ын зардлыг чинь төсөв дээрээ бүхлээрээ 200 тэрбумаар тавьчихсан шүү дээ. Тэгээд одоо энийгээ бид сая хэрэгжүүлэхдээ төсвийн ерөнхийлөн захирагч нар руу нь зардлынх нь ангиллыг нь тохируулж тавьсантай холбоотойгоор гарч ирсэн зардал. Зардал хооронд нь шилжүүлэх, түүнээс биш зардал өсөж байгаа асуудал огт байхгүй. Өсөж байгаа зардал зөвхөн төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмсэн дүнгээр л өснө.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Тодотголын төсөл өргөн баригдсанаас харахад дэмжиж болох боломжтой зүйлүүдийг нь дэмжээд байгаа огт хов хоосон тийм сөрөг зүйлийг хэлэхгүй байгаа. Тийм болохоор дэмжиж хэлсэн зүйлийг минь надад буцааж битгий яриарай гэж сануулж хэлмээр байгаа юм. Хэдэн төгрөг хаанаас, хаашаа явж байна вэ гэдэг л энэ төсвийн тодотголын гол асуудал шүү дээ. Тэр 3 асуудлууд байгаад байгаа юм. Бид цалин, тэтгэвэр нэмэхийг дэмжиж байгаа, үүн дээр дэмжиж байгаа гэдгийг илэрхийлж байна. Зарлаад байгаа тэр хэмнэлтийн 1.44 их наядын 1/3 нь л

жинхэнэ таналт, жинхэнэ хэмнэлт байна лээ шүү дээ. Зээллэгийн дээд хэмжээ нь 2 их наяд 190 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаагаа орлуулах заалт дотор оруулчихсан, хөрөнгө оруулалт нь цөөрөөд, урсгал зардал нь өсөөд байгаа юм. Төсвийн бүтцийн чанар нь муудаж байна гэж харагдаад байгаа юм.

Тэгээд нөгөө тогтмол ордог орлогыг нэг удаагийн буюу ногдол ашгаар шилжүүлж байвал энэ чинь дараа дараагийнхаа жилдээ хүндрэлүүд нь учрахгүй юм уу? Ахмад настны суурь тэтгэвэр, тэр боловсрол, эрүүл мэнд гээд шатахууны нөөц, эрчим хүчний өсөлтөөс иргэдийг хамгаалах энэ зүйлүүдийг дэмжиж байгаа гэдгээ эхлээд хэлчихье. Тэгээд энэ орлогын бүтэц нэг удаагийн эх үүсвэр лүү шилжиж байна гэдэг чинь дараа дараачийнхаа зүйлүүд дээр яаж болох юм бэ гэж. Ногдол ашгийг болохоор 1 их наяд 65 тэрбум гэж байгаа юм. Ямар компаниудаас, ямар санхүүгийн тайланд үндэслэж, ямар хугацаанд төвлөрөх юм бэ гэдгийг гаргаж ирсэн зүйл байгаа юм уу? Төсөөллөө хийгдсэн юм уу?

Нүүрсний тэнцвэржүүлсэн үнээ 133.7 ам.доллар, зэсээ 8341 гээд тавьчихсан. Энэ таамаглал хэрвээ биелэгдэхгүй тохиолдолд нөгөө бусад хувилбараар нь бодсон бодолт нь байгаа юу? Улсын болон орон нутгийн алдагдлын өсөлтийг тусад нь задалж үзүүлэх, энийгээ Байнгын хороонд орж ирэхэд үзүүлж чадах уу? 998 тэрбумынхаа зарцуулах эрхийг аймаг, нийслэл, төсөл хөтөлбөр болгоноор нь задалсан жагсаалт нь байгаа юу? Өмнөговь ч гэдэг юм уу буураад, Дундговь, Ховдынх нь 38, 15 дахин нэмэгдэж байгаа төсөв байж байгаа. Эд нар маань яаж, ямар зүйлээр, яаж нэмэгдэж байгаа юм бэ? Тэгээд зарим нэг дугаарлалтын алдаа зүйлүүд байх шиг байна лээ тэр 11 дүгээр зүйл дээр 2 их наяд 600, тэр чинь 367 нь болохоор тэр 9 дүгээр зүйл рүүгээ орох байх тэрийгээ өөрсдөө харна биз дээ.

Тэгээд энэ бид энэ төсвийг тодотгохдоо түрүүн төсвийн хүрээ ярьж байх үед бүгдээрээ Занданшатар Ерөнхий сайдтай, Жавхлан Сангийн сайдтай ЗГ ер нь их муу сайд нар байсан гээд дүгнэчихсэн шүү дээ. Ялангуяа Ардын намынхан өөрсдөө тэгж дүгнэсэн. Энэ чуулганы танхимд нэлээн хэд хэлэгдчихсэн, хариулахдаа ч тэгж хариулсан. Яг нэр зааж хэлээгүй боловч маш буруу төсөв, 2026 оны төсвийг батлуулсан, одоо засвар хийж байна, алдаагаа засаж байна гээд. Тэгэхээр бид энэ төсвийн тодотголыг жилд, зарим жилд 2, зарим жилд ингээд тогтмол хийж байна. Төсвөө тодотгохдоо хуульдаа өөрчлөлт оруулаад эхэлж байна. Энийгээ ер нь яаж өөрчлөх юм бэ, тэр талаар бодсон зүйл нь юу байгаа юм бэ?

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя, Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Гишүүний асуултад хариулъя. Тэгээд өмнөх сайд нар, дарга нар их муу ажиллаж байгаа, бид сайн ажиллаж байгаа гэж яриагүй. Бид төсвийнхөө бодлогоо хэрэгжүүлж, ЗГ-ын залгамж халааныхаа дагуу бодлогоо хэрэгжүүлээд л явж байгаа. Харин энэ тодотгол хийх үндсэн том шалтгаан өнгөрсөн намрын төсөв батлахад УИХ дээр гарсан шийдвэрийн алдааг бид харин засаж байгаа гэдгийг харин тодотгоод хэлчихье. ЗГ цалин нэмнэ гэж оруулж ирээгүй шүү дээ өнгөрсөн онд, Их Хурал дээр нэмсэн. Тэр нэмсэн алдааг чинь бид одоо засаад тодотголоор оруулаад ирж байгаа юм.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг УИХ дээр баталдаггүй. Орон нутгийн Иргэдийн Хурал өөрсдөө ямар хөрөнгө оруулалт, төсвөө хэрэгжүүлэхээ тэндээ бие даасан Иргэдийн Хурлаараа батлаад явдаг. УИХ нэгдсэн төсөв дээрээ хөрөнгийн зардлын нийт хэмжээг нь тавьж өгдөг. Төсвийн алдагдлаараа өнөөдөр

орон нутгийн төсөв 2 буюу нийслэл дээр 2.8 их наядын ашиглаж чадаагүй хөрөнгө оруулалт алдагдал болоод явж байна. Энэ асуудлаа шийдвэрлэхийн тулд төсөв дээр 988-аар оруулаад ирлээ. Энэ төсвийн өмнө хавар их яриад байсан төсвийн гадуур нийслэл чинь яваад байна гээд байсан. Тэгээд нэгдсэн төсвийнхөө бодлогын хүрээнд орон нутаг буюу нийслэлийн алдагдлыг бид өмнөх онд санхүүжүүлж чадаагүй дүнгээр нь 2.8-аас 9.8-ыг нь энэ төсвийнхөө алдагдлынхаа гарч ирж байгаа орон зай буюу 1 их наядын орон зай дээр нийслэлдээ энэ төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжийг нь хөрөнгийн зардлын хэмжээгээр нь гаргаад явж байгаа юм. Ийм л асуудлууд байгаа.

Зээлийн хэмжээ нэг их наяд төсвийн, энэ бол дотоодын бонд төсвийн дэмжлэг 200 сая ам.долларыг АХБ-аас /ADB - Asian Development Bank/ авахаар ярилцаад явж байгаа. АХБ-аас эдийн засгийн тогтворгүй, геополитикийн тогтворгүй нөхцөлд бүх улс орнуудад төсвийн дэмжлэг үзүүлж байгаа. Бид болзошгүй эрсдэлээс сэргийлэх гэж байгаа юм. Зээлийн шугам 26 онд нийтдээ 250 сая ам.долларын 125 сая ам.долларыг нь 26 онд ашиглая гэж байгаа. Бид зээлийн шугам байхгүй юу энэ зээлийн. Шаардлагатай тодорхойгүй нөхцөл байдал, гамшгийн нөхцөл байдал үүсэх, энэ гол нэрийн бүтээгдэхүүний хомсдол үүссэн нөхцөлд бид бэлэн байя гэж байгаа юм. Ард түмнээ эрсдэлд оруулахгүйн төлөө л ЗГ ажиллаж байгаа юм. Тэр үүргээ биелүүлэх хүрээнд оруулж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Дөнгөж саяхан сануулсан юм сан, дэмжиж болох зүйлийг хэлээд өнгөрсөн. Тэгээд дэмжиж болж байгаа зүйлийг эргүүлж битгий надад хариулаарай гэсэн. Би өөр зүйл асуусан шүү дээ. Өөр зүйл асуусан. Нэг удаагийн орлого ногдол ашиг гэдэг нэг удаа тооцож бодоод гаргаж ирдэг ашиг, тогтмол ногдол ашиг гэдэг байх уу, үгүй юу тухайн тухайн жилээсээ болно. Энийгээ тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь анхааруулсан байна лээ шүү дээ танилцуулга дээрээ, дүгнэлт дээрээ. Тэгээд гаалийн татвар нь 900 хэд байлаа даа, хэдэн тэрбумаар буурчихсан, татварын орлого нь 1 их наяд 20 тэрбумаар буурчихсан, тэгснээ ашигт малтмал ашигласны нөөц төлбөр нь 200 тэрбумаар, 1 их наяд.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Ногдол ашиг тогтвортой орж ирнэ Батбаатар гишүүнээ. Бидний баталсан Төрийн өмчийн хороо, энэ төрийн өмчийн талаарх хууль дээр чинь ийм юм байгаа шүү дээ. Ногдол ашгийн 30-аас доошгүй хувийг төвлөрүүлэх ёстой 1 дүгээрт, 2 дугаарт компани ашиггүй ажиллавал татан буулгана л гэж байгаа шүү дээ. ТӨК-уд цаашдаа ашигтай ажиллах ёстой. Бид өмнө нь 2025 оноос өмнө тараасан ногдол ашгаас иргэдэд тараасан ногдол ашиг байгаа, эндээсээ төрд олгоогүй ногдол ашгаасаа бүр авъя гэж байгаа юм. Та "Эрдэнэс Монгол" нэгдлийн балансыг үзээрэй, 3.4 тэрбумын цэвэр ашигтай байгаа, эндээс нь төр ногдол ашгаа татаж авъя гэж байгаа юм. Тэр нь 1 их наяд байхгүй юу. Түүнээс биш бид компанийн, тэр, тэр компанийн тэндээс нь авна гэж байгаа асуудал огт байхгүй. Өнөөдөр "Эрдэнэс Монгол" дээр уул уурхайн компаниудын нэгдсэн ашиг, Баялгийн сангийн хуулиараа бүгдээрээ тэнд төвлөрч байгаа. 34 хувь нь Баялгийн сангаараа Ирээдүйн өв сан руу орж байгаа, 66 хувь нь тэр компани дээр үлдэж байгаа тэр төсөв.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Төсвийн тухай хуулийг өргөн мэдүүлэх бүрэн эрх ЗГ-т байгаа. Гэхдээ улсын төсвийг хэлэлцэх, өөрчлөх, батлах онцгой бүрэн эрх УИХ-д хадгалагдаж байгаа шүү гэдгийг энэ ташрамд сануулъя. Тийм ч учраас өнөөдөр УИХ ээлжит бусаар хуралдаад шөнөөр орой болсон ч хамаагүй энэ эдийн засгийн бодлогын асуудлуудаа хэлэлцээд байж байна. Тэгээд өргөн мэдүүлсэн төсөл чинь бодлогын хувьд алдаатай байна гэхээр, ийм бодит шүүмжлэл хэлэхээр улс төржлөө, зөвхөн намайг эсэргүүцэхийн төлөө та нар эсэргүүцээд байна гээд урдаас өөрөө улс төржөөд байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаад байна.

Бид чинь энэ эдийн засгийн нөхцөл байдалдаа санаа зовоод ийм зүйл яриад байгаа шүү дээ. Тэгээд сая гишүүд маш тодорхой асуудлуудыг ярьж байна шүү дээ. Тухайлбал, Энхтүвшин нарын гишүүдийн хэлж байгаатай санал нэг байна, ЗГ-аас оруулж ирсэн төсвийн тодотгол чинь энэ төсвийн тусгай шаардлагуудад нийцээгүй байна гээд аудитын дүгнэлт гарчихсан байхад бид ингэж дэс дараалал зөрчөөд хэлэлцэх нь зөв юм уу, буруу юм уу гэхэд өмнө нь ингээд болоод байсан юм гээд. Үгүй ээ, өмнө нь ингэж болгоод байсан Засгийн газрууд чинь огцорчихсон байж байгаа шүү дээ. Яагаад гэвэл алдаа гаргасан учраас. Тэгээд тэр алдаануудыг нь ингээд давтаад байгааг чинь буруутгахаар, би л ингээд зөв юм хийж байна гээд урдаас ийм юм яриад байх юм. Тэгээд үнийн өсөлт бид бүхний дайсан гэдгийг чинь л бид хэлээд байна шүү дээ. Энэ үнийн өсөлтөө яах гээд байгаа юм бэ?

Инфляц ийм өндөр байхад, мөнгөний бодлого ийм хатуу байхад төсвөө танах ёстой гэдгийг эдийн засагч нар, энэ судлаач нар, иргэний нийгмийнхэн, сэтгүүлчид бүгд хэлээд байгаа байхгүй юу. Сая өнөөдөр гишүүд аргаа бараад, Төв банк нь торомз дарж байхад засаг хааз дараад байна гэж нэг хэлж үзлээ. Өнөөдөр хэдэн төгрөгийн тэтгэвэр, цалингийн нэмэгдэл олгосныг чинь маргааш нь суйлах гээд байна гэж нэг хэлж үзлээ. Энэ чинь ингээд энэ бодит эдийн засгийн бодлого чинь буруу яваад байна гэдгийг л гишүүд хэлээд байгааг зүгээр яагаад сонсохыг хүсэхгүй байгаад байгаа юм бэ? Түүнээс биш бид энэ тэтгэврийн нэмэгдлийг огт эсэргүүцээгүй шүү дээ. Сая наадмын өмнө Нийгмийн даатгалын багц хууль чинь дотор нь зөндөө асуудлууд байсан. Тэр нэрийн данс буруу байсан гэдэгтэй би санал нийлэхгүй байсан.

Гэхдээ богино хугацаанд энэ ахмадуудынхаа асуудлыг шийдэх ёстой гэдэг үндэслэлээр АН-ын гишүүд бүгдээрээ дэмжээд явуулсан шүү дээ. Тэгээд ийм байхад ерөөсөө шүүмжлэл сонсохгүй ингээд урдаас ийм худлаа яриад байна дээрээс нь, энийгээ 1.4 их наяд төгрөгийн хэмнэлт хийсэн гээд л бүр янз бүрийн постер [poster] ил хийгээд л цацсан. Тэгэнгүүт одоо бодит байдал дээр юу гарч ирж байна вэ гэхээр урсгал зардлын бодит хэмнэлт чинь 433 тэрбум төгрөг л байна шүү дээ. Тэгээд тэр хөрөнгийн зардлаас болохоор тэр хэмнэлтийн хуульд орчихсон 250 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал хасагдаж байгаа юм байна. Цаад тал нь болохоор тэр нөгөө Нийслэлийн бондын ашиглагдаагүй зардлын орон зай, тэгээд бодитоор ярь л даа. Урсгал зардлаа бид танахыг шаардсан, тэгээд 1.4 их наядыг бид хэмнэчихлээ, энэ ёстой сайд нарын төсвөөс таналаа гээд л ингээд л попроод байдаг. Гэтэл тэрэнд чинь яг бодит хэмнэлт нь 400 тэрбум төгрөг. Тэгээд ийм зүйл ярихаар яагаад ингээд бид рүү дайраад байгааг чинь ерөөсөө ойлгохгүй байгаад байна.

Тэгээд одоо бид л ерөөсөө ийм мундаг хүмүүс болоод л энэ ТӨК-удын ногдол ашгийг л төвлөрүүлэх гээд байна гээд байгаа. Сая наадмын өмнө хэдүүлээ хамтдаа сууж байгаад л энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуулийг батлаа биз дээ. Тэгээд тэрний дагуу та нар төрийн өмчийн бодлогоо оруулж ирэх ёстой шүү дээ. Гэтэл ингээд энэ нөгөө төсвийн тодотгол дагуулаад Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, тэр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.10-т ногдол ашгийн зохицуулалтыг нэмж байгаа. Тэгээд тэр мэр нь ерөөсөө тэр нөгөө танилцуулга, энэ тэр тооцоо судалгаа нь маш дутуу. Дээрээс нь энэ Франклин Темплтон [Franklin Templeton], Блэкроктой [BlackRock] ингээд л янз бүрийн санамж бичиг байгуулаад байна гээд л постер л яваад байдаг, ерөөсөө тэр бодит бичиг баримтууд нь Их Хурал дээр ирдэггүй. Тэгээд энэ нөхцөл байдлыг чинь л бид шүүмжлээд байна шүү дээ. Тэгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм, Жаргалан гишүүнийг ойлгож байна. Та маш ажил хэрэгч саналууд хэлж байна одоо л. Баялгийн сангийн хуулийн тэр заалт, ТӨК-ийн хуультай нийцүүлж байгаа гол нь. Франклин Темплтонтой санамж бичиг зураад тэд саналаа бэлдэж байгаа юм, 3 дахид тэр Блэкрок санамж зураад ажлаа эхлэх гэж байгаа. Ингээд Их Хурлын тогтоолоор чиглэл өгсний дараа бид хуулийнх нь дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад, эдгээр компаниудын аль нэгэн компанийн хамгийн боломжит саналыг аваад бид яг хэлэлцээрээ ороод албажуулсны дараа Их Хурал энэ өмчийн эзэн учраас Их Хуралд энийг өргөн мэдүүлнэ. 10 дугаар сарын 15-аас өмнө ТӨК-ийн хуулийн дагуу бодлогоо Их Хуралд оруулж ирнэ. Бүгд хуулийн хугацаатай л явж байгаа юм.

Би сонсохгүй байгаа огт биш. Би өглөөнөөс хойш та бүхнийг сонсож байна, саналуудыг чинь хүлээж авч байна, ажил хэрэгч ийм санал хэлбэл би үргэлж авсаар байх болно. Өнөөдөр төсвийн тодотголоор 1.4 их наядыг хэмнэсэн үү гэвэл хэмнэсэн. Би тантай санал нэг байна. Урсгал зардал 433.4 тэрбумаар хэмнэсэн, 5 сарын 31-нд наад хөрөнгө оруулалтын тендерийн ажлууд чинь зарлагдаж чадаагүй, гэрээ хийгдээгүй учраас 252.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн байхгүй юу. Тэгээд нийслэлийн үнэт цаас чинь 758 худлаа биш, уул уурхайн бүс эдийн засаг чинь агших ийм эрсдэлтэй болчихоод байна. Тэр нь юутай холбоотой вэ гэхээр наад худалдаа, үйлчилгээний салбар чинь өөрөө татвар бүрдэхгүй, дээрээс нь төсөв тасраад 2.2 их наядын алдагдалтай болчихоод байна шүү дээ. Тэгэхээр үүнийг нөхөхийн тулд уул уурхайн ТӨК-ийн ногдол ашгаар бусад салбарыгаа идэвхжүүлж байж эдийн засгаа сэргээх шаардлагатай болоод байгаа байхгүй юу.

Тийм учраас ирэх оны төсөв дээр би 9 шийдвэр гээд энэ тодотголтойгоо уялдуулаад араас нь ямар бодлого хэрэгжүүлж болох вэ гэдгээ оруулж ирсэн юм. Ямар ч мөнгө төгрөг хэвлээгүй, Баялгийн сангийн аль ч сангийн хуваарилалт руу ороогүй, санхүүгийн хэрэгсэл ашиглаад ажлын байр шингээдэг салбарууд руу бодлого оруулж байгаа байхгүй юу. Тийм учраас тэр барилгын салбарыг дэмжье гээд. Тийм учраас тэр дундаж давхаргыг дэмжих тодорхой зээл, тусламж гаргах ёстой гэж хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд ТӨК-уд дээр тэр 20 компани хэрвээ ингээд багц гарчихвал хөрөнгө босох юм байна гээд байгаа байхгүй юу. Яагаад тодотгол дээр Үнэт цаасны хууль оруулж ирж байгаа вэ гэхээр би санхүүгийн захыг л богино хугацаанд дэмжих гээд байгаа байхгүй юу. Энэ тодотголыг дэмжээд өгвөл СЗХ наад Тавантолгой компани чинь 2 дахь зах зээлд бүртгүүлээд нээлттэй болгочихвол ЗГ 10 хувьтай наад Үнэт цаасны хууль дээр 3 дугаар дээр нь заалт нь

байгаа байх. Тэр дижитал биржээр энэ тэр гаргая гээд байгаа байхгүй юу. Энэ ер нь цогц арга хэмжээ. Тийм тэгэхээр тантай хамтраад ажиллахад бэлэн байна.

С.Бямбацогт: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Энэ ТӨК-удын реформыг хийхийн тулд эхний ээлжид засаг энэ төрийн өмчийн бодлогоо оруулж ирээд, тэгээд Их Хурал дээр бүгдийг нь энэ цогцоор нь ярих хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхгүй ингээд төсөв дагалдуулаад энэ Үндэсний баялгийн сангийн хуулиа ч өөрчлөөд, оролдоод ингээд бид чинь ингээд ерөөсөө 1 юман дээр төвлөрч чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд л дандаа нэг ийм гал унтраах, дандаа л ингээд нэг ийм онцгой нөхцөл байдал үүссэн нөгөө хаа хамаагүй хаа байсан янз бүрийн асуудлуудыг татаж авчраад, одоо л ингэхгүй бол болохгүй байна гээд энэ ийм байдлаар явж ирсэн юм чинь энэ алдаа завхралуудыг чинь бий болгочоод бид ийм эдийн засгийн хүнд нөхцөл байдалд орчихоод байна шүү дээ. Тэгээд үнэхээр харамсалтай байна, 2026 оны эхний 7 сарын байдлаар Монгол Улс 12 тэрбум ам.долларын энэ экспорт хийчихсэн сууж байна шүү дээ. Бид түүхэнд байгаагүй их хэмжээний нүүрс гаргачихсан сууж байна. Зэсийн экспорт хамгийн өндөр түвшиндээ явна. Ийм нөхцөлд бид ийм арчаагүй юм яриад сууж байхдаа үнэхээр бүр хэлэх үг олдохгүй байгаад байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Та бидний баталсан ТӨК-ийн хууль 1 сарын 1-нээс хэрэгжих гэж байгаа учраас Баялгийн сангийн хуультай нийцүүлж байна. Гэнэтийн юм орж ирээгүй, хувьчлалын бодлого буюу ямар нэгэн компанийг хувьчлах бодлогын ямар ч асуудал төсвийн тодотголыг дагаж орж ирээгүй. Энэ 10 дугаар сарын 15-наас өмнө хувьчлалын бодлоготойгоо уялдуулаад аль компанийг нээлттэй болгох юм, хувьчлах юм, нэгтгэх юм яах юм, ийх юм гэдгийг Их Хурал өөрөө л шийднэ. Энэ та бүхний эрх. Тэрнээс биш энэ тодотгол дагуулаад янз бүрийн тийм юм орж ирээгүй шүү дээ. ТӨК-ийнхоо хуультай л нийцүүлж байна, өөр юу ч байхгүй, нууж хаагаад байх юм байхгүй шүү дээ энд чинь. Тэгээд л ингээд явж байна. Тэгээд санхүүгийн захаа босгоё гэдэг ийм бодлого явуулж байна л гэж би хэллээ шүү дээ. Та нэг их тийм харамсаад байх юм бол байхгүй байх. Харин ч энэ бодлогын асуудал дээр таны энэ оролцсон ТӨК-ийн хууль, энэ Эдийн засгийн эрх чөлөө, Зөвшөөрөл гээд олон хуулиудыг чинь хэрэгжүүлэх гэж ЗГ ажиллаж байна. Харамсах биш удахгүй баярлах байх.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя, үгээ хэлье.

Г.Очирбат: Зөв зөв. Тэгээд өнөөдөр асуултууд их асуулаа. Хариултаа ерөөсөө авч чадсангүй. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс эхлээд энэ Төсвийн тухай хуулиа өөрчилье гээд байгаа шүү дээ. Хууль зөрчөөд байна гээд байгаа. Хууль засаглаж байгаа юм уу Монгол Улсад, хүн засаглаж байгаа юм уу? Зүгээр орж ирээд л гоё үг юм яриад л уянгалаад л ингээд цаашаа явах юм уу. Хууль засаглаж байвал хуулиа мөрдөцгөөе, хуулийнхаа зөрүүг арилгацгаая. Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 гээд хэлээд байгаа юм. Энэ зөрчлөө арилгаад цаашаа алхацгаая.

АН-ынхан энэ хүүхдийн мөнгөнөөс авхуулаад иргэддээ яг амьдрал ахуйд нь одоо хүртэл дэм болж байгаа олон хуулийн төслийг санаачилсан. Бид эрүүл мэндийн салбарынхаа нийт ажилчдынхаа цалинг 20 биш 40 хувиар нэммээр байна. Энэ соёл, төрийн үйлчилгээний албан хаагчдынхаа цалинг 50 хувь биш 100 хувь нэммээр байна. 97 мянган багш, ажилчдынхаа цалинг 674 тэрбум биш, 1.4 тэрбумаар нэммээр байна. Энэ ер нь суурь тэтгэврээ олгоход энэ 435 мянган ахмадынхаа тэтгэврийг чадвал нэг дахин нэммээр байна бүр, тэгэхдээ яаж тэрийг л хэлээд байгаа шүү дээ. Эдийн засгийнхаа зөв бүтцийг олъё, эдийн засгаа зөв солонгоруулъя. Бодлогын дэмжлэгүүдийнхээ үр дүнг харъя. Инфляц 13 хувьтай өсчихсөн, инфляцыг бууруулж өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн тэр хүнсний хувьсгал гэдэг ажлыг санаачлаад явсан 1.4 их наяд төгрөгийг зах зээл рүү нийлүүлээд, одоо үр дүн хаана байна вэ, махныхаа энэ үнийг өсгөчихгүй юм сан гээд 840 тэрбум төгрөгийг шинэ хоршоо гээд гаргасан. Одоо үр дүн чинь хаана байгаа юм бэ? Ямар ч бодитой үр дүн гарахгүй байна шүү дээ. Тэгэхээр бид нарын хэлж байгаа санаа эдийн засгийн сууриар нь тэлье, эдийн засгаа төрөлжүүлэе, татвар төлөгч нарынхаа тэр боломж, бололцоог нэмэгдүүлж татвараа авч тэрүүгээрээ төр бодлогоо хэрэгжүүлээд цаашаагаа явъя л гэсэн санаа.

Харин нэг давуу тал гарч ирж байна. Сүүлийн энэ олон жил энэ ЭТТ гэдэг компанитай холбоотой жил болгон хэдэн их наяд төгрөг цаанаа алга болсон гэдгийг мэдэхгүй байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн ч гэсэн одоо асуугаад тэр 2, 3 их наядын асуудал ярьж байна. Жил болгон хэдэн төгрөгийг хаашаа үрж байсан юм. Сүүлийн 10 жил МАН-ынхан дарга, цэргийг нь бүгдийг нь тавьсан, тэр нөхдүүд хаана байна. Энэ Алтангэрэл гишүүний тэр санаачилсан хуулийн төслийг хурдан оруулж ирмээр байна. Тэгээд хэдүүлээ сууриар нь асуудлаа шийдэхгүй бол зүгээр нэг ингээд косметик [cosmetic] юм яриад л, тэгээд л тэндээс 1 их наядыг оруулаад ирчихье, дараа жил тэгж байгаад 3.5-ыг оруулаад ирчихье гээд л. Ирэх жилийн 2027 оны төсөв дээр тэр дахиад ОТ-той холбоотой 3 их наяд төгрөгийн асуудал яригдаад л байгаа. Хаана, хэн, ямар гэрээ хийсэн юм, ямар хэлэлцээр явсан юм мэдэхгүй. Их Хурлын 126 гишүүнээс хэд нь мэддэг юм байгаа юм би лав ойлгохгүй байгаад байгаа.

Тэгсэн мөртөө төсвийнхөө төслийг оруулаад ирчихсэн авна гээд. Тэгээд ийм байдалтай байх юм уу. Иргэдээ бодитой үнэхээр яг бодитой дэмжих гэж байвал энэ олон мөнгөнүүдээ тэр ногдол ашиг хэлбэрээр хувьцаанд нь хуваарилаад өгөх цаг нь болсон. Тэгэхгүй одоо төсөв рүүгээ татаж авч байгаад л дахиад л дураараа баруун, зүүнгүй цацах гэж байна шүү дээ. Яах вэ энэ удаагийнх нь энэ манай эрүүл мэндийн, боловсролын салбараа дэмжих гэж байна гэж оруулж ирж байна. Дараа нь яах юм тэгээд, ЭТТ дараа жил 5 их наядын ашигтай ажиллавал яах юм? ОТ магадгүй дахиад энэ технологийн салбар хөгжөөд ярьж байгаа 3-аас чинь илүү 6 их наядыг ногдол ашигт өгөхөөр болбол яах юм? Ингээд асуудлууд зөндөө байна. Тэгэхээр энийг сууриар нь шийдэх ёстой. Тэгээд PR хийж АН-ынхныг муухай харагдуулахаа болих хэрэгтэй шүү.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэболд: 2024 оны 7 сарын 2-ны өдөр бид энд Монгол Улсын Үндсэн Хууль дээр тангараг өргөсөн, аливаа явцуу ашиг сонирхлоос ангид, ард түмнийхээ төлөө, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн дээдлэхээ Үндсэн хуулийн өмнө тангарагласан байгаа. Тэр УИХ-ын олон чухал функцийн [function] хамгийн чухал нь бол тухайн жилийн төсвийг батлах. Төсвийн тодотгол орж ирж байна гэдэг бол мөн

л адилхан энэ онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа үйл явц. Бид ардчилсан орон, нэг намын дангаар ноёрхсон дарангуйлалтай оронд бол сөрөг хүчин үг хэлэхгүй байж болно. Гэхдээ бид чөлөөт нийгмийн үзэл санааг дэмждэг ардчилсан орон учраас асуудлыг 7 хэмжиж, нэг огтлох, олон талаас нь хэлэлцэж, шүүн тунгаах ийм эрх чөлөөт орны иргэд. АН сөрөхийн тулд засгийн бодлогыг улдан эсэргүүцээд байгаа юм биш.

Монгол Улсын Ерөнхий сайд өнөөдөр цалин, тэтгэвэр нэмье гэхээр юундаа ард түмнээсээ 5 цаас харамлаад байгаа юм бэ гэдэг өгүүлбэрийг хэллээ. Асар хариуцлагагүй үг хэллээ. Харин оруулж ирж байгаа бодлогыг нь илүү зөв хэмжүүртэй, зөв бүтэцтэйгээр, улсын ашиг сонирхолд нийцсэн байдлаар яаж батлах вэ гэдэг дээр бид үгээ хэлээд байгаа юм. Түүнийг нь болбол хувь хүн рүү нь чиглэсэн дайралт болгож байгаад харамсаж байна. Нэг зүйлийг тодорхой асуусан нь хулгайн асуудал, авлига, хээл хахуулийн асуудал. Нэг үе бүр далан хэд болтлоо бууж байсан Авлигын төсөөллийн индекс [index] өнөөдөр 100 гараад явчихлаа. Бид амаараа ажил ярьдаг боловчиг ачир дээрээ Монгол Улсын өрсөлдөх чадвар хойшоо ухарсаар байна, иргэдийн амьдрал доройтсоор байна. Энэнээс чинь болоод үнийн өсөлт, энэ авлига, хээл хахуулиас чинь болоод иргэдийн амьдрал доройтоод байна л гэдгийг хэлээд байгаа юм.

Гэтэл төсөв чинь өөрөө хэр хэмжээний тоо орж ирэхээс илүүтэйгээр цаана нь хулгайгаасаа тэр хамгаалагдсан байх, авлига, хээл хахуулиасаа таслагдсан байх, ангижирсан байх тэр боломж, бололцоог нь асуугаад байдаг. Энэ дээр тодорхой үг хэлсэнгүй. Тодорхой нэр устай албан тушаалтан тодорхой нэвтрүүлэгт ороод улс төрийн зорилгоор мэдэгдлүүд хийдэг. Тэрийг нь хууль, хүчний байгууллагууд шалгасан юм уу, үгүй юм уу гэдэг нь асар тодорхойгүй. Иргэд, олон нийтийг талцуулдаг. “Муу дээрээ муу муухай дээрээ улцан” гэдэг шиг ийм ард иргэдээ талцуулсан нөхцөл байдалд л оруулаад байгаа юм. 24 оны 11 сарын сүүлээр тухайн үеийн УИХ-ын дэд дарга Булгантуяагийн ахалсан Монгол Улсын парламентаас гарч байгаа бүх шийдвэрүүд нь хүн төвтэй байх 5 шалгуурыг бид баталсан. Тэгээд өнөөдөр оруулж ирж байгаа төсөв үүндээ ядаж л нийцэх ёстой байхгүй юу. Төсөв иргэд рүүгээ чиглэсэн, иргэдийн амьжиргаа руугаа чиглэсэн, өсөлт рүү чиглэсэн, бизнесийн орчин руугаа чиглэсэн, бүтээн байгуулалт руу чиглэсэн, дарга тойрсон эрх мэдлийг хуягладаг төсөв биш, иргэдийнхээ амьжиргааг ахиулахад чиглэсэн шударга, ил тод төсөв байх ёстой. Түүний эх сурвалж нь асар тодорхой, уян хатан, хэмжигдэхүйц, дээрээс нь үр өгөөжтэй байх ёстой гэсэн зүйлийг л бид хэлээд байгаа юм.

АН гэнгүүт “муу л бол баруун хойд талын хар овоохой” гэдэг шиг гээд PR-н золиос болоод байж болохгүй. Асуудалд нь АН юм уу, Ардын намдаа биш, өнөөдөр эрх барьж байгаа бол аливаа асуудлыг ул суурьтай, олон талаас нь сонсох сэтгэлийн тэнхээ, хаттай байх ёстой гэдэг зарчмыг л бид хэлж байгаа. Цааш цаашдаа ч үүнийгээ шаардах болно гэдгээ тодорхой хэлье.

С.Бямбацогт: Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Түрүүн асуулт асуух боломжоор хангаж өгсөн Их Хурлын даргад талархал илэрхийлье. Төсвийн тодотголоо хэлэлцээд нэгдүгээр хэлэлцүүлгийг нь хийгээд явж байгаа энэ чинь нөгөө муу хэлээд байгаа АН-аас чинь л 4, 5 хүн сууж байна. Сайдууд чинь ч бараг алга байна. Их Хурлын дарга тэгэхээр нэг жоохон хариуцлагатай байхгүй бол энэ чинь Монгол Улсын Их Хурал чинь

ингээд хоосон зааланд нэг хэдэн төрийн албан хаагч, ТНБД нар сууж байгаад нэг цэц булаалдаад байгаа юм байхгүй шүү дээ. Бид аль болохоор ажил хэрэгч байдлаар хандъя гээд энэ үдшийн 23:00 цаг болж байхад ингээд асуудлаа яриад сууж байна. Тэгээд цаашдаа энэ ирц дээрээ анхаараарай гэж Их Хурлын даргад хэлэх гэсэн юм.

Тэгээд нөгөө төсвийн тодотголоо ярьж байгаа учраас нэг ойр зуурын юмнуудыг энэ сайд нарт нь хэлэхгүй бол болохгүй байна. Жишээлэхэд энэ Боловсролын зээлийн сан дээр улсын төсвөөс 127 тэрбум төгрөгийн эх үүсвэр аваад, эргэн төлөлтөөсөө 140 тэрбум төгрөг аваад, нийтдээ 270 тэрбум төгрөгөөр дахиад Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг явуулна гэж төсөвлөсөн. Тэгтэл энэ 140 тэрбум төгрөг дотроос чинь эргэн төлөлт хийгдэх 140-н чинь 128 нь гадаадад сурсан буюу улаан намын, цагаан байрныхны үр хүүхдүүд нь сурсан гадаадад сурсан нөхдүүдийн эргэн төлөлтийг хийлгэе гээд төсөвт суулгаад явсан чинь 2026 оны 9 сарын байдлаар нийтдээ 367 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэхээс зөвхөн 500 сая төгрөг л хийгдсэн байна. Нөгөө Боловсролын яам чинь цалин нэмэх, багш нарын цалин нэмэх мөнгө алга л гээд байгаа энэ Боловсролын зээлийн сангийн хулгай дээрээ анхаарч ажиллаад, шаардлага тавиад явах юм бол бидэнд боломж байна шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Тэгээд энэ нөгөө төлүүлэх биш чөлөөлөх арга хэмжээ авах гээд байна уу Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга энд байх шиг байна. Төлүүлэх ёстой, чөлөөлөх биш энэ чинь зээл, энийгээ анхаарч ажиллаарай.

2 дугаарт нь Баянхонгор аймгийн Шаргалжуут рашааны чиглэлд тавигдах 60 километр автозам тавина гээд 3, 4 жил болж байгаа, төсөвт өртөг мөнгөө бүгдийг нь авсан 500 орчим сая төгрөг л төсөв дээр үлдсэн байх Баярмагнай дарга бас байгаа. Гэтэл яг бодит байдал дээрээ 1 километр ч зам тавигдаагүй, бүх мөнгөө авчихсан. Та энэ зун өөрөө очсон, харсан байлгүй дээ, энэ рүүгээ энэ ЗТЯ өөрөө хяналт хэрэгжүүлдэг бол өгсөн мөнгөнийхөө араас замаа нэхэж явахгүй бол зам ч үгүй, мөнгө ч үгүй болчихлоо гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

3 дугаарт нь сая энэ Дэлгэрсайхан сайд хэлж байгаад дутуу орхигдчихлоо. Баруун аймаг руу гарч байгаа тэр "Драгон" гэж нэрлэдэг бид нарын тэр нөгөө авто терминалын асуудлыг нэн даруй анхааралдаа аваад цэгцэлж болдог эрх мэдэл байдаг бол цэгцлээд, жолооч нарын асуудлыг нэг талд нь шийдэд өгөхгүй бол ширэнгийн хууль үйлчлээд байна шүү гэдгийг хэлсэн. Тэгээд яг хариултаа хэлэх гэж байхад нь цаг нь дуусчихлаа. Тэгэхээр Баярмагнай дарга энэ дээр анхаарч байгаад маргааш нь нөгөөдөртөө багтаагаад нэг хариу, тайлбар ирүүлээд би тэд нарыг нь жолооч нарт нь хэлчихвэл сайн байна. Аль болохоор цэгцлээд л явмаар байна гэдэг ийм саналуудыг л хэлээд байгаа юм. Иргэдээс ирж байгаа саналуудыг хэлж байгаа шүү гэдгийг зөвөөр ойлгоосой.

Эцэст нь хэлэхэд бол яах вэ мөрөөдөл биелэх сайхан юм. Тэгээд энэ тэтгэвэр нэмэх боломжтой байна гээд жилийн өмнө яриад зогсож байсан мөрөөдөл маань одоо нэг биелээд явж байгаад нь энэ чинь зөвхөн миний ч мөрөөдөл биш, АН-ынхны мөрөөдөл, тухайн үед боломжгүй бирд биш дээ л гээд байсан тэгээд биелүүлж байгаад нь их талархаж байна. Тэгээд манай ахмадууд ч гэсэндээ энэ өнөөдрөөс хойш нэг жоохон зоо нуруу нь тэнийгээд, АН ч гэсэн энийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж байсан юм байна шүү гэдгийг анхаарч хараасай гэж хүсэж байна. Баярлалаа та бүхэнд.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Батбаатар: Өнөөдөр энэ төсвийн тодотголыг Иргэний Зориг Ногоон Нам улс төрийн шалтгаанаар эсэргүүцэхээр биш, тоог нь тулгаж үг хэлж, ярьж байгаа юм. 22 жилийн өмнө ЗГ-ын мөрийн хөтөлбөрт хоёрдогч үнэт цаасны зах зээл гэдэг заалтыг ЗГ-ын мөрийн хөтөлбөрт баахан юм болж байж оруулсан. Харамсалтай нь тэр хэрэгжээгүй. Өнөөдөр Ерөнхий сайд тэрийг дахин гаргаж ирж, Монгол Улсын санхүүгийн тулгуурыг энэ ломбардын системээс, мөнгө хүүлэлтийн системээс, лоббиноос [lobby] салгахаар оруулж ирж чадаж байгаа бол үнэхээр талархана.

Ер нь ЗГ ашгийн төлөө, ард түмэнтэйгээ, бизнес эрхлэгчидтэй өрсөлдөх ёсгүй шүү дээ. ЗГ татвар, эрх зүйн орчноороо асуудлаа шийддэг энэ чиглэл рүүгээ л явах ёстой. Өнөөдрийн төсвийн тодотголд байгаа ахмад настанд суурь тэтгэвэр олгох, боловсрол, эрүүл мэндийн салбарын цалингийн зөрүүг арилгах, шатахуун, хүнсний стратегийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг Иргэний Зориг Ногоон Нам дэмжинэ. Бидний асуудал зорилтод биш, түүнийг санхүүжүүлэх аргад байгаад байгаа юм. Санхүүжүүлэх арга дээрээ цаг богино учраас товчхон 3 зүйлийг хэлье.

1.44 их наяд төгрөгийн хэмнэлт гэдэг тоог задлаад үзэхээр хэмнэлт биш, дахин хуваарилалт болж байгаа юм. Үүний 750 тэрбум нь нийслэлийн үнэт цаасны санхүүжилт. Энэ бол зардлын таналт биш, урсгал зардлынх нь жинхэнэ таналт нь 433 тэрбум. 1 их наяд 152 тэрбумаар өсөж байгаа, хэмнэсэн гэж байгаа 433 тэрбумыг тооцвол шинээр нэмсэн урсгал зардал нь 1 их наяд 585 тэрбум болж байгаа юм. Тэгэхээр энэ зардал болон шинээр нэмж байгаа зардлыг нь хэмнэсэн зардалтайгаа тулгаж харьцуулсан тэр хүснэгтийг Байнгын хорооны хурлыг эхлэхэд ЗГ нэмж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

2 дугаарт, энэ багц дотор байгаа төсөл дотор байгаа хамгийн том тоо нь өөрөө танилцуулгадаа ороогүй. 562 тэрбумын зээллэгээс 2 их наяд 752 тэрбум болж өөрчлөгдсөн. Энэ 2 их наяд 190 тэрбумын нэмэлт зээллэг үүсэж байгаа юм. ЗГ бүсээ чангалсан шиг чангална гэсэн тоо нь өөр зүйлийг харуулаад байна. Бүс нь чангарсангүй, зээлэнд сууна уу гэж харагдаж байна. Мөн төсвийн бүтцийн чанар муудаж байгаа, хөрөнгө оруулалт нь 250 тэрбумаар буурсан. Энэ бол сургууль, эмнэлэг 250 тэрбумаар цөөрч байхад зээл нь 2 их наядаар нэмэгдэж байна л гэсэн үг.

Эцэст нь энэ зарим нэг техникийн асуудлаараа анхаараарай гэж үзсэн. Магадгүй техникийн алдаа гарсан уу, алдаатай бичсэн үү, дугаарлалт тэр юун дээр тэрийгээ нэг харчхаарай гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Гаалийн орлогыг ногдол ашгаар нөхөж байгаа магадгүй өөдрөг төсөөлөл хэлж байна тийм байвал сайн. Гэхдээ өндөр ашгийг ЗГ иргэдийнхээ олж болох ашгаас булаацалдаж, бизнес хийж, өрсөлдөж болохгүй гэдэг үндсэн зарчмаа харвал энэ тийм сайн зүйл биш. Тийм болохоор Ерөнхий сайдын амлаад байгаа тэр компаниудын өөрчлөлт нь хурдан болоосой гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ.

Б.Жаргалан: Энэ зун энэ үнийн өсөлт даамжраад, шатахууны хомсдол үүсэж эхэлсэн цагаас хойш УИХ дахь АН-ын бүлгийн зүгээс энэ ЗГ төсвийн тодотголоо оруулж ирээч, энэ макро эдийн засгийн бодлогоо Их Хурал дээрээ ярьж, энэ асуудал чинь даамжрах юм бол бид инфляцаа цаашид зогсоож чадахгүй нөхцөлд хүрэх нь

байна шүү гэж удаа дараалан анхааруулсан, шаардсан. Түүний хүрээнд өнөөдөр нэг 7 хоногийн өмнө ч болтугай УИХ хуралдаад энэ төсвийн тодотголоо хэлэлцээд эхэллээ.

Тэгэхээр ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн тодотгол хүлээлтэд хүрэхгүй байна гэдгийг түрүүн хэлсэн. Бид урсгал зардлаа танаач гэдэг шаардлагыг удаа дараалан тавьж байгаа. Эхний ээлжид ЗГ өөрөө бүсээ чангалаач, ЗГ бүтэц, бүрэлдэхүүнээ цомхотгооч. Тэгж байж дараа нь иргэдээсээ та нар бүсээ чангал гэдэг ийм хэлэх эрхтэй хүртэл болно шүү дээ. Гэтэл энэ ЗГ үлгэр дуурайлал үзүүлж чадахгүй, тэгээд 1.4 их наядын хэмнэлт хийсэн төсөв оруулж ирлээ л гээд байсан. Тэгээд яг эцсийн бүлэгт урсгал зардлаасаа 433 тэрбум төгрөг танасан ийм л байдалтай тодотгол оруулж ирлээ. Нөгөө талд нь болохоор төсвийн алдагдал 2 дахин нэмэгдсэн, 2 их наяд болсон байж байгаа. Тэр хэмжээгээр улсын өр нэмэгдээд явж байгаа манай бусад үзүүлэлтүүд суларч байгаа.

Тэгэхээр энэ нөхцөлд бид яах ёстой вэ гэдгээ Их Хурал дээр нэлээн чамбай ярих ёстой гэж бодож байна. Яагаад вэ гэхээр ер нь бид сүүлийн 10 жилийн хугацаанд маш их хэмжээний түүхий эдийн экспорт хийсэн, маш их хэмжээний төсвийн зарцуулалт хийсэн. Гэхдээ яг үнэндээ бодитоор нүдэнд үзэгдэж, гарт баригдах тийм бүтээн байгуулалт ч гэсэндээ ховор байлаа. Тэгээд түрүүн хэлсэнчлэн энэ жилийн хувьд гэхэд гадаад худалдааны үзүүлэлтүүд маш сайн байгаа, 12 тэрбум ам.долларын экспорт хийчхээд сууж байгаа хэр нь л энэ дотооддоо төгрөгийн ханшаа ийм хүнд байдалд оруулчихаад ингээд сууж байна гэдэг ерөөсөө л макро эдийн засгийн бодлогын алдаа шүү дээ. Тэгэхээр энэ бодлогын алдаандаа бодит дүгнэлтүүд хийгээд, тэгээд бид цаашид хэрхэн яаж явах юм бэ гэдгээ одоо ярихгүй бол дахиад л ахиад хэдэн жилийн дараа алдагдсан боломжийн өртөг шүү энэ тэр гээд л янз бүрийн юм яриад л сууж байна. Тэгэхээр бид энэ ирээдүйгээсээ, энэ цаг хугацааг ерөөсөө хулгайлмааргүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд түрүүн энэ ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотойгоор Ерөнхий сайд би энэ өвлийн цагт, өвөл ирж байгаа энэ цаг хугацаанд хүмүүсийг ажлаас нь халмааргүй байна энэ тэр гэсэн юм яриад байх шиг байна. Учралын ЗГ, Учрал Ерөнхий сайдаар 3 сарын 30-нд томилогдсон, өнөөдөр яг 162 хоног болж байна, 5 сар 8 хоног гэсэн үг. Тэгээд энэ хангалттай реформ хийх цаг хугацаа мөн. Тэр битгий хэл, энэ өмнөх ЗГ-ын бид алдааг засварлалаа энэ тэр гээд л яриад байгаа. Тэгэхээр та 3 сарын 30-наас хойш, ЗГ нь хэд хоногийн дараа сайд нар нь томилогдсон байх, тэр цаг хугацаанаас хойш энэ төсвийн тодотголоо оруулж ирээд, тэр Занданшатарын ЗГ-ын алдаануудыг засварлаад энэ бүтэц, бүрэлдэхүүнээ шинэчилчих бүрэн цаг хугацаа байлаа шүү дээ. Гэтэл бид ерөөсөө ингээд ажлаа аваад удаагүй байна гээд л өчигдөр төрсөн юм шиг юм яриад л, тэгээд янз бүрийн байдлаар ингээд нэг ийм шалтаг тоочоод байгаа явдал туйлын харамсалтай байна.

АН-ын зүгээс иргэдийн орлогыг хамгаалах шаардлагатай гэдгийг удаа дараалан хэлсэн. Харамсалтай нь манай эрх баригч намын сэтгэлгээгээр энэ иргэдийн орлогыг хамгаална гэдэг нь энэ төрийн албанд ажиллаж байгаа, ТӨК-удад ажиллаж байгаа 210 хэдэн мянган хүн, ТӨК-уд дээр чинь ахиад 50, 60 мянган хүмүүс байгаа, энэ хүмүүсийгээ л ер нь иргэн гэж боддог юм шиг байна шүү дээ. Тэр цаана нь хувийн хэвшлийн салбарт ажиллаж байгаа 1 сая гаруй хүмүүсийн чинь асуудал маш хүнд байдалд байгаа гэдгийг яагаад та нар.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад байнгын хороонд шилжүүллээ. Байнгын хороодоор асуудлууд яригдана. Тэгээд ирэх 7 хоногт чуулган дээр санал хураалтууд явагдана, тэгж байж төсвийн тодотгол цаашаа явна.

23.13 цаг

Өнөөдрийн чуулганд идэвхтэй оролцсон эрхэм гишүүддээ баярлалаа. Мөн ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа, УИХ-ын Тамгын газрын ажилтнууддаа баярлалаа. Өнөөдөр нэлээн орой болтол хуралдлаа. Ямар ч байсан төсвийн тодотголыг Монгол Улсын Их Хурал цаг алдалгүй хэлэлцэж эхэллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА